

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГА

МОНГОЛ УЛСЫН АРВАН ХОЁРДУГААР БҮЮУ 2017 ОНЫ ТАЙЛАН



АГУУЛГА

| | | |
|------|--|-----|
| 1 | Танилцуулга..... | 7 |
| 1.1 | Холбогдох мэдээлэл | 7 |
| 1.2 | Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг роль | 8 |
| 1.3 | Оролцогчид..... | 8 |
| 1.4 | Талархал..... | 8 |
| 2 | Гүйцэтгэлийн хураангуй..... | 9 |
| 2.1 | Салбарын тойм | 9 |
| 2.2 | Оүитбс-ын оролцоо | 9 |
| 2.3 | Тайлангийн цар хүрээ | 9 |
| 2.4 | Засгийн газрын нийт орлого | 10 |
| 2.5 | Нэгтгэлийн үр дүнгийн хураангуй | 13 |
| 2.6 | мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдал..... | 14 |
| 2.7 | Гол асуудлууд..... | 19 |
| 3 | Тохируулгын аргачлал болон цар хүрээг тодорхойлох нь | 22 |
| 3.1 | Танилцуулга..... | 22 |
| 3.2 | Цар хүрээг тодорхойлох нь | 23 |
| 3.3 | Арга аргачлал..... | 30 |
| 3.4 | Баталгаажуулалт..... | 32 |
| 4 | Тохируулгын үр дүн..... | 34 |
| 4.1 | Анхлан тайлагнасан урсгалуудын хураангуй | 34 |
| 4.2 | Анхны тохируулаагүй зөрүү болон тайлагнаагүй компаниуд | 35 |
| 4.3 | Тохируулаагүй үлдсэн зөрүү | 37 |
| 4.4 | Тайлагнаагүй компаниуд | 38 |
| 4.5 | Нэгтгэлийн үр дүн..... | 40 |
| 5 | Монголын олборлох салбар..... | 42 |
| 5.1 | Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого (шаардлага 2.1) | 42 |
| 5.2 | Уул уурхай | 58 |
| 5.3 | Ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэл, экспорт (шаардлага 3.1)..... | 83 |
| 5.4 | Газрын тос болон байгалийн хий..... | 86 |
| 5.5 | Олборлох салбарын зүгээс эдийн засагт оруулсан хувь нэмэр | 97 |
| 5.6 | Засгийн газрын байгууллагууд..... | 103 |
| 5.7 | Олборлох салбар дахь төрийн оролцоо | 105 |
| 5.8 | Төсвийн үйл явц болон орлогын хуваарилалт | 122 |
| 6 | Бусад асуудлууд..... | 129 |
| 6.1 | Бенефициар эзэд (Шаардлага 2.5)..... | 129 |
| 6.2 | Гэрээний ил тод байдал | 132 |
| 6.3 | Бэлэн бус орлого (Шаардлага 4.1.В)..... | 134 |
| 6.4 | Дэд бүтцэд хөрөнгө оруулах ба бартерын солилцоо (шаардлага 4.1.Г)..... | 135 |
| 6.5 | Нийгмийн зарцуулалт (шаардлага 6.1) | 136 |
| 6.6 | Тээврийн орлого (Шаардлага 4.1.Е) | 137 |
| 6.7 | Хандив..... | 137 |
| 6.8 | Нөхөн сэргээлтийн мэдээлэл..... | 138 |
| 6.9 | Цахим тайлагналын систем | 146 |
| 6.10 | Ашигласан усны мэдээлэл | 148 |
| 6.11 | Хог хаягдлын мэдээлэл | 148 |
| 6.12 | ОУИТБС-ын тайлангийн задаргааны түвшин, хэлбэр (шаардлага 4.7)..... | 149 |
| 7 | Зөвлөмж | 154 |
| 7.1 | Өмнөх жилийн нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт | 154 |
| 7.2 | ОУИТБС-ын тайлагнал, түүний хэрэгжилтэд өгөх зөвлөмж | 155 |
| 8 | Хавсралтууд | 161 |

Энэхүү тайлан болон хавсралтуудыг Монголын ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын албаны хүсэлтээр, санаачлагын зорилгын үүднээс МОУИТБС-ын Үндэсний Зөвлөл болон Ажлын Хэсгийн оролцогч талуудын хэрэгцээнд зориулсан болно.

ОУИТБС-ын шаардлага болон Ажлын даалгаврын дагуу ил тод болох шаардлагатай зарим мэдээллүүдийг хавсралтаар харуулсан ба их хэмжээний мэдээлэл агуулсан зарим хавсралтуудыг ашиглахад хялбар байх үүднээс ОУИТБС-ын Засаглалыг дэмжих төслийн вебсайтад Ms Excel форматаар ил тод тавьсан.

| Хавсралтын дугаарууд | Хавсралтын тайлбар | Хавсралтыг үзэх линк |
|--|---|---|
| 1, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11а, 11б, 11в, 12, 13, 14, 15, 16в, 16г, 16д, 16е, 16ж, 16з, 16и, 17, 18, 19, 20а, 20б, 21, 21а, 21б, 21в, 21г, 21д, 22, 23, 24, 25, 26, 27а, 27б, 30, 31, 32 | Үндсэн тайлантай хамт хэвлэгдэх ба ОУИТБС-ын засаглалыг дэмжих төслийн вебсайтад тавигдана. | http://www.eitimongolia.mn/mn/reconciliation-report |
| 2, 3, 16а, 16б, 16ё,28,29,33 | Үндсэн тайлангаас тусдаа ОУИТБС-ын засаглалыг дэмжих төслийн вэбсайтад тавигдана. | http://www.eitimongolia.mn/mn/reconciliation-report |

Товчлолууд ба Тодорхойлолтууд

| | | |
|------------------|---|---|
| ААН | Аж ахуйн нэгж | Entity |
| ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | Corporate Income Tax |
| Ам.доллар | Америкийн нэгдсэн улсын мөнгөн тэмдэгт (доллар) | United States Dollars |
| АМГТГ | Ашигт малтмал газрын тосны газар | Mineral Resources and Petroleum Authority |
| АМНАТ | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | Fee for exploitation and exploration of mineral resources |
| АНУ | Америкийн нэгдсэн улс | The United States of America |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт | International Standards on Auditing |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос улс | The Republic of Korea |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард улс | The People's Republic of China |
| БО | Байгаль орчин | Environment |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Ministry of Environment and Tourism |
| БОНХАЖЯ | Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам | Ministry of Environment, Green Development and Tourism |
| БОХТ | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | Environmental protection plan |
| БӨ | Бенефициар өмчлөгч | Beneficial owner |
| БУУ | Бичил уул уурхай | Micro mining |
| БХГ | Бүтээгдэхүүн хуваах гэрээ | Product Sharing Agreement |
| ГЕГ | Гаалийн ерөнхий газар | Customs General Administration |
| ГТГ | Газрын тосны газар | Petroleum Authority |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдхүүн | Gross Domestic Product |
| ДЦС | Дулааны цахилгаан станц | Thermal Power Plant |
| ЗГ | Засгийн газар | Government |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар | Governor's office |
| МОУИТБС | Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга | Mongolia Extractive Industry Transparency Initiative |
| МУ | Монгол улс | Mongolia |
| МУУА | Монголын уул уурхайн үндэсний ассоциаци | Mongolian Mining Corporation |
| МХЕГ | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | State Professional Inspection Agency |
| Мян.тн | Мянган тонн | Thousand tonnes |
| НББ | Нягтлан бодох бүртгэл | Accounting |
| НББОУС | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт | International Accounting Standards |
| НДС | Нийгмийн даатгалын сан | Social Insurance Fund |
| ННФ | Нээлттэй нийгэм форум | Open Society Forum |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар | Value Added Tax |
| ОНХНС | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан | Local Development Consolidated Fund |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан | Local Development Fund |
| ОТАХ | Олон талт ажлын хэсэг | Multi-Stakeholder Working Group |
| ОУИТБС | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга | Extractive Industry Transparency Initiative |

| | | |
|--------------|--|---|
| ОХУ | Оросын холбооны улс | Russia Federation |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт | International Standards on Financial Reporting |
| СЯ | Сангийн яам | Ministry of Finance |
| ТАН | Төлсөн Авсанаа Нийтэл | Publsih what you pay |
| ТББ | Төрийн бус байгууллага | Non-governmental Organization |
| ТБУ | Тогтвортой бичил уурхай | Sustainable artisanal mining |
| ТЕГ | Татварын ерөнхий газар | General Department of Taxation |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч | General budget governor |
| ТЕХ | Татварын ерөнхий хууль | General Law of Mongolia on Taxation |
| ТӨААН | Төрийн өмчит аж ахуйн нэгж | State-Owned Entities |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | Government agency for policy coordination on state property |
| ТӨК | Төрийн өмчит компани | State-Owned Companies |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани | State-Owned Joint Stock Company |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл | Board of Directors |
| ТЭЗҮ | Техник эдийн засгийн үндэслэл | Technical and Economic Feasibility Study |
| УИХ | Улсын их хурал | Parliament of Mongolia |
| УУХҮЯ | Уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн яам | Ministry of mining and heavy industry |
| ҮАГ | Үндэсний аудитын газар | Mogolian National Audit office |
| ҮАҮТ | Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө | National action plan |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо | National statistics of Mongolia |
| ХБ | Хөрөнгийн бирж | Stock Exchange |
| ХК | Хувьцаат компани | Joint Stock Company |
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Ministry of labor and social protection |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани | Limited Liability Company |
| ШУТИС | Шинжлэх ухаан технологийн их сургууль | Mongolian University of Science and Technology |
| ЭБМЗ | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл | Mineral professional council |

“Харт Нойрс” Лтд
Мэргэшсэн Нягтлан бодогчид
89 High StreetThame, Oxfordshire
3EH England

Tel: 44 01844 21 88 36
Website: www.hart-nurse.co.uk

“Улаанбаатар Аудит Корпораци” ХХК
Далай тауэр, 9 дүгээр давхар,
Сүхбаатар дүүрэг, 1 дугаар хороо,
Юнеско-гийн гудамж, Улаанбаатар хот
Монгол Улс
Утас: 976-7011-0744, 976-7011-0799
Факс: 976-7011-0722
Вебсайт: www.grantthornton.mn

**Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод
Байдлын Санаачилгын Ажлын Хэсэг**

Монгол Улсын ОУИТБС-ын Засаглалыг дэмжих төсөл
Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж,
Туушин компанийн байр, 314 тоот

2018 оны 12 сарын 19-ний өдөр

Англи Улсын “Харт Нойрс” Лтд ба Монгол Улсын “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн консерциум нь МОУИТБС-ын 12 дугаар тайлан буюу 2017 оны Нэгтгэлийн ажлыг (“Гэрээт ажил”) хийхээр сонгогдон, гэрээ байгуулсан билээ.

Монголын уул уурхайн болон газрын тосны үйлдвэрлэл, хайгуулын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс 2017 онд Засгийн газарт төлсөн материаллаг төлбөр хийгээд Засгийн газрын хүлээн авсан материаллаг орлогын урсгалын аудитын нэгтгэлийн гэрээт ажлыг 2018 оны 07 дугаар сарын 19-нөөс 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгээс баталсан Гүйцэтгэх ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг Холбогдох үйлчилгээний олон улсын стандарт 4400 буюу Санхүүгийн мэдээлэлд тохиролцсон горимуудыг гүйцэтгэх гэрээт ажлын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.

Бид нэгтгэсэн болон бидний анхааралд өртсөн зүйлсээ энэхүү тайлан, түүний хавсралтуудаар тайлагнаж байна. Учир нь гүйцэтгэсэн горимууд нь нэгтгэлийн болон шалгах ажлыг АОУС буюу Шалгах Ажлын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэх зорилго агуулаагүй бөгөөд бидний зүгээс энэхүү тайланд харуулсан тодорхой мэдээллүүд, тэдгээртэй холбогдох аливаа гүйлгээнүүдэд ямар нэгэн баталгаа өгөх үүрэггүй юм.

Энэхүү тайлан нь Ажлын даалгаварт тусгагдсан зүйлсийн хүрээнд Олон талт ажлын хэсэгт болон Үндэсний Зөвлөлд мэдээлэхэд зориулагдсан болно.

Тус тайлан нь зөвхөн заагдсан зүйлсийн хүрээнд хийгдсэн бөгөөд аливаа нэгэн нэгжийг бүхлээр нь хамарсан санхүүгийн тайлангуудийн хүрээнд хийгдээгүй.

“Харт Нойрс” Лтд
Мэргэшсэн Нягтлан бодогчид

“Улаанбаатар Аудит Корпораци” ХХК

1 ТАНИЛЦУУЛГА

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (ОУИТБС) гэдэг нь байгалийн баялгаас (ашигт малтмал, газрын тос, байгалийн хий) олж буй орлогыг олон нийтэд ил тод болгосноор түүнийг нийтийн сайн сайхны төлөө зөв захиран зарцуулахад нь оролцогч талуудын хариуцлагыг өндөржүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий дэлхий нийтийн түншлэл юм. ОУИТБС нь нэг талаас олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниуд төлснөө тайлагнана, нөгөө талаас Засгийн газар тэдгээр компаниудаас хүлээн авсан орлогоо тайлагнана. Хоёр талаас ирүүлсэн тайланг олон улсын хөндлөнгийн аудитын байгууллага тулган баталгаажуулалт хийж, аудитаар баталгаажсан нэгдсэн тайлан гаргаж, түүнийг олон нийтэд ил тод болгоно. Энэхүү үйл явцыг төр, компани, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий олон талт оролцогчдын бүлэг удирдан явуулж, хянан зохицуулна.

1.1 ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга бол (“ОУИТБС”) газрын тос, байгалийн хий, олборлох салбарт ил тод байдал, тайлагналыг сайжруулахад зориулсан глобал стандарт юм. Монгол улсын Засгийн газар ОУИТБС-ыг хүлээн авч байгаа тухайгаа 2006 онд зарласан бөгөөд дагалдан хийгдэх ажлуудыг хэрэгжүүлж, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зорилгоор ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийг болон Олон талт оролцогчдын ажлын хэсгийг (“ОТАХ”) Засгийн Газар, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн төлөөлөл оролцуулан байгуулсан юм.

ОУИТБС-д нэгдсэнээс эхлэн ОУИТБС-ын 11 удаагийн тайланг Монгол улс бэлтгэн гаргасан бөгөөд энэхүү арван хоёр дахь удаагийн тайлангийн Хараат бус хянагч-нэгтгэгчээр “Харт Групп” болон “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн хамтарсан консерциум томилогдсон юм.

2016 онд дахин шинэчилж, 2016 оны 2-р сарын 24-25-нд Лима хотод хуралдсан ОУИТБС-ын олон улсын хуралдаанаар баталсан ОУИТБС-ын Стандарт нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зарчмууд болон шаардлагуудыг агуулдаг.

2016 оны ОУИТБС-ын энэ стандарт нь ОУИТБС-ын мэдээллийг цуглуулахад тайлан гаргалтын одоогийн системүүдийг ашиглах, үр дүнг ил тод байлгахыг улс орнуудад хөхүүлэн дэмждэг. Энэ Стандарт нь олборлох үйл ажиллагааг эзэмшиж, ашиг хүртэж байгаа хувь хүмүүсийн тухай мэдээллийг одоо ил болгохыг шаарддаг. Олборлох төслүүдийн тендерт оролцож, ажиллаж, хөрөнгө оруулж байгаа компаниуд өөрсдийн бенефициар өмчлөгчид буюу ашиг хүртэгч эзэд нь хэн бэ гэдгийг мэдээллэдэг байхыг бүх улс орнууд баталгаажуулах шаардлагатай юм. Энэ шаардлага 2020 оны 1-р сарын 1-ээс эхлэн албан ёсоор хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.

ОУИТБС-ын чанарыг баталгаажуулах механизм буюу ОУИТБС-ын шаардлагуудыг улс орнууд баримталж байгаа эсэхийг шалгаж тогтоодог баталгаажуулалтыг 2016 оны ОУИТБС-ын Стандартын хүрээнд улам боловсронгуй болгосон юм. Энэ Стандартыг дагаж мөрдөх журмыг өөрчлөөгүй боловч гишүүнчлэл бүхий улс орнуудын харилцан адилгүй байдал, минимум шаардлагуудыг давуулан биелүүлэх чармайлтууд, хэрэгжүүлэх явцаа үргэлжлүүлэн сайжруулж байгаа зэргийг үнэлгээ дүгнэлтэд өргөн хүрээнд харгалзах юм. Өдгөө Монгол улсад ОУИТБС-ыг баталгаажуулах үйл явц үргэлжилж байна.

2016 оны ОУИТБС-ын стандартын бусад онцлог талууд бол ОУИТБС-ын тайлангуудад дэвшүүлсэн саналуудыг төрийн байгууллагууд, ОТАХ сайтар анхаарч, холбогдох үйл ажиллагаанууд явуулж байгаа эсэх, тэгснээр олборлох үйлдвэрлэлийн удирдлагын хүрээнд шаардлагатай шинэчлэл, өөрчлөлтүүд хийгдэж байгаа эсэх, тодорхойгүй, ойлгомжгүй зүйлсийг тодорхой болгох, зөрчигдөж байгаа зүйлсийг залруулах зорилгоор бусад шинэчлэлүүд хийгдэж буй эсэхийг онцлон анхаардаг явдал юм.

Энэхүү тайлан нь ОУИТБС-ын хамгийн сүүлд буюу 2016 оны 2-р сард шинэчлэгдсэн стандартын дагуу Монгол улсад хийгдэж байгаа ОУИТБС-ын 3 дахь тайлан юм.

1.2 ХАРААТ БУС ХЯНАГЧ-НЭГТГЭГЧИЙН ҮҮРЭГ РОЛЬ

Монгол улсын ОУИТБС-ын арван хоёр дахь удаагийн нэгтгэл тайланг гүйцэтгэгч Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг ролийг Ажлын даалгаварт тодорхойлсон бөгөөд үндсэн элементүүд нь дараах байдалтай байна. Үүнд:

- Тайланд тусган нэгтгэхээр ОТАХ-ийн санал болгосон хамрах хүрээг шалган нягталж, санал дүгнэлт гаргах,
- Тайланд оруулах мэдээллийг цуглуулахын тулд мэдээлэл авах загвар маягтууд боловсруулж бэлтгэх, ОТАХ-ийн шийдсэний дагуу тайлан гаргахад шаардагдах төрийн болон хувийн байгууллагуудад тэдгээр маягтыг хүргүүлэх,
- Тайлан гаргах байгууллага, иргэдээс мэдээлэл авахдаа цахим тайлагналын систем, мэдээлэл авах маягтууд, зохих бусад хэрэгслүүдийг ашиглах,
- Хүлээж авсан мэдээллийг харьцуулж, аль болох өргөн хүрээг хамруулан нэгтгэх,
- Тайланд тусгасан санхүүгийн мэдээллийн хамрах хүрээний талаар дүгнэх, шаардлагатай бол, тайлан гаргах процессыг ирээдүйд сайжруулахын тулд санал дэвшүүлэх,
- Тайланд тусгасан орлого, төлбөрийн мэдээллийг болон Монгол улсын олборлох салбарт холбогдох бусад мэдээллийг нэгтгэж, ОТАХ-ийн хэвлэн нийтлүүлэх тайланг боловсруулж бэлтгэх.

Бидний бэлтгэсэн энэхүү тайлангийн зорилго бол Нэгтгэл тайланг бэлтгэх зорилгын хүрээнд Ажлын даалгаварт тодорхойлсон асуудлуудын талаар ОТАХ болон Үндэсний Зөвлөлд мэдээлэл өгөх явдал юм.

Тус тайланг Англи, Монгол хэлээр бэлтгэсэн бөгөөд хэрэв Англи, Монгол хувилбарын хооронд аливаа зөрчил, тохирохгүй зүйлс гарвал Англи хэл дээрх хувилбарыг баримтална.

1.3 ОРОЛЦОГЧИД

Тайлан, мэдээллийг нэгтгэхэд оролцсон талууд нь:

- Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас материаллаг орлого хүлээн авч байгаа төрийн болон орон нутгийн төрийн байгууллагууд,
- Олборлох салбарыг хянах, зохицуулах, тайлан гаргуулах хариуцлага бүхий Засгийн Газрын яам, агентлагууд (5.6 бүлгийг үзнэ үү)
- Олборлох салбарт ажиллаж байгаа төрийн өмчийн компаниуд (5.7.1 бүлгийг үзнэ үү)
- Холбогдох шийдвэрийн дагуу төрийн байгууллагуудад материаллаг төлбөр төлж байгаа, олборлох салбарын компаниуд, (3.2.7 бүлгийг үзнэ үү) зэрэг юм.

Нэгтгэл тайланд оролцож байгаа төрийн байгууллагууд, компаниудын тухай мэдээллийг 3.2 бүлэг болон Хавсралт 1,2 болон 3-аас үзнэ үү.

1.4 ТАЛАРХАЛ

“Харт Нойрс Лтд” болон “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн Консерциум нь биднийг Засгийн Газар, төрийн төрөл бүрийн байгууллага, агентлагуудын болон олборлох компаниудын голлох удирдлага, ажилтнуудтай хийх хурал уулзалтыг зохион байгуулахад тусалж, тэдгээр байгууллагаас зөвшөөрөл, албан бичиг баримтууд авах, явуулахад тусалж, бусад ажлуудад дэмжлэг үзүүлсэн Ерөнхий сайдын ахлах зөвлөх, МОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энх-Амгалан, МОУИТБС-ын Засаглалыг дэмжих төслийн Ш.Цолмон зохицуулагчтай хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

2 ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

2.1 САЛБАРЫН ТОЙМ

Олборлох үйлдвэрлэл нь Монголын эдийн засгийн голлох салбар юм. 2017 онд олборлох салбар ДНБ-ний **23.4%**-ийг эзэлж, **4.9 тэрбум ам.долларын** орлого экспортоос олсон нь нийт экспортын **79.6%**-ийг эзэлж байна.

Засгийн газар олборлох салбараас орлогынхоо томоохон хэсгийг бүрдүүлдэг бөгөөд 2017 онд олборлох салбараас **2,240.6 тэрбум төгрөг** хүлээн авсан байна. Түүнчлэн төрөөс уул уурхайн компаниудад хувь эзэмших байдлаар, тухайлбал Эрдэнэс Монгол компаниар дамжуулан түүний салбар компаниудыг эзэмшиж, олборлох үйл ажиллагаанд шууд оролцож байна.

2.2 ОУИТБС-ЫН ОРОЛЦОО

МУ-ын Засгийн газар нь 2005 оны 12 сард ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр шийдэж, 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс ОУИТБС-ын нэр дэвшигчээр элссэн. Баталгаажуулалтыг амжилттай давснаар 2010 оны 10 дугаар сарын 19-ний өдөр бүрэн нийцсэнд тооцогдсон.

ОУИТБС-ыг хэрэгжүүлж эхэлсэнээс хойш Монгол улс нь 11 удаагийн тайлан гаргасан. Энэхүү тайлан нь ОУИТБС-ын 12 дахь удаагийн тайлан бөгөөд ОУИТБС-ын 2016 онд батлагдсан шинэ Стандартын дагуу толилуулж буй 3 дахь удаагийн тайлан юм.

ОУИТБС-ын Удирдах хорооноос 2017 оны 1 дүгээр сард Монгол Улсын 2016 оны ОУИТБС-ын баталгаажуулалтын дүнг баталж, засч сайжруулах 8 зөвлөмжүүдийн биелэлтийг 2018 оны 1 дүгээр сард хянан хэлэлцэж, 2 дугаар сард Монгол Улсыг ОУИТБС-ын стандартын шаардлагыг хангасан орноор хүлээн зөвшөөрсөн нь ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй 50 гаруй орнуудаас 2-дох орон болсон нь томоохон амжилт гэж үзэж байна.

2.3 ТАЙЛАНГИЙН ЦАР ХҮРЭЭ

Энэхүү тайлан нь уул уурхай, газрын тос болон байгалийн хийн салбар дахь дараах сэдвүүдийг хамарсан. Үүнд:

- Олборлох салбарын төлбөр, орлого
- Эдийн засагт оруулсан хувь нэмэр
- Үйлдвэрлэл болон экспорт
- Олборлох салбар дахь төрийн оролцоо
- Лиценз болон гэрээний ил тод байдал
- Ашигт малтмал, газрын тосны нөөцийн тойм
- Нийгмийн зардал болон байгалийн нөхөн сэргээлт
- Компанийн өмчлөл

Сүүлийн сэдвийн тухайд Монголын ОУИТБС нь бүх олборлох үйлдвэрлэлийн компаниудын бенефициар өмчлөгчийн мэдээллийг 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн албан ёсоор ил тод болгох ОУИТБС-ын Шаардлагад хэрхэн нийцүүлэх талаар аль хэдийн судалж байна. Бенефициар эздийн талаар компаниудын ирүүлсэн мэдээлэл өмнөх жилүүдтэй харьцуулахад энэ жил илүү ахицтай байсан ба дэлгэрэнгүйг 6.1 дэх бүлгээс үзнэ үү.

Мөн ашигласан ус, уул уурхайн хог хаягдал болон төслөөр тайлагнах шаардлагын талаар Ажлын даалгаварт заасны дагуу шинээр оруулсан ба дэлгэрэнгүйг 6.10, 6.11, 6.12 гэсэн бүлгүүдээс харна уу.

МОУИТБС-ын Ажлын хэсэг нь 230 компани (11 ТӨААН-үүдийг оролцуулаад) –ийн улсын болон орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийг тайлагнахаар баталсан бөгөөд Засгийн газрын 50 байгууллага (21 орон нутгийн байгууллагыг оролцуулаад) нь эдгээр компаниас хүлээн авсан орлогоо тайлагнасан.

Төлбөр, орлогыг харьцуулж, тохируулсан бөгөөд дэлгэрэнгүй үр дүнг энэхүү тайлан болон Хавсралт 9, 10-д тусгасан.

2.4 ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ОРЛОГО

2.4.1 Нийт олборлох үйлдвэрлэлийн салбараас 2017 онд Засгийн газрын хүлээн авсан орлого

Монгол улсад 2017 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 3,708 тусгай зөвшөөрлийг 2,225 компанид олгоод байна.

Улсын болон орон нутгийн түвшний төрийн байгууллагууд нь олборлох үйлдвэрлэлийн бүх компаниудаас хүлээн авсан орлогоо МОУИТБС-ын цахим тайлагналын системд тайлагнасан. ЗГ-ын тайлагналаар тусгай зөвшөөрөлтэй 170 компаниас ямар нэг орлого хүлээн аваагүй бол харин тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй 40 компаниас хүлээн авсан орлогоо ЗГ цахим тайлагналын системд оруулсан байна. Нийтдээ 2,091 компаниас орлого хүлээн авсан гэж тайлагнажээ. Энэ талаар 2.7.6 бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан.

Эдгээр 2,091 компаниас олборлох үйлдвэрлэлийн бус 23 компанийг хасвал цайхим тайлангийн систем дээр олборлох үйлдвэрлэлийн нийт 2,068 компани тайлагнасан байгаа юм.

2,068 компаниас 2,240,581 сая төгрөгийн орлого хүлээн авсан гэж тайлагнажээ, үүнд:-

Хүснэгт 2.1

| Засгийн газрын байгууллага | Засгийн газрын нийт орлого (сая төгрөгөөр) |
|---|--|
| Татварын ерөнхий газар | 1,367,064 |
| Ашигт малтмал, газрын тосны газар | 281,298 |
| Гаалийн ерөнхий газар | 221,303 |
| Нийгмийн даатгалын ерөнхий газар | 170,524 |
| Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 11,177 |
| Байгаль орчин, аялал жуулчлалын яам | 2,419 |
| Орон нутаг | 121,826 |
| Торгууль | 1,815 |
| Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | 18,811 |
| Бусад | 44,343 |
| Нийт | 2,240,581 |

Энэхүү ОУИТБС-ын тайлангийн цар хүрээнд нийцсэн төлбөр, орлогын урсгал бүрээс олсон нийт орлогын дэлгэрэнгүйг, баталсан материаллаг¹-ийн түвшнээс доогуур орлогыг хамруулаад Хавсралт 6-д харуулав.

2.4.2 Тохируулгын цар хүрээ

Цар хүрээг тодорхойлох шатанд Засгийн газрын ба компаниудын зүгээс тайлагнасан урсгалуудыг тохируулах зорилгоор ОТАХ-ээс 230 компанийг сонгож авсан. Сонголтыг хэрхэн хийсэн талаар 3.2-р бүлэгт тайлбарласан. Эдгээр сонгосон компаниудаас ЗГ-ын хүлээж авсан орлогыг тохируулгын дараах байдлаар мөн салбарын хэмжээний нийт урсгалтай харьцуулж, цар хүрээг Хүснэгт 2.2-д харуулсан болно.

¹ ОУИТБС-ын Стандарт 2016, Шаардлага 4.1.г

Хүснэгт 2.2

| Засгийн газрын байгууллага | Засгийн газрын орлого | | |
|---|-------------------------------|-------------------------------|--------------|
| | Олборлох салбарын бүх компани | Нэгтгэлд хамруулсан компаниуд | |
| Сая төгрөгөөр | Тохируулгын дараа | Тохируулгын дараа | Хувиар |
| Татварын ерөнхий газар | 1,367,064 | 1,362,973 | 99.7% |
| Ашигт малтмал, газрын тосны газар | 281,298 | 265,746 | 94.5% |
| Гаалийн ерөнхий газар | 221,303 | 218,299 | 98.6% |
| Нийгмийн даатгалын ерөнхий газар | 170,524 | 162,942 | 95.6% |
| Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 11,177 | 11,104 | 99.3% |
| Байгаль орчин, аялал жуулчлалын яам | 2,419 | 969 | 40.1% |
| Орон нутаг | 121,826 | 120,339 | 98.8% |
| Тохируулсан урсгалын дүн | 2,175,611 | 2,142,372 | 98.5% |
| Торгууль | 1,815 | | |
| Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | 18,811 | | |
| Бусад | 44,343 | | |
| Дүн | 2,240,581 | | |

2.4.3 Засгийн газрын тайлагнасан орлогын тохируулга

Тохируулгын явцад, нэгтгэлд хамруулсан компаниудтай холбоотойгоор ЗГ-ын анх тайлагнасан дүнгүүдийг дахин илэрхийлэхэд хүргэсэн асуудлууд гарсан. Нэгтгэлд хамруулсан компаниудын тухайд ЗГ-ын анх тайлагнасан орлогыг, ЗГ-ын орлогын тохируулгын дараах дүнтэй харьцуулж Хүснэгт 3-д харуулсан болно.

Хүснэгт 2.3

| Засгийн газрын байгууллага | Засгийн газрын орлого | | | Өөрчлөлт %-иар |
|---|-------------------------------|--------------------|---------------|-------------------|
| | Нэгтгэлд хамрагдсан компаниуд | | | |
| Сая төгрөгөөр | Тохируулгын өмнө | Тохируулгын дараах | Тохируулга | |
| Татварын ерөнхий газар | 1,389,880 | 1,362,973 | -26,907 | -1.9% |
| Ашигт малтмал газрын тосны газар | 265,543 | 265,746 | 203 | 0.1% |
| Гаалийн ерөнхий газар | 194,240 | 218,299 | 24,059 | 12.4% |
| Нийгмийн даатгалын ерөнхий газар | 165,049 | 162,942 | -2,107 | -1.3% |
| Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 11,084 | 11,104 | 20 | 0.2% |
| Байгаль орчин аялал жуулчлалын яам | 7,509 | 969 | -6,540 | -87.1% |
| Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | 7,481 | 18,434 | 10,953 | 146.4% |
| Бусад | 242 | 46,073 | 45,831 | 18938.4% |
| Орон нутгийн түвшин | 104,058 | 120,339 | 16,281 | 15.6% |
| Нийт дүн | 2,145,086 | 2,206,879 | 61,793 | 2.9% |

Нэгтгэлийн үр дүнд орлогын хэмжээнд хийсэн томоохон тохируулгуудыг дурдвал:

Татварын ерөнхий газар

“Саусгоби сандс” ХХК нь татварын шалгалтаар 24,0 тэрбум төгрөгийн ААНОАТ, 2,4 тэрбум төгрөгийн төгрөгийн НӨАТ-ийн нөхөн татвар төлсөн. Энэ нь ногдуулсан татварын орлого бус нөхөн татвар учир улсын төсөвт төлсөн бусад албан татварт ангилал шилжүүлж, залруулсан.

Гаалийн ерөнхий газар (ГЕГ)

“Оюу Толгой” ХХК-ийн 2017 оны 1-7 сарын хооронд төлсөн гааль, НӨАТ-ийн 24,3 тэрбум төгрөгийг ГЕГ тайлагнаагүй байсан. Үүний шалтгаан нь гаалийн мэдүүлэгт санхүүгийн хувьд бүрэн хариуцагч байгууллага нь “Оюу толгой” ХХК боловч мэдүүлэгч байгууллага нь “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК байсан.

Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг

Хоёр төрийн байгууллага хүлээн авсан хандивын дүнгээ бүтэн дүнгээр тайлагнаагүй:

- “Оюу толгой” ХХК нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-аар дамжуулан Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлж, 12 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн. Гэвч Өмнөговь аймаг нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-аас аймагт байгуулсан бүтээн байгуулалтаар тайлагнасан.
- “Цайртминерал” ХХК нь “Дорноговь их хөгжил сан” ТББ-аар дамжуулан Дорноговь аймагт дэмжлэг үзүүлж, 0.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн боловч Дорноговь аймгийн зүгээс тайлагнаагүй.

Бусад орлого

Бусад орлогын дүнд дараах томоохон хэмжээний хоёр тохируулга хийсэн:

- “Саусгоби Сэндс” ХХК-ийн Татварын ерөнхий газарт нөхөн төлсөн ААНОАТ, НӨАТ болох 26.4 тэрбум төгрөгийг зохих орлогын урсгал руу нь ангилал шилжүүлэн тохируулсан.
- “Оюу Толгой ХХК”-ийн “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-иар дамжуулан ГЕГ-т 2017 оны 8-12 сарын хооронд төлсөн гааль, НӨАТ-ийн 16.8 тэрбум төгрөгийг ГЕГ тайлагнаагүй. Үүний шалтгаан нь гаалийн мэдүүлэгт санхүүгийн хувьд бүрэн хариуцагч болон мэдүүлэгч байгууллага нь “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК байсан (дээрх тайлбарыг үзнэ үү).

Орон нутгийн орлого

Орон нутгийн төлбөр, орлогын хувьд орон нутгийн засаг захиргаа нь хүлээн авсан орлогоо бүрэн гүйцэд тайлагнахгүй байгаагаас их хэмжээний зөрүү үүсэж байна.

Өмнөх жилүүдийн нэгтгэлд ч гэсэн компаниуд нь бүрэн тайлагнадаг, орон нутгийн засаг захиргаа дутуу тайлагнадаг асуудал өнөөдрийг хүртэл хэвээр байсаар байна, цаашид энэ тал дээр анхаарал тавьж ажиллах шаардлагатай юм.

Нэгтгэлийн үр дүнд нэмж хийгдсэн зүйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг 4.5.2–р хэсгээс үзнэ үү.

2.5 НЭГТГЭЛИЙН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

2.5.1 ЗГ ба компаний урсгалуудын харьцуулалт, тохируулгын дараах байдлаар

Тохируулгын үр дүнг Хүснэгт 2.4-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 2.4

| Үзүүлэлт | сая.төг | сая.төг |
|--|---------|-------------|
| ЗГ-ын дүн тохируулгын дараа | | 2,206,879 |
| Компанийн дүн тохируулгын дараа | | 2,207,116 |
| Тайлбарлагдаагүй цэвэр зөрүү | | -236 |
| Тохируулгын хүсэлтэд хариу ирүүлээгүй компаниуд | | |
| <u>Баярсгоулд ХХК</u> | | |
| - ЗГ тайлагнасан | 50 | |
| - Компани тайлагнасан | 202 | |
| - ЗГ дутуу тайлагнасан | | -152 |
| <u>Жи Пи Эф ХХК</u> | | |
| - ЗГ тайлагнасан | 3,176 | |
| - Компани тайлагнасан | 3,212 | |
| - ЗГ дутуу тайлагнасан | | -36 |
| | | -188 |
| Бусад тайлбарлагдаагүй зөрүү | | |
| ЗГ компаниудаас илүү тайлагнасан орлого | | 62 |
| ЗГ компаниудаас дутуу тайлагнасан орлого | | -110 |
| Тайлбарлагдаагүй цэвэр зөрүү | | -236 |

Ажлын хэсэг Цахим тайлагналын системд тайлагнасан Засгийн газрын орлогын мэдээнээс нэгтгэлд хамрагдах 230 компанийг сонгосон бөгөөд үүнээс 2 компани нь цахим тайлагналын системд тайлангаа тушаагаагүй мөн Хараат бус хянагч-нэгтгэгчийн² нэмэлт хүсэлтээр тайлангаа ирүүлээгүй байна. Эдгээр 2 компаниас шалтгаалан үүсэж буй цэвэр зөрүү 188 сая төгрөг юм.

Хараат бус хянагч-нэгтгэгч гэрээт ажил эхэлснээс хойш 2 сарын хугацаанд ажиллахдаа 2017 оны нэгтгэлээр анх үүссэн 122 тэрбум төгрөгийн зөрүүг 48 сая төгрөг болгож буурууллаа.

² Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 4.4 хэсгээс үзнэ үү.

2.5.2 Олборлох салбарын орлогын хураангуй

Компанийн тайлагнасан төлбөрийн мэдээг ЗГ-ын тайлагнасан орлогын дүнтэй тохируулсны дараа 2017 онд олборлох үйлдвэрлэлийн компаниудын нийт төлбөрийн 75%-ийг 6 компаниас төлсөн бол, топ 20 компанийн төлсөн төлбөрийн дүн нь олборлох үйлдвэрлэлийн компаниудаас ЗГ-ийн хүлээж авсан нийт орлогын 91.5%-ийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 2.5

| | Компаний нэр | Компанийн мэдээгээр | Нийт дүнд эзлэх % (дангаар) | Нийт дүнд эзлэх % (өссөн дүнгээр) |
|----|------------------------------------|---------------------|-----------------------------|-----------------------------------|
| | | сая.төг | | |
| 1 | Эрдэнэт үйлдвэр ХХК | 563,688.7 | 25.2% | 25.2% |
| 2 | Оюу толгой ХХК | 414,786.7 | 18.5% | 43.7% |
| 3 | Петрочайна Дачин Тамсаг Монгол ХХК | 235,879.1 | 10.5% | 54.2% |
| 4 | Эрдэнэс Таван толгой ХК | 229,532.4 | 10.2% | 64.4% |
| 5 | Таван толгой ХК | 146,494.5 | 6.5% | 71.0% |
| 6 | Монголын Алт МАК ХХК | 108,945.5 | 4.9% | 75.8% |
| 7 | Энержи Ресурс ХХК | 78,176.3 | 3.5% | 79.3% |
| 8 | Цайртминерал ХХК | 67,729.2 | 3.0% | 82.4% |
| 9 | Саусгоби Сэндс ХХК | 47,749.8 | 2.1% | 84.5% |
| 10 | Си Өү Эй Эл ХХК | 23,977.8 | 1.1% | 85.6% |
| 11 | Шинь Шинь ХХК | 20,539.7 | 0.9% | 86.5% |
| 12 | Болдтөмөр ерөө гол ХХК | 15,546.9 | 0.7% | 87.2% |
| 13 | Монголросцветмет ХХК | 14,357.2 | 0.6% | 87.8% |
| 14 | Чинхуа МАК Нарийн сухайт ХХК | 13,250.1 | 0.6% | 88.4% |
| 15 | Өсөх Зоос ХХК | 13,176.1 | 0.6% | 89.0% |
| 16 | Багануур ХК | 12,173.9 | 0.5% | 89.5% |
| 17 | Эрдэнэс Монгол ХХК | 11,703.3 | 0.5% | 90.1% |
| 18 | Доншен газрын тос (Монгол) ХХК | 11,557.4 | 0.5% | 90.6% |
| 19 | Сентеррагоулд Монголия ХХК | 11,551.8 | 0.5% | 91.1% |
| 20 | МоЭнКо LLC | 10,182.6 | 0.5% | 91.5% |
| | Бусад компаниуд | 189,582.0 | 8.5% | |

Бүх компаниудийн дүн

2,240,581.0

Компаниудаас ирүүлсэн төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 12,13- аар оруулав.

2.6 МЭДЭЭЛЛИЙН ИЖ БҮРЭН, ҮНЭН ЗӨВ БАЙДАЛ

2.6.1 Засгийн газар

2.6.1.1 МОУИТБС-ын Цахим тайлагналын системийг ашигласан байдал

Төрийн бүх байгууллагууд МОУИТБС-ын Цахим тайлагналын системийг ашиглаж мэдээгээ ирүүлсэн.

2.6.1.2 Удирдлагын баталгаажуулалт

Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгээс тавьсан шаардлагын дагуу ОУИТБС-ын нэгтгэл тайлангийн тоон мэдээллийг хангалттай баталгаажуулсан байх ёстой. Өөрөөр хэлбэл тайлагнагч төрийн байгууллага болон компанийн ахлах түвшний удирдлагаас өгөгдсөн маягтаар бичгэн баталгаа авах юм.

Иймээс бид төрийн 10 яам, агентлаг руу бидэнд ирүүлсэн мэдээллүүд нь үнэн зөв гэсэн Удирдлагын хариуцлагын захидлыг баталгаажуулж ирүүлнэ үү гэж хүссэн боловч 7 байгууллагаас хариу ирж, 3 байгууллага хариу ирүүлээгүй.

Хүснэгт 2.6

| № | Нэр | Анхны нэгтгэлийн зөрүүгийн мэдээлэл | Анхны нэгтгэлийн зөрүүгийн тайлбар | Удирдлагын төлөөллийн захидал |
|----|--|-------------------------------------|------------------------------------|-------------------------------|
| 1 | Ашигт малтмал, газрын тосны газар | √ | √ | × |
| 2 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | ○ | ○ | √ |
| 3 | Гаалийн ерөнхий газар | √ | √ | √ |
| 4 | Сангийн яам | √ | √ | √ |
| 5 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | √ | √ | √ |
| 6 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | √ | ○ | × |
| 7 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | √ | √ | √ |
| 8 | Уул уурхайн яам | √ | √ | √ |
| 9 | Стандарт хэмжил зүйн газар | √ | ○ | × |
| 10 | Татварын ерөнхий газар | ○ | √ | √ |

- Шаардлагагүй
- Эксэль файл хүлээн авсан, гарын үсэг зурсан баримт хүлээн аваагүй
- √ Гарын үсгээр баталгаажсан баримт хүлээн авсан
- ×

Удирдлагын хариуцлагын захидал ирүүлээгүй төрийн байгууллагууд:

- Ашигт малтмал, газрын тосны газар
- Нийгмийн даатгалын ерөнхий газар
- Стандарт хэмжил зүйн газар

МОУИТБС-ын Ажлын алба эдгээр агентлаг газруудтай холбогдон асуудлыг тодруулж, тавьсан шаардлагыг биелүүлээгүй шалтгаан үндэслэлийг Ажлын хэсэгт танилцуулах нь зүйтэй.

Орон нутгийн 4 аймгаас Удирдлагын хариуцлагын захидал ирүүлээгүй:

- Говь-Алтай
- Говьсүмбэр
- Сүхбаатар
- Сэлэнгэ

МОУИТБС-ын Ажлын алба эдгээр орон нутгийн удирдлагуудтай холбогдон асуудлыг тодруулж, тавьсан шаардлагыг биелүүлээгүй шалтгаан үндэслэлийг Ажлын хэсэгт танилцуулах нь зүйтэй.

2.6.1.3 Аудитын баталгаажуулалт

Үндэсний аудитын газраас аудитыг нь хийсэн Засгийн газрын байгууллагууд нь ОУИТБС-ын цахим тайлагналын системд оруулж тайлагнасан тоон мэдээллээ баталгаажуулсан аудиторын мэдэгдлийг ирүүлээгүй.

2.6.2 Төрийн өмчит аж ахуйн нэгж (ТӨААН)

МОУИТБС-ын Ажлын хэсгээс шаардсан мэдээллүүдийг гаргаж өгөх болон цахим тайлагналын системийн хэрэглээ нь ОУИТБС-ын тайлагналын үйл явцын тухайд хийж буй засгийн газрын хүчин чармайлтыг харуулах чухал хэсэг юм.

2.6.2.1 МОУИТБС-ын Цахим тайлагналын системийг ашигласан байдал

Ажлын цар хүрээг тодорхойлсон 2018 оны 8 дугаар сарын 14-ны өдөр МОУИТБС-ын цахим тайлангийн системд тайлагнаагүй ТӨААН-үүд байхгүй, бүгд тайлагнасан болно.

2.6.2.2 Удирдлагын хариуцлагын захидал

Нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдээс

- “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон
- “Баянтээг” ХК нь Удирдлагын хариуцлагын захидал ирүүлээгүй байна.

МОУИТБС-ын Ажлын алба эдгээр ТӨААН-үүдтэй холбогдон асуудлыг тодруулж, тавьсан шаардлагыг биелүүлээгүй шалтгаан үндэслэлийг Ажлын хэсэгт танилцуулах нь зүйтэй.

2.6.2.3 Аудиторын мэдэгдэл

ТӨААН-үүдийн баталгаажуулалттай холбогдуулан ҮАГ-тай уулзалт хийж, ҮАГ-ын байр суурь, гаргасан шийдвэр, цаашдын төлөвийг сонирхож дараах дүгнэлтэд хүрсэн. Үүнд:

- ҮАГ-аас баталсан Санхүүгийн тайланд аудит хийх журмын 15.4.2-д “Олборлох үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн төсөвт төвлөрүүлсэн төлбөрийг ОУИТБС-ын Ажлын алба болон орлого хүлээн авсан Засгийн газрын байгууллагуудтай тулган баталгаажуулж, дүгнэлт гаргах” гэж заасан байна.
- Засгийн газар компаниудаас хүлээн авсан орлогоо 5-6 дугаар сард багтаан тайлагнадаг. Төсвийн тухай хуулиар ҮАГ-ын хувьд дараа оны 2 сарын 15 гэхэд төсвийн шууд захирагч нарын тайланд аудит хийж дүгнэлтээ гаргадаг. ҮАГ-аас 5-6 сард гаргасан тайланг баталгаажуулах хүн хүч, цаг хугацааны боломжгүй гэдгээ илэрхийлсэн.
- ҮАГ-ын хувьд төсвийн шууд захирагч нарын санхүүгийн тайланд аудит хийж байхдаа ОУИТБС-ын тайлан гаргадаг төрийн байгууллагуудыг санхүүгийн тайлангийн аудитыг хийж байх явцдаа ОУИТБС-ын тайланг нь давхар баталгаажуулах боломжтой гэж үзэж байна.
- ТӨААН-үүдийн аудитлагдсан санхүүгийн тайлан ҮАГ-ын вэбсайт дээр ил тод болсон боловч СТОУС-ын шаардлага хангасан (хавсралт тодруулгууд бүхий) санхүүгийн тайлангуудыг бүрэн нийтлээгүй тул хэрэглэгчид компаний талаарх бүрэн мэдээллийг авч чаддаггүй байна.

Нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдээс аудиторын мэдэгдлийг ирүүлээгүй: Үүнд:

- Эрдэнэт үйлдвэр ХХК
- Багануур ХК
- Дархан төмөрлөгийн үйлдвэр ХК
- Улаанбаатар төмөр зам /Чулуун завод/ ХНН
- Монголросцветмет ХХК
- Тавантолгой ХК
- Баянтээг ХК

2.6.2.4 Аудитлагдсан санхүүгийн тайлан

Дараах гурван ТӨААН нь Ажлын хэсгийн шаардлагад нийцүүлэн аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлээгүй. Үүнд:

- Тавантолгой ХК

- Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХК
- Баянтээг ХК

2017 оны Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг харахад бидний анзаарснаар ҮАГ нь 13 ТӨААН-д “хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна. Үүнээс олборлох салбарын 3 компани байна:

- “Шивээ-Овоо” ТӨХК
- “Эрдэнэс таван толгой” ХК
- Мон Атом ХХК

Харин үлдсэн 10 компани нь олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаггүй компаниуд байна.

ЗГ-ын нэгтгэсэн тайланд ҮАГ-аас “Шивээ-Овоо” ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн буруу илэрхийлэлтэй холбогдуулж 15 тэрбум, “Эрдэнэс таван толгой” ХК -ийн санхүүгийн тайлангийн буруу илэрхийлэлтэй холбоотойгоор 11.2 их наяд төгрөгийн зөрчилд хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна.

Хараат бус-хянагч нэгтгэгчид ирүүлсэн аудитлагдсан санхүүгийн тайланг хянаж үзэхэд хэд хэдэн асуудлаар аудитын дүгнэлтийг хязгаарласан байсан. Тухайлбал: Эрдэнэс Таван Толгой ХК-ийн хувьд хөндлөнгийн аудиторын гаргаж тавьсан асуудлууд нь нэгж хувьцааны үнийн анхны тооцоолол нотлох баримтгүй, нүүрс овоолгын бүртгэл үлдэгдлийн талаар болон нөхөн сэргээлтийн бүртгэл тооцоо, эсвэл тооцооллыг сайжруулдаггүй гэсэн утгатай байсан. Хараат бус аудиторын Нягтлан бодох бүртгэлийн зөрүүний тодруулгатай холбоотой зөвлөмжөөс харахад ТӨААН-үүдийн санхүүгийн удирдлагын чадавхыг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

Эдгээр компаниудаас ЗГ-ын хүлээн авсан орлогын дүнг дор харуулав:

Хүснэгт 2.7

| Компани сая.төг | Тохируулгын дараах орлогын нийт дүн | |
|-------------------------|---|---------|
| | ЗГ | Компани |
| Шивээ-Овоо ТӨХК | 4,995 | 4,995 |
| Эрдэнэс Таван Толгой ХК | 229,532 | 229,532 |
| Мон Атом ХХК | Материаллаг төлбөр байхгүй, нэгтгэлд хамрагдаагүй | |

2.6.3 Хувийн компаниуд

2.6.3.1 МОУИТБС-ын Цахим тайлагналын системийг ашигласан байдал

Нэгтгэлд хамрагдсан 219 компани (ТӨААН-ийг оруулаагүй)-иас 177 компани нь цахим тайлагналын системийг ашиглан төлбөрөө тайлагнасан. 42 компани нь МОУИТБС-ын цахим тайлагналын системд тайлан мэдээгээ ирүүлээгүй бөгөөд эдгээр компаниудаас нэмэлт маягтаар мэдээллийг цуглуулсан.

Эдгээр 42 компаний тайлагнасан орлого нийтдээ 247,340 сая төгрөг байсан нь нийт орлогын 11%-ийг эзэлж байна. Цахим тайлагналын систем ашиглаагүй компаниудын дотроос Петровича Дачин Тамсаг компанийн тайлагнасан дүн 235,873 сая.төгрөг байлаа.

Уг шаардлагыг биелүүлээгүй компаниудын мэдээллийг 4.2 хэсгээс үзнэ үү.

Цахим тайлагналын системийг ашиглах шаардлагыг чухалчлах болон практик хүндрэл (тайланг оруулах хугацаа хэр нийцтэй байгаа г.м) байгаа эсэхийг тодорхойлох, эдгээр хүндрэлийг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлыг олборлох үйлдвэрлэлийн компаниудтай цаашид илүү ихээр ажиллах шаардлагатай байна.

2.6.3.2 Удирдлагын баталгаа

Тайланд хамрагдсан 219 компаниас (ТӨААН-үүдийг оруулаагүй) 24 компани нь Ажлын хэсгийн баталсан горимтой үл нийцэж, Удирдлагын хариуцлагын захидлыг баталгаажуулж ирүүлээгүй. Удирдлагын хариуцлагын захидал ирүүлээгүй компаниудаас тайлагнасан орлогын дүн 585,782 сая.төгрөг бөгөөд энэ нь нийт тайлагнасан орлогын 27% болж байна.

Уг шаардлагыг биелүүлээгүй компаниудын мэдээллийг Хавсралт 7-с үзнэ үү.

2.6.3.3 Аудиторын мэдэгдэл

Түүнчлэн бүх компаниуд (ТӨААН-үүдийг оруулаагүй)-иас холбогдох аудиторуудаасаа мэдэгдэл гаргуулж өгөхийг хүссэн. 121 компани нь ОУИТБС-д ирүүлж буй тайлангаа “Аудитын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн, аудитлагдсан санхүүгийн тайлантайгаа уялдуулсан” гэсэн баталгаажуулсан аудиторын мэдэгдлээ ирүүлсэн. Аудиторын мэдэгдлээ ирүүлээгүй компаниудаас тайлагнасан орлогын дүн 1,753,235 сая.төгрөг бөгөөд энэ нь нийт тайлагнасан орлогын 79% болж байна.

Уг шаардлагыг биелүүлээгүй компаниудын мэдээллийг Хавсралт 7-с үзнэ үү.

Энэ нь өмнөх тайлангуудтай харьцуулахад дэвшилттэй байна.

2.6.3.4 Аудитлагдсан санхүүгийн тайлан

219 компаниас 146 компани нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн хуулбараа ирүүлсэн ба үүнээс найман аудитын тайлан нь хязгаарлалттай дүгнэлт авсан байсан бол үлдсэн нь зөрчилгүй дүгнэлт авсан болсон.

Аудитлагдсан санхүүгийн тайлангийн хуулбараа ирүүлээгүй компаниудаас тайлагнасан төлбөрийн дүн 443,935 сая.төгрөг бөгөөд энэ нь нийт тайлагнасан орлогын 20% болж байна.

Уг шаардлагыг биелүүлээгүй компаниудын мэдээллийг Хавсралт 7-с үзнэ үү.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хүссэний зорилго нь тайлагнаж буй компаниудын баталгаажуулалтын орчин нөхцөлийг шалгах боломжтой болох юм. Энэ шаардлагыг хангахын тулд компаниудтай цаашид илүү хамтран ажиллах шаардлагатай байна.

2.6.4 Хураангуй

Зарим Засгийн газрын байгууллагуудаас Удирдлагын хариуцлагын захидал ирүүлээгүй үед Засгийн газрын тайлагнасан дүнд хязгаарлагдмал баталгаа байгаа юм. Хараат бус нэгтгэгч нь толилуулсан дүнгүүдийг аудитладаггүй бөгөөд тайлагнагч нэгжүүдээс ирүүлэх баталгаажуулалтад найддаг.

Удирдлагын хариуцлагын захидлыг нийт ТӨААН-үүдээс 2-оос бусад нь ирүүлсэн ба ТӨААН-ийн санхүүгийн тайланд өгсөн аудитын хязгаарлалттай дүгнэлт нь ТӨААН-үүдийн санхүүгийн тайланг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Бид гурван ТӨААН-үүдийн санхүүгийн тайлантай танилцаж чадаагүй.

Нэгтгэлд хамрагдсан компаниудын 90% нь Удирдлагын хариуцлагын захидлаа, 47% нь Аудиторын мэдэгдлээ ирүүлсэн ба бидэнд ирүүлсэн мэдээллээр санхүүгийн тайлангийн 78% нь аудитын зөрчилгүй дүгнэлттэй байсан нь компанийн тоон дүнг баталгаажуулахад томоохон хувь нэмэр оруулж байна. Тайлант оны хувьд хамгийн том компаниудын ирүүлсэн баталгаажуулалтын мэдээлэл зарим нэг талаараа дутмаг байлаа.

Хүснэгт 2.8

| Компанийн нэр | Аудитын тайлан | Аудиторын мэдэгдэл | Удирдлагын хариуцлагын захидал | Тайлагнасан дүн (тэрбум төгрөг) | Зэрэглэл | Нийт төлбөрт эзлэх хувь |
|-------------------------|----------------|--------------------|--------------------------------|---------------------------------|----------|-------------------------|
| Эрдэнэт | √ | × | × | 563.69 | 1 | 25.16% |
| Оюу Толгой | √ | × | √ | 414.79 | 2 | 18.51% |
| Петрочайна Дачин Тамсаг | √ | × | √ | 235.88 | 3 | 10.53% |
| Эрдэнэс Таван толгой | √ | √ | √ | 229.53 | 4 | 10.24% |
| Тавантолгой | × | × | √ | 146.49 | 5 | 6.54% |
| Монголын Алт МАК | × | × | √ | 108.95 | 6 | 4.86% |
| Энержи Ресурс | √ | × | √ | 78.18 | 7 | 3.49% |
| Цайртминерал | √ | √ | √ | 67.73 | 8 | 3.02% |
| Саусгоби Сэндс | √ | √ | √ | 47.75 | 9 | 2.13% |
| Си Өү Эй Эл | √ | √ | √ | 23.98 | 10 | 1.07% |

2.7 ГОЛ АСУУДЛУУД

2.7.1 Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийг батлуулах шаардлага

Уул уурхайн компаниудтай холбоотой мэдээллийг гаргаж өгөх асуудал нь бусад хуулиудаар хязгаарлагдаж байна. Тухайлбал:

- Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс ТЕХ-д заасны дагуу тухайн ААН-ийн зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн нэмэлт мэдээлэл, тодруулга, тайлбар өгөх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн.
- ГЕГ нь мөн Гаалийн ерөнхий хуулиар заасан хязгаарлалтаас шалтгаалан компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг Хараат бус хянагч-нэгтгэгчид гаргаж өгөх боломжгүй байгаа нь харагдаж байсан.
- Стандартчилал хэмжил зүйн газраас сорьцын хяналтаар орсон мэдээлэл хүсэхэд энэ нь Төрийн албаны нууцын тухай хуулиар хориглосон байх жишээтэй.
- Эрдэнэс Монгол ХК нь ТӨААН-үүдтэй холбоотой мэдээллийг гаргаж ирүүлэх боломжгүйгээ мэдэгдсэн боловч ямар шалтгаанаар мэдээлэл ирүүлэх боломжгүйгээ мэдэгдээгүй
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын зүгээс үндсэн болон нэмэлт мэдээллийн маягтаар гаргаж ирүүлэхийг хүссэн мэдээлэл, ялангуяа Бенефициар эздийн мэдээллийг Хувь хүний нууцтай холбоотой тул гаргаж өгөхөөс татгалзаж байсан.

2.7.2 Тайлагнаагүй компаниуд

Нийт 42 компани анхны тайлангаа цахим тайлангийн системд оруулаагүй байсан нь анхны зөрүүнд өндөр дүнгээр нөлөөлсөн. Анхлан тайлагнаагүй томоохон төлбөр бүхий компаниудыг танилцуулбал:

- Петрочайна Дачин Тамсаг ХХК (235,879 сая төгрөг),
- Монцемент Билдинг Материалс ХХК (2,412 сая төгрөг)
- Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХК (2,406 сая төгрөг) гэх мэт.

Анхны тайлангаа илгээж, нэгтгэлийн явцад холбогдсон боловч үүссэн зөрүүг тодруулах, цахим тайлангийн системд нэмэлт мэдээллийн маягтаар Хараат бус нэгтгэгчид тайлангаа ирүүлээгүй 2 компанийн хувьд Засгийн газар нь эдгээр компаниудаас хүлээн авсан 188.0 сая төгрөгийг тайлагнасан бөгөөд энэ нь нийт ЗГ-ын хүлээн авсан дүнтэй харьцуулахад материаллаг биш байна.

Жилээс жилд тайланд хамрагдах байдалд нааштай өөрчлөлт гарч, жил бүр тайлангаа тушаах компаниудын тоо өсөж байгаа боловч зарим компаниуд материаллаг дүн бүхий төлбөр төлсөн боловч тайлагнадаггүй, нэгтгэлийн явцад нэмэлт мэдээллийн маягыг цахим тайлангийн

системд сайн дураараа бөглөж, илгээхээс татгалздаг явдал байсаар байна. Энэ нь хуулийн шаардлагаар заавал тайлангаа тушаадаг байдлыг хэвшүүлэх нь зүйтэй болохыг харуулж байна.

2.7.3 ЗГ-ын байгууллагуудын тайлагналын чанарыг дээшлүүлэх тухай

Засгийн газрын зарим байгууллагууд болон компаниудын хувьд анхлан тайлагнасан дүнгээс материаллаг хэмжээний дүнгээр тохируулга хийгдэж байгаагаас харахад цахим тайлагналын системд анх тайлагнахдаа хайхрамжгүй хандаж байгааг илтгэж байна. Иймээс Засгийн газрын хүлээн авсан орлогоо, уул уурхайн компаниуд нь төлсөн төлбөрийн мэдээгээ ОУИТБС-ын цахим тайлагналын системд хариуцлагатай, үнэн зөв тайлагнаж байх асуудлыг хэвшүүлэх шаардлагатайг харуулж байна.

2.7.4 Баталгаажуулалтын үр дүн эргэлзээтэй байна

ОУИТБС-ын стандартад өгөгдөл мэдээний чанарын асуудлыг чухлаар авч үздэг, ялангуяа олон улсын жишгийг дагаж мөрдөх болон тохируулгын хэрэгцээг багасгахыг зорьж байгаа бол заавал биелүүлэх ёстой юм.

Төрийн байгууллагууд болон, ТӨААН ба компаниуд нь цахим тайланд тайлагнасан төлбөр орлогын мэдээлэл болон нэмэлтээр ирүүлсэн мэдээллээ үнэн зөв гэдгийг баталгаажуулж, аудиторын мэдэгдэл, Удирдлагын хариуцлагын захидал, аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлэх шаардлагыг ОТАХ-ээс тавьдаг.

Тайлагнагч байгууллагууд энэхүү баталгаажуулалтын гол шаардлагуудыг 2017 онд хэрхэн биелүүлсэнийг өмнөх ОУИТБС-ын тайлангуудын мэдээллүүдтэй харьцуулсан үр дүнг хүснэгтээр оруулав.

Хүснэгт 2.9

| | ОУИТБС тайлан | | |
|---|---------------|------|------|
| | 2015 | 2016 | 2017 |
| Улсын түвшний төрийн байгууллага | | | |
| Нэгтгэлд хамрагдсан тоо | 10 | 8 | 10 |
| Удирдлагын баталгаа ирүүлээгүй | 6 | 7 | 3 |
| Аудиторын мэдэгдэл ирүүлээгүй | 10 | 8 | 10 |
| ТӨААН | | | |
| Нэгтгэлд хамрагдсан тоо | 10 | 11 | 11 |
| Удирдлагын баталгаа ирүүлээгүй | 1 | 1 | 2 |
| Аудитлагдсан СТ ирүүлээгүй | 4 | 2 | 3 |
| Хувийн компаниуд | | | |
| Нэгтгэлд хамрагдсан тоо | 192 | 202 | 219 |
| Удирдлагын баталгаа ирүүлээгүй | 45 | 39 | 24 |
| Аудитлагдсан СТ ирүүлээгүй | 119 | 65 | 73 |

Төрийн байгууллагууд ба ТӨААН-үүд удирдлагын баталгаажуулах захидлаа бүрэн ирүүлэхгүй явдал байсаар байхын зэрэгцээ ТӨААН-үүд бүгд аудитлагдсан санхүүгийн тайлангийн хуулбараа ирүүлээгүй байна.

Нөгөө талаас, хувийн компаниуд удирдлагын хариуцлагын захидал болон аудитлагдсан санхүүгийн тайлангаа мөн нэг бүрчлэн ирүүлээгүй байгаа хэдий ч сүүлийн үед харьцангуй дэвшилттэй харагдаж байна.

Хараат бус-хянагч нэгтгэгч оролцогч талуудын төлбөр, орлогын дүнд их хэмжээний тохируулга хийсээр байгаагаас харахад ОУИТБС-д буруу тайлагнасан оролцогч талуудын хариуцлагыг дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байгаа юм.

2.7.5 Петрожайна Дачин Тамсаг ХХК

Тус компани нь цахим системд анх тоон мэдээллээ тайлагнаагүй байна. Компаниас дараа нь хүлээж авсан тайлангаас харахад 2017 онд Засгийн газарт 235 тэрбум төгрөг төлснөөр тайлагнасан байна, Үүнд:

- Ашигт газрын тос - 190 тэрбум төгрөг
- ГТНАТ - 29 тэрбум төгрөг
- Бусад - 16 тэрбум төгрөг

Компани уг дүнг баталгаажуулсан Удирдлагын хариуцлагын захидлыг Хараат бус нэгтгэгчид ирүүлсэн. Гэвч тус компани 2017 оны санхүүгийн тайландаа зөвхөн 35 тэрбум төгрөгийн орлого тайлагнасан бөгөөд уг санхүүгийн тайлан нь аудитлагдаж, компанийн удирдлагын хариуцлагын захидлаар баталгаажсан тайлан байна.

Энэ бол томоохон тайлбарлагдаагүй зөрүү юм. Санхүүгийн тайлан нь аудитлагдсан хэдий ч буруу байх магадлалтай ба Монгол улсын хуулийг зөрчсөн гэж үзэж байна.

Мөн компанийн зүгээс тайлагнасан дүн нь компанийн аудитлагдсан санхүүгийн тайлантай нийцэж буй гэдгийг баталсан аудиторын мэдэгдэл Хараат бус хянагч-нэгтгэгчид ирүүлээгүй гэдгийг онцолж байна.

АМГТГ энэ асуудлыг лавшруулан шалгаж, цаашлаад Сангийн яам компанийн тайланг хянаж, санхүүгийн тайлан нь үнэн зөв эсэхийг хянахыг зөвлөж байна.

2.7.6 Компаний жагсаалтын бүрэн бус байдал

Эхлэлийн үйл явцын дараа Хараат бус хянагч-нэгтгэгч нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаний тоог (2,225) цахим тайлан дээрх ЗГ-ын тайлангаар орлого төвлөрүүлсэн гэх компаниудын тоотой (2,091) харьцуулж үзэх боломжтой болсон.

Энэхүү харьцуулалтаар тайлбарлагдаагүй зөрүү үүссэн. Зөрүүг цааш тодруулахад:-

| | |
|---|--------------|
| АМ-ын тусгай зөвшөөрөлтэй компани | 2,225 |
| Цахим тайлагналын системд ороогүй | -174 |
| | <hr/> |
| | 2,051 |
| Цахим тайлагналын системд орсон боловч | |
| АМ-н тусгай зөвшөөрөлгүй компаниуд | 40 |
| Цахим тайлангийн систем дээр байгаа компаний тоо | <hr/> |
| | 2,091 |

МОУИТБС-ын Ажлын алба нь дараах үйл явцыг баримталсан:-

1. МОУИТБС нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй бүх компаний жагсаалтыг гаргасан
2. МОУИТБС нь уг жагсаалтаа Сангийн Яам руу өгсөн, Сангийн яам нь ЗГ-ын яам агентлагуудаас санхүүгийн мэдээллийг цуглуулах ажлыг зохион байгуулдаг.
3. ЗГ-ын яам агентлагууд нь жагсаалтад орсон Компаниудаас хүлээн авсан орлогын мэдээллийг тайлагнана
4. Дээрх процессийн дүнд бий болсон мэдээллийг Хараат бус хянагч-нэгтгэгч хүлээн авч нэгтгэлд хамруулах компаниудийг сонгохдоо ашиглана.

Зөвхөн цахим тайлагналын систем дээр байгаа компаниуд руу ЗГ-т төлсөн төлбөрийн мэдээллээ ирүүлэх хүсэлтийг гаргасан. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй хэдий ч ЗГ тухайн компаниас орлого хүлээн авсан гэж тайлагнаагүй бол тэдгээр компанийг нэгтгэлд оруулахгүй.

Сангийн яам, МОУИТБС-ын Ажлын албаны зүгээс ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудыг ЗГ орлого хүлээж авсан гэж тайлагнасан эсэхээс үл хамааран бүгдийг нь цахим тайлагналын системд хамруулсан эсэхийг шалгаж үзээгүй байна.

Хэрэв энд онцлон дурдсан 174 компаний нэг эсвэл түүнээс дээш тооны компани ЗГ-т төлбөр төлсөн байгаад ЗГ түүнийг нь ямар нэг шалтгаанаар цахим систем дээр тайлагнаагүй бол тэдгээр төлбөрүүд нэгтгэлд орж чадаагүй хоцорно гэсэн үг.

Цахим тайлангийн системд оруулсан ЗГ-ын тайлангийн мэдээгээр орлого төвлөрүүлээгүй, гэхдээ ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 174 компаний жагсаалтыг Хавсралт 32(а)-д оруулав.

Тусгай зөвшөөрөлтэй компаний жагсаалтанд байхгүй компаниудаас (эдгээр 40 компаний жагсаалтыг Хавсралт 32(б)-с үзнэ үү) хүлээж авсан орлогоо засгийн газар яагаад тайлагнасан шалтгааны тухайд одоогоор тайлбар өгөөгүй байна.

Тайлант хугацаанд тухайн компаниас ЗГ орлого хүлээж авсан гэж тайлагнасан эсэхээс үл хамааран Цахим тайлагналын систем дээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй бүх компанийг оруулахыг бид зөвлөж байна. Түүнчлэн ОУИТБС-ын нэгтгэл тохируулга хийхэд хамруулах компаниудыг сонгохоосоо өмнө МОУИТБС Ажлын алба нь цахим систем рүү ороод энэ асуудал бүрэн гүйцэд хийгдсэн эсэхийг шалгадаг байх нь зүйтэй.

3 ТОХИРУУЛГЫН АРГАЧЛАЛ БОЛОН ЦАР ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ

3.1 Танилцуулга

Харт Нойрс Лтд, Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хамтарсан консерциум (Хараат бус Хянагч-нэгтгэгч) нэгтгэл тайланг гэрээт ажлын даалгаварт тодорхойлсон шаардлагын дагуу гүйцэтгэх үүрэгтэй. Энэхүү нэгтгэлээр олборлох салбарын компаниудын төлсөн төлбөрийг, ЗГ-ын хүлээн авсан орлоготой тохируулах ажил хийдэг бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг энэ бүлэгт оруулсан болно.

Тохируулгыг хийхдээ мөнгөн суурьт нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтална.

Хэрэв цахим тайлагналын системд төлсөн болон хүлээн авсан байгууллагуудын аль аль нь материаллаг хэмжээний төлбөр эсвэл орлого орхигдуулсан бол бидний ажил эдгээрийг шийдэх бололцоогүй бөгөөд энэ нь тайланд орохгүй байх эрсдэлтэй юм. Харин ЗГ болон компанийн аль нэг нь тайлагнасан бол нөгөө талын орхигдсон мэдээллийг олж авч, нэгтгэлд хамруулах бүрэн боломжтой. Үүнээс бусад тохиолдолд бол тэдгээр орхигдсон төлбөр орлогын мэдээллүүд бидний тайланд багтаагүй.

Бид тайлагнагч байгууллагуудаас бөглөж ирүүлсэн маягт, мэдээлэл ба тэднээс өгсөн тайлбарт үндэслэн өөрсдийн ажлыг гүйцэтгэсэн ба тоо мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдалд аудит хийгээгүй болно.

Энэхүү ажлыг гүйцэтгэх явцад тайлагнагч байгууллагуудаас хүлээн авсан тайлбар, мэдээлэл үнэн зөв гэдэгт бид найдаж байна.

Бидний тайлан 2018 оны 8 сарын 14-ныг хүртэл хүлээн авсан төлбөр орлогын мэдээлэл болон 2018 оны 11 сарын 7-ныг хүртэлх цахим тайлагналын нэмэлт мэдээллээс бүрдсэн. Энэ хугацаанаас хойш хүлээн авсан ямар нэгэн мэдээлэл энэхүү тайланд орохгүй.

3.2 ЦАР ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ

3.2.1 Танилцуулга

Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны нэгтгэл тайланд хамрагдах цар хүрээг тодорхойлохдоо ОТАХ-тэй хамтран дараах асуудлуудыг харгалзаж үзсэн. Үүнд:

- Тайланд хамрагдах уул уурхайн салбарын үндсэн мэдээллүүдийн хүрээг тогтоох,
- Тайланд хамрагдсан компаниудаас авах нэмэлт мэдээллүүдийн хүрээг тогтоох,
- Тайланд хамрагдах материаллаг төлбөр төлсөн компаниудыг тодорхойлох,
- Тайланд хамрагдах материаллаг төлбөр хүлээж авсан төрийн байгууллагуудыг тодорхойлох,
- Тайлан хамрагдах материаллаг төлбөр бүхий санхүүгийн урсгалуудыг тодорхойлох,
- Тайлагнасан тоо мэдээлэл нь үнэн зөв гэдгээ баталгаажуулах хувилбарууд

3.2.2 Цар хүрээ тодорхойлох ба Эхлэлийн семинар

Эхлэлийн үе шатанд бид ОУИТБС-ын 2017 оны тайланд оруулах шаардлагатай агуулга, мэдээлэл, Ажлын даалгаврын Хавсралт 2-т орох баримт бичгүүдийг хянан шүүж, энэ талаар хэд хэдэн оролцогч талуудтай урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Эхлэлийн үе шатны зорилго нь ОУИТБС-ын тайлагналын үйл явцын хамрах хүрээг зөв тодорхойлж, мэдээлэл цуглуулах журам, ОУИТБС-ын тайланг хэвлэх хуваарь зэргийг баталгаажуулах явдал юм.

Бид МОУИТБС-ын Ажлын албанаас 2018 оны 7 дугаар сарын 6-нд зохион байгуулсан олон талт ажлын хэсэг (цаашид ОТАХ гэх)-ийн гишүүдийг хамруулсан семинарт оролцож, 2017 оны ОУИТБС-ын тайлангийн агуулга, холбогдох тодорхойлолтууд болон ил тод болгох мэдээллийн материаллаг хэмжээний босго үзүүлэлтүүдийг авч хэлэлцсэн бөгөөд, энэхүү тайланд семинарын үеэр авсан саналыг тусгасан.

3.2.3 Материаллаг байдлын босго үзүүлэлт

Бид нэгтгэлд хамруулах компанийг сонгохдоо ашиглах материаллагийн түвшин тодорхойлохын тулд ОУИТБС-ын Ажлын албанаас 2018 оны 8-р сарын 14-нд бидэнд ирүүлсэн Засгийн газрын тайлан дээрх уул уурхай, газрын тосны салбараас Засгийн газрын хүлээн авсан орлогын урсгалыг харгалзан үзсэн.

Материаллаг байдлыг тооцохдоо улсын татвар, орон нутгийн татварыг тус тусад нь харгалзаж үзсэн.

ОУИТБС-ын тайланд хамрагдах төлбөр, орлогын материаллаг байдлыг Эхлэлийн семинар дээр ОТАХ-тэй хэлэлцэж, ОТАХ үүнийг дараах байдлаар шийдвэрлэсэн. Үүнд:

Хүснэгт 3.1

| Аргачлал | Улсын түвшний төлбөр, орлого бүхий нэгтгэлд сонгогдсон компаниуд | Орон нутгийн түвшний төлбөр, орлого бүхий нэгтгэлд сонгогдсон компаниуд |
|----------------------------|--|---|
| Заавал хамруулах | 300.0 сая болон түүнээс дээш улсын түвшний төлбөр, орлого бүхий компаниуд | 100.0 сая болон түүнээс дээш улсын түвшний төлбөр, орлого бүхий компаниуд |
| | 100.0 саяас дээш, 300.0 саяас бага төлбөр, орлого бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг, олборлолт явуулж буй компаниуд | 30.0 саяас дээш, 100.0 саяас бага төлбөр, орлого бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг, олборлолт явуулж буй компаниуд |
| Түүвэрлэн хамруулах | 100.0 саяас дээш, 300.0 саяас бага улсын түвшний төлбөр орлого бүхий хайгуулын компаниуд | 30.0 саяас дээш, 100.0 саяас бага орон нутгийн түвшний төлбөр орлого бүхий хайгуулын компаниуд |
| Нэгтгэх | Давхацсан компаниудын давхардлыг арилгах | Давхацсан компаниудын давхардлыг арилгах |

Эхлэлийн семинарийн үед материаллаг бус зөрүүг нэгтгэлийн явцад шалгахгүй байх талаар тохиролцсон. Засгийн газар болон компаниудын тайлагнасан дүнгийн хоорондын зөрүү нь доорх дүнгээс илүү (дээш, доош) зөрж байвал, тухайн зөрүүг уг түвшнээс доош түвшинд хүртэл зөвшөөрөгдсөн цаг хугацаанд судалж, шалгана.

Заавал шалгах шаардлагатай зөрүүний талаар доор харуулав.

Хүснэгт 3.2

| Шалгах босго | Аливаа дан санхүүгийн урсгалын хувьд | Компанийн хувьд |
|--|--------------------------------------|--|
| Улсын түвшний санхүүгийн урсгал | 500.0 сая төгрөгөөс дээш зөрүү | 1,000.0 сая төгрөгөөс дээш зөрүү (цэвэр) |
| Орон нутгийн түвшний санхүүгийн урсгал | 25.0 сая төгрөгөөс дээш зөрүү | 50.0 сая төгрөгөөс дээш зөрүү (цэвэр) |

3.2.4 Тайланд хамруулах санхүүгийн урсгалуудыг сонгох

МОУИТБС-ын цахим тайлагналын системд оруулсан санхүүгийн урсгал нь өмнөх жилүүдийн туршлагад үндэслэсэн. Биднийг хараат бус нэгтгэгчээр томилох үед гэрээт ажил эхлэхээс өмнө бараг бүх төрийн байгууллагууд болон олон компани цахим тайлагналын системд тайлангаа ирүүлсэн байсан учир тайлангийн маягтыг шалгах нөхцөл бүрдээгүй.

ОТАХ нь МОУИТБС-ын цахим тайлагналын системд бүх компаниуд шаардлагатай мэдээллээ оруулаагүй учир зөрүүгийн материаллагийн түвшинтэй харгалзуулан, бүх материаллаг урсгалыг хамруулан системийн бүх урсгалыг оруулахаар шийдвэрлэсэн. Нийт улсын түвшний 32 орлогын урсгалаас хамгийн материаллаг гэж үзэж буй 20 орлогын урсгалыг сонгоход нийт урсгалын 99.96 хувийг эзэлж байна.

ОТАХ нь улсын төсөвт төлсөн дараах санхүүгийн урсгалуудыг хамруулахаар шийдвэрлэсэн. Үүнд:-

Хүснэгт 3.3

| № | Сонгож авсан улсын түвшний орлогын урсгалууд | Дүн | Эзлэх хувь | Эзлэх хувь |
|------------|--|------------------|---------------|-----------------|
| | | Сая.төг | | /өссөн дүнгээр/ |
| 1 | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр | 816,037.09 | 37.95% | 37.95% |
| 2 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 445,215.58 | 20.71% | 58.66% |
| 3 | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого | 198,039.70 | 9.21% | 67.87% |
| 4 | Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл | 177,622.28 | 8.26% | 76.13% |
| 5 | Нэмэгдсэн өртгийн албан татвар (Гааль) | 121,018.73 | 5.63% | 81.76% |
| 6 | Нэмэгдсэн өртгийн албан татвар (ТЕГ-т төлсөн) | 106,158.96 | 4.94% | 86.69% |
| 7 | Гаалийн үйлчилгээний хураамж | 61,213.52 | 2.85% | 89.54% |
| 8 | Гаалийн албан татвар | 56,535.98 | 2.63% | 92.17% |
| 9 | Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр | 38,921.35 | 1.81% | 93.98% |
| 10 | Агаарын бохирдлын төлбөр | 34,785.82 | 1.62% | 95.60% |
| 11 | Рояльти | 31,665.42 | 1.47% | 97.07% |
| 12 | Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар | 18,809.06 | 0.87% | 97.94% |
| 13 | Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | 11,165.55 | 0.52% | 98.46% |
| 14 | БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ | 9,130.08 | 0.42% | 98.89% |
| 15 | Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | 7,868.89 | 0.37% | 99.25% |
| 16 | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр | 4,436.62 | 0.21% | 99.46% |
| 17 | Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал | 3,549.76 | 0.17% | 99.63% |
| 18 | Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | 3,218.83 | 0.15% | 99.78% |
| 19 | Автобензин, дизелийн түлшний албан татвар | 2,639.14 | 0.12% | 99.90% |
| 20 | Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр | 1,433.69 | 0.07% | 99.96% |
| Дүн | | 2,149,466 | 99.96% | |

3.2.5 Орон нутгийн түвшний урсгал (шаардлага 4.1.6)

Нийт орон нутгийн түвшний 13 урсгалаас бусад гэж тайлагнасан урсгалыг хасаж, 12 орлогын урсгалыг сонгоход, нийт урсгалын 93.57 хувийг эзэлж байна.

Нэгтгэлийн тайланд доорх хүснэгтэд дурдсан 12 орлогын урсгалыг хамруулахаар болсон.

Хүснэгт 3.4

| № | Сонгож авсан орон нутгийн түвшний орлогын урсгалууд | Дүн | Эзлэх хувь | Эзлэх хувь |
|---|---|-----------|------------|-----------------|
| | | Сая.төг | | /өссөн дүнгээр/ |
| 1 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 42,424.80 | 39.96% | 39.96% |
| 2 | Ус ашигласны төлбөр | 38,830.67 | 36.57% | 76.53% |
| 3 | Газрын төлбөр | 12,148.98 | 11.44% | 87.98% |

| № | Сонгож авсан орон нутгийн түвшний орлогын урсгалууд | Дүн | Эзлэх хувь | Эзлэх хувь |
|------------|---|---------------|---------------|-----------------|
| | | Сая.төг | | /өссөн дүнгээр/ |
| 4 | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал | 1,613.26 | 1.52% | 89.50% |
| 5 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | 1,378.67 | 1.30% | 90.79% |
| 6 | Торгууль | 1,069.24 | 1.01% | 91.80% |
| 7 | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 890.02 | 0.84% | 92.64% |
| 8 | Ус бохирдуулсны төлбөр | 773.01 | 0.73% | 93.37% |
| 9 | Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн | 131.17 | 0.12% | 93.49% |
| 10 | Нөхөн төлбөр | 59.7 | 0.06% | 93.55% |
| 11 | Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг | 21.16 | 0.02% | 93.57% |
| 12 | Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | 0.52 | 0.00% | 93.57% |
| Дүн | | 99,341 | 93.57% | |

3.2.6 Төрийн байгууллагуудын сонголт

Сонгогдсон санхүүгийн урсгалуудыг хүлээж авсан төрийн байгууллагуудыг 2017 оны нэгтгэл тайланд хамруулахаар болсон. ОТАХ-ийн гишүүдээс дараах улсын түвшний төрийн байгууллагуудыг нэгтгэлд хамруулахаар шийдвэрлэсэн:-

- Татварын Ерөнхий Газар
- Гаалийн ерөнхий газар
- Ашигт малтмал, газрын тосны газар
- Сангийн яам
- Хөдөлмөрийн яам
- Нийгмийн даатгалын ерөнхий газар
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
- Уул уурхайн яам
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
- Стандарт хэмжил зүйн газар

ОТАХ-ээс нэгтгэлд хамруулахаар зөвшөөрсөн орон нутгийн байгууллагууд нь дараах байдалтай байна. Үүнд:

- Улаанбаатар хотын ЗДТГ
- Дүүргүүдийн ЗДТГ
- Аймгуудыг ЗДТГ
- Сумдын ЗДТГ

3.2.7 Компаниудын сонголт

Эхлэлийн семинар дээр ЗГ-т төлсөн төлбөр нь 300 сая төгрөгөөс дээш дүнтэй бол материаллаг гэж үзэн, энэ нөхцлийг хангасан 148 компанийг хамруулах саналыг Хараат бус хянагч-нэгтгэгчээс тавьсан байдаг. Гэвч ОТАХ өмнөх жилүүдийн адил 200-аас дээш компани нэгтгэлд хамруулаж гэсэн санал тавьсан.

Иймээс, нэгтгэлд хамрагдах компаниудыг сонгохдоо өмнөх жилүүдийн нэгтгэлд ашиглаж байсан аргын адил тохиролцсон материаллагийн босгоос дээш дүнтэй төлбөр хийсэн бүх компаниудыг шууд хамруулах, уг босгоос доош дүнтэй төлбөр бүхий компаниудаас түүвэрлэн хамруулах замаар сонголтыг хийхийг ОТАХ-т санал болгосон.

МОУИТБС-н цахим тайлагналын систем ашиглан 2018 оны 8 сарын 4-ны өдрийг хүртэл тайлагнасан ЗГ-ын орлогод дүн шинжилгээ хийж, материаллаг төлбөр төлсөн байдлаар ангилал хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3.5

| Хамрах төрөл | Компанийн тоо | | Төлбөр, орлого (сая төгрөгөөр) | | | Хамрах хувь % |
|----------------------|---------------|--------------|--------------------------------|----------------|------------------|---------------|
| | Улсын | Орон нутгийн | Улсын | Орон нутгийн | Нийт | |
| Шууд хамруулах | 222 | 56 | 2,039,380 | 104,053 | 2,143,434 | 95.0 |
| Түүвэрлэн хамруулах | 59 | 9 | 8,833 | 426 | 9,258 | 0.4 |
| Хамрагдаагүй компани | 1,787 | 681 | 25,029 | 1,066 | 26,095 | 1.2 |
| Уул уурхайн бус | 23 | 7 | 76,981 | 625 | 77,606 | 3.4 |
| Нийт | 2,091 | 753 | 2,150,223 | 106,169 | 2,256,392 | 100.0 |

Хүснэгтээс харахад ОТАХ-ээс тогтоосон материаллагийн босго дүн (300 сая төгрөг)-гээр шууд хамруулах компаниудын нь салбарын нийт орлогын 95%-ийг, түүвэрлэн хамруулах компаниудын тоог хамтад нь авч үзвэл нэгтгэлд сонгогдсон бүх компани нийт орлогын 95.4%-ийг эзэлж байна.

Нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын сонгох суурь нь Засгийн газарт материаллаг төлбөр төлсөн бүх компаниудыг хамруулах байсан. Уг суурь зарчмын дагуу ОТАХ нь улсын болон орон нутгийн түвшинд хийгдсэн төлбөрүүдэд анхаарлаа хандуулж, улсын болон орон нутгийн төсөвт материаллаг хэмжээний төлбөр төлсөн компаниудыг хамруулсан.

Бид МОУИТБС-ын цахим тайлагналын систем дээрх 2018 оны 8 дугаар сарын 14-ний байдлаарх мэдээллийг үндэслэл болгож, нийт 2091 компанийн мэдээллээс материаллаг төлбөр төлсөн компаниудыг сонгохдоо Засгийн газрын тайланд үндэслэсэн ба улсын болон орон нутгийн орлогын урсгалын материаллагийн босгыг тодорхойлохдоо тус тусад нь харгалзан үзсэн.

Засгийн газрын байгууллагуудын цахим тайлагналын системд оруулсан анхны ирүүлсэн мэдээллийг хураангуйлбал:

Хүснэгт 3.6

| Үзүүлэлт | Компаниудын тоо | сая төгрөг |
|--------------------------------------|-----------------|------------------|
| Улсын татвар, төлбөр, хураамж | 2091 | 2,142,354 |
| Орон нутгийн татвар, төлбөр, хураамж | | 114,038 |
| Нийт заавал тайлагнах урсгал | 2091 | 2,256,392 |
| Сайн дурын тайлагнал | | 101,320 |
| Нийт тайлагнасан урсгал | 2091 | 2,357,712 |

Заавал тайлагнах урсгал нь бүх байгууллагуудын тайлагнах ёстой урсгал бөгөөд компаниудаас хуулийн дагуу төлөхийг шаарддаг төлбөр, орлого байна. Сайн дурын урсгал нь ОТАХ-ээс тодорхойлсноор компаниудаас сайн дурын үндсэн дээр тайлагнахыг шаарддаг төлбөр, орлого юм.

Бид Засгийн газрын ирүүлсэн тайланд 100 сая төгрөгөөс дээш төлбөр, орлого бүхий компаниудыг хянаж үзээд улсад их хэмжээний татвар, төлбөр, хураамж төлсөн боловч үндсэн үйл ажиллагаа нь уул уурхайн бус 23 компанийг тодорхойлсон. Гэвч үйл ажиллагаа нь олборлох үйлдвэрлэлд хамаарахгүй тул эдгээр компанийг нэгтгэлд оруулаагүй, ингээд үлдсэн 2,068 компаниас сонголтоо хийсэн.

Эдгээр компаниудын төлбөр, орлогын дүнг Засгийн газрын байгууллагуудын тайлагнасан байдлаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3.7

| № | Компанийн регистр | Компанийн нэр | Дүн | № | Компанийн регистр | Компанийн нэр | Дүн |
|----|-------------------|-------------------------|---------|------------|-------------------|--------------------|---------------|
| | | | Сая.төг | | | | Сая.төг |
| 1 | 2082489 | Магнай трейд | 60,687 | 13 | 2027194 | Эрэл | 519 |
| 2 | 2659603 | ОЧИР УНДРАА | 2,902 | 14 | 5191823 | Ремикон | 478 |
| 3 | 2054701 | Гацуурт | 2,260 | 15 | 2061899 | Баярс констракшн | 408 |
| 4 | 2070022 | Нарантуул трейд | 1,513 | 16 | 2068508 | Реактив | 388 |
| 5 | 2577127 | ГБТ Трейдинг | 1,137 | 17 | 5000505 | Таван толгой транс | 378 |
| 6 | 5430682 | Терра Энержи | 1,092 | 18 | 2057573 | Макс Импэкс | 377 |
| 7 | 2580462 | Касстаун | 846 | 19 | 2579634 | МЕС | 335 |
| 8 | 2034719 | Хөвсгөл зам | 761 | 20 | 2031256 | Очир төв | 273 |
| 9 | 5476992 | Нэйшнл инженеринг групп | 712 | 21 | 2630478 | Геомастер | 243 |
| 10 | 2861224 | Эсто | 671 | 22 | 2660954 | Агайын | 240 |
| 11 | 5385075 | Дарданговь | 594 | 23 | 2096102 | Ди Эйч Эл | 221 |
| 12 | 2593009 | Бридж Констракшн | 570 | Дүн | | | 77,606 |

Материаллаг хэмжээний төлбөр төлсөн компаниудыг сонгохдоо дээр дурдсан залруулагдсан орлогын багцад шинжилгээ хийсэн. Үүнд:

Хүснэгт 3.8

| Төлбөр орлогын ангилал | Компанийн тоо | | | | Тайлагнасан төлбөр, орлого | | | |
|------------------------|---------------|-------------|---------------|-------------|----------------------------|-------------|---------------|-------------|
| | Дангаар | | Өссөн дүнгээр | | Дангаар | | Өссөн дүнгээр | |
| | Тоо | Хувь хэмжээ | Тоо | Хувь хэмжээ | Дүн | Хувь | Дүн | Хувь хэмжээ |
| 300 тэрбумаас дээш | 2 | 0.1% | 2 | 0.1% | 926,702 | 42.5% | 926,702 | 42.5% |
| 100-300 тэрбум | 4 | 0.2% | 6 | 0.3% | 695,583 | 31.9% | 1,622,285 | 74.5% |
| 10-100 тэрбум | 14 | 0.7% | 20 | 1.0% | 361,048 | 16.6% | 1,983,333 | 91.0% |
| 1-10 тэрбум | 31 | 1.5% | 51 | 2.5% | 105,309 | 4.8% | 2,088,642 | 95.9% |
| 300 саяас 1 тэрбум | 78 | 3.8% | 129 | 6.2% | 39,411 | 1.8% | 2,128,053 | 97.7% |
| 100 саяас 300 сая | 148 | 7.2% | 277 | 13.4% | 24,368 | 1.1% | 2,152,420 | 98.8% |
| 100 сая хүртэл | 1791 | 86.6% | 2068 | 100.0% | 26,366 | 1.2% | 2,178,787 | 100.0% |
| Нийт | 2068 | 100% | | | 2,178,787 | 100% | | |

Тайлагнасан төлбөр, орлогыг улсын болон орон нутгаар нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3.9

| Төлбөр орлогын ангилал | Үүнээс | | | |
|------------------------|----------------|---------|----------------|---------|
| | Улсын | | Орон нутгийн | |
| | Төлбөр, орлого | Эзлэх % | Төлбөр, орлого | Эзлэх % |
| 300 тэрбумаас дээш | 859,868 | 41.5% | - | 0.0% |
| 100-300 тэрбум | 691,208 | 33.3% | - | 0.0% |
| 10-100 тэрбум | 338,061 | 16.3% | 83,093 | 78.7% |
| 1-10 тэрбум | 98,103 | 4.7% | 11,374 | 10.8% |

| Төлбөр орлогын ангилал | Үүнээс | | | |
|------------------------|------------------|---------------|----------------|---------------|
| | Улсын | | Орон нутгийн | |
| | Төлбөр, орлого | Эзлэх % | Төлбөр, орлого | Эзлэх % |
| 300 саяас 1 тэрбум | 36,016 | 1.7% | 5,586 | 5.3% |
| 100 саяас 300 сая | 24,025 | 1.2% | 2,016 | 1.9% |
| 100 сая хүртэл | 25,962 | 1.3% | 3,477 | 3.3% |
| Нийт | 2,073,242 | 100.0% | 105,545 | 100.0% |

Эхлэлийн семинарын үед ОУИТБС-ын ОТАХ-ийн санал болгосноор 200-аас дээш компани сонгох тухай саналыг хүлээн авч, нэгтгэлд хамрагдах 230 компанийг (11 ТӨААН-ийг оруулаад) сонгосон ба орон нутгийн түвшний төлбөр, орлогын нэгтгэлд сонгогдсон 65 компани нь бүгд улсын түвшинд сонгогдсон компаниудтай давхцсан тул давхцлыг арилгасан. Нийт төлбөр, орлогыг улсын болон орон нутгийн түвшнээр ангилан, ангилал тус бүрдээ материаллагийн түвшинг тогтоосон.

2017 онд улсын төсөвт төлсөн нийт төлбөр, орлогын 98.8%, орон нутгийн төсөвт шилжүүлсэн төлбөр орлогын 96.4%-ийг 100 сая төгрөгөөс дээш татвар, төлбөр, хураамж төлсөн 277 компани эзэлж байна. Эдгээр 277 компанийн Засгийн газарт (улсын болон орон нутгийн) төлсөн төлбөр нь нийт дүнгээрээ 2.15 их наяд төгрөг буюу Засгийн газрын хүлээн авсан нийт орлогын 98.8%-ийг эзэлж байна.

Эдгээр 277 компаниас 230 компанийг сонгохдоо дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэж сонголтыг хийсэн. Үүнд:

1. ОУИТБС Стандартын төлбөр, орлогыг бүрэн тайлагнах гэсэн шаардлагыг хангаж бүх томоохон компаниудыг хамруулахын үүднээс нийт 300 сая төгрөгөөс дээш Засгийн газрын тайлагнасан орлого (улсын болон орон нутгийн)-ыг төвлөрүүлсэн компанийг нэг бүрчлэн хамруулах - 129 компани;
2. Орон нутагт 100 сая төгрөгөөс дээш татвар, төлбөр, хураамж төлсөн компанийг нэг бүрчлэн хамруулах – 16 компани;
3. Түүнчлэн, ЗГ-ын тайлагналаар 100-300 сая төгрөг төлсөн гэх 148 компаниас түүврийн аргаар сонгож хамруулах - 85 компани

Доор дурдсан хүчин зүйлсийг харгалзан сонголт хийсэн:

- 1) Улсын болон орон нутгийн төвлөрсөн төлбөрүүдийн цар хүрээг нэмэгдүүлж буй эсэх
- 2) Засгийн газар болон компаниудын тайлагнасан дүнгүүдийн хооронд материаллаг зөрүү үүсч байвал (жишээ нь: Засгийн газар нийт 100 сая төгрөг хүлээж авсан гэж тайлагнасан боловч, компани 1.0 тэрбум төгрөг төлсөн гэж тайлагнасан, эсвэл эсрэгээрээ байх тохиолдол)
- 3) Засгийн газрын болон компаниудын тайлагнасан дүнгүүдийн харьцуулалт, өнгөрсөн хугацааны төлбөрийн мэдээлэл гэх мэт бусад хүчин зүйлс
- 4) 2017 онд олборлолт явуулж, уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан байх

Улсын түвшний төлбөр, орлогын нэгтгэлд сонгогдсон компаниудыг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3.10

| Сонголт хийсэн аргачлал | Тоо | Дүн /сая.төг/ | % |
|---|-----|---------------|-------|
| Заавал хамруулах | | | |
| 300.0 сая болон түүнээс дээш улсын татвар, төлбөр, хураамж төлсөн компаниуд | 129 | 2,128,053 | 97.7% |
| Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий уул уурхайн олборлолт явуулдаг компаниуд (100.0 саяас дээш, 300.0 саяас бага) | 85 | 14,472 | 0.7% |

| Сонголт хийсэн аргачлал | Тоо | Дүн /сая.төг/ | % |
|--|------------|------------------|--------------|
| Дэд дүн | 214 | 2,142,525 | 98.3% |
| Түүвэрлэн хамруулах (100.0 саяас дээш, 300.0 саяас бага) | 16 | 2,560 | 0.1% |
| Нийт хамруулах | 230 | 2,145,085 | 98.5% |

Орон нутгийн түвшний төлбөр, орлогын нэгтгэлд сонгогдсон компаниудыг харуулбал дараах байдалтай байна.Үүнд:

Хүснэгт 3.11

| Сонголт хийсэн аргачлал | Тоо | Дүн /сая.төг/ | % |
|--|-----------|----------------|--------------|
| Заавал хамруулах | | | |
| 100.0 сая болон түүнээс дээш улсын татвар, төлбөр, хураамж төлсөн компаниуд | 28 | 102,068 | 96.6% |
| Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий уул уурхайн олборлолт явуулдаг компаниуд (30.0 саяас дээш, 100.0 саяас бага) | 28 | 1,526 | 1.4% |
| Дэд дүн | 56 | 103,594 | 98.1% |
| Түүвэрлэн хамруулах (30.0 саяас дээш, 100.0 саяас бага) | 9 | 362 | 0.3% |
| Нийт хамруулах | 65 | 103,956 | 98.4% |

Дээр дурьдсан үндсэн үйл ажиллагаа нь уул уурхайн бус компаниудыг нийт Засгийн газрын тайлангаас хасаж, аргачлалын дагуу хамрагдах компаниудыг сонгосон. Үүнд:

Хүснэгт 3.12

| Үзүүлэлт | Компаниудын тоо | Төлбөр, орлогын дүн сая.төгрөгөөр |
|---|-----------------|-----------------------------------|
| Улсын түвшний төлбөр, орлого | 2,091 | 2,150,223 |
| Орон нутгийн түвшний төлбөр, орлого (Давхардсан тоогоор) | 924 | 106,169 |
| Нийт төлбөр, орлого | 2,091 | 2,256,392 |
| Үндсэн үйл ажиллагаа нь уул уурхайн бус компаниуд (100 саяас дээш татвар, төлбөр, хураамж төлсөн) | -23 | -77,606 |
| Цэвэр төлбөр, орлогын дүн | 2,068 | 2,178,787 |
| Нэгтгэлд хамрагдахаар сонгогдсон компаниуд | 230 | 2,145,085 |
| Хамрагдсан хувь хэмжээ | 11.1% | 98.5% |
| Хамрагдаагүй компаниуд | 1,838 | 33,701 |
| Хамрагдаагүй компанийн хувь хэмжээ | 88.9% | 1.5% |

Компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

3.3 АРГА АРГАЧЛАЛ


3.3.1 Мэдээллийн цуглуулалт

Хараат бус хянагч-нэгтгэгч нь МОУИТБС-ын цахим тайлагналын системийг ашиглан төлбөр орлогын мэдээлэл болон орлогын бус мэдээллийг цуглуулсан ба анхны зөрүүг тодруулсан.

Сонгогдсон компаниудаас анхны зөрүүгийн шалтгааныг тодруулсан нэмэлт мэдээллийг цаасан баримтаар, эдгээр мэдээлэл нь үнэн зөв гэсэн баталгааг Удирдлагын хариуцлагын захидлаар гаргуулан авсан. Төрийн байгууллагуудаас тайланд орох уул уурхайн салбарын талаарх үндсэн

мэдээлэл, статистик тоон мэдээллүүд болон эдгээрийн үнэн зөвийг баталсан Удирдлагын хариуцлагын захидлыг цаасан баримтаар авсан.

Цахим тайлангийн систем дэх талуудын оролцооны байдлыг харуулбал дараах байдалтай байна.



3.3.2 2017 оны нэгтгэлд ашигласан маягтууд

Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.10, Газрын тосны тухай хуулийн 36.1, Цөмийн энергийн тухай хуулийн 28.6.4, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 34.10 заалтуудын дагуу “тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд тухайн жилд улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, олборлосон, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээг маягтын дагуу тайлагнаж, олон нийтэд мэдээлдэг” билээ.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд болон төрийн байгууллагуудын ОУИТБС-ын тайланг тайлагнах маягыг ҮСХ-ны даргын зөвшөөрснөөр Сангийн сайдын 2016 оны 2-р сарын 5-ны өдрийн 43 тоот тушаалаар шинэчлэн баталсан.

2018 оны 7 сарын 6-нд Хараат бус хянагч-нэгтгэгчийг томилсон, энэ үед ОУИТБС-ын 2017 оны тайланг “МОУИТБС цахим тайлагнал”-ын системээр 2018 оны 4 сарын 15-ныг хүртэл хүлээн

авсан байсан тул Хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс 2017 оны нэгтгэлд ашиглах тайлангийн маягтад саналаа өгч, боловсруулах боломжгүй болсон.

МОУИТБС-ын Ажлын алба нь МОУИТБС цахим тайлагналын систем дэх батлагдсан маягтын дагуу төлбөр, орлогын мэдээллийг хүлээж авсан. Бид цахим тайлангийн маягтуудыг 43-р тогтоолоор батлагдсан 6 маягттай харьцуулан үзэхэд хэлбэрийн хувьд яг адилхан биш боловч батлагдсан маягтын мэдээллүүдийг цахим тайлагналын маягтууд ерөнхийд нь багтаасан, санхүүгийн бүх урсгалуудыг хамруулсан байна.

3.3.3 Задаргааны түвшин

ОУИТБС-ын стандарт 4.7-д “Олон талт оролцогчдын бүлэг нь мэдээллийг олон нийтэд зориулан хэвлэн нийтлэхэд ямар түвшинд хүртэл задлах боломжтой байх асуудлыг зөвшилцөх шаардлагатай. ОУИТБС-ын тайлангийн мэдээлэл нь компаниуд, төрийн байгууллагууд болон орлогын урсгал нэг бүрээр нь дэлгэн харуулах боломжтой байх ёстой” гэж заасан байдаг.

ОУИТБС Ажлын хэсэгтэй хийсэн эхлэлийн семинар дээр МУ-ын 2017 оны тайлангийн хувьд нэгтгэлийн үр дүнг компаниуд, төрийн байгууллагууд болон орлогын урсгал нэг бүрээр нь тайлагнахаар гэж тохиролцсон.

6.12-р бүлэгт дурьдсаны дагуу, төслийн түвшинд тайлагнах асуудлыг 2018 оны МОУИТБС тайлангаас хэрэгжүүлж эхэлнэ.

3.4 БАТАЛГААЖУУЛАЛТ

3.4.1 Монгол улсын аудит, баталгаажуулалтын орчин нөхцөл

Монгол улсын аудитын ажиллагааг хэрэгжүүлэх дээд байгууллага нь Монголын Үндэсний Аудитын Газрын (“МҮАГ”) юм. МҮАГ нь олон улсын аудитын INTOSAI байгууллагын гишүүн бөгөөд тус байгууллагын стандартуудын дагуу үйл ажлаа явуулж байна.

МҮАГ нь Засгийн Газрын яам, агентлагууд болон төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайлан болон ЗГ-ын нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж, УИХ-аар батлуулдаг. Орон нутгийн төрийн байгууллагууд (аймаг, сумд) санхүүгийн тайлангаа жил тутам гаргаж, МҮАГ-н харьяа орон нутгийн аудитын байгууллагаар хянуулж байх ёстой.

Мөн төрийн өмчит компаниудын жил тутмын санхүүгийн тайланд аудит хийх ажиллагааг МҮАГ хариуцдаг боловч тэдгээр аудитыг гүйцэтгүүлэхийн тулд зохих хэмжээний чадварлаг хувийн аудитын байгууллагуудыг сонгон шалгаруулах журмаар томилж ажиллуулахыг зөвшөөрдөг бөгөөд бодит практикт голдуу ингэж ажиллаж байна. Тэдгээр аудитын байгууллагууд Аудитын Олон Улсын Стандартын дагуу аудитын ажлыг гүйцэтгэж байна.

Хөндлөнгийн аудит хийлгэж байх шаардлагатай компаниуд нь өөрийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газарт жил тутам 6 дугаар сард багтаан хүргүүлэх үүргийг хүлээнэ. Гэхдээ Татварын ерөнхий хуульд заасан нууцлалтай холбоотой заалтаас хамаараад Сангийн яамны зүгээс тухайн компанийн шууд өгсөн зөвшөөрөлгүйгээр санхүүгийн тайланг шууд ил тод болгох боломжгүй юм.

Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газар нь уул уурхайн компаниудын зүгээс аудитын хамааралтай шаардлагуудыг даган мөрдүүлэх чиглэлд тодорхой үүрэг ролийг гүйцэтгэж болно.

Хувийн өмчит компаниуд НББ-ийн тухай хуулийн 4.1-д заасны дагуу СТОУС-ын дагуу санхүүгийн тайлангаа гаргах ёстой бөгөөд нийт борлуулалтын орлогын хэмжээ, эсвэл цэвэр хөрөнгө нь тодорхой түвшнээс давсан бол бүх компаниуд санхүүгийн тайландаа хөндлөнгийн аудит хийлгэж байхыг хуулиар шаарддаг.

3.4.2 ОУИТБС-ын тайлангийн баталгаажуулах явц

Засгийн Газрын байгууллагууд, ТӨААН-үүд болон олборлох компаниуд өөрсдийн мэдээллийг Цахим тайлангийн системд оруулах шаардлагатай бөгөөд шаардлага гарах бүрт нэмэлт мэдээллийг Хараат бус хянагч-нэгтгэгчид өгч байх ёстой байдаг.

Тайлагнаж буй тоо мэдээний бүрэн гүйцэд, найдвартай байдлыг тайлагнагч байгууллага хариуцна.

Тайлан гаргаж байгаа байгууллагууд өөрсдийн өгсөн мэдээллийг найдвартай гэдгийг Хараат бус хянагч-нэгтгэгчид батлах үүрэгтэй.

3.4.2.1 Засгийн газрын яам, агентлагууд

2017 оны тайлангийн хамрах хүрээг хэлэлцэх хурлын үеэр “тайлан гаргаж байгаа төрийн байгууллага/агентлаг бүрийн ахлах удирдлагын төлөөлөл нь тухайн тайлан, мэдээлэлд бичгээр баталгаа гаргаж байх”-аар ОТАХ тохиролцсон юм.

ҮАГ-тай уулзалт хийж, ҮАГ-аас баталсан Санхүүгийн тайланд аудит хийх журамд “Олборлох үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн төсөвт төвлөрүүлсэн төлбөрийг ОУИТБС-ын Ажлын алба болон орлого хүлээн авсан Засгийн газрын байгууллагуудтай тулган баталгаажуулж, дүгнэлт гаргах” гэж орсон байдаг тэгэхээр төрийн байгууллагуудаас ирүүлэх ОУИТБС-ын тайланг нь баталгаажуулах боломжтой юу гэдэг асуудлаар ярилцсан. ҮАГ-ын хувьд төсвийн шууд захирагчид, ба төрийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитыг хийж байх явцдаа ОУИТБС-ын тайланг нь давхар баталгаажуулах боломжтой гэж үзэж байна.

2017 онд ийм ажил хийгдээгүй тул энэ байдал давтагдахаас зайлсхийж, МҮАГ өөрийн 2018 оны ажлын тайландаа тусгаж ажиллахыг зөвлөж байна.

3.4.2.2 Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд

Тайлан гаргаж байгаа ТӨААН бүрийн Гүйцэтгэх удирдлага нь өөрсдийн тайлан, мэдээлэлд ТУЗ-ийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий баталгааг бичгээр гаргаж өгөхийг, мөн ТӨААН бүр аудит хийлгэсэн санхүүгийн тайлангаа өгч байхаар Ажлын хэсэг шийдвэрлэсэн юм.

ТӨААН-иудаас ирүүлсэн хариултын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 7-д, ТӨААН-иудын аудит хийлгэсэн санхүүгийн тайлангуудын мэдээг нэгтгэн Хавсралт 19-д үзүүлэв.

Түүнчлэн ОТАХ-аас Төрийн өмчит бүх компаниуд “ОУИТБС-ын тайланд өгсөн мэдээлэл нь АОУС-ын дагуу аудит хийлгэсэн санхүүгийн тайлангуудтай тохирч байгаа бөгөөд үнэн, зөв” гэдгийг тэдгээрийн аудиторроор батлуулан ирүүлэх ёстой гэж шийдвэрлэсэн.

ТӨААН-иудын аудиторруудын ирүүлсэн хариултын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 7-д оруулав.

3.4.2.3 Хувийн компаниуд

Тайлан гаргаж байгаа компаниудын Гүйцэтгэх удирдлага нь өөрсдийн тайлан, мэдээлэлд ТУЗ-ийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий баталгааг бичгээр гаргаж өгөхийг, мөн компани бүр аудит хийлгэсэн санхүүгийн тайлангаа өгч байхаар ОТАХ-тэй тохиролцсон юм.

Баталгаажуулалтыг илүү сайжруулах үүднээс бид зөвхөн аудитын дүгнэлт бус аудитлагдсан иж бүрэн санхүүгийн тайланг ирүүлдэг байхыг зөвлөж байгаа. Жишээ дурьдахад Петрочайна дачин тамсаг ХХК-ийн санхүүгийн тайлангаас бид компанийн санхүүгийн тайлан дээрх дүн мэдээ, ОУИТБС-д тайлагнасан дүн мэдээ хоёр материаллаг зөрүүтэй байгааг олж мэдсэн, харин аудитын дүгнэлтийн хуудас дангаараа бидэнд ийм мэдээлэл өгч чадахгүй.

Компаниудын аудитлагдсан тайлангаа ирүүлсэн эсэх статистикийг, компаниудаас ирүүлсэн хариугийн хамт Хавсралт 19-аар оруулав.

Түүнчлэн компаниуд “ОУИТБС-ын тайланд өгсөн мэдээлэл нь АОУС-ын дагуу аудит хийлгэсэн санхүүгийн тайлануудтай тохирч байгаа бөгөөд үнэн, зөв” гэсэн баталгааг өөрсдийн хөндлөнгийн аудиторроос мэдэгдэл байдлаар гаргуулж ирүүлэх ёстой гэж ОТАХ-аас шийдвэрлэсэн.

Хувийн компаниудын аудиторуудын мэдэгдэлийг Хавсралт 7-д оруулсан байгаа.

4 ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

Төлбөр, орлогын анхны нэгтгэлээр нийт 122.5 тэрбум төгрөгийн цэвэр зөрүү үүссэн ба Хараат бус хянагч-нэгтгэгч ЗГ-ын тайланд 61.8 тэрбумын нэмэгдэх тохируулга, компанийн дүнд 184.5 тэрбум төгрөгийн нэмэгдэх тохируулгыг цэвэр дүнгээр тус тус хийсэн.

Нэгтгэлийн явцад 2 компани мэдээллээ ирүүлээгүйгээс 188 сая төгрөгийн (дэлгэрэнгүйг 4.3 бүлгээс харна уу) зөрүүг шийдэж чадаагүй.

Энэ зөрүүг нэгтгэлээс хассанаар нийт 48 сая төгрөг буюу ЗГ-ын тайлагнасан нийт орлогын 0.002 хувьтай тэнцэх зөрүү тайлбарлагдаагүй үлдэж байна.

4.1 АНХЛАН ТАЙЛАГНАСАН УРСГАЛУУДЫН ХУРААНГУЙ

Анхлан тайлагнасан төлбөр, орлого болон нэгтгэлийн тохируулгыг нэгтгэн харуулбал дараах байдалтай байна. Үүнд:-

Хүснэгт 4.1

| Тайлан гаргагч: | Компанийн тоо | Сонгогдсон гол орлогын урсгалууд (сая төгрөгөөр) | | |
|--|---------------|--|-----------------------|----------------|
| | | Улсын хэмжээнд | Орон нутгийн хэмжээнд | Нийт |
| Анхны тайлан | | | | |
| ЗГ-ын байгууллага | 230 | 2,041,028 | 104,058 | 2,145,085 |
| Хувийн компаниуд | 177 | 877,758 | 95,716 | 973,474 |
| ТӨААН-үүд | 11 | 938,287 | 110,807 | 1,049,095 |
| Анхны нэгтгэлийн зөрүү | 42 | 224,982 | -102,466 | 122,516 |
| Нэгтгэл | | | | |
| ЗГ-ын тохируулга | | 45,513 | 16,281 | 61,794 |
| Компанийн тохируулга | | 270,687 | -86,141 | 184,547 |
| ЗГ-ын дүн тохируулгын дараа | | 2,086,541 | 120,339 | 2,206,879 |
| Компанийн дүн тохируулгын дараа | | 2,086,733 | 120,383 | 2,207,116 |
| Нэгтгэлийн зөрүү (нэгтгэлийн маягт ирүүлэхээс татгалзсан компаниудыг оруулаад) | | -192 | -44 | -236 |
| Хасах нь: нэгтгэлийн тохируулгын маягт ирүүлээгүй компанийн дүн | | -188 | - | -188 |
| Эцсийн тайлбарлагдаагүй цэвэр зөрүү | | -4 | -44 | -48 |

4.2 АНХНЫ ТОХИРУУЛААГҮЙ ЗӨРҮҮ БОЛОН ТАЙЛАГНААГҮЙ КОМПАНИУД

Анхны нэгтгэлийн зөрүү нь доорх үндсэн шалтгаануудаас үүдэж байна. Үүнд:

сая төгрөгөөр

Хүснэгт 4.2

| Орлогын урсгал (сая.төрөг) | Компанийн анхны тайланд хийсэн тохируулга | Засгийн газрын анхны тайланд хийсэн тохируулга | Нийт тохируулсан дүн |
|---|---|--|----------------------|
| Анхны тайлангаа бүхэлд нь болон зарим урсгалыг огт тайлагнаагүй | 252,336 | 50,376 | 302,712 |
| Анхны тайланд дутуу тайлагнасан | 55,520 | 41,589 | 97,109 |
| Давхардуулж тайлагнасан | (57,556) | (4,932) | (62,488) |
| Анхны тайланд илүү тайлагнасан | (27,454) | (15,205) | (42,660) |
| Аккруэл сууриар тайлагнасан | (34,982) | 212 | (34,770) |
| Өссөн дүнгээр тайлагнасан | (1,047) | (6,408) | (7,454) |
| Холбоотой талын хоорондын гүйлгээтэй холилдуулж тайлагнасан | 1,968 | (6,060) | (4,092) |
| Мөнгөн дүнг мянгачилж тайлагнасан | 189 | 3,414 | 3,603 |
| Засгийн газарт байршуулсан урьдчилгаа төлбөрийг тайлагнасан | (2,357) | - | (2,357) |
| Орлогын урсгалын ангилал андуурч тайлагнасан | (1,064) | (295) | (1,359) |
| Сайн дурын мэдээллийг тайлагнасан | (1,006) | - | (1,006) |
| Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй, бусад үйл ажиллагаанаас төлсөн төлбөр | - | (798) | (798) |
| Ханшийн зөрүүнээс үүдсэн | - | (98) | (98) |
| Бусад | (0) | - | (0) |
| Нийт | 184,547 | 61,794 | 246,341 |

Нийт хийгдсэн тохируулгын байдлаас харахад

- а) анхны тайлангаа огт тайлагнаагүй, тайлагнасан боловч зарим орлогын урсгалыг тайлагнаагүй,
- б) дутуу тайлагнасан зөрчлөөс шалтгаалан

анхны зөрүү үүссэн байна.

Иймд 399,850 сая төгрөгийн нэмсэн тохируулга хийсэн бөгөөд томоохон тохируулгуудыг тодруулбал дараах байдалтай байна.

Анхлан тайлагнаагүй томоохон төлбөр бүхий компаниудыг танилцуулбал:

- Петрочайна Дачин Тамсаг ХХК нь 235,879 сая төгрөг,
- Монцемент Билдинг Материалс ХХК нь 2,412 сая төгрөг,
- Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХК нь 2,406 сая төгрөгийн ГЕГ-т төлсөн НӨАТ болон гаалийн үйлчилгээний хураамж,

Засгийн газрын хүлээн авсан орлогыг огт тайлагнаагүй төрийн байгууллагуудыг танилцуулбал:

- Өмнөговь аймагт төлсөн Таван Толгой ХК-ийн Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг 23,421 сая төгрөг,
- Гаалийн ерөнхий газрын “Цахилгаан дамжуулах үндэсний төв” ТӨХК-иар дамжуулан төлсөн “Оюу Толгой” ХХК-д хамаарах импортын цахилгаан эрчим хүчний НӨАТ, гаалийн албан татвар болох 18,172 сая төгрөг,
- Нийгмийн даатгалын ерөнхий газарт төлсөн “Цемент Шохой” ХК-ийн Аж ахуйн нэгжээс

төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл 1,946 сая төгрөг,

Анхны тайланд Засгийн газрын дутуу тайлагнасан орлогыг танилцуулбал:

- Гаалийн ерөнхий газар нь “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-иар дамжуулан төлсөн “Оюу Толгой” ХХК-ийн НӨАТ, гаалийн албан татвар 24,348 сая төгрөгийг орхигдуулсан.
- Орхон аймгийн Засаг дарга болон “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирлын хооронд байгуулсан газрын төлбөр суутган төлөх гэрээний 1,371 сая төгрөгийн төлбөрийг орхигдуулсан.

Энэ нь Засгийн газрын зарим байгууллагууд болон зарим компаниуд нь цахим тайлагналын системд анх тайлагнахдаа хайхрамжгүй хандаж байгааг илтгэж байна. Иймээс Засгийн газар нь хүлээн авсан орлогоо, уул уурхайн компаниуд нь төлсөн төлбөрийн мэдээгээ МОУИТБС-ын цахим тайлагналын системд маш хариуцлагатай тайлагнаж байх шаардлагатайг харуулж байна.

2017 оны ОУИТБС-ын Нэгтгэл тайланд хамрагдсан 230 компаниас 3 компанийн анхны тайлан зөрүүгүй байсан ба эдгээр компаниудыг харуулбал:

Хүснэгт 4.3

сая төгрөгөөр

| # | Компанийн регистр | Компанийн нэр | Засгийн газар тайлагнасан | Компани тайлагнасан | Анхны зөрүү |
|-------------|-------------------|------------------|---------------------------|---------------------|-------------|
| 1 | 2705133 | Онтрэ | 2,312 | 2,312 | 0 |
| 2 | 5267552 | Налгар хөндий | 116 | 116 | - |
| 3 | 2730588 | Могол Интернэшнл | 115 | 115 | 0 |
| Нийт | | | 2,543 | 2,543 | 0 |

Цахим тайлагналын системд тайлагнаагүй 42 компани нь 248,122 сая төгрөгийн анхны зөрүү үүсгэж байна. Зөрүү үүсгэж байгаа компаниудыг харуулбал:

сая төгрөгөөр

Хүснэгт 4.4

| # | Компанийн нэр | Төлбөр | # | Компанийн нэр | Төлбөр |
|----|---------------------------|---------|----|--------------------------------|--------|
| 1 | ПетрочайнаДачинТамсаг | 235,628 | 22 | Сауд гоби коэл транс | 236 |
| 2 | Монцементбилдингматериалс | 1,971 | 23 | Грийн стэйшн | 234 |
| 3 | Сэнтуриямонгу | 708 | 24 | Эрдэнэдорно | 193 |
| 4 | Уулс-ноён | 569 | 25 | Шинэлонгда | 164 |
| 5 | ИмпайргазМонголиа | 547 | 26 | Сонор трейд | 154 |
| 6 | БУМАН-ОЛЗ | 499 | 27 | Бэрэнгрупп | 149 |
| 7 | Эрдэнийнолз | 495 | 28 | Таны Зам | 131 |
| 8 | Монголгазар | 437 | 29 | Мегатек манюфактуринг монголиа | 131 |
| 9 | Ганбаттулга | 423 | 30 | Нью Саймин Рисорсэс | 128 |
| 10 | Ган-Илч | 412 | 31 | Эм Кэй Эм Эн майнинг | 121 |
| 11 | Нутгийнбуянгрупп | 400 | 32 | Ариг гал | 121 |
| 12 | Зууннаймансуврага | 388 | 33 | Эм Ди Эф И | 119 |
| 13 | Талынхаргуй | 360 | 34 | Си Эф Си Групп | 114 |
| 14 | УГАНОГОЛД | 344 | 35 | Коулдголд монгол | 112 |
| 15 | Бэрхресорсиз | 341 | 36 | Баянтэгш импекс | 105 |
| 16 | Баянуул | 327 | 37 | Алтанбарга | 104 |
| 17 | ТЭГШТПЛАНТ | 298 | 38 | Би Вай Эйч | 104 |

| # | Компанийн нэр | Төлбөр | # | Компанийн нэр | Төлбөр |
|----|-----------------|--------|----|----------------------|----------------|
| 18 | Коммонмакс | 291 | 39 | Жаргалантрашаант | 102 |
| 19 | Эрчимбаянөлгий | 288 | 40 | Талын баялаг эрдэнэс | 101 |
| 20 | ГалаксиМайнинг | 247 | 41 | Оргилмоунт | 100 |
| 21 | ЮниверсалКоппер | 243 | 42 | Оуяашиёу | 184 |
| | | | | Нийт | 248,122 |

4.3 Тохируулаагүй үлдсэн зөрүү

Доорх хүснэгт нь тохируулгын дараах тайлбарлагдаагүй зөрүүгийн шинжилгээг харуулж байна, үүнд 2 дараах төрлийн зөрүүг тусдаа баганаар оруулсан:

- ЗГ-ын тайлагнасан дүн компаний тайлагнасан дүнгээс илүү (А багана), цэвэр дүнгээр болон
- ЗГ-ын тайлагнасан дүн компаний тайлагнасан дүнгээс дутуу тайлагнасан ЗГ-ын дүн (Б багана), цэвэр дүнгээр

Хүснэгт 4.5

Сая төгрөгөөр

| Төлбөр, орлого (санхүүгийн урсгалаар) | Засгийн газар илүү/(дутуу) тайлагнасан | |
|--|--|--------------|
| | А | Б |
| БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ | - | (138) |
| Гаалийн үйлчилгээний хураамж | - | (66) |
| Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | 42 | - |
| Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | - | (24) |
| Бусад | - | (18) |
| Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | - | (16) |
| Торгууль | - | (14) |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар (Гааль) | 14 | - |
| Газрын төлбөр | - | (8) |
| Торгууль | - | (6) |
| Гаалийн албан татвар | 5 | - |
| Бусад | - | (4) |
| Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн | - | (1) |
| Нөхөн төлбөр | - | (1) |
| Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр | - | (1) |
| Цэвэр тохируулаагүй зөрүү | 62 | (298) |

Тохируулагдаагүй үлдсэн томоохон зөрүүнүүдийг компани тус бүрээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 4.6

сая төгрөгөөр

| Компани | Урсгал | Компаниас Засгийн газар | | Тайлбар |
|----------------|---|-------------------------|-------------------|----------------------------|
| | | Илүү тайлагнасан | Дутуу тайлагнасан | |
| Баярсгоулд ХХК | Торгууль | - | (12) | Холбогдож чадаагүй компани |
| | Нөхөн төлбөр | - | (2) | |
| | БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль | - | (138) | |

сая төгрөгөөр

| Компани | Урсгал | Компаниас Засгийн газар | | Тайлбар |
|--------------------------------|---|-------------------------|-------------------|----------------------------|
| | | Илүү тайлагнасан | Дутуу тайлагнасан | |
| | хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ | | | |
| Жи Пи Эф ХХК | Улсын төсөвт төлсөн бусад албан татвар | - | (36) | Холбогдож чадаагүй компани |
| Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХХК | Гаалийн албан татвар | 3 | - | |
| | Нэмэгдсэн өртгийн албан татвар (ГЕГ-т төлсөн) | 7 | - | |
| | Гаалийн үйлчилгээний хураамж | - | (28) | |
| Эко алтан заамар ХХК | Гаалийн албан татвар | 0 | - | |
| | Нэмэгдсэн өртгийн албан татвар (ГЕГ-т төлсөн) | 1 | - | |
| | Гаалийн үйлчилгээний хураамж | - | (0) | |
| | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | - | (0) | |
| | Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн | - | (1) | |
| | Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | - | (11) | |
| Анд Сөүрвэй ХХК | Газрын төлбөр | - | (6) | |
| Петрочайна Дачин Тамсаг ХХК | Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | 44 | - | |
| | Гаалийн үйлчилгээний хураамж | - | (32) | |
| | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | - | (17) | |
| | Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | - | (10) | |
| Монголросцветмет ХХК | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | - | (3) | |
| | Орон нутгийн төсөвт төлсөн бусад албан татвар | - | (1) | |
| Эрдэнэт үйлдвэр ХХК | Нэмэгдсэн өртгийн албан татвар (ГЕГ-т төлсөн) | 4 | - | |
| Бусад зөрүү | | 4 | (3) | |
| Нийт | | 62 | (298) | |

4.4 Тайлагнаагүй компаниуд

Цахим тайлагналын системд тайлагнасан Засгийн газрын орлогын мэдээнээс нэгтгэлд хамрагдах 230 компанийг сонгосон бөгөөд үүнээс 2 компани нь цахим тайлагналын системд анхны тайлангаа тушаасан боловч тохируулгын явцад нэмэлт хүсэлтээр тайлангаа ирүүлээгүй компаниуд байна. Эдгээр 2 компаниас шалтгаалан үүсэж буй цэвэр зөрүү 188 сая төгрөг юм.

Компаниуд нь доорх шалтгааны улмаас тайлагнаагүй байна. Үүнд:

Хүснэгт 4.7

Сая төгрөгөөр

| # | Регистрийн № | Компанийн нэр | ЗГ-ын дутуу тайлагнасан орлого | Тайлбар |
|-------------|--------------|----------------|--------------------------------|--|
| 1 | 5099854 | Баярсгоулд ХХК | 152 | Огт холбогдож чадаагүй. Ажлын оффис дээр очиж үзэхэд буруу хаяг байсан. |
| 2 | 5421624 | Жи Пи Эф ХХК | 36 | Газрын лицензээ алдсан шүүхээр явж байгаа, мэдээлэл, судалгаа гаргаж өгөх боломжгүй гэсэн хариу өгсөн. |
| Нийт | | | 188 | |

Компаниудын үүсгэж буй зөрүү нь ОТАХ-тай тохиролцсон материаллагын босгоос доош буюу материаллаг бус дүнтэй байна.

4.5 НЭГТГЭЛИЙН ҮР ДҮН

4.5.1 Улсын хэмжээний нэгтгэлийн үр дүн (орлогын урсгалаар)

Хүснэгт 4.8

| Орлогын урсгал | Анхны тайлагнасан | | | Залруулга | | Тохируулгын дараа | | |
|--|-------------------|---------|----------|-----------|---------|-------------------|---------|-------|
| | ЗГ | Компани | Зөрүү | ЗГ | Компани | ЗГ | Компани | Зөрүү |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 442,114 | 417,902 | 24,212 | (24,120) | 92 | 417,994 | 417,994 | (0) |
| Гаалийн албан татвар | 41,959 | 57,630 | (15,671) | 8,650 | (7,026) | 50,609 | 50,604 | 5 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар (ТЕГ-т төлсөн) | 97,779 | 104,198 | (6,419) | (2,589) | (9,009) | 95,189 | 95,189 | 0 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар (Гааль) | 89,844 | 88,207 | 1,637 | 17,145 | 18,768 | 106,989 | 106,975 | 14 |
| Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар | 1,750 | 586 | 1,164 | (1,697) | (533) | 53 | 53 | - |
| Автобензин, дизелийн түлшний албан татвар | 200 | - | 200 | (197) | 3 | 3 | 3 | - |
| Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр | 815,035 | 818,736 | (3,702) | (11) | (3,713) | 815,024 | 815,024 | 0 |
| Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр | 23,441 | 19,115 | 4,327 | (77) | 4,250 | 23,364 | 23,365 | (1) |
| Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр | 4,125 | 1,953 | 2,172 | 2 | 2,175 | 4,127 | 4,127 | 0 |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээнд тухайн жилд гарын үсэг зурсны урамшуулал | 370 | 370 | - | - | - | 370 | 370 | - |
| Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | 3,052 | 2,582 | 470 | (98) | 372 | 2,954 | 2,954 | - |
| Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | 11,084 | 6,087 | 4,997 | 20 | 4,975 | 11,104 | 11,062 | 42 |
| Агаарын бохирдлын төлбөр | 34,753 | 34,126 | 627 | 10 | 637 | 34,763 | 34,763 | (0) |
| Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл | 165,049 | 156,096 | 8,953 | (2,106) | 6,846 | 162,942 | 162,942 | 0 |
| Гаалийн үйлчилгээний хураамж | 60,687 | 47,407 | 13,280 | (40) | 13,306 | 60,647 | 60,713 | (66) |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал | 3,501 | 3,039 | 462 | 184 | 646 | 3,685 | 3,685 | - |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр | 1,349 | 1,300 | 49 | 193 | 242 | 1,541 | 1,541 | - |
| Төрийн өмчийн ногдол ашиг | - | 1 | (1) | - | (1) | - | - | - |
| Засгийн газарт төлсөн урьдчилгаа төлбөр | - | 118 | (118) | - | (118) | - | - | - |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого | 198,040 | 7,991 | 190,048 | - | 190,048 | 198,040 | 198,040 | - |

| Орлогын урсгал | Анхны тайлагнасан | | | Залруулга | | Тохируулгын дараа | | |
|--|-------------------|------------------|----------------|---------------|----------------|-------------------|------------------|--------------|
| | ЗГ | Компани | Зөрүү | ЗГ | Компани | ЗГ | Компани | Зөрүү |
| Рояльти | 31,665 | 2,113 | 29,553 | - | 29,553 | 31,665 | 31,665 | - |
| Торгууль | 81 | 5,185 | (5,104) | 1,660 | (3,429) | 1,742 | 1,756 | (14) |
| Нөхөн төлбөр | - | 1,179 | (1,179) | - | (1,178) | - | 1 | (1) |
| БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ | 7,509 | 1,099 | 6,410 | (6,540) | 9 | 969 | 1,108 | (138) |
| Бусад | 161 | 18,844 | (18,683) | 44,171 | 25,505 | 44,331 | 44,349 | (18) |
| Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | 7,481 | 20,181 | (12,700) | 10,953 | (1,732) | 18,434 | 18,449 | (16) |
| Улсны хэмжээний нэгтгэлийн дүн | 2,041,028 | 1,816,046 | 224,982 | 45,513 | 270,687 | 2,086,541 | 2,086,733 | (192) |

4.5.2 Орон нутгийн хэмжээний урсгалын нэгтгэлийн үр дүн: орлогын урсгалаар

Хүснэгт 4.9

| Орлогын урсгал | Анхны тайлагнасан | | | Залруулга | | Тохируулгын дараа | | |
|---|-------------------|------------------|------------------|---------------|-----------------|-------------------|------------------|--------------|
| | ЗГ | Компани | Зөрүү | ЗГ | Компани | ЗГ | Компани | Зөрүү |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 41,959 | 29,472 | 12,487 | (12,360) | 128 | 29,600 | 29,600 | 0 |
| Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 811 | 1,050 | (238) | 408 | 194 | 1,219 | 1,243 | (24) |
| Газрын төлбөр | 11,865 | 14,423 | (2,559) | 2,636 | 85 | 14,500 | 14,509 | (8) |
| Ус ашигласны төлбөр | 38,446 | 38,422 | 24 | 3,898 | 3,923 | 42,344 | 42,344 | (0) |
| Ус бохирдуулсны төлбөр | 719 | 3 | 717 | (640) | 76 | 79 | 79 | - |
| Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | 1,294 | 31,141 | (29,846) | 302 | (29,545) | 1,596 | 1,596 | 0 |
| Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | 1 | 1,626 | (1,625) | 391 | (1,235) | 391 | 391 | - |
| Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал | 1,613 | 489 | 1,124 | 449 | 1,573 | 2,062 | 2,062 | - |
| Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг | 21 | 23,458 | (23,437) | 23,437 | (0) | 23,458 | 23,458 | - |
| Торгууль | 859 | 13,207 | (12,349) | 1,428 | (10,915) | 2,287 | 2,293 | (6) |
| Нөхөн төлбөр | 13 | 252 | (239) | (4) | (243) | 9 | 9 | 0 |
| Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн | 56 | 226 | (170) | 32 | (137) | 87 | 89 | (1) |
| Бусад | 6,401 | 52,755 | (46,354) | (3,694) | (50,043) | 2,707 | 2,711 | (4) |
| Орон нутгийн хэмжээний нэгтгэлийн дүн | 104,058 | 206,524 | (102,466) | 16,281 | (86,141) | 120,339 | 120,383 | (44) |
| Нийт | 2,145,085 | 2,022,569 | 122,516 | 61,794 | 184,547 | 2,206,879 | 2,207,116 | (236) |

5 МОНГОЛЫН ОЛБОРЛОХ САЛБАР



Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.11-д заасны дагуу Засгийн газрын холбогдох шийдвэрээр Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 69.58 хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдох боломжтой юм байна. 2018 оны эхний улирлын байдлаар энэ нь 8.0 хувьтай байгаа нь цаашид олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын тоо өссөөр байхыг харуулж байна.

Уул уурхайн салбар Монгол Улсын эдийн засагт 2017 оны байдлаар Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 23.4%, аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний 73%, нийт экспортын 79.6%, нийт гадаадын хөрөнгө оруулалтын 72%-ийг эзэлж байна.

5.1 ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ БОЛОН ТӨСВИЙН БОДЛОГО (ШААРДЛАГА 2.1)

5.1.1 Олборлох салбарын эрх зүйн зохицуулалт

Энэхүү хэсэгт Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарыг зохицуулж буй хууль, тогтоомжийн талаарх мэдээллийг оруулсан. МОҮИТБС-ын 2017 оны тайланд дараах хууль, тогтоомжийн талаар тайлбар тодорхойлолт орууллаа:

- 2017 оны эцэс хүртэл үйлчилж байсан хууль, тогтоомжууд,
- 2018 оны эхний хагас жилийн байдлаар шинээр гарсан болон өөрчлөлт орсон хууль, тогтоомжууд,
- ойрын хугацаанд батлагдах магадлалтай тухайн салбарт чухал ач холбогдолтой хууль, тогтоомжууд гэсэн байдлаар тодорхойлсон болно.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн олборлох салбарт хамааралтай зорилтын хэрэгжилтийн талаар мэдээлэл оруулсан.

5.1.1.1 Уул уурхай, газрын тос, цөмийн энергийн салбарын эрх зүйн тогтолцооны өнөөгийн байдал

Уул уурхай, газрын тос, цөмийн энергийн салбарын эрх зүйн тогтолцоо болон практикт үүсэж байгаа зөрүүтэй байдлын талаар энэ хэсэгт танилцуулав. Ашигт малтмалын тухай, Газрын хэвлийн тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Байгаль орчны багц хуулиуд зэрэг 30 гаруй хууль, 40 гаруй журмаар тус салбарын асуудлыг тодорхой хүрээнд зохицуулж байгаа боловч тэдгээрийн өөр хоорондын уялдаа, хэрэгжүүлэх механизм хангалттай бус байна.

Дэлхий нийтийн уул уурхайн чиг хандлага нь тогтвортой, харилцан ашигтай, ногоон хөгжлийн чиг хандлагад тулгуурлаж, тасралтгүй хөгжиж буй энэ цаг үед төрийн үйлчилгээ, хөрөнгө оруулалтын тогтвортой орчин, орон нутгийн иргэдтэй харилцах зэрэг асуудлуудыг илүү нарийвчилж зохицуулах шаардлагатай байна.

Уул уурхайн салбар дахь авилгын судалгаанд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос ашиглалт хүртэлх үе шатанд буй авилгын эрсдэлүүдийн үндсэн шалтгааныг уул уурхайн салбарын хууль, эрх зүйн баримт бичгүүд нь:

- (i) хэт ерөнхий зохицуулалттай буюу тухайлсан зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй,
- (ii) аливаа зохицуулалтад тавигдах шаардлагууд тодорхойгүй,
- (iii) дагалдах дүрэм, журмууд нь төдийлөн мэргэжлийн арга зүйд тулгуурлаагүй гэж тодорхойлсон байна.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгээс гаргадаг Баялгийн засаглалын индекс 2017 оны тайлангаас харахад Монгол Улс нь байгалийн баялгийн засаглалын индексээр “Засаглал хангалттай” гэсэн ангилалд багтаж байгаа боловч “Орлогын менежмент” үзүүлэлтээр Монгол Улс 100 оноо авахаас 54 оноо, “Төрийн өмчийн компанийн засаглал”-ын үзүүлэлтээр 40 оноо, “Монгол Улсын үндэсний баялгийн сан буюу Төсвийн тогтворжуулалтын сан”-гийн хувьд 42 оноог тус тус авсан байна. Өөрөөр хэлбэл, эдгээр гол үзүүлэлтүүдээр баялгийн засаглал султай, дундаас доогуур үнэлгээтэй байна. Түүнчлэн аюулгүй байдлын дүрэм зэрэг уул уурхайн чухал шаардлагатай зарим баримт бичиг нь “журам гаргах үндэслэлийг хуульд заагаагүй” гэсэн шалтгаанаар мухардалд орж байсан нь салбарт ажиллагсдын аюулгүй, эрүүл орчинд ажиллах байдлыг эрсдэлд оруулж байна.

Олборлогч, боловсруулагч компаниудын тоо нэмэгдэж, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой олон төрлийн харилцааг Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд зохицуулахад хүндрэл учирч байгаагийн зэрэгцээ “тусгай зөвшөөрөл олголт”, “ашигт малтмал ашигласны төлбөр”-ийн асуудлыг зохицуулж буй хуульд уул уурхайн үйл ажиллагааг зохицуулах процессын чанартай өөрчлөлтүүдийг олон давтамжтай оруулах нь хөрөнгө оруулагчдын итгэлцэлд эрсдэл бий болгож байна. Иймд Ашигт малтмалын тухай хуулиас уул уурхайн процессын зохицуулалтуудыг тусгаарлах нь хөрөнгө оруулалтын орчныг тогтвортой хадгалах, сайжруулах чиглэлээр хийж буй цогц ажилд эерэг түлхэц өгнө.

Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль нь уурхайн амьдралын мөчлөгтэй холбоотой харилцааг иж бүрнээр нь зохицуулаагүй, эдгээрийн зарим зохицуулалт нь орчин үеийн хөгжлийн чиг хандлагатай төдийлөн уялдахгүй байна. Ашигт малтмалын тухай хууль нь “тусгай зөвшөөрөл”-тэй холбоотой харилцааг голчлон зохицуулж байгаа ба уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, олборлолт, баяжуулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нөхөн сэргээлт, хаалттай холбоотой харилцааг иж бүрнээр нь зохицуулахгүй байгаа тул холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, шинэтгэл хийх шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.3 дахь хэсэгт “Эдийн засаг, бизнес, худалдаа, өмч, санхүүгийн эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, өмчлөх эрхийн баталгааг алдагдуулсан хууль тогтоомж, шийдвэрийг засч сайжруулна” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны “Уул уурхайн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хэсэг байгуулах тухай” А/67 дугаар тушаал баталсан байна. Уг судалгааны ажлын хэсэг нь

- Ашигт малтмалын тухай,
- Газрын тосны тухай,
- Газрын хэвлийн тухай,
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай,
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай,
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай,
- Цөмийн энергийн тухай,
- Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай,
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай,
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай гэсэн

эрдэс баялгийн салбарын 10 хуульд дүн шинжилгээ хийж, нийт 267 давхардал, 150 зөрчил, 150 хийдэл тогтоосон байна.

5.1.1.2 Салбарын гол хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлт болон хуулийн төслүүд

Тус салбарын гол хуулиуд болон тэдгээрт 2017 он, 2018 оны эхний хагас жилд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг дор харуулав. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль, 2006 (2017 онд 2 удаа, 2018 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан)
- Газрын хэвлийн тухай хууль, 1988
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, 2014
- Цөмийн энергийн тухай хууль, 2009
- Газрын тосны тухай хууль, 2014 (2017 онд нэмэлт оруулсан)
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, 2005
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009
- Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2009
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2009, 2015
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2013

5.1.1.3 2017 оноос 2018 оны эхний хагас жилийн байдлаар холбогдох хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтүүд болон хуулийн төслүүдийн мэдээлэл

Хүснэгт 5.1

| Хуулийн нэр, огноо | Зүйл заалт | Гол агуулга, тайлбар |
|------------------------------------|--------------------------------|--|
| Ашигт малтмалын тухай хууль | | |
| 2017 | 35.10 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн бүтээн байгуулалт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоохдоо улсын байцаагчийн актаар зогсоодог байсан бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу зогсоодог болгож өөрчилсөн. |
| 2017 | 49.4.8 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэн өгч байгаа талын бүрдүүлэх баримт бичигт Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.14 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу тооцсон үнэ, тайлбар, танилцуулгыг хавсаргахыг нэмж оруулсан. |
| | 49.12 | Эцсийн эзэмшигч нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шууд бусаар шилжүүлсэн бол харьяа татварын албанд шилжүүлэх шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор мэдэгдэхийг нэмж оруулсан. |
| | 56.1.9, 56.1.10, 56.1.11 | Тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэлд дараах үндэслэлүүдийг нэмж оруулсан. Үүнд: -Тус хуулийн 49.1, 49.2, 49.3-т заасныг зөрчиж тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн бол, |

| | | |
|---|-----------------------|--|
| | | -Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тус хуулийн 49.4.8, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.11, 16.14-д заасан аргачлалын дагуу холбогдох татварыг тайлагнаагүй, эсхүл үнэлгээ тооцоход шаардагдах мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан, худал мэдүүлж тайлагнасан, -Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11.1.12, 15.2.10, Татварын ерөнхий хуулийн 18.1.14-т заасны дагуу холбогдох байгууллагад үнэн зөв мэдээлээгүй |
| | 11.1.25 | Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үүрэгт тус хуулийн дагуу ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалтын талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах гэж өөрчлөн найруулсан. |
| | 17 | Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шалгаруулалтын талбайг ялгах тухай зүйлийг бүхлээр нь өөрчлөн найруулсан. |
| | 18 | Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргах, түүнийг бүртгэх тухай журам бүхий зүйлийг өөрчлөн найруулсан. |
| | 20 | Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион байгуулах, тусгай зөвшөөрөл олгох тухай зүйлийг өөрчлөн найруулсан. |
| | 24.2 | Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо тус хуулийн 18 дугаар зүйл болон мөн тус хуулийн 20.1 заасан журмыг нэгэн адил баримтлана гэж өөрчлөн найруулсан. |
| 2018 | 26.12, 27.1.14, 49.13 | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд газар ашиглах эрхээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрхийг улсын бүртгэлд бүртгүүлнэ. Ингэснээр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авсан этгээдийн газар ашиглах эрх нь эрхийн улсын бүртгэлд бүртгэснээр үүсдэг болсон. Мөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүрэгт газар эзэмших эрхээ улсын бүртгэлд бүртгүүлсэн байх үүргийг нэмж оруулсан. |
| Газрын тосны тухай хууль | | |
| 2017 | 43.1 | Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад үүсэх төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч хэлэлцээрийн журмаар шийдвэрлэж чадаагүй маргааныг арбитрын хэлэлцээртэй эсэхээс шалтгаалан шийдвэрлэх арга замыг ялгаатай зааж өгсөн. |
| Татварын ерөнхий хууль | | |
| 2017 | 13.4.9 | Татварын алба нь татвар төлөгч, татвар суутгагч бүрийн хувьд бүрдүүлэх хувийн хэрэгт газар эзэмших, ашиглах эрхтэй хуулийн этгээд болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн мэдээлэлийг нэмж бүрдүүлэхийг заасан. |
| | 71 ¹ .10 | Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон, шилжүүлснийг бүртгэсэн талаархи мэдээллээ татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад сар бүр хүргүүлэхийг нэмж оруулсан. |
| | 71 ¹ .11 | Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хуулийн этгээдийн улсын бүртгэл хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хуулийн этгээдийн улсын бүртгэл, эцсийн эзэмшигчийн бүртгэлийн өөрчлөлтийн мэдээллийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад сар бүр хүргүүлэхийг нэмж оруулсан. |
| | 18.1.14 | Татвар төлөгчийн үүргийн нэгийг газар эзэмших, ашиглах эрхтэй хуулийн этгээд болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн талаархи мэдээлэл, түүний өөрчлөлтийн тухай мэдээллийг шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор харьяа татварын албанд бүртгүүлэх гэж өөрчлөн найруулсан. |
| Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль | | |
| 2017 | 7.3 | Ус бохирдуулсны төлбөрийг төвлөрүүлдэг Байгаль хамгаалах сангийн нэрийг "Байгаль орчин, уур амьсгалын сан" гэж өөрчилсөн. |
| Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль | | |
| 2017 | 101 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолтын тухай 101 дүгээр зүйлийг нэмсэн. |
| 2017 | 23.9, 23.10 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшигч нь ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах талаар баталгаа гаргах үүргийг нэмсэн бөгөөд тус баталгааны маягыг Авлигатай тэмцэх газар баталахыг нэмж оруулсан. |
| 2017 | 23.7 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргийг гүйцэтгэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсч болох нь тогтоогдсон бол түүнийг |

| | | |
|---|------------------|---|
| | | тухайн албанд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан томилохоос татгалзах үүрэгтэй гэж өөрчлөн найруулсан. |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль | | |
| 2017 | 19.14-19.17 | Жилийн албан татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэлийн болон хувцас үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг бол зөвхөн тухайн салбарт явуулсан үйл ажиллагаанаас олсон орлогод ногдох албан татварыг 90%-р хөнгөлнө гэсэн нэмэлт заалтыг оруулсан. |
| 2017 | 12.1.36 | Албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд спортын холбоо, спортын клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжээс тухайн татварын жилд хандивласан 10 сая хүртэлх төгрөгтэй тэнцэх хэмжээний хандив, хөрөнгийг нэмж оруулсан. |
| 2017 | 4.1.8 | Эцсийн эзэмшигч гэсэн нэр томъёог нэмж, түүнийг тайлбарласан. |
| 2017 | 16.11, 16.14 | Эрх борлуулсны орлогыг тухайн эрх эзэмшигч, түүний эцсийн эзэмшигчийн шилжүүлсэн хувьцаа, хувь оролцооноос тухайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцаанд ногдох хэмжээгээр тусгай зөвшөөрлийн үнэлгээнээс хувь тэнцүүлэн тооцож албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох ба албан татвар ногдуулах аргачлал, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох аргачлалыг тус тус санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж нэмж оруулсан. |
| 2017 | 16.12, 16.13 | Эрх борлуулсны орлогыг тухайн эрх эзэмшигч, түүний эцсийн эзэмшигчийн шилжүүлсэн хувьцаа, хувь оролцооноос тухайн газар эзэмших, ашиглах эрхтэй этгээдийн хувьцаанд ногдох хэмжээгээр газрын эрхийн үнэлгээнээс хувь тэнцүүлэн тооцож албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох ба татварын ногдлыг тодорхойлох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж нэмж оруулсан. |
| Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль | | |
| 2017 | 5.6 | Агаарын бохирдлын нөхөн төлбөрийг улсын төсөвт төлөх байсныг агаарын бохирдлын эсрэг санд төлөхөөр өөрчилж байна. |
| Байгаль орчныг хамгаалах тухай хууль | | |
| 2017 | 49.1, 54.9-54.11 | Эдгээр заалтууд дах байгаль хамгаалах гэснийг байгаль орчин, уур амьсгалын гэж өөрчилсөн. |
| 2017 | 27.1.7, 27.1.3 | Улсын байцаагчийн эрх, үүргийн нэг болох Зөрчлийн тухай хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авах мөн хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг нь түр зогсоох гэж өөрчлөн найруулсан. |
| Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль | | |
| 2017 | 3.1.3, 3.1.10 | "Байгаль орчны стратегийн үнэлгээ" болон " эрсдэлийн үнэлгээ"-ний тодорхойлолт дах "байгалийн гамшигт үзэгдэлтэй" гэснийг "гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюултай" гэж өөрчлөн найруулсан. |
| Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль | | |
| 2/9/2017 | 20.1.2 | Усны ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх чөлөөлт дэх байгалийн бусад гэснийг хасан найруулсан. |
| Зөрчлийн тухай хууль | | |
| 2/2/2017 | 5.1 | Терроризмтой тэмцэх тухай хууль зөрчих тухай зүйлд нэмэлт заалт оруулсан. |
| 2/2/2017 | 11.29 | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих тухай зүйлийг өөрчлөн найруулсан. |
| 12/21/2017 | 15.28 | Орон нутгийн хамгаалалтын тухай хууль зөрчих тухай зүйлийг нэмж оруулсан. |

5.1.1.4 Салбарын харилцааг зохицуулж буй бусад хуулиудыг багцлан доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5.2

| Байгаль орчны чиглэлийн | Төсөв, татварын чиглэлийн |
|--|--|
| Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, 2010 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006 |
| Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 | Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, 2008 |
| Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, 2017 |
| Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012 | Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, 2012 |
| Газрын тухай хууль, 2002 | Ирээдүйн өв сангийн тухай хууль, 2016 |
| Газрын төлбөрийн тухай хууль, 1997 | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2006, 2015 |
| Ойн тухай хууль, 2012 | Татварын ерөнхий хууль, 2008 |
| Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012 | Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010 |
| | Үл хөдлөх эд хөрөнгийн татварын тухай хууль, 2000 |
| | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, 2010 |
| Хариуцлагийн чиглэлийн | Бизнесийн харилцаа, орчны чиглэлийн |
| Аудитын тухай хууль, 1997, 2015 | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001 |
| Зөрчлийн тухай хууль, 2017 | Захиргааны ерөнхий хууль, 2015 |
| Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017 | Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 |
| Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2015 | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, 2015 |
| Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012 | |

5.1.1.5 Хуулийн төслүүд

Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх ажлын хүрээнд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар батлуулсан.

Батлагдсан үзэл баримтлалын дагуу

- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,
- Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай,
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль,
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усан сангийн хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн

төслийг тус тус боловсруулж, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

Мөн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан салбарын татварын эрх зүйн орчны талаар судалгаа хийж, холбогдох мэргэшсэн хүмүүстэй уулзалт зохион байгуулж, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

5.1.2 Олборлох үйлдвэрлэлийн салбарт хэрэгжиж буй хууль, тогтоомжууд

Монгол улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт хэрэгжиж байгаа эрх зүйн гол баримт бичгүүдийн зохицуулалтын тухай хураангуйлан танилцуулав.

5.1.2.1 Ашигт малтмалын тухай хууль, 2006

УИХ-аас Ашигт малтмалын тухай хуулийг 2006 онд баталсан. Уг хууль нь ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалуудыг хамардаг. Монгол Улсын ашигт малтмалын нөөцөд оруулах хөрөнгө оруулалттай холбогдох горим, зохицуулалт болон ашигт малтмалыг эрэх, хайх, уурхайтай холбоотой байгаль орчныг хамгаалах зэрэг журмуудын үндсэн суурь болдог. Уг хууль 11 бүлгээс бүрдэх ба ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг хадгалах нөхцөл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, тусгай зөвшөөрөл дуусгавар болох зэргийг багтаасан ашигт малтмалын салбар дахь төрийн зохицуулалттай холбогдсон харилцааг зохицуулдаг. Ашигт малтмалын тухай хуульд 2007 болон 2008 оны эхний хагас жилийн байдлаар онд орсон өөрчлөлтүүдийг дээрх хураангуй хүснэгтээс харна уу.

5.1.2.2 Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, 2014

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг УИХ-аас 2014 онд баталсан. Уг хууль нь хайрга, шавар, боржин чулуу, элсэн чулуу зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалуудыг хамардаг бөгөөд хайгуул, олборлолттой холбоотой байгаль орчныг хамгаалах, хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой журмуудын үндсэн суурь болдог. Уг хууль 10 бүлгээс бүрдэх ба ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг хадгалах нөхцөл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, тусгай зөвшөөрөл дуусгавар болох зэргийг багтаасан түгээмэл тархацтай ашигт малтмалын талаар төрийн зохицуулалттай холбоотой харилцааг зохицуулдаг.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11.2.5-д зааснаар аймаг, нийслэлийн засаг дарга өөрсдийн харьяа нутаг дэвсгэрт хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

5.1.2.3 Газрын тосны тухай хууль, 2014

Газрын тосны тухай хуулийг шинэчилэн найруулж УИХ-аас 2014 оны 7 сард баталсан. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор уг шинэчлэлийг хийсэн. Өмнөх үеүдэд батлагдсан гэрээнд өөрчлөлт ороогүй боловч шинэчлэгдсэн хууль нь газрын тос олборлогчдод тодорхой хөнгөлөлтийг үзүүлсэн. Уг хуульд зааснаар газрын тосны бүтээгдэхүүнийг

- i) Газрын тос ,
- ii) уламжлалт бус газрын тос гэсэн үндсэн хоёр төрөлд хувааж үздэг.

Газрын тос гэдэгт түүхий нефть, байгалийн хий ба боловсруулсан тосыг, харин уламжлалт бус газрын тос гэдэгт тослог элс, шатдаг занарыг ойлгоно.

Шинэчилсэн хуульд зонхилох газрын тосны ажиллагаа болон нэршлийн судалгаа, газрын тосны хайгуул болон олборлолтын талаар тодорхойлсон. Газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрлийг заавал авна. Газрын тосыг хадгалах, тээвэрлэх, судалгааны ажил эрхлэх бол холбогдох төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Шинээр олгосон газрын тосны хайгуулын хугацаа нь 8 хүртэл жил байх бөгөөд төрийн захиргааны байгууллага 2 хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. Газрын тосны ашиглалтын хугацаа 25 хүртэл жил байх бөгөөд гэрээлэгч ашиглалтын хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тохиолдолд

төрийн захиргааны байгууллага 5 хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. Уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа 10 хүртэл жил байх бөгөөд уг хугацааг төрийн захиргааны байгууллага 5 хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.

Газрын тосны тухай хуулиар газрын тосны эрэл хийхээр төлөвлөсөн хуулийн этгээд нь АМГТГ-т хүсэлт гаргах үүрэгтэй байдаг. БХГ-нд оролцохоос өмнө эрэл хийж дууссан хуулийн этгээд нь гүйцэтгэлийн тайланг АМГТГ-т өгч дүгнэлт гаргуулах үүрэгтэй.

АМГТГ-тай БХГ-г шууд байгуулсан хуулийн этгээдэд УУХҮЯ нь хайгуулын тусгай зөвшөөрлийг олгоно. Түүнчлэн, АМГТГ-ын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох заалтын дагуу БХГ хийх боломжгүй ч хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгарсан бол уг компанид хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдоно.

Газрын тосны тухай хуульд зааснаар гэрээлэгч нь газрын тосыг арилжаалах ажиллагааг эхэлсэн тохиолдолд газрын тосны зардлыг нөхөн авах боломжтой. Өртөгт газрын тосны хэмжээ нь тухайн жилд олборлосон нийт газрын тосноос нөөц ашигласны төлбөрт ногдох газрын тосыг хасаад үлдэх тосны 40 хүртэл хувь хамаарна. Хайгуул, ашиглалт, боловсруулалтын зардлууд нь БХГ-ний заалтад дурдагдсан дүнгээр бүрэн хэмжээгээр нөхөгдөх боломжтой. Тус хуулийн 32 дугаар зүйлийн дагуу БХГ дуусгавар болох үед өртөг нөхөгдөх зардлаас нөхөгдөөгүй үлдсэн хэсгийг гэрээлэгчид олгохгүй. ЗГ гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардалд хүү төлөхгүй.

2014 оны Газрын тосны тухай хуулийн шинэчлэл нь нэмэлт журам болон БХГ загвар зэрэг чухал өөрчлөлтийг агуулсан. Засгийн газрын 2015 оны 104 тоот тогтоолоор БХГ-ний загварыг баталсан.

Газрын тосны тухай хуулийн 7.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Газрын тосны нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмыг боловсруулж, Газрын тосны бүртгэл, тооцооны журмыг боловсруулахаар АМГТГ-аас Ажлын хэсэг ажиллаж байна.

5.1.2.4 Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, 2005

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг УИХ-аас 2005 оны 7 сард баталсан. Энэ хуулиар газрын тосны бүтээгдэхүүнтэй холбогдох үйл ажиллагааны дэд ангилал (импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт)-ыг тодорхойлсон. Газрын тосны бүтээгдэхүүн гэж газрын тос болон химийн нэгдлүүдийг боловсруулах замаар гарган авсан бүх төрлийн шатахуун, тусгай шингэн, шатдаг хий, тос тосолгооны материал, битум, мазут болон бусад бүтээгдэхүүнийг хэлнэ.

Импорт, үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаанд газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл шаардлагатай. Харин тээвэрлэлт болон хадгалалтын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл шаардлагагүй боловч Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, ГТГ-аас гаргасан холбогдох дүрэм журмыг мөрдөх шаардлагатай.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд 2013 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр газрын тосны бүтээгдэхүүнийг жижиглэн худалдаалах ажиллагаанд нэмэлт тусгай зөвшөөрөл шаардах болсон.

5.1.2.5 Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009

УИХ-аас 2009 онд Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай гэсэн “урт нэртэй хууль”-ийг баталсан. Уг хууль нь усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох болон тухайн газарт байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Энэ хуулийн хориг нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийг Монгол Улсын Засгийн Газар тодорхойлох бөгөөд заасан бүс нутагт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно. Энэхүү хуулийн хүрээнд ашигт малтмал хайх, ашиглах олон тооны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. “Урт нэртэй хууль”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль 2009 онд батлагдсан.

“Урт нэртэй хууль” батлагдсанаар гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглогдож, улмаар хуулиар хориглогдсон талбайд ашигт малтмалын ашиглалтын 576 тусгай зөвшөөрөл хамрагдаж, үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон.

Дээрх хуулийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Засгийн газраас таван тогтоол баталсан. Хуулийг хэрэгжүүлэх явцад олон хүндрэлүүд гарч байна. Тухайлбал, хуулиар хориглосон талбайн хилийн зааг тогтоох, онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг хасуулах, энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулах гэрээ, Тусгай зөвшөөрлийн төлбөртэй холбоотой асуудлуудыг дурдаж болно.

5.1.2.6 Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, 2015

Урт нэртэй хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд дараах агуулга бүхий зохицуулалтуудыг баталсан.

Урт нэртэй хууль батлагдахаас өмнө буюу 2009 оноос өмнө тус хуулиар хориглосон талбайд тусгай зөвшөөрөл авсан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь урт нэртэй хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдсанаас хойш 3 сарын дотор үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх тухай хүсэлтээ АМГ-т гаргана.

Өргөдөл гаргасан тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй БОНХАЖЯ (хуучин нэрээр), АМГ болон холбогдох аймгийн Засаг дарга гэрээ байгуулах бөгөөд Засгийн Газар энэхүү гэрээний загварыг батлана. Хуулийн дагуу гэрээний хэрэгжилтэд Мэргэжлийн Хяналтын Газар хяналт тавина.

Хэрэв урт нэртэй хуулиар хориглосон талбайд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх хүсэлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигч тогтоосон хугацаанд гаргаагүй эсвэл зохих журмын дагуу дээр дурдсанаар гэрээ байгуулаагүй тохиолдолд тухайн ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлах бөгөөд энэ тохиолдолд дахин тухайн талбайд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг аливаа этгээдэд олгохгүй.

Уг хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газраас гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, мөн усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс (усны сан бүхий газрын эргээс 200 метр)-д олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, байгаль орчны нөхөн сэргээлт хийлгэх асуудлыг зохицуулах холбогдох журмууд гаргахаар зохицуулсан.

Уг журам, гэрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлыг 100 хувь урьдчилан байршуулах нөхцөл, хяналт тавих төрийн байгууллагын албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон.

Ойн сан бүхий газарт олгосон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ойн тухай хуулийн тодорхой зүйл, заалтуудыг дагаж мөрдөхөөр зохицуулсан. Харин хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүстэй давхацсан тохиолдолд Усны тухай хууль, ойн сан бүхий газартай давхацсан тохиолдолд Ойн тухай хуулийн дагуу тус тус шийдвэрлэхээр хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгажээ.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлт хийгээгүй тохиолдолд нөхөн сэргээлт хийхэд гарах зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашиглалт явуулсан хугацаанд олсон орлоготой нь уялдуулан нөхөж гаргуулахаар тогтоосон.

5.1.2.7 Захиргааны ерөнхий хууль, 2015

Эрдэс баялгийн салбарт төрийн захиргааны байгууллагатай хийгддэг хэдэн төрлийн гэрээ байдаг. Тухайлбал, Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ зэрэг юм. Эрх зүйн зохицуулалтын дутагдалтай байдлаас шалтгаалан эдгээр гэрээг байгуулах үйл явц, түүний агуулга нь ихэнхдээ хаалттай байдаг. Угтаа эрдэс баялгийн гэрээнд ил тод байдал, олон нийтийн оролцоог хангах нь уг салбар

дахь орлогын урсгалыг хянах, нийгмийн шударга ёсыг хангах, улмаар байгаль орчин, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад чухал ач холбогдолтой.

2016 оны 7 дугаар сарын 1-ээс хэрэгжиж буй Захиргааны ерөнхий хууль нь эрдэс баялгийн гэрээний ил тод байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үздэг.

5.1.2.8 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2013

Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах, хууль бус хэрэглээг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулна.

5.1.2.9 Цөмийн энергийн тухай хууль, 2009

Цөмийн энергийн тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

5.1.2.10 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001

УИХ-аас Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг 2001 оны 02 сард баталсан бөгөөд ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд мөрдөх горимыг тодорхойлох, зохицуулахад онцгой анхаарал хандуулсан.

Хайгуулын тусгай зөвшөөрөл болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГ-аас авахаас гадна зөвшөөрөлд хамрагдах эдэлбэр газар харьяалагдаж буй аймгийн захиргаа нь тусгай зөвшөөрөл бүрийг батлах шаардлагатай. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хууль тогтоомж, дүрэм журмын мөрдөлтөд хяналт тавих геологи, уул уурхайн улсын хяналтын газар болон орон нутгийн захиргааны үүрэг, хариуцлагуудыг уг хуулиар тодорхойлсон.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг зөвхөн Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулсан хязгаарлагдмал хариуцлагатай компани эсвэл хувьцаат компанид олгоно. Монгол Улсын иргэн эсвэл гадаадын иргэн буюу хувь хүн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчээр бүртгүүлэх эрхгүй.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд 2014 онд өөрчлөлт орсон бөгөөд уламжлалт болон уламжлалт бус газрын тосны хайгуул хийх болон ашиглах үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөлтэйгөөр хийгдэх бизнесийн ажиллагааны жагсаалтад нэмэгдсэн.

5.1.2.11 Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль нь аж ахуйн нэгж, байгууллагад ус бохирдуулсны төлбөр ногдуулах, усны бохирдуулалтын хэмжээнээс хамааран усны бохирдуулалтын төлбөрийн дээд болон доод хэмжээг тодорхойлох, усны нөөцийг “бохирдуулсны төлбөр”-ийн зарчмыг хэрэгжүүлэх зорилготой.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл сав газрын захиргаа ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэж авна.

Уг хуулийн дагуу ус бохирдуулсны төлбөр төлөгчийн гаргасан (i) хаягдал усны стандартад нийцүүлэн зөвшөөрсөн хязгаарын дотор байгальд шууд нийлүүлж байгаа хаягдал ус, (ii) ариутгах татуургад нийлүүлэх бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд агууламжийн стандартад нийцүүлэн ариутгах татуургад нийлүүлж байгаа хаягдал усанд ус бохирдуулсны төлбөр ногдуулна.

Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усанд бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлалыг байгаль орчны асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

5.1.2.12 Аудитын тухай хууль, 2015

Аудитын тухай хуулийг шинэчлэн найруулж УИХ-аас 2015 онд баталсан. Уг хуулийн хүрээнд дараах аж ахуйн нэгжүүд санхүүгийн тайландаа аудит хийлгэх шаардлагатай. Үүнд:

- Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ыг мөрддөг аж ахуйн нэгж, байгууллага,
- Нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг аж ахуйн нэгж, байгууллага,
- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллага,
- Монгол Улсын дагаж мөрддөг Олон Улсын гэрээ хэлэлцээрийн дагуу санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэхээр заагдсан бусад аж ахуйн нэгж, байгууллага.

5.1.2.13 Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, 2015

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.2-т СТОУС-ыг зайлшгүй мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагуудыг заасан бөгөөд эдгээр нь санхүүгийн тайландаа аудит хийлгэх шаардлагатай.

Харин дор дурдсан хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагууд нь Жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын Олон улсын стандартыг дагаж мөрдөнө. Иймд тэд хөндлөнгийн аудит хийлгэх шаардлагагүй. Харьцуулалтыг дор харуулав.

| СТОУС-ыг зайлшгүй мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагууд | Жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын Олон улсын стандартыг дагаж мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагууд |
|--|---|
| <ul style="list-style-type: none"> • Гадаад, дотоодын хөрөнгийн биржид бүртгүүлсэн бүх төрлийн хувьцаат компани, • Гадаад, дотоодын хөрөнгийн биржид бүртгүүлэхээр хүсэлт гаргасан компани, • Банкны үйл ажиллагаа, банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа, ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал ашиглах болон газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага, • Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой бусад аж ахуйн нэгж, • Улс төрийн нам, Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан төрийн чиг үүргийг гэрээгээр хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллага, • Арилжааны банкнуудтай хамтарч ажилладаг тусгай зориулалтын компани, хөрөнгө оруулалтын сангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага. | <ul style="list-style-type: none"> • Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн, • Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 149-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн, • Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн, • Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 49-өөс дээшгүй бөгөөд 1 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн, • Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 19-өөс дээшгүй бөгөөд үйлдвэрлэл эрхэлдэг, 250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиг үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн, эсхүл контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 9-өөс дээшгүй бөгөөд худалдаа, үйлчилгээ эрхэлдэг, 250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиг үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн. |

5.1.2.14 Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт (2016)

Засгийн Газрын 2016 оны 409 дүгээр тогтоолоор Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт батлагдсан. Энэхүү стандартын дагуу хайгуул болон олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь үйл ажиллагааны үе шатуудын хүрээнд үүссэн бүхий л ажил гүйлгээгээ нягтлан бодох бүртгэлийн тайландаа тусгаж өгөхийг шаардсан. Энэ стандартын хүрээнд газрын тос болон байгалийн хийн олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэл хамаарахгүй.

5.1.2.15 Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай Засгийн Газрын тогтоол, 2016

ЗГ-аас жил бүр Монгол Улсад ажиллах гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тодорхойлсон тогтоол гаргадаг. Энэхүү тогтоол нь салбар бүрийн хувьд нийт ажилчдын хэдэн хувь нь гадаад ажилчид болон мэргэжилтнүүд байхаар зөвшөөрөгдсөн тухай жагсаалтыг хавсралтаар заасан байдаг. Энэхүү хавсралтад тусгагдаагүй салбарын хувьд уг тогтоолын дагуу нийт ажиллагчдын 5 хүртэл хувь нь гадаадын ажилчид, мэргэжилтнүүд байхаар зөвшөөрөгдсөн гэж ойлгоно.

Засгийн Газрын 2016 оны 137 дугаар тогтоолоор 2017 онд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагчдын тоонд эзлэх гадаадын ажиллах хүч, мэргэжилтний хувийг хавсралтаар баталсан. ОУ-ийн салбарт 2017 онд ажиллах нийт ажилчдын тоонд гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувь өмнөх оны түвшинтэй ижил байхаар баталсан байна. Мэдээллийг дараах хүснэгтэд 2016-17 оны байдлаар тусгав.

Хүснэгт 5.3

| Хувь хэмжээ (Нийт ажилчдын тоонд эзлэх хувь) | | | | | | | | | |
|---|-----------------------------|------|---------------|------|----------------|------|---------------------------|------|--------------|
| ОУ-ийн үйл ажиллагаа | Дүрмийн сан (Сая төгрөгөөр) | | | | | | | | |
| | 100 хүртэлх | | | | | | 101 ба түүнээс дээш | | Өөрчлөлт (+) |
| | 15-30 ажилчид | | 31-50 ажилчид | | 51-100 ажилчид | | Ажилчдын тоо харгалзахгүй | | |
| | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 | 2016 | 2017 | |
| Газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолт | 10% | 10% | 20% | 20% | 60% | 60% | 70% | 70% | |
| Бусад ОУ-ийн үйл ажиллагаа | 10% | 10% | 20% | 20% | 20% | 20% | 25% | 25% | - |

Эх сурвалж: ЗГ-ын 2015 оны 432 дугаар тогтоол болон 2016 оны 137 дугаар тогтоол.

5.1.3 Эрдэс баялагийн салбарт Төрөөс баримтлах бодлогууд

5.1.3.1 Төрөөс эрдэс баялгийн салбарт 2025 он хүртэл баримтлах бодлого

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэнэ.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилго нь хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино.

Энэхүү бодлогын баримт бичиг нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим, хөгжлийн чиглэлийг тодорхойлж, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэх бөгөөд тэдгээр нь эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, дунд, урт хугацааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, төсөлд тусгагдан хэрэгжинэ.

5.1.3.2 Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого

“Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”-ын залгамж чанарыг хадгалан энэ салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүний нөөц, үндэсний ажиллах хүчийг чадавхжуулах, мэргэшүүлэх шаардлагын үүднээс Засгийн газрын 2018 оны 6 сарын 6-ны өдрийн хуралдаанаар “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ыг хэлэлцэн Засгийн газрын 169 дүгээр тогтоолоор батласан.

Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын зорилго нь Монгол Улсын газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангахад оршино.

Энэхүү шинэчилсэн төрийн бодлогыг 2018-2027 онд 2 үе шаттай хэрэгжүүлэх бөгөөд I үе шат буюу 2018-2021 онд газрын тосны салбарын бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож, дэд бүтцийг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой газрын тосны компанийг байгуулах ажлыг эхлүүлснээр улсын нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадвар дээшилнэ, II үе шат буюу 2022-2027 онд стратегийн ач холбогдол бүхий газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажил эрчимжиж, газрын тосны нөөц, олборлолт нэмэгдэн боловсруулах үйлдвэр байгуулагдаж, хүний нөөцийн чадавх бэхжиж, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурь бий болно.

5.1.3.3 Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого

Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын зорилт нь цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгаа гүнзгийрүүлэн судлах, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч тэргүүлэгч орны нэг болох, улмаар цөмийн энергийг эдийн засаг, нийгмийн салбарт өргөн хүрээнд ашиглах, хүний эрүүл мэндэд аюулгүй, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй технологиор цөмийн эрчим хүч үйлдвэрлэхэд оршино.

5.1.3.4 Шинээр болон шинэчлэн хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, журам, зааврууд

Олборлох үйлдвэрлэлийн салбарт хэрэгжиж буй хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд 2017-2018 оны эхний хагас жилийн байдлаар шинэчилсэн болон шинээр гарсан журам, заавруудын талаар энд танилцуулав.

1. Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам, болон Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам /Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоол/,
 - Ашигт малтмалын овоолго, хаягдлыг дахин боловсруулснаар ордын ашиглалт, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшин, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэлбэрээр улсын төсөвт төвлөрөх орлого, ажлын байрыг нэмэгдүүлэхээс гадна байгаль орчныг нөхөн сэргээх, хүрээлэн буй орчныг хамгаалахад ач холбогдолтой.
2. Алт-2 Үндэсний хөтөлбөр /Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоол/,
 - Уг хөтөлбөрт алтны олборлолтын хэмжээг жилд 2-3 тонноор нэмэгдүүлж, улмаар 2020 онд 25 тоннд хүргэсэн байх, Монгол банкинд тушаах алтны хэмжээг тогтвортой өсч, гадаад валютын нөөц нэмэгдсэнээр үндэсний валютын ханш тогтворжиж, Монгол Улсын зээлжих зэрэглэл, төлбөрийн чадвар сайжирсан байх зэрэг зорилтууд дэвшүүлсэн.
3. Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох журам /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/01 дүгээр тушаал/,
4. Эрдэс баялгийн бодлогын зөвлөлийн ажиллах журам /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/16 дугаар тушаал/,
5. Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/129 дугаар тушаал/,

6. Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/206 дугаар тушаал/,
7. Цооногийн каротажийн судалгаанд цацраг идэвхт битүү үүсгүүр ашиглахад мөрдөх цацрагийн аюулгүйн дүрэм /Цөмийн энергийн комиссын 2017 оны 12 дугаар тогтоол/,
8. Цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйл ажиллагаанд мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм /Цөмийн энергийн комиссын 2018 оны 01 дүгээр тогтоол/,
9. Нөөц ашигласны төлбөр болон, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам /Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоол/,
10. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны А/50, А/31 тоот тушаал/,
11. Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавигдах шаардлагын төсөлд хийсэн нөхцөл байдлын дүн шинжилгээ /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/07 дугаар тушаал/,
12. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журмын төсөлд хийсэн нөхцөл байдлын дүн шинжилгээ /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/06 дугаар тушаал/,
13. Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/08 тушаал/.

5.1.4 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд гарсан эрх зүйн баримт бичгүүд

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд Ашигт малтмалын тухай хууль (2006), Цөмийн энергийн тухай хууль (2009), Газрын тосны тухай хууль (2014), Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль (2014), Зөрчлийн тухай хууль (2017), Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017) зэрэг 6 хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна.

ОУИТБС-ыг нэвтрүүлэхтэй холбоотойгоор дараах төрийн бодлогын баримт бичгүүд батлагдсан байна, үүнд:

- УИХ-ын тогтоолоор баталсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014)-д ил тод байдлын болон хариуцлагатай уул уурхай, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг олон улсын санаачилгыг дэмжин хөгжүүлэх,
- Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2016)-т олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах талаар тусган,
- Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2017)-нд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах 6 төрлийн арга хэмжээг 2017-2023 оны хугацаанд 2 үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 381 дүгээр тогтоолоор Нээлттэй засгийн түншлэлийн 2 дахь шатны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө (2016-2018)-г батлан байгалийн баялгийг ашиглах бенефициал өмчлөгчийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 1 дүгээр тогтоолоор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгыг дэмжин, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоол болон 2017 оны 263 дугаар тогтоолуудаар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах (зарим) арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгожээ. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 190 дүгээр тогтоолоор олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус

хөрөнгийн тайланг жил бүр гаргаж, нийтэд мэдээлж, тайлагнаж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон байна. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах хамтын ажиллагааны гэрээний загвар, мөн 2015 оны 104 дүгээр тогтоолоор Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг баталсан байна.

Ерөнхий сайдын захирамж болон холбогдох яамдын сайдын тушаал, шийдвэрээр 15 гаруй дүрэм, журам, санамж бичиг, төлөвлөгөө батлагдан салбарын үйл ажиллагааг зохицуулж байна.

5.1.5 Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр

УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд уг хөтөлбөрт геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үндсэн зорилгын хүрээнд 17 төрлийн зорилтыг хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн төсөл, гадаад зээл, тусламжийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогод тус тус тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг даргад даалгасан.

5.1.6 Төсвийн бодлого, төсвийн хууль тогтоомж (шаардлага 2.1)

5.1.6.1 Төсвийн бүрдэлт, хуваарилалт

Төсөв нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх хэрэгсэл бөгөөд тухайн оны хугацаанд төрийн санд хуримтлагдах нийт орлого, түүнийг зарцуулах арга хэмжээг багтаасан орлого, зарлагын тэнцэл юм.

Төсвийн орлого нь татварын болон татварын бус орлого, тусламжаас бүрддэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлогоос Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв санд ногдох хэсгийг хасаад үлдсэн орлогыг Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого гэнэ.


Татварын орлогод Татварын ерөнхий хуулийн дагуу тогтоосон татвар болон төлбөр орно. Татварын бус орлогод

- (i) Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;
- (ii) Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр;
- (iii) Төрийн болон орон нутгийн өмчийг хувьчилсан, худалдсан, түрээсэлсний орлого;
- (iv) Торгуулийн төлбөр;
- (v) Төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлого;
- (vi) ЗГ-т олгосон зээл, тусламж;
- (vii) Хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлсэн бусад орлого орно.

Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардлаас бүрдэнэ. Төсвийн зарлага нь төрөөс иргэдэд боловсрол олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх зэрэг төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулагддаг.

Монгол Улс **нэгдсэн төсөвтэй**. Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Орон нутгийн төсөв нь нэгдсэн төсвийн бүрдэл болдог. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ. Улсын Их Хурал нь Улсын төсөв,

Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг баталдаг бол орон нутгийн төсвийг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталдаг.



Улсын төсөв. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яамд болон тэдгээрийн харьяа байгууллагуудын бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг улсын төсөв гэнэ. Улсын төсөв нь нэгдсэн төсвийн 80% орчмыг эзэлдэг.

Эх үүсвэр: Иргэдийн төсөв-2018, СЯ

Орон нутгийн төсөв. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрдүүлэн зарцуулах төсвийг хэлнэ. Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг болон улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг Улсын Их Хурал баталдаг.

Нийгмийн даатгалын сангийн төсөв. Нийгмийн даатгалын хуулийн дагуу ажилтан болон ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, улсын төсвөөс олгосон санхүүжилтээр бүрдүүлсэн орлогоор Нийгмийн даатгалын хуулиудад заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу төр, иргэн, байгууллагаас төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхэд зарцуулдаг.

5.1.6.2 Төсвийн хууль тогтоомжууд

Улсын төсөвтэй холбоотой хууль тогтоомжид Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу гаргасан бусад хууль тогтоомжийн актууд орно.

Монгол Улсын төсвийн бодлого доор дурдсан хуулийн хүрээнд зохицуулагдана.

Төсвийн тухай хууль. Улсын нэгдсэн төсөв нь Төсвийн тухай хуулиар зохицуулагддаг. Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, эрдэс баялагийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэ хууль нь зарчмын хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Энэхүү хуулиар ирээдүйн тэнцвэрт алдагдлын хувь, өрийн зөвшөөрөгдөх хэмжээ, зарлагын өсөлтийн хувь болон төсвийн орлогын тооцооллын процесс зэргийг тодруулж өгсөн. Үүнд:
 - нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх.
 - Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.
 - Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байна.
 - ЗГ-ын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх (энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан).
- Төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн бодлогыг тодорхойлсон байх. Энэхүү хүрээ нь Засгийн газрын санхүүгийн зорилтуудыг, түүний хүлээгдэж буй төсвийн гүйцэтгэл, болон макро эдийн засгийн (ажил эрхлэлтийн түвшин, хэрэглээний үнийн индекс, гэх мэт) болон дараагийн гурван жилд баримтлах төсвийн төсөөлөл (төсвийн тэнцэл, төсвийн хөрөнгө оруулалт, гэх мэт) агуулсан байх ёстой.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль. Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Ирээдүйн өв сангийн тухай хууль. Ирээдүйн өв сангийн тухай хууль нь УИХ-аар 2016 онд батлагдаж, 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс бүх нийтээр дагаж мөрдөхөөр болсон. Энэ хуулийн зорилт нь

- нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Ирээдүйн өв санг байгуулах,
- түүнд хөрөнгө төвлөрүүлэх, сангийн өгөөжийг хуваарилах, сангийн хөрөнгийг удирдах бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах,
- макро эдийн засгийн тогтвортой, үр ашигтай удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

5.2 УУЛ УУРХАЙ

5.2.1 Монголын ашигт малтмалын тухай тойм

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2,225 компанийн 3,708 тусгай зөвшөөрөлтэй талбай дээр 50 төрлийн ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

Сүүлийн 3 жилийн дунджаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын эзлэх хувь 18.7% байсан. Тус үзүүлэлт нь 2017 онд өмнөх оноос 4.5%-иар өссөн байна.

Сүүлийн 3 жилийн дунджаар Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувь 73% байсан. Тус үзүүлэлт нь 2017 онд өмнөх оноос 6.5%-иар буурсан байна.


Дараах хүснэгтээр уул уурхайн салбарын сүүлийн 3 жилийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг харуулав.

Хүснэгт 5.4

| № | Үзүүлэлт | 2015 он | 2016 он | 2017 он |
|-------|--|-----------------------|------------------------|------------------------|
| 1 | Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо | 3,329 | 3,580 | 3,369 |
| | Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо | 1,494 | 1,558 | 1,624 |
| | Хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо | 1,835 | 2,022 | 1,745 |
| 2 | Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбай | 13.9 сая га | 13.5 сая га | 10.7 сая га |
| | Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай | 1.3 сая га | 1.4 сая га | 1.6 сая га |
| | Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай | 12.6 сая га | 12.1 сая га | 9.1 сая га |
| 3 | Нийт нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь | 8.9% | 8.6% | 6.8% |
| | Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь | 0.8% | 0.9% | 1.0% |
| | Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь | 8.1% | 7.7% | 5.8% |
| 4 | ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь | 17.1% | 17.2% | 21.7% |
| 5 | АҮ-ийн нийт үйлдвэрлэлд УҮҮ-ийн эзлэх хувь | 67.2% | 79.1% | 72.6% |
| 6 | УУ-н гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл | | | |
| | Зэсийн баяжмал (метал агуулгаар) | 890.7 мян.тн | 1,445.1 мян.тн | 1,317.1 мян.тн |
| | Молибдений баяжмал (метал агуулгаар) | 5,441.0 тн | 5,173.7 тн | 5,616.7 тн |
| | Алт | 14,556.2 кг | 18,435.7 кг | 19,846.0 кг |
| | Хайлуур жоншны баяжмал | 230.8 мян.тн | 34.1 мян.тн | 55.2 мян.тн |
| | Төмрийн хүдэр, баяжмал | 6,173.4 мян.тн | 2,209.9 мян.тн | 3,675.0 мян.тн |
| | Цайрын баяжмал | 89.6 мян.тн | 100.2 мян.тн | 82.7 мян.тн |
| 7 | Экспортод гаргасан гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн | | | |
| | Төмрийн хүдэр, баяжмал | 5,065.1 мян.тн | 6,084.8 мян.тн | 6,257.8 мян.тн |
| | Зэсийн баяжмал | 1,477.8 мян.тн | 1,562.0 мян.тн | 1,472.2 мян.тн |
| | Цайрын хүдэр, баяжмал | 84.1 мян.тн | 126.0 мян.тн | 118.2 мян.тн |
| | Боловсруулаагүй, хагас боловсруулсан алт | 11,300 кг | 19,168.5 кг | 14,554.5 кг |
| Нүүрс | 14,426.4 мян.тн | 25,713.9 мян.тн | 33,400.1 мян.тн | |
| 8 | Олборлосон нүүрс | 23,979 мян.тн | 35,096.5 мян.тн | 49,480.3 мян.тн |
| 9 | Баяжуулсан нүүрс | 22,125 мян.тн | 33,831.7 мян.тн | 41,904.6 мян.тн |
| 10 | Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн ГСА | 9.3 тэрбум төг | 9.3 тэрбум төг | 13.4 тэрбум төг |
| 11 | АМГТГ-ын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт | 118.9% | 114.4% | 103.4% |

Эх сурвалж: 2015, 2016, 2017 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар, Гадаад худалдаа 2016, Гадаад худалдаа 2017, Монгол улсын үндэсний статистикийн хороо

2017 онд ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд хүлээлгэн өгсөн ордууд дараах байдалтай байсан. Тухайлбал:



Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ хуудас 10, 2017 он, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

5.2.2 Ураны тухай тойм мэдээлэл

Тайлант оны эцсийн байдлаар 5 компанийн 10 ширхэг уран олборлолтын тусгай зөвшөөрөл, 8 компанийн 20 ширхэг ураны хайгуулын тусгай зөвшөөрөл байсан. Тайлант онд ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд ураны нөөц нэмж бүртгэгдээгүй байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр ураны тусгай зөвшөөрлүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 16(и)-ээс харна уу.

5.2.3 Стратегийн ач холбогдол бүхий ордууд

“Ашигт малтмалын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 1.5-д “Засгийн газар нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох тухай саналыг Улсын их хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасан байна.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд нь үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн түвшинд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд болзошгүй нөлөөтэй байж болох эсхүл тухайн жилд нийт ДНБ-ний 5%-иас илүү үйлдвэрлэх боломжтой эсвэл үйлдвэрлэж байгаа ордууд юм.

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар болон 2015 оны 1 дүгээр сарын 23-ний өдрийн 11 тоот тогтоолоор батлагдсан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 16 ордуудын товч мэдээллийг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт 5.5

| № | Ордууд | Ашигт малтмалын төрөл | Байршил | Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд | Эзэмшлийн хувь | |
|---|-----------|-----------------------|------------------------|---|----------------|-----|
| | | | | | ТӨР | ААН |
| 1 | Асгат | Мөнгө | Баян-Өлгий, Ногооннуур | Монголросцветмет ХХК Эрдэнэс Монгол ХХК | 51 | 49 |
| 2 | Багануур | Нүүрс | Улаанбаатар, Багануур | Багануур ХК | 75 | 25 |
| 3 | Бороо | Алт | Сэлэнгэ, Баянгол | Бороо гоулд | 0 | 100 |
| 4 | Бүрэнхаан | Фосфорит | Хөвсгөл, Алаг-Эрдэнэ | Сутайхэн цо ХХК Топруонхэнцо ХХК Талст маргад ХХК | 0 | 100 |

| № | Ордууд | Ашигт малтмлын төрөл | Байршил | Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд | Эзэмшлийн хувь | |
|----|-----------------|----------------------|----------------------|--|----------------|-----|
| | | | | | ТӨР | ААН |
| 5 | Гацуурт | Алт | Сэлэнгэ, Мандал | Сентеррагоулд Монголия ХХК | Хэлэлцэж байна | |
| 6 | Гурванбулаг | Уран | Дорнод, Дашбалбар | | | |
| 7 | Дорнод | Уран | Дорнод, Дашбалбар | | | |
| 8 | Мардай | Уран | Дорнод, Дашбалбар | Адамасмайнинг ХХК | | |
| 9 | Нарийн сухайт | Нүүрс | Өмнөговь, Гурвантэс | Монголын Алт МАК ХХК | 0 | 100 |
| | | | | Чинхуа МАК НС ХХК | | |
| | | | | Саус гоби сэндс ХХК | | |
| | | | | Өсөх зоос ХХК | | |
| 10 | Оюу толгой | Зэс, алт | Өмнөговь, Ханбогд | Оюу толгой ХХК | 34 | 66 |
| | | | | Онтрэ ХХК | | |
| 11 | Таван толгой | Нүүрс | Өмнөговь, Цогтцэций | Тавантолгой ХК | 51 | 49 |
| | | | | Энержи Ресурс ХХК | 0 | 100 |
| | | | | Эрдэнэс ТТ ХХК | 100 | 0 |
| 12 | Төмөртэй | Төмөр | Сэлэнгэ, Хүдэр | Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК | 100 | |
| 13 | Төмөртэйн овоо | Цайр | Сүхбаатар, Сүхбаатар | Цайрт Минералс ХХК | | 100 |
| 14 | Шивээ овоо | Нүүрс | Говьсүмбэр, Сүмбэр | Шивээ-Овоо ХК | 90 | 10 |
| | | | | Эрдэнэс монгол ХК | | |
| | | | | Эйкүсора ХХК | | |
| 15 | Цагаан суварга | Зэс, молибден | Дорноговь, Мандах | Эрдэнэс Цагаан суварга ХХК | 0 | 100 |
| | | | | Монголын Алт МАК ХХК | | |
| 16 | Эрдэнэтийн овоо | Зэс, молибден | Орхон, Баян-Өндөр | Эрдэнэт үйлдвэр ХХК | 51 | 49 |

5.2.4 Монголын ашигт малтмалын нөөц

Монголын Ашигт малтмалын нөөцийг Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) бүртгэж, тайлагнадаг. Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэгдсэн нөөцийн сүүлийн 3 жилийн мэдээллийг хураангуйлан харуулав. Эрдэнэтийн зэсийн ордын баруун, төв хэсгийн нөөц тодотголоор шинэчлэгдэн бүртгэгдсэн. Үүнд:

Хүснэгт 5.6

| д/д | Ордын төрөл | Хэмжих нэгж | 2016 он | | 2017 он | | Нийт |
|-----|-------------------|-------------|-------------|-----------|-------------|-----------|--------------|
| | | | хүдэр/ шлих | метал | хүдэр/ шлих | метал | метал |
| | | | | | | | |
| 2 | Алт (шороо) | кг | 6,581.00 | 5,955.00 | 3,375.00 | 3,015.00 | 43,940.00 |
| 3 | Төмөр | мян.тн | 54,463.00 | 18,030.00 | 45,656.00 | 11,871.00 | 350,431.00 |
| 4 | Холимог метал | мян.тн | 15,091.00 | | - | - | - |
| | Зэс | тн | - | 57,547.00 | - | - | 1,775,167.00 |
| | Цайрын исэл | тн | - | 41,043.00 | - | 78.00 | 1,126,034.00 |
| | Цайр | тн | - | - | - | - | 36,322.00 |
| | Хар тугалга | тн | - | - | - | 83.00 | 244,939.00 |
| | Гянтболдын исэл | тн | - | - | - | 1,636.00 | 1,553,766.00 |
| | Төмрийн усан исэл | тн | - | - | - | - | 715,897.00 |
| 5 | Молибден | мян.тн | - | - | - | - | 650.00 |
| 6 | Гянтболд | мян.тн | - | - | 503.00 | 4.00 | 349,319.00 |

| д/д | Ордын төрөл | Хэмжих нэгж | 2016 он | | 2017 он | | Нийт |
|-----|----------------|-------------|----------------|----------------------|----------------|----------|---------------|
| | | | хүдэр/ шлих | метал | хүдэр/ шлих | метал | метал |
| | | | 7 | Газрын ховор элемент | мян.тн | - | - |
| 8 | Зэс | мян.тн | 2,042,008.00 | 7,789,024.00 | 29,183.00 | 135.00 | 53,577,456.00 |
| 9 | Цагаан тугалга | мян.тн | - | 90.00 | - | 1.00 | 10,961.00 |
| 10 | Хайлуур жонш | мян.тн | 801.00 | 335.00 | 1,178.00 | 665.00 | 16,841.00 |
| 11 | Уран | мян.тн | 5.00 | - | - | - | 95,159.00 |
| 12 | Нүүрс | сая.тн | 1,295.00 | - | 3,869.00 | 3,580.00 | 27,868.00 |
| 13 | Шатдаг занар | сая.тн | - | - | - | - | 1,840.00 |
| 14 | Шохойн чулуу | сая.тн | 155.00 | - | - | 186.00 | 1,767.00 |

Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ хуудас 9, 2017 он, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

5.2.5 Бичил уурхай

Гар аргаар ашигт малтмал олборлох буюу бичил уул уурхай

Гар аргаар ашигт малтмал олборлох буюу Бичил уул уурхай гэдэг нь өргөн утгаараа Монгол Улсын нутаг дэвсгэрт нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн (ихэвчлэн хууль бус) эрхэлж буй ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хэлнэ. БУУ-н үйл ажиллагааны улирлын шинж чанар, тогтворгүй байдал болон албан ёсны статистик мэдээллийн дутмаг байдлаас шалтгаалан энэхүү тайланд бичил уул уурхайн салбарыг Монгол Улсын голлох олборлох салбарын тоймоос тусад нь авч үзсэн болно.

Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгааны дүнгээр нийт 11,962 иргэд бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаагаас 9,596 иргэн судалгаанд хамрагджээ. Нийт бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид болон бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй гэр бүлийн гишүүдийн 4.5 мянга буюу 37.6 хувь нь Баруун бүсэд, 4.2 мянга буюу 35.2 хувь нь Төвийн бүсэд, 1.7 мянга буюу 14.9 хувь нь Хангайн бүсэд, 1.3 мянга буюу 10.6 хувь нь Улаанбаатар хотод, 0.2 мянга буюу 1.7 хувь нь Зүүн бүсэд бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байна.

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид Сүхбаатар, Дархан-Уул, Орхон аймгаас бусад 18 аймаг, нийслэлийн 1 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаагийн 1674 буюу 17.4 хувь нь Говь-Алтай аймагт, 1216 буюу 12.7 хувь нь Улаанбаатар хотод, 998 буюу 10.4 хувь нь Өмнөговь аймагт, 898 буюу 9.4 хувь нь Сэлэнгэ аймагт, 821 буюу 8.6 хувь нь Ховд аймагт, 745 буюу 7.8 хувь нь Баянхонгор аймагт, 657 буюу 6.8 хувь нь Төв аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа нь нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 73.0 хувийг эзэлж, үлдсэн 27.0 хувь нь бусад аймагт байна.

Ашигт малтмалын илрэл бүхий нийт 113 (бичил уурхайн зориулалтаар дүгнэлт гаргасан) орд газрын 332 цэг, аманд бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаагийн 205 буюу 61.7 хувь нь 4 аймаг, 1 дүүрэгт байршиж, тэдгээрийн 88 нь Налайх дүүрэгт, 37 нь Баянхонгор аймагт, 29 нь Төв аймагт, 29 нь Өмнөговь аймагт, 22 нь Говь-Алтай аймагт байршиж байна.

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоогоор уул уурхайн салбарын голлох нэр төрөл болох алт, нүүрсний илрэл бүхий орд газар ихтэй Баянхонгор, Төв, Увс, Улаанбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл зэрэг аймгууд тэргүүлж байна. Харин жонш, гянтболд зэрэг ашигт малтмалын илрэл бүхий орд газартай Зүүн бүсийн аймгууд доогуур байранд орж байна. Үүнээс харахад бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын төвлөрөл нь ашигт малтмалын төрлөөс шууд хамааралтай байна.

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 51.4 хувь 2016 онд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдсан байна. Бичил уурхай эрхлэгчдээс нийгэм, орон нутагт 22.1 хувь нь тодорхой хэмжээний оруулсан гэжээ.

Судалгаанд хамрагдсан 6948 бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 73.5 хувь нь алт, 10.9 хувь жонш, 10.5 хувь нь нүүрс, 2.5 хувь нь гянтболд, 0.7 хувь үнэт чулуу, 0.2 хувь нь шохойн чулуу, 0.1 хувь нь элс хайрга, үлдсэн хувь нь бусад төрлийн ашигт малтмал олборлож байна.

Алт олборлох үйл ажиллагаанд оролцогч нийт 5108 иргэний 71.5 хувь нь хувиараа/дангаараа алт олборлогч, 23.8 хувь нь нөхөрлөл/хоршооны ахлагч/гишүүн, үлдсэн 4.8 хувь нь гэр бүлийнхээ алт олборлолтын үйл ажиллагаанд оролцогч, бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч байна. Судалгаанд хамрагдсан алт олборлогчид 2016 онд нийт 212.0 кг алт олборлож, нэг граммыг дунджаар 68.1 мянган төгрөгөөр борлуулсан байна.

5.2.5.1 Хууль, эрх зүйн орчин

Бичил уурхайн үйл ажиллагааг Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-аар зохицуулж байна. Шинэчлэн батлагдсан журам нь бичил уурхайн албажуулалтын хүрээг тэлэхэд эерэг үр нөлөө үзүүлээд зогсохгүй журмын дагуу бичил уурхайчид хуулийн этгээдийн нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйл ажиллагаа явуулж татварын холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар төлдөг болсноор бичил уурхайгаас улс орны эдийн засагт оруулж буй хувь нэмрийг бодитойгоор тооцох боломж бүрдүүлнэ.

Энэхүү тогтоолд аймгуудын засаг захиргааны чадавхийг бэхжүүлэх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхээр заасан. Аймгийн засаг захиргаа нь сумын БУУ-н үйл ажиллагааны тайланг нэгтгэн АМГТГ-т хүргэхээр үүрэг болгосон. Мөн тогтоолд бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм (АМГ-ын даргын 2011 оны 153-р тушаал, Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм)-ийг дагаж мөрдөх, бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг тусгасан байна.

Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчинтой болсноор бичил уурхайн эрхлэгчид төрийн үйлчилгээ авах боломжтой болж, нөхөн сэргээлт хийдэг болсон байна. Мөн хүдэр баяжуулах цехээр олборлосон алтаа ялгуулдаг болсноор мөнгөн усны хэрэглээ буурсан байна.

АМГТГ-аас хүргүүлсэн БУУ эрхлэгчид, олборлосон ашигт малтмалын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 29-д харуулав.

5.2.5.2 Бичил уул уурхайн эдийн засагт оруулж буй хувь нэмэр

IRIMongolia судалгааны байгууллага нь бичил уурхайн эдийн засагт оруулж буй хувь нэмрийн талаар 2016-2017 оныг хамарсан “Орон нутгийн хөгжилд бичил уурхайгаас оруулж буй хөрөнгө оруулалт” суурь судалгаа хийсэн байна. Энэхүү судалгааны үр дүнд бичил уурхай эрхлэгчдийн зүгээс орон нутгийн эдийн засагт үзүүлж буй үржигдэх нөлөө нь 1,189 гэсэн үр дүн гарсан бөгөөд энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны тайлангаас харж болно.

5.2.5.3 Бичил уурхайн талаарх мэдээллийн тархац, эх сурвалж

Орон нутгийн иргэдэд бичил уурхайн танилцуулга мэдээллийг олон нийтийг хамарсан сайн дурын ажил болон хандивын аянаар дамжуулан түгээдэг. Харин бичил уурхай эрхлэгчдийн болон олборлолтын талаарх статистик мэдээллийг Монголын бичил уурхайн нэгдсэн Дээвэр холбоо, Тогтвортой бичил уурхайн төсөл болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас авах боломжтой.

Өнөөдрийн байдлаар Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоонд 15 аймгийн 45 суманд байрлах 79 гишүүн байгууллагын 429 нөхөрлөлийн 6,300 гаруй бичил уурхай эрхлэгчид бүртгэлтэй байна. Энэхүү холбооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг <http://bichiluurhai.mn/> сайтаас үзнэ үү.

Орон нутаг дахь гишүүн ТББ-уудын мэдээллийг Хавсралт 28-аас харна уу.

Үндэсний Статистикийн Хороо нь Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлагтай хамтран “Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны нэгдсэн тайлан 2016” буюу 2 дахь удаагийн судалгааг хийсэн. Монгол Улсын нутаг дэвсгэрт гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэд

болон тэдгээртэй хамааралтай бүхий л үйл ажиллагааг газар зүйн байршлаар нь тогтоож, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд тэдний оруулж буй хувь нэмрийг тодорхойлоход энэхүү судалгааны үр дүн хувь нэмэр оруулж байна. Үндэсний Статистикийн Хорооноос 2017 онд гаргасан “Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны нэгдсэн тайлан 2016”-г <http://sam.mn/бичил-уурхай-эрхлэгчдийн-судалгааны-нэгдсэн-тайлан-2016/> линк-ээр үзнэ үү.

Бичил уурхайн байршлийн талаарх мэдээллийг Тогтвортой бичил уурхай төсөл боловсруулж байгаа бөгөөд байршлыг тодорхой координатаар тэмдэглэх боломжгүй, зөвхөн бичил уурхай эрхлэгчдийн тооноос хамааруулан тодорхой нэг аймаг, сумд бичил уурхай эрхлэж байна гэсэн мэдээллийг тэмдэглэсэн газрын зургийг бэлтгэх боломжтой гэж төслийн зүгээс мэдэгдсэн.

5.2.5.4 Монголд хэрэгжиж буй Тогтвортой Бичил Уурхайн Төсөл

Тогтвортой бичил уурхай (ТБУ) төсөл нь Швейцарийн хөгжлийн агентлагын дэмжлэгтэйгээр 14 дэх жилдээ хэрэгжиж байна. Төслийн 4 дэх үе шат 2015-2018 оны хугацаанд үргэлжлэх юм.

Төслийн 4-р үе шатны зорилго нь эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хариуцлагатай, хүний эрхэд суурилсан Монгол Улсын бичил уурхайн салбарыг төлөвшүүлэх, бичил уурхайгаар олборлосон алтны худалдааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийлүүлэлтийн сүлжээг албажуулах, бичил уурхайн талаарх дэлхийн бусад орны сайн туршлагаас суралцах, өөрсдийн туршлагаас хуваалцахад дэмжлэг үзүүлэх явдал юм.

Европийн Холбоо 2021 оноос гарал үүсэл нь тодорхой болсон алт болон бусад гурван төрлийн ашигт малтмалыг худалдан авах тухай мэдэгдсэн. Мөн Монголбанкнаас алтны дотоодын худалдан авалтыг хийхдээ Худалдан авалтын гэрээ байгуулахыг шаардах бодлого баримтлахаар төлөвлөж байна.

Иймд БУУ-аар олборлосон ашигт малтмалыг гарал үүслийн бичигтэйгээр экспортлох шаардлагатай болж байгаа учир ТБУ төсөл нь бичил уурхайгаас бий болсон ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээ-гарал үүслийг сайжруулах, түүнийг тодорхой болгох зорилготойгоор ажиллаж байна. Энэхүү зорилгын хүрээнд Дархан, Баянхонгор аймагт сорьцийн хяналтын лабораторийг 2018 онд нээсэн байна.

Мөн төслийн хүрээнд бичил уурхайн олборлолтын талаарх мэдээллийг түгээх мобайл аппликейшн хийж байна.

5.2.5.5 Нөхөн сэргээлтийн байдал

2016 оны байдлаар нийтдээ 3701.7 га талбайг бичил уурхайн үйл ажиллагааны зориулалтаар ашиглаж байна. Бичил уурхайд ашиглаж буй газрын хэмжээ, эвдрэлд орсон газрын хэмжээ, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ, бүсээр

Хүснэгт 5.7

| Бүс | Ашиглаж байгаа талбайн хэмжээ, га | | Олборлолт явуулж эхэлснээс хойш эвдрэлд орсон талбайн хэмжээ, га | | Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ, га | |
|-------------|-----------------------------------|--------|--|--------|--|-------|
| | 2012 | 2016 | 2012 | 2016 | 2012 | 2016 |
| БҮГД | 8319.2 | 3701.7 | 8288.0 | 3228.4 | 594.3 | 382.8 |
| Баруун | 2871.3 | 499.5 | 4741.0 | 583.9 | 78.6 | 220.7 |
| Хангайн | 1584.8 | 924.7 | 808.8 | 886.0 | 146.9 | 55.2 |
| Төвийн | 2113.2 | 1276.3 | 1271.0 | 801.0 | 4.3 | 102.4 |
| Зүүн | 558.9 | 110.4 | 521.2 | 66.7 | 356.5 | 4.2 |
| Улаанбаатар | 1191.0 | 890.8 | 1000.0 | 890.8 | 8.0 | 0.3 |

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид ашигт малтмал олборлох хугацаанд нийт 3,228.4 га талбайг эвдрэлд оруулсан бөгөөд 583.9 га буюу 18.1 хувь нь Баруун бүсэд, 886.0 га буюу 27.4 хувь нь Хангайн бүсэд, 801.0 га буюу 24.8 хувь нь Төвийн бүсэд, 66.7 га буюу 2.1 хувь нь Зүүн бүсэд, 890.8 га буюу 27.6 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Нийт бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг бүсээр авч үзвэл, Төвийн бүсэд 102.4 га болж өмнөх судалгааны дүнгээс 98.1 гагаар, Баруун бүсэд 220.7 га болж 142.1 га-гаар нэмэгдсэн байна. Харин Улаанбаатар хотод 0.3 га болж 7.7 га-гаар, Хангайн бүсэд 55.2 га болж 91.7 га-гаар, Зүүн бүсэд 4.2 га болж 352.4 га-гаар тус тус буурсан байна. Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ нь олборлолт явуулж эхэлснээс хойш эвдрэлд орсон нийт талбайн 11.9 хувийг эзэлж байна.

5.2.6 Эрдэс баялагийн засаглал

Засаглал нь тухайн улсад эрх мэдлийг дамжуулан хэрэгжүүлдэг уламжлал, институцийн багц болох боломжтой гэдэг бөгөөд:

- Эрх мэдэлтнүүдийг сонгох, солих үйл явц
 - Дуу хоолой бөгөөд хариуцлага тооцолт
 - Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл, терроризмаас ангид байх
- Засгийн газрын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чадавх
 - Засгийн газрын үр дүнтэй ажиллагаа
 - Хяналтын чанар
- Хоорондын харилцааг нь зохицуулагч институцэд иргэд болон төрийн зүгээс хүндэтгэлтэй хандах байдал
 - Хуулийн засаглал
 - Авилгын хяналт

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс гаргасан судалгаагаар Монгол Улс хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг импортод зарцуулж буй бөгөөд үндсэндээ энэ хөрөнгө уул уурхай болон барилгын салбарт шингэж байна.

Манай улстай адил эрдэс баялгийн асар их нөөцтэй орнуудад дэлхийн зах зээл дээрх эрдсийн үнэ өсөхөд хөрөнгө оруулалтын урсгал нэмэгддэг ч, нүүрс, зэсийн үнэ буурахад хөрөнгө оруулалтын түвшин ч мөн адил буурдаг байна. Баялгийн нөөц ихтэй орнуудад хөрөнгө оруулалт татах, түүнийг зөв ашиглах боломж байгаа ч улс төрийн тогтвортой байдал хамгийн чухал гэдгийг судлаачид тодотгодог.

2017 он манай улсын хувьд эдийн засагт үүссэн хүндрэлийг арилгаж, төсвийн хариуцлагыг дээшлүүлэн, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээсэн жил байсан. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлт хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 3.8 хувьд хүрчээ. Уул уурхайн салбараас улсын төсөвт 1.8 их наяд төгрөгийн орлого оруулдаг 2017 онд 671 сая ам.доллар бүхий уул уурхайн бус салбарын экспорт хийсэн байна. Уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлыг арилгахаар 2018 онд уул уурхайн бус салбарын экспортын эзлэх хувийг нийт экспортын хэмжээнд 20 хувь, 2021 онд 30 хувьд хүргэх зорилтыг төр засгаас дэвшүүлжээ.

Тиймээс улсын эдийн засагт экспортын төрөлжилт шаардлагатай гэдгийг эрдэмтэд, салбарын мэргэжилтнүүд онцолж байна. Уул уурхайгаас бусад ноос, ноолуур болон арьс, шир гэсэн салбаруудад л харьцангуй давуу тал байгаа ч харамсалтай нь сүүлийн жилүүдэд эдгээр салбарын бүтээгдэхүүний экспортод үзүүлэх хувь хэмжээ буурч байгаа аж.

Экспортын хэмжээ анх удаа буюу 2017 оны үзүүлэлтээр зургаан тэрбум ам.долларыг давж, гадаад худалдааны тэнцэл 1.9 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.2 тэрбум ам.доллар, алтны худалдан авалт 20 тоннд хүрч, хандивлагч орон, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр төлбөрийн тэнцэл нэг тэрбум гаруй ам.долларын ашигтай гарсан нь эдийн засагт эерэг дохио өгч улмаар улсын гадаад валютын нөөц гурван тэрбум ам.долларт хүрчээ.

5.2.7 Ашигт малтмалын лиценз

Тайлант оны жилийн эцсийн байдлаарх ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ, аймаг, нийслэлээр ангилан дараах хүснэгтээр харуулав.


Хүснэгт 5.8

| № | Аймаг, нийслэл | Бүгд | | | Үүнээс: | | | | | |
|----|----------------|---------------|-----------------|--------------------|---------------|-----------------|--------------------|---------------|-----------------|--------------------|
| | | | | | Ашиглалт | | | Хайгуул | | |
| | | Лицензийн тоо | Талбай /мян.га/ | Талбайн эзлэх хувь | Лицензийн тоо | Талбай /мян.га/ | Талбайн эзлэх хувь | Лицензийн тоо | Талбай /мян.га/ | Талбайн эзлэх хувь |
| 1 | Архангай | 37 | 31.9 | 0.6 | 26 | 12.6 | 0.23 | 11 | 19.4 | 0.35 |
| 2 | Баян-Өлгий | 76 | 251.7 | 5.5 | 25 | 10.6 | 0.23 | 51 | 241.1 | 5.27 |
| 3 | Баян-Хонгор | 178 | 485 | 4.2 | 84 | 58.5 | 0.51 | 94 | 426.5 | 3.69 |
| 4 | Булган | 123 | 243.3 | 5 | 67 | 34.3 | 0.7 | 56 | 209 | 4.29 |
| 5 | Өвөрхангай | 52 | 118.1 | 1.9 | 29 | 15.8 | 0.25 | 23 | 102.3 | 1.63 |
| 6 | Говь-Алтай | 184 | 970.1 | 6.8 | 47 | 67.5 | 0.48 | 137 | 902.6 | 6.36 |
| 7 | Говьсүмбэр | 17 | 58.7 | 10.6 | 12 | 38.7 | 6.99 | 5 | 20 | 3.6 |
| 8 | Дархан-Уул | 82 | 20.7 | 6.3 | 67 | 6.3 | 2.85 | 15 | 11.4 | 3.49 |
| 9 | Дорноговь | 419 | 1773.5 | 16.2 | 170 | 213.8 | 1.95 | 249 | 1,559.7 | 14.26 |
| 10 | Дорнод | 184 | 596.4 | 4.8 | 69 | 57.2 | 0.46 | 115 | 539.2 | 4.37 |
| 11 | Дундговь | 231 | 979.5 | 13.1 | 95 | 156.1 | 2.09 | 136 | 823.3 | 11.03 |
| 12 | Завхан | 90 | 566.9 | 6.9 | 8 | 13.8 | 0.17 | 82 | 553.1 | 6.7 |
| 13 | Өмнөговь | 228 | 1656 | 10 | 98 | 532.7 | 3.22 | 130 | 1,123.3 | 6.8 |
| 14 | Орхон | 9 | 11 | 13.1 | 9 | 11 | 13.12 | 0 | 0 | 0 |
| 15 | Сүхбаатар | 112 | 514.5 | 6.2 | 61 | 49.9 | 0.61 | 51 | 464.5 | 5.64 |
| 16 | Сэлэнгэ | 199 | 126.9 | 3.1 | 141 | 37.4 | 0.9 | 58 | 89.4 | 2.16 |
| 17 | Төв | 460 | 534 | 7.2 | 305 | 143.2 | 1.94 | 155 | 390.8 | 5.28 |
| 18 | Увс | 181 | 685.6 | 9.9 | 42 | 17.3 | 0.25 | 139 | 668.3 | 9.6 |
| 19 | Улаанбаатар | 185 | 14.1 | 3 | 169 | 12.5 | 2.64 | 16 | 1.6 | 0.34 |
| 20 | Хөвсгөл | 31 | 94.3 | 0.9 | 20 | 10.8 | 0.11 | 11 | 83.5 | 0.83 |
| 21 | Ховд | 132 | 417 | 5.5 | 32 | 13.4 | 0.18 | 100 | 403.6 | 5.31 |
| 22 | Хэнтий | 262 | 549.2 | 6.8 | 107 | 40.7 | 0.5 | 155 | 508.5 | 6.3 |
| | Улсын хэмжээнд | 3,369 | 10,698.3 | 6.8 | 1,624 | 1,557.2 | 0.99 | 1,745 | 9,141.13 | 5.82 |

Эх сурвалж: 2017 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 18, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар


Жич: Зарим тусгай зөвшөөрлийн талбай нь нэгээс дээш аймгийн хилийг дамнасан байгаа тул аймаг тус бүрийн тоо дээр нэмэгдэж байгаа болно.

Хайгуулын болон ашиглалтын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлүүдийн тоо, сүүлийн 10 жилээр



Эх сурвалж: 2017 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 19, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн ашигт малтмалын төрлөөрх бүтэц



Эх сурвалж: 2017 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 20, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

5.2.7.1 Ашигт малтмалын тухай хуулинд тусгагдсан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эрх, үүргийн зохицуулалтууд

Ашигт малтмалын тухай хуулинд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой дараах онцлох зохицуулалтууд орсон байдаг. Үүнд:

Хүснэгт 5.9

| Хуулийн заалтын дугаар | Эрх, үүрэг бүхий талууд | Ашигт малтмалын тухай хуулиар олгогдсон эрх, үүрэг |
|------------------------|---|--|
| 8.1.5. | Улсын Их Хурал | Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачлагаар тодорхой нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг, эсхүл хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хязгаарлах буюу хориглох |
| 9.1.11. | Засгийн газар | Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хайгуулын болон энэ хуулийн 24.1-т зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх |
| 11.1.13. | Төрийн захиргааны байгууллага, Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар томилогдсон Сонгон шалгаруулалтын комисс | Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох, дүгнэлт гаргах |
| 11.1.16. | Төрийн захиргааны байгууллага | Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг өргөдлийг хүлээн авч бүртгэх |
| 11.1.19. | Төрийн захиргааны байгууллага | Түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох |
| 11.1.25. | Төрийн захиргааны байгууллага | энэ хуулийн дагуу ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалтын талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах |
| 20.1. | Төрийн захиргааны байгууллага | Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 10.1.2-д заасан журмын дагуу зохион байгуулах |
| 26.1 | Төрийн захиргааны байгууллага, АМГТГ | Энэ хуулийн 25.1-д заасан өргөдлийг хүлээн авч, хянан, шийдвэрлэх |

Эх сурвалж: Ашигт малтмалын тухай хуулийн 2018.06.21-ний өдрийн шинэчилсэн найруулга

5.2.7.2 Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд орсон өөрчлөлт, 2018 он

Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн УУХҮЯ-ны сайдын А/28 дугаар тушаалаар өөрчлөн, баталсан. Шинэчилсэн найруулгад дараах онцлох өөрчлөлтүүд орсон. Үүнд:

Хүснэгт 5.10

| Өмнөх заалт | Нэмэлт өөрчлөлт |
|--|-----------------------------|
| Орон нутгийн тусгай хэрэгцээний газартай эсхүл хууль бус олборлолтод өртсөн талбайтай сонгон шалгаруулалтын талбай нь давхцаж байвал тухайн газарт тусгай зөвшөөрлийг олгох хязгаарлагдмал сонгон шалгаруулалтад оролцох эрхийг орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд олгоно (2017 оны шинэчлэн найруулсан журмын 1.6 дугаар заалт) | Заалтыг хүчингүй болгосон |
| Сонгон шалгаруулалтын комиссын саналын эрхтэй гишүүдийн 70 ба түүнээс дээш хувийн ирцтэйгээр сонгон шалгаруулалт хүчин төгөлдөр болно | 80% болгон өөрчилсөн. |
| Техникийн саналыг 10 (арав) өдөрт багтаан үнэлж, дүгнэлт гаргах | 5 өдөр болгож өөрчилсөн. |
| Комиссын нэгдсэн дүгнэлтийг Төрийн захиргааны байгууллагын даргад ажлын 2 өдөрт багтаан хүргүүлэх | 1 өдөр болгож өөрчилсөн. |
| Төрийн захиргааны байгууллагын дарга Комиссын нэгдсэн дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан холбогдох тушаал гаргах | 2 өдөр болгож өөрчилсөн. |
| Сонгон шалгаруулалтын журмаар олгогдсон тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг төрийн захиргааны байгууллагын цахим хуудас дээр нийтэд мэдээлнэ | Өдөр тутмын сонинд нийтэлнэ |

- Сонгон шалгаруулалтыг тасралтгүй зохион явуулах, ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс 3 (гурав) хүртэл тооны сонгон шалгаруулалтын комиссыг томилж болох бөгөөд комиссын бүрэлдэхүүний 2/3-ийг хагас жил тутамд өөрчилж болно гэсэн заалтыг нэмж оруулсан.
- Техникийн саналд өгөх шалгуур үзүүлэлтүүдийг өмнөх журамд зааснаас илүү нарийвчлалтай, тодорхой зааж өгсөн.
 - Техникийн саналыг 10 (арав) өдөрт багтаан үнэлж, дүгнэлт гаргах заалтыг 5 өдөр болгож, Комиссын нэгдсэн дүгнэлтийг Төрийн захиргааны байгууллагын даргад ажлын 2 өдөрт багтаан хүргүүлэх заалтыг 1 өдөр болгож, Төрийн захиргааны байгууллагын дарга Комиссын нэгдсэн дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан холбогдох тушаал гаргах заалтыг 2 өдөр болгон хугацааг богиносгосон байна.
 - “Сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн техникийн болон үнийн саналууд, тэдгээрийг хэрхэн үнэлсэн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” “Төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон талбайн солбицлыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад

хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтууд оруулснаар сонгон, шалгаруулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулсан байна.

- 2018 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтын журмаар олгодог болсон. (Эх сурвалж: Монгол улсын Их хурлын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт буюу тус хуулийн 7.1 дүгээр заалт) Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь 2017 оны хувьд ямар байсан талаар дараагийн хэсгүүдээс харна уу.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь 2017 онд өмнөх оныхтой ижил байсан.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Хүснэгт 5.11

| Үе шат | Төрийн захиргааны байгууллага | Үйл явц |
|--------|-------------------------------|--|
| 1 | АМГТГ | Өргөдөл гаргахаар бүртгүүлсэн этгээдэд дугаар олгож, өргөдөл хүлээн авна. |
| 2 | АМГТГ-ын Кадастрын хэлтэс | Хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, боломжтой эсэхийг тогтооно. |
| 3 | Орон нутгийн засаг захиргаа | Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг аймгийн эсвэл хотын захиргаа руу 30 хоногийн дотор хариу авахаар хүргүүлэх бөгөөд хэрэв энэ хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд АМГ тухайн орон нутгийн засаг захиргааг уг саналыг зөвшөөрсөн гэж үзнэ. |
| 4 | АМГТГ | Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг зөвшөөрөл хүсэгч ажлын 10 өдөрт багтаан төлнө. |
| 5 | АМГТГ-ын Кадастрын хэлтэс | АМГ нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгох бөгөөд дараа нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 удаа тус бүр 3 жилийн хугацаатай сунгаж болно. |

Эх сурвалж: АМГТГ

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөл болгож өөрчлөх үйл явц

Өөрийн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг байршилд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргагч нь бусад өргөдөл гаргагч талуудаас давуу эрхтэй байдаг.

Хүснэгт 5.12

| Үе шат | Төрийн захиргааны байгууллага | Үйл явц |
|--------|--|--|
| 1 | АМГТГ | Хүсэлт хүлээн авна. |
| 2 | АМГТГ-ын Хуулийн хэлтэс | Хуулиар хориглосон зүйлс байгаа эсэх эсвэл барагдуулаагүй төлбөр байгаа эсэхийг тодорхойлно. |
| 3 | АМГТГ-ын Кадастрын хэлтэс | Кадастрын системд хайгуулын тусгай зөвшөөрөл нь бүртгэгдсэн эсэхийг шалгана. |
| 4 | АМГТГ-ын Кадастрын хэлтэс | Ашиглалтын талбай нь бусад тусгай зөвшөөрлийн газар, усны нөөц, улсын тусгай хэрэгцээний газар болон нөөцөд авсан талбай зэрэг газруудтай давхацсан эсэхийг шалгана. |
| 5 | АМГТГ-ын Уул Уурхайн болон Нүүрсний хэлтэс | Хүсэлт гаргагч нь олборлолтоос үүсч болох экологийн хохирлыг нөхөн сэргээх боломжтой эсэхийг шалгана. |
| 6 | АМГТГ-ын Хуулийн хэлтэс | Хүсэлт гаргагч нь Кадастрын хэлтсийн даргын гаргасан төлөвлөгөө болон бусад хууль дүрэм журмуудыг дагаж мөрдөж буй эсэхийг шалгана. |
| 7 | АМГТГ-ын Кадастрын хэлтэс | Координатаар тогтоосон талбайн зургийг зөвшөөрөх: АМГ нь өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан зохих шийдвэр гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Хэрэв зөвшөөрөл олгохоос татгалзсан бол шалтгаан, |

| Үе шат | Төрийн захиргааны байгууллага | Үйл явц |
|--------|-------------------------------|--|
| | | хуулийн үндэслэлийг дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ. |
| 8 | АМГТГ | Мэдэгдэл авсан өдрөөс хойш 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлнө. |
| 9 | АМГТГ-ын Кадастрын хэлтэс | Эхний жилийн төлбөрийг хуулийн дагуу хийснээс хойш ажлын 3 өдөрт багтаан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгох бөгөөд дараа нь ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2 удаа тус бүр 20 жилийн хугацаатай сунгаж болно. |

Эх сурвалж: АМГТГ

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулах замаар олгох үйл явц

Дараах шалгууруудын аль нэгийг хангасан тохиолдолд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг нийтэд нээлттэй болгож сонгон шалгаруулах замаар олгоно. Үүнд:

- Хайгуулын ажил хийсэн аж ахуйн нэгж нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаагүй;
- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн талбайд;
- Зохих хууль журмыг эсвэл шүүхийн шийдвэрийг зөрчсөнөөс үүдэн ашиглалтын тусгай зөвшөөрлийг буцаан авсан;
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан.

Хүснэгт 5.13

| Үе шат | Төрийн захиргааны байгууллага | Үйл явц |
|--------|------------------------------------|--|
| 1 | АМГТГ | Сонгон шалгаруулах үйл явцыг эхлүүлж захирамж гаргана. |
| 2 | АМГТГ | Олон нийтэд сонгон шалгаруулалтыг зарлана. |
| 3 | АМГТГ | Сонгон шалгаруулалтын саналыг авна. Сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ. |
| 4 | АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс | Сонгон шалгаруулалтын саналыг нээнэ. |
| 5 | АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс | Сонгон шалгаруулалтад оролцогчдыг ирүүлсэн баримтуудад үндэслэн үнэлнэ. |
| 6 | АМГТГ-ын сонгон шалгаруулах комисс | Сонгон шалгаруулалтад ирүүлсэн үнийн саналыг нээнэ. |
| 7 | АМГТГ | Сонгон шалгаруулалтын саналд үнэлээ хийж дууссанаас хойш 5 хоногийн дотор ялагчийг зарлана. |
| 8 | АМГТГ | Шалгарсан оролцогчид сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг 10 хоногт багтаан төлөх тухай мэдэгдэл өгнө. Бусад оролцогч нарт шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг өгнө. |
| 9 | АМГТГ-ын Кадастрын хэлтэс | АМГТГ-ын даргын болон сонгон шалгаруулах комиссын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийг олгоно. |

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газрын сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох журам

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үйл явц

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг дараах нөхцөлд аж ахуйн нэгжийн хооронд бүрэн буюу хэсэгчлэн шилжүүлж болно. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нэгдэх, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шинээр бий болсон аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.
- Хараат, охин компани нь толгой компанидаа тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.

- Аж ахуйн нэгж эрэл, хайгуулын талаарх анхдагч материал, тайлан зэрэг мэдээллийг худалдан авч, зохих албан татварыг төлсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.
- Аж ахуйн нэгж нь уурхайг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, баримт бичгийн хамт худалдан авч зохих татварыг төлсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.

Хүснэгт 5.14

| Үе шат | Төрийн захиргааны байгууллага | Үйл явц |
|--------|---|---|
| 1 | АМГТГ-ын Кадастрын хэлтэс | Холбогдох бичиг баримтуудыг хүлээн авна. |
| 2 | АМГТГ-ын Кадастрын болон Хуулийн хэлтэс | Бичиг баримтууд болон бусад мэдээллүүдэд шалгалт хийнэ. |
| 3 | АМГТГ-ын Кадастрын хэлтэс | Шалгах ажиллагаа дууссаны дараа 5 хоногт багтаан шийдвэр гаргана. |

Эх сурвалж: АМГТГ

Лиценз олгоход ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд (шаардлага 2.2.а.и)

2017 онд лиценз олгоход ашигласан техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэд харуулав. Үүнд:

Хүснэгт 5.15

| № | Шалгуур үзүүлэлтүүд | Өгөх оноо | Нийт онооны хязгаар |
|--|---|-----------|---------------------|
| Техникийн үнэлгээ | | | |
| 1 | Геологи хайгуулын ажил явуулах төслийн баримт бичгийн үнэлгээ | | 30 |
| | Геологи хайгуулын ажлын талаар | 1-10 | |
| | Ажлын аргачлал оновчтой, өмнөх судалгааны материалыг бүрэн судалсан (10) | | |
| | Ажлын аргачлал оновчтой, өмнөх судалгааны материалыг бүрэн бүрэн судлаагүй (5) | | |
| | Ажлын аргачлал оновчгүй, өмнөх судалгааны материалыг бүрэн судлаагүй (1) | | |
| | Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн төлөвлөлт, ажлын нэр төрөл, түүнд зарцуулах зардал, хэрэгжүүлэх хугацааг харгалзан: | 0-5 | |
| | Бүрэн хангалттай (5) | | |
| | Хангалттай (3) | | |
| | Хангалтгүй (0) | | |
| | Ажиллах хүчийг харгалзан: Төсөлд ажиллуулахаар төлөвлөсөн монгол ажилчдын тоо, нийт ажилчдын тоонд тэдгээрийн эзлэх хувь хэмжээ | 3-5 | |
| | 90%-иас дээш монгол ажилчидтай (5) | | |
| | 90% буюу түүнээс доош монгол ажилчидтай(3) | | |
| | Орон нутгийн удирдлагатай хамтран ажилласан байдлыг харгалзан (үйл ажиллагааны төрөл болон төлөвлөсөн зардал) | 3-5 | |
| | Байгаль орчны хамгаалал,ажлын байр, ашигт малтмалын үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн барилга байгууламжтай холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д заасан хэмжээнээс илүү үйл ажиллагаа явуулсан (5) | | |
| Байгаль орчны хамгаалал,ажлын байр, ашигт малтмалын үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн барилга байгууламжтай холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д заасан хэмжээг хангасан үйл ажиллагаа явуулсан (3) | | | |
| Хайгуул, үйлдвэрлэл, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд дэвшилтэт технологи болон аргачлалыг ашиглаж буйг харгалзан: | 0-5 | | |

| № | Шалгуур үзүүлэлтүүд | Өгөх оноо | Нийт онооны хязгаар |
|---------------------------|---|-----------|---------------------|
| | Дэвшилтэт технологи болон аргачлалыг ашигладаг (5) | | |
| | Дэвшилтэт технологи болон аргачлалыг ашигладаггүй (5) | | |
| | Геологи хайгуулын ажлын туршлага | | 10 |
| 2 | Монголын геологи хайгуул, уул уурхайн салбарт 5-аас дээш жилийн туршлагатай | 10 | |
| | Монголын геологи хайгуул, уул уурхайн салбарт 5-аас доош жилийн ажилласан туршлагатай хэдий ч бусад салбарт 10-аас доошгүй жилийн туршлагатай | 7 | |
| | Шинээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж (тухайн онд байгуулагдсан) | 3 | |
| 3 | Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал, туршлага, чадвар | | 10 |
| | Тус компани нь монгол зөвлөх болон мэргэжсэн геологичидтой. | 10 | |
| | Геологич мэргэжлийн үндсэн ажилтантай. | 7 | |
| | Гэрээгээр геологич ажиллуулдаг. | 5 | |
| | Геологич мэргэжлийн үндсэн ажилтан болон гэрээт геологич байхгүй. | 3 | |
| 4 | Техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал | | 5 |
| | Тус компани нь геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өөрийн өрөм, геофизикийн багажтай. | 5 | |
| | Тус компани нь геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрөм, геофизикийн багажны 50-иас доошгүй хувийг түрээсэлдэг. | 3 | |
| | Тус компани нь геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрөм, геофизикийн багажаа бүгдийг нь түрээсэлдэг. | 1 | |
| | Нийт техникийн оноо | | 55 |
| Санхүүгийн үнэлгээ | | | |
| | Үнийн саналын үнэлгээ | | 45 |
| | Үнийн саналын доод хэмжээнээс бага, үсгээр эсвэл тоогоор бичсэн тоо хэмжээ зөрүүтэй байдал | 0 | |
| 5 | Хамгийн өндөр үнийн санал | 45 | |
| | Бусад үнийн саналуудыг дараах томъёог ашиглан бодох ба гарсан дүн аравтын бутархайтай байна. | 45 хүртэл | |
| | | | |
| | $\frac{S_{\text{оролцогчийн үнийн санал}}}{S_{\text{хамгийн өндөр үнийн санал}}} \times 45$ | | |
| | Нийт санхүүгийн оноо | | 45 |
| Нийт оноо | | | 100 |

Дээрх шалгуур үзүүлэлтүүдийг 2018 оны 2 дугаар сарын 13-нд өөрчлөн баталсан ба шинэчилсэн шалгуур үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5.16

| № | Шалгуур үзүүлэлт | Жишиг | Онооны хязгаар | Нийт онооны хязгаар |
|---------------------------------------|--|-------|----------------|---------------------|
| | | оноо | | |
| Төслийн баримт бичгийн үнэлгээ | | | | 25 |
| 1 | Геологи хайгуулын ажлын талаар | | 0-15 | |
| | Арга, аргачлал, төлөвлөлт оновчтой, дэвшилтэт аргачлал, техник технологийн шийдэл бүхий, өмнөх судалгааны материалыг бүрэн судалсан | 13-15 | | |
| | Арга, аргачлал, төлөвлөлт оновчтой, дэвшилтэт аргачлал, техник технологийн шийдэл бүхий, өмнөх судалгааны материалыг бүрэн судлаагүй | 10-12 | | |
| | Арга, аргачлал, төлөвлөлт оновчтой, өмнөх судалгааны материалыг бүрэн судалсан | 7-9 | | |

| № | Шалгуур үзүүлэлт | Жишиг | Онооны хязгаар | Нийт онооны хязгаар |
|------------------|---|-------|----------------|---------------------|
| | | оноо | | |
| | <i>Арга, аргачлал, төлөвлөлт оновчгүй, дэвшилтэт аргачлал, техник технологийн шийдэл бүхий, өмнөх судалгааны материалыг бүрэн судлаагүй</i> | 4-6 | | |
| | <i>Арга, аргачлал, төлөвлөлтгүй, дэвшилтэт аргачлал, техник технологийн шийдлийг үйл ажиллагаандаа тусгаагүй, өмнөх судалгааны материалыг бүрэн судлаагүй</i> | 1-3 | | |
| | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөлт, ажлын нэр төрөл, түүнд зарцуулах зардлын хэмжээ, хэрэгжүүлэх хугацааг харгалзан | | 0-6 | |
| | <i>Бүрэн хангалттай</i> | 6 | | |
| | <i>Хангалттай</i> | 3 | | |
| | <i>Хангалтгүй</i> | 0 | | |
| | Орон нутгийг хөгжүүлэх, хамтран ажиллах төлөвлөгөө | | 0-4 | |
| | <i>Энэхүү журмын 3.3.2.8 дугаар заалтыг хангасан</i> | 4 | | |
| | <i>Энэхүү журмын 3.3.2.8 дугаар заалтыг хангаагүй</i> | 0 | | |
| 2 | Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал болон тэдгээрийн туршлага чадвар | | | 11 |
| | <i>Төсөлд ажиллах Монгол ажилтнуудын эзлэх хувь 100% бол</i> | 3 | 1-3 | |
| | <i>Төсөлд ажиллах Монгол ажилтнуудын эзлэх хувь 90%-аас дээш бол</i> | 2 | | |
| | <i>Төсөлд ажиллах Монгол ажилтнуудын эзлэх хувь 90% буюу түүнээс доош бол</i> | 1 | | |
| | <i>Төсөлд МУ-ын зөвлөх геологич ажиллах бол</i> | 3 | 0-3 | |
| | <i>Төсөлд МУ-ын мэргэшсэн геологич ажиллах бол</i> | 2 | | |
| | <i>Төсөлд МУ-ын зөвлөх болон мэргэшсэн геологич аль аль нь байхгүй бол</i> | 1 | | |
| | <i>Төсөлд оролцох ИТАжилтан болон Геологичид нь 100 хувь үндсэн ажилтантай бол</i> | 5 | 1-5 | |
| | <i>Төсөлд оролцох ИТАжилтан болон Геологичид нь үндсэнболон гэрээт ажилчдаас бүрдэх бол</i> | 3-4 | | |
| | <i>Төсөлд оролцох ИТАжилтан болон Геологичид нь 100 хувь гэрээт ажилтантай бол</i> | 2 | | |
| | <i>Төсөлд ямар нэг тодорхой ИТАжилтан болон геологич тусгаадаагүй бол</i> | 1 | | |
| 3 | Геологи, хайгуулын ажлын болон үйл ажиллагааны туршлага | | | 10 |
| | <i>Геологи, хайгуулын салбарт 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан бол</i> | 4 | 1-4 | |
| | <i>Геологи, хайгуулын 5-10-н жил үйл ажиллагаа явуулсан бол</i> | 2-3 | | |
| | <i>Геологи, хайгуулын салбарт 5 хүртэл жил үйл ажиллагаа явуулсан бол</i> | 1 | | |
| | <i>Бусад салбарт 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан бол</i> | 2 | 1-2 | |
| | <i>Бусад салбарт 5 хүртэл жил үйл ажиллагаа явуулсан бол</i> | 1 | | |
| | <i>Геологи хайгуулын төсөл, үйл ажиллагааг бие даан явуулсан, хангалттай баялаг туршлагатай</i> | 3-4 | 1-4 | |
| | <i>Геологи хайгуулын төсөл, үйл ажиллагаа явуулсан болон туслан гүйцэтгэгчээр оролцож байсан</i> | 1-2 | | |
| 4 | Төсөлд ажиллах техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал | | | 9 |
| | <i>Төсөл хэрэгжүүлэгч ААН геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өөрийн эзэмшлийн өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан бол</i> | 7-9 | 1-9 | |
| | <i>Төсөл хэрэгжүүлэгч ААН геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжийн 50-аас дээшгүй хувийг түрээсэлдэг бол</i> | 4-6 | | |
| | <i>Төсөл хэрэгжүүлэгч ААН геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжийг бүгдийг түрээсэлдэг бол</i> | 1-3 | | |
| НИЙТ ОНОО | | | | 55 |

5.2.7.3 Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Монгол улсын Цөмийн энергийн тухай хуулиар энэ үйл ажиллагаа нь зохицуулагддаг ба тус хуулийн 18 дугаар зүйл “Тусгай зөвшөөрөл олгох журам”-аар нарийвчлан зохицуулагддаг ба дараах үе шатаар явагддаг. Үүнд:

Хүснэгт 5.17

| Үе шат | Төрийн захиргааны байгууллага | Үйл явц |
|--------|--|--|
| 1 | Цөмийн энергийн комисс | Санал гаргана |
| 2 | Тагнуулын төв байгууллага | Санал гаргана |
| 3 | Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага | Санал гаргана |
| 4 | АМГТГ | Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу өргөдөл гаргахад бүрдүүлэх баримт бичгүүдийг шалгаж, тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага хангасан эсэхийг тодорхойлно. |
| 5 | АМГТГ | Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хувьд 1-3 сарын дотор, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хувьд 6-12 сарын дотор тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг шийдвэрлэнэ. |
| 6 | АМГТГ | Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө. |
| 7 | АМГТГ | Шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгүүлнэ. |

Эх сурвалж: Цөмийн энергийн тухай хууль

Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага

- Техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан байх;
- Бүс нутгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаачлагатай оролцдог байх;
- Компанийн засаглал болон нийгмийн хариуцлага, ёс зүйн талаархи дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн байх;
- Үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх;
- Ажиллагсдын сургалт, дадлагын асуудлыг шийдэж ирсэн туршлагатай байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх санхүүгийн чадавхитай байх;
- Байгаль орчны болон биологийн нөхөн сэргээлт хийх санхүүгийн чадавхитай байх;
- Хариуцлагатай уул уурхайг хөтлөн явуулдаг, энэ талаар зохих туршлага хуримтлуулсан байх;
- Уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, шаардлагыг хангаж ажилладаг байх.

Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага

- Дээр дурдсан хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах бүх шаардлагуулыг хангах;
- Цацраг идэвхт ашигт малтмалыг энхийн зорилгоор, дэлхийн зах зээлийн үнэд хүргэж борлуулах чадвартай, санхүүгийн хувьд бүрэн бие даасан байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын боловсруулалт, борлуулалтаар дэлхийн зах зээлд тогтвортой, тэргүүлэх байр суурь эзэлсэн байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт хийх санхүүгийн чадавхитай байх;

- Цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах олон жилийн туршлагатай байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн ашиглах тэргүүний технологитой байх;
- Цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах, ашиглахдаа эдийн засгийн илүү үр ашигтай, дэвшилтэт технологи ашигладаг байх;
- Цөмийн технологи нэвтрүүлэх чадвартай байх.

5.2.7.4 Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь Монгол улсын Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиар зохицуулагддаг. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь дараах үе шатаар явагддаг. Үүнд:

Хүснэгт 5.18

| Үе шат | Төрийн захиргааны байгууллага | Үйл явц |
|--------|-------------------------------|---|
| 1 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Өргөдлийг бүртгэж, хүлээн авна. |
| 2 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуульд заасан зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага, өргөдлийн материалын иж бүрдлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд бүртгэсэн даруйд нь анхан шатны шүүлт хийж, шаардлагыг хангаагүй бол өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, татгалзсан шалтгаан, үндэслэлийг дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэнэ. |
| 3 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Өргөдөлд дурдсан талбай нь ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон, түрүүлж ирүүлсэн өргөдөлд дурдсан талбайтай давхцаж байгаа эсэхийг тогтоолгох өргөдлийг холбогдох материалын хамт төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ. |
| 4 | Төрийн захиргааны байгууллага | Өргөдөлд дурдсан талбай, холбогдох баримтуудыг шалган үзээд, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой, эсхүл боломжгүй талаар мэдэгдэнэ. |
| 5 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Хэрэв төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл олгох боломжгүй талаар хариу ирвэл өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэнэ. |
| 6 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Хэрэв төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл олгох боломжтой талаар хариу ирвэл тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч ажлын 10 өдрийн дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох, эсэх асуудлыг шийдвэрлэнэ. |
| 7 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Хэрэв тусгай зөвшөөрөл олгогдохоор шийдэгдвэл тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлөх тухай өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ. |
| 8 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Хэрэв тусгай зөвшөөрөл олгогдохоор шийдвэр гарснаас хойш өргөдөл гаргасан этгээд нэг сарын дотор тусгай зөвшөөрлийг аваагүй, эсхүл эхний жилийн төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлөөгүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга өргөдлийг бүртгэлээс хасаж өргөдөл гаргасан этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэнэ. |
| 9 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Хэрэв өргөдөл гаргасан этгээд эхний жилийн төлбөрийг хуульд заасан хугацаанд төлсөн бол ажлын таван өдөрт багтаан түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгоно. |
| 10 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, тухайн хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай байрших аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага, мэргэжлийн |

| Үе шат | Төрийн захиргааны байгууллага | Үйл явц |
|--------|-------------------------------|--|
| | | хяналтын байгууллагад түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон тухай мэдэгдэнэ. |
| 11 | Төрийн захиргааны байгууллага | Хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ. |

Эх сурвалж: Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах эрхтэй байдаг. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь дараах үе шатаар явагддаг. Үүнд:

Хүснэгт 5.19

| Үе шат | Төрийн захиргааны байгууллага | Үйл явц |
|--------|-------------------------------|---|
| 1 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Өргөдлийг бүртгэж, хүлээн авна. |
| 2 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудас тус бүрд бүртгэлийн он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгнө. |
| 3 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Өргөдөл бүртгэсэн даруйд өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд анхан шатны шүүлт хийнэ. |
| 4 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь хуульд заасан шаардлагыг хангаагүй бол өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, татгалзсан шалтгаан, үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэнэ. |
| 5 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлөөр олгогдсон талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан бол өргөдөл гаргасан талбай нь хайгуулын талбайн хилийн дотор бүрэн багтаж байгаа эсэхийг тодруулна. |
| 6 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Өргөдөл гаргасан талбай нь тусгай хэрэгцээ болон нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайтай ямар нэгэн байдлаар давхцаж байгаа эсэхийг тодруулна. |
| 7 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Хайгуулаар тогтоогдсон ашигт малтмалын нөөцийн хэмжээ, үнэлгээ нь олборлолтоос үүсч болох байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн сэргээхэд хүрэлцэх эсэхийг тодруулна. |
| 8 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 15 өдөрт багтаан доор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. |
| 9 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан бол онцгой эрхийнх нь дагуу уурхайн талбай олгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуульд заасан хугацаанд төлүүлнэ. |
| 10 | Аймаг, нийслэлийн Засаг дарга | Өргөдөлд дурдсан талбай нь ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайн аль нэг хэсэгтэй давхцсан бол ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, татгалзсан шалтгаан үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, энэ тухай өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэнэ. |

Эх сурвалж: Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль

5.2.7.5 Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг шалгасан байдал

Монголын “Нээлттэй нийгэм форум”-ын хүсэлтэнд дурдагдсан 4 тусгай зөвшөөрөл болон бидний шалгалтын түүвэрт багтсан ашиглалтын болон хайгуулын 65 тусгай зөвшөөрөл, нийт 69 тусгай

зөвшөөрлүүдийн баримтуудын иж бүрдлийг шалгах ажлыг АМГТГ-ын архивын өрөөнд явуулсан. Шалгалтын ажлын үр дүнг дараах 3 хэсэгт бүлэглэн орууллаа.

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм журам мөрдсөн байдал

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 9 дүгээр сарын 7-ний өдрийн 359 дугаар тогтоолоор "Монголросцветмет" ХХК-ийн XV-003595, XV-004211 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг цуцалсан ба үүнтэй холбоотойгоор нөхөн олговорт зориулан XV-20580 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг Засгийн газрын тус тогтоолоор олгосон.

Ийнхүү тусгай зөвшөөрлүүдийг цуцалсан болон нөхөн олговорт зориулан тусгай зөвшөөрөл шууд олгосон үйл ажиллагаа нь хууль, эрх зүйн талаасаа зөрчилгүй байна. Өөрөөр хэлбэл Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.3-д заасан "Засгийн газар улсын тусгай хамгаалалттайгаас бусад тусгай хэрэгцээний газарт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй" гэсэн заалтыг үндэслэсэн байна.

Мөн хуулийн 9.1.13-д заасан "Засгийн газар нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээнд авах зорилгоор төрийн мэдэлд шилжүүлэн авч нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохирсоны үндсэн дээр улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбай болон энэ хуулийн, 26.9-д заасан талбайгаас тусгай зөвшөөрөл олгож болно", 56.1.3-д "Хайгуулын болон уурхайн талбайг энэ хуулийн 13.1.3-т заасны дагуу нөөц болон тусгай хэрэгцээнд авч, эсхүл тухайн талбайд ашигт малтмал хайх, ашиглахыг хуулиар хориглож нөхөх олговрыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрэн төлсөн" гэсэн заалтуудыг үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Гэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.13-т заасны дагуу тухайн компанитай хэлэлцэн тохирсон эсэхийг нотлох баримтыг бүрдүүлээгүй буюу АМГТГ-ын архивт байхгүй байгаа нь дээрх хуулийг бүрэн дагаж мөрдсөн эсэх талаар тодорхойгүй байдлыг үүсгэж байгаа юм.

Мөн үүнээс гадна Засгийн газрын тогтоолоор хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны горим нь дээр дурдсан тусгай зөвшөөрөл олгох үндсэн горимуудтай хэрхэн уялдсан болон тусгай зөвшөөрөл олгоход тавигддаг дээр дурдсан хуульд заасан шалгууруудыг хэрхэн хангасан талаар ямар нэгэн баримт бичиг тусгай зөвшөөрлийн хавтаст материал дотор байхгүй байсан. Нөгөө талаас нь харвал ашигт малтмалын тухай хуулийн тэдгээр заалт, горимууд нь хоорондоо хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй байна.

Одоогоор олгогдсон байгаа XV-019518, XV-018795, XV-017883, XV-019777, XV-019480, XV-019524 дугаар бүхий хайгуулын тусгай зөвшөөрлүүдэд орон нутгийн Засаг даргуудаас татгалзсан хариуг тухайн үед нь ирүүлж байсан байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 19.6-д "Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасан саналыг **дэмжсэн хариу өгсөн бол** төрийн захиргааны байгууллага тухайн талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг мөн хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөх тухай өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ" гэж заасныг зөрчиж, орон нутгийн Засаг дарга нараас татгалзсан хариу ирүүлсэн байхад тусгай зөвшөөрлүүдийг олгосон байна.

Гэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн 17.2-д "Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 17.1-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч, **45 хоногийн дотор** төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг **зөвшөөрсөн гэж үзнэ**. Аймаг,

нийслэлийн Засаг дарга **хуульд заасан үндэслэлээр татгалзсан хариу өгч болно.**” гэж заасан байдаг ч аймаг, нийслэлийн Засаг дарга нараас ирүүлсэн татгалзсан хариунуудад хуульд заасан үндэслэлүүдээ дурьдаж оруулдаггүй байна.

Энэхүү нөхцөл байдлыг дүгнэн харахад орон нутгийн Засаг даргаас татгалзсан хариу ирсэн боловч хуульд заасан үндэслэл нь тодорхойгүй бол түүнийг хэрхэн тодруулах тухай горим, шаардлага хуулинд байдаггүй. Мөн 45 хоногийн дотор орон нутгийн Засаг даргаас хариу ирээгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ гэсэн заалтын дагуу тусгай зөвшөөрлүүд олгогдох үндэслэлтэй байна. Орон нутгийн Засаг даргаас татгалзсан хариу ирсэн ч ямар үндэслэлээр эцсийн шийдвэр гаргасан тухай баримт бичиг хавтаст материалуудад оруулдаггүй байна.

Өргөдлөөр ирүүлсэн хайгуулын талбайд хийсэн АМГТГ-ын Кадастрын хэлтсийн зураг зүйн шүүлтийн үр дүнд татгалзсан эсвэл тохируулга хийх шаардлагатай гэсэн талбайнуудад XV-019518, XV-018795, XV-017795, XV-016010 дугаар бүхий тусгай зөвшөөрлүүд олгогдсон байна.

Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 19.2.3-т "Хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцсан бол хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжгүйг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх" гэж заасныг зөрчсөн байх үндэслэлтэй байна.

[Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм журам мөрдсөн байдал](#)

Бидний түүвэрт хамрагдсан 2017 онд олгогдсон 12 ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн архивын бичиг баримт бүрдэлтүүдийг шалгаж үзэхэд 6 тусгай зөвшөөрлүүдийн баримтын иж бүрдэл дутуу байсан. Үүнд:

- MV-021000-001-NM зөвшөөрөл зураг зүйн шүүлтийн тодорхойлолт байхгүй.
- MV-020885-001-NM зөвшөөрөл 2 дахь жилийн төлбөр төлсөн тодорхойлолт байхгүй.
- MV-021000-001-NM, MV-020806-001-NM, MV-020972-001-NM, MV-020984-001-NM зөвшөөрлүүд нь хил тогтоосон тухай актыг ирүүлээгүй тус тус зөрчлүүд ажиглагдлаа.

Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн:

- 26.1.2. "бүртгэсэн даруйд өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 24.3, 24.4, 25.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд анхан шатны шүүлт хийх" гэсэн заалт,
- 34.2."Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараа жилийн төлбөрийг тухайн тусгай зөвшөөрлийг олгосон өдрөөс эхлэн тооцож жил бүр урьдчилан төлнө." гэсэн заалт,
- 34.4."Тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн өдрийг банкны гүйлгээ хийсэн өдрөөр тооцох бөгөөд холбогдох баримтыг төрийн захиргааны байгууллагад ирүүлснээр тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлсөнд тооцно." гэсэн заалт,
- 36.1."Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 26.5-д заасны дагуу тусгай зөвшөөрлийн бүртгэлд бүртгүүлснээс хойш 3 сарын дотор мэргэжлийн хяналтын албаны тавьсан техникийн шаардлагын дагуу уурхайн талбайн хилийг тогтоолгож, байнгын шав тэмдэг тавих бөгөөд уурхайн талбайн хилийн хэмжилтийг төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан этгээдээр хийлгэж, хил тогтоосон тухай актыг тус албанд ирүүлнэ." гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

АМГТГ-ын Кадастрын хэлтсийн Зураг зүйн шүүлт хийхэд ашиглалтын тусгай зөвшөөрөл өгөхийг хуулиар хориглосон талбайтай давхцалтай байгаа ч "татгалзах зүйлгүй ба **лавлах зүйл байгаа**" гэх дүгнэлт бүхий MV-020806-001-NM, MV-020784-001-NM, MV-020814-001-NM, MV-020945-001-NM, MV-020969-001-NM, MV-020971-001-NM, MV-020885-001-NM дугаартай 7 ашиглалтын тусгай

зөвшөөрлүүдийг 2017 онд олгосон байна. Гэвч ямар лавлах ажиллагаа хийгдсэн, давхцалтай талбайн хэсгүүдийг ямар үндэслэлээр олгох шийдвэр гаргасан талаарх хуульд заасан үндэслэл бүхий баримтыг архивын материалд хавсаргаагүй байна. Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 24-р зүйлийн 24.4.2-д “Тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай давхцаагүй” байх шаардлагыг зөрчсөн байна гэх үндэслэлтэй байна. Мөн эдгээр ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой маргаан ирээдүйд үүсэх магадлалтай байна.

БОНХАЖЯ-наас Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхцалтай гэх албан бичиг хариу ирүүлсэн боловч олгогдсон MV-020972-001-NM, MV-020885-001-NM тусгай зөвшөөрлүүд байна.

Энэ нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4-р зүйлийн 4.1-д заасан “Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Тус хуулийн зөрчлөөс шалтгаалан хуулийн маргаан үүсэх эрсдэлтэй байна. Тухайлбал АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ны 263 дугаар шийдвэрээр MV-020885-001-NM дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Тус талбай нь ой, ус, тусгай хамгаалалтын газрын хилийн заагтай давхцалтай байгааг тогтоосон учраас тийнхүү хүчингүй болгосон байна.

АМГТГ-ын Кадастрын хэлтсийн Зураг зүйн шүүлт хийхэд MV-020781-001-NM дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн зарим хэсэг нь орон нутгийн тусгай хэрэгцээний газартай давхцалтай гэсэн үр дүн гарсан байсан боловч тусгай зөвшөөрлийг олгосон байсан. АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2018 оны 4 дүгээр сарын 5-ны 205 дугаар шийдвэрээр тус тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой хэсгүүдийг буцаасан байна.

АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 6 дугаар сард MV-020969-001-NM дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гарсан. Гэтэл тус тусгай зөвшөөрлийг 2017 оны 11 дүгээр сарын 22-нд олгосон байна. Энэ хугацаанд тусгай зөвшөөрөл хүссэн компани нь Кадастрын хэлтсийн дарга солигдсоны улмаас олгогдохгүй удааширч байгаа тухай шүүхэд гомдол гаргаж байжээ. Тухайн зөвшөөрлийг олгоогүй удаашруулсан хуулийн шалтгаан болон сүүлд нь олгохоор шийдвэрлэсэн хуулийн үндэслэл бүхий баримт хавсаргаагүй буюу тодорхойгүй байна.

“Монголиан нэшнл рийр ийрт корп” компанийн MV20783 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийн баримтууд нь архивт байхгүй байсан.

[Тусгай зөвшөөрөл шилжүүлэх үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм журам мөрдсөн байдал](#)

MV-017111-008-TF тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхдээ олборлолт явуулсан талбайн хэсэгт нөхөн сэргээлт хийсэн тухай орон нутгийн Байгаль орчны хяналтын албаны тодорхойлолтыг бүрдүүлж, хавсаргаагүй байна.

MV-017117-009-TF, MV-013786-011-TF, MV-013787-011-TF тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг орон нутгийн Засаг даргаас нөхөн сэргээлт хийгээгүй гэсэн тодорхойлолт ирүүлсэн ч тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлсэн байна.

Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай 49 дүгээр зүйлд зааснаар ашиглалтын тусгай зөвшөөрөл шилжүүлэн өгч буй тал нь тухайн талбайн олборлолт явуулсан хэсэгт нөхөн сэргээлт хийсэн тухай байгаль орчны хяналтын албаны тодорхойлолтыг шилжүүлэх тухай өргөдлийн хамт хавсаргана гэсэн хуулийн шаардлагыг зөрчсөн байна. Төрийн захиргааны байгууллага нь мөн тус зүйлийн 49.5.1-д “Өргөдөл нь энэ зүйлд заасан шаардлагыг

хангасан эсэх"-г хянан үзээд шилжүүлэх тухай шийдвэрийг гаргана гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй гэх үндэслэлтэй байна.

“Алтандорнод Монгол” ХХК-иас “Заамар гоулд” ХХК-д MV-020868-001-ТР дугаар бүхий тусгай зөвшөөрлийг шилжүүлэх тухай АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэрээс өөр ямар нэгэн баримт бичиг архивын материалд байхгүй байна.

Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай 49 дүгээр зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл шилжүүлэн өгч буй тал нь шилжүүлэх тухай өргөдлийн хамт баримт бичгүүдийг хавсаргах тухай хуулийн шаардлагыг хэрэгжүүлээгүй гэх үндэслэлтэй байна.

Тусгай зөвшөөрөл шилжүүлэх үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанаас хяналтын шат дамжлага бага, шилжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талууд бага буюу АМГТГ-ын Кадастрын болон Хуулийн хэлтэс горимын ажлуудыг гүйцэтгэдэг. (Жич: Шилжүүлэх үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлэх үйл явц” хэсгээс харна уу.) Ийм байдлаас шалтгаалан тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авч буй хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийг анх авсан хуулийн этгээдэд тавигдаж байсан шалгууруудыг бүрэн хангаж буй эсэх талаарх хяналт харьцангуй зөрүүтэй гэж дүгнэж болно.

Бидний шалгалтын явцад ажиглагдсан дээр дурдсан хууль, журам зөрчсөн олон тохиолдлуудаас харахад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх үйл ажиллагаануудад талуудын зарим шаардлагатай эрх, үүргүүдийг нарийвчлан тодорхойлон, хуулиар зохицуулаагүйгээс хуулийн маргаан үүсэх, талууд хохирох эрсдэл нэлээдгүй байна.

Тусгай зөвшөөрлийн өргөдлийн статистик мэдээлэл

Тусгай зөвшөөрөл авахаар гаргасан өргөдлийн статистик мэдээллийг сүүлийн 8 жилээр харьцуулан харуулав.

Хүснэгт 5.20

| Өргөдлийн төрөл | 2010 он | 2011 он | 2012 он | 2013 он | 2014 он | 2015 он | 2016 он | 2017 он |
|--------------------------|-------------|-------------|-------------|------------|------------|-------------|------------|------------|
| БҮГД | 1982 | 1760 | 1050 | 626 | 791 | 3002 | 613 | 813 |
| Шинээр авах | 527 | 103 | 114 | 102 | 113 | 2522 | 131 | 288 |
| а. Ашиглалтын | 100 | 103 | 114 | 102 | 98 | 87 | 103 | 65 |
| б. Хайгуулын | 427 | 0 | 0 | 0 | 0 | 2335 | 0 | 0 |
| в. Сонгон шалгаруулалтын | - | - | - | - | 15 | 100 | 28 | 223 |
| Сунгуулах | 836 | 980 | 586 | 305 | 453 | 249 | 173 | 231 |
| Шилжүүлэх | 454 | 462 | 187 | 10 | 53 | 92 | 139 | 153 |
| а. Ашиглалтын | 52 | 67 | 43 | 10 | 36 | 52 | 49 | 78 |
| б. Хайгуулын | 402 | 395 | 144 | 0 | 17 | 40 | 90 | 75 |
| Барьцаалах | 59 | 94 | 50 | 67 | 44 | 22 | 33 | 37 |
| а. Ашиглалтын | 44 | 59 | 39 | 47 | 40 | 22 | 30 | 32 |
| б. Хайгуулын | 15 | 35 | 11 | 20 | 4 | 0 | 3 | 5 |
| Талбай буцаах | 106 | 121 | 113 | 142 | 128 | 117 | 137 | 104 |
| а. Ашиглалтын | 6 | 6 | 7 | 18 | 12 | 24 | 26 | 14 |
| б. Хайгуулын | 100 | 115 | 106 | 124 | 116 | 93 | 111 | 90 |

Эх сурвалж: 2017 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 24, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

Тайлант хугацаанд сонгон шалгаруулалтад оролцсон аж ахуй нэгжийн жагсаалтыг Хавсралт 16(ж)-ээс харна уу. Мөн тэдгээр сонгон шалгаруулалтын үнэлгээний жагсаалтыг Хавсралт 16(ж)-ээс харна уу.

5.2.7.6 2017 онд шинээр олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүд (шаардлага 2.2.a.iii)

Лиценз эзэмшигчдийн бүх өөрчлөлтийн дэлгэрэнгүйг ОУИТБС-ын тайланд тусгах нь Стандартын шаардлага юм. АМГТГ-ын олон нийтэд мэдээлсэн уул уурхай, геологийн статистик мэдээлэлд тусгай зөвшөөрлийн статистик мэдээлэл нь бидэнд гаргаж өгсөн мэдээллээс зөрүүтэй байсан. Энэ талаар 2015 оны нэгтгэлийн тайланд дэлгэрэнгүй тайлбарласан.

АМГТГ-аас бидэнд өгсөн мэдээллээр 2017 онд ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл 77, хайгуулын тусгай зөвшөөрөл 30, шилжүүлсэн тусгай зөвшөөрөл 139 байсан. АМГТГ-ын олон нийтэд мэдээлсэн уул уурхай, геологийн статистик мэдээлэлд дараах байдлаар тусгагдан байна. Үүнд:

Хүснэгт 5.21

| Бүртгэлийн төрөл | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|--------------------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|
| Шинээр олгосон | 235 | 79 | 95 | 72 | 113 | 827 | 750 | 151 |
| а.Ашиглалт | 90 | 79 | 95 | 72 | 97 | 91 | 93 | 77 |
| б.Хайгуул | 145 | 0 | 0 | 0 | 2 | 697 | 629 | 41 |
| в.Сонгон шалгаруулалт | - | - | - | - | 14 | 39 | 28 | 33 |
| Талбай буцаасан | 105 | 89 | 141 | 146 | 119 | 150 | 166 | 97 |
| а.Ашиглалт | 6 | 4 | 7 | 16 | 13 | 25 | 25 | 13 |
| б.Хайгуул | 99 | 85 | 134 | 130 | 106 | 125 | 141 | 84 |
| Цуцалсан/Хүчингүй | 458 | 275 | 270 | 347 | 123 | 173 | 241 | 237 |
| а.Ашиглалт | 39 | 65 | 139 | 43 | 14 | 10 | 37 | 35 |
| б.Хайгуул | 419 | 210 | 131 | 304 | 109 | 163 | 204 | 202 |
| Дуусгавар болсон | 248 | 225 | 175 | 253 | 289 | 179 | 124 | 176 |
| Шилжүүлсэн | 448 | 441 | 200 | 8 | 51 | 88 | 146 | 136 |
| а.Ашиглалт | 59 | 58 | 47 | 8 | 38 | 46 | 50 | 62 |
| б.Хайгуул | 389 | 383 | 153 | 0 | 13 | 42 | 96 | 74 |
| Сунгуулсан | 791 | 997 | 601 | 317 | 444 | 336 | 167 | 162 |
| Барьцаалсан | 50 | 62 | 38 | 61 | 40 | 22 | 29 | 39 |
| а.Ашиглалт | 36 | 39 | 22 | 42 | 34 | 22 | 27 | 34 |
| б.Хайгуул | 14 | 23 | 16 | 19 | 6 | 0 | 2 | 5 |
| Барьцаа чөлөөлсөн | | 28 | 42 | 31 | 29 | 24 | 16 | 39 |
| а.Ашиглалт | | 8 | 15 | 29 | 24 | 19 | 12 | 38 |
| б.Хайгуул | | 20 | 27 | 2 | 5 | 5 | 4 | 1 |
| Нөхөн олгосон | | 94 | 56 | 15 | 11 | 19 | 35 | 26 |
| а.Ашиглалт | | 29 | 16 | 9 | 7 | 10 | 15 | 19 |
| б.Хайгуул | | 65 | 40 | 6 | 4 | 9 | 20 | 7 |

Эх сурвалж: 2017 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 25, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

2017 оны жилийн эцсийн байдлаар ашигт малтмалын 10 ба түүнээс дээш тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалтыг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 5.22

| № | Аж ахуйн нэгжийн нэр | Тусгай зөвшөөрлийн тоо | Талбайн хэмжээ | Хуулийн этгээдийн ангилал | Хөрөнгө оруулагч улс |
|---|----------------------|------------------------|----------------|---------------------------------------|----------------------|
| 1 | Алтандорнод монгол | 36 | 155,158.87 | Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай | Виржиний Арлууд |
| 2 | Монголросцветмет | 30 | 16,136.38 | Дотоодын А.А.Н | Монгол |
| 3 | Монголын алт МАК | 24 | 62,365.29 | Дотоодын А.А.Н | Монгол |

| № | Аж ахуйн нэгжийн нэр | Тусгай зөвшөөрлийн тоо | Талбайн хэмжээ | Хуулийн этгээдийн ангилал | Хөрөнгө оруулагч улс |
|----|---------------------------|------------------------|----------------|---------------------------------------|----------------------|
| 4 | Гацуурт | 17 | 9,565.92 | Дотоодын А.А.Н | Монгол |
| 5 | Цайна инвестмент Монголиа | 16 | 223,973.65 | Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай | Сингапур |
| 6 | Олон-Овоот гоулд | 14 | 90,111.63 | Дотоодын А.А.Н | Монгол |
| 7 | Гобуикоул энд энерги | 13 | 11,452.21 | Дотоодын А.А.Н | Монгол |
| 8 | Кожеговь | 12 | 237,919.38 | Дотоодын А.А.Н | Монгол |
| 9 | Хүннү говь алтай | 12 | 2,206.74 | Дотоодын А.А.Н | Монгол |
| 10 | МАК Цемент | 11 | 7,973.18 | Дотоодын А.А.Н | Монгол |
| 11 | Ричфлюорит | 11 | 6,387.64 | Дотоодын А.А.Н | Монгол |
| 12 | Эрэл | 11 | 10,996.61 | Дотоодын А.А.Н | Монгол |
| 13 | Голден гроуз айбекс | 10 | 121,409.54 | Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай | Канад |
| 14 | ЖАСКО | 10 | 116,537.50 | Дотоодын А.А.Н | Монгол |
| 15 | МОЭНКО | 10 | 12,807.40 | Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай | Сингапур |

Эх сурвалж: 2017 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 26, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар
2017 оны жилийн эцсийн байдлаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий 100,000 ба түүнээс дээш гектар талбайг эзэмшигчдийн жагсаалтыг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 5.23

| № | Аж ахуйн нэгжийн нэр | Тусгай зөвшөөрлийн тоо | Талбайн хэмжээ | Хуулийн этгээдийн ангилал |
|---|-------------------------|------------------------|----------------|---------------------------------------|
| 1 | Кожеговь | 12 | 237,919.38 | Дотоодын А.А.Н |
| 2 | Цайна инвестмент монгол | 16 | 223,973.65 | Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай |
| 3 | Монгол ураниум ресурс | 2 | 191,728.63 | Дотоодын А.А.Н |
| 4 | Алтандорнод монгол | 36 | 155,158.87 | Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай |
| 5 | Пибодивинсвей ресорсез | 7 | 122,077.80 | Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай |
| 6 | Голден гроуз айбекс | 10 | 121,409.54 | Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай |
| 7 | ЖАСКО | 10 | 116,537.50 | Дотоодын А.А.Н |
| 8 | Монлаа | 4 | 108,678.98 | Дотоодын А.А.Н |
| 9 | Эф Ви Эс Пи | 4 | 104,232.36 | Гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай |

Эх сурвалж: 2017 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 26, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

5.2.7.7 Тусгай зөвшөөрлийн ил тод байдал (шаардлага 2.3)

АМГТГ-ын кадастрын цахим хуудсанд (<http://cmcs.mram.gov.mn/cmcs#c=License>) хүчин төгөлдөр байгаа 3,435 тусгай зөвшөөрлийн мэдээллийг нийтэд ил болгосон байна. Харин ураны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээллүүдийг оруулаагүй байна.

МОУИТБС-ын Ажлын алба цахим хуудсанд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг нийтэд ил болгодог. 2018 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 3,708 тусгай зөвшөөрлийн мэдээллүүдийг оруулсан боловч зарим тусгай зөвшөөрлүүдийн ашигт малтмалын төрлийг буруу оруулсан байна.

Мөн цахим хуудасны “Ил тодын шигтгээ” цэсний хэсэгт 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх тусгай зөвшөөрлүүдийн статистик тойм мэдээллүүдийг харуулсан ба мэдээллээ шинэчлээгүй байна. Мөн тус цэсний бүтээгдэхүүн борлуулалт, татвар төлөлт гэх мэт мэдээллийн хэсгүүд нь 2012 оноос шинэчлэгдээгүй, мөн тус цахим хуудасны зарим хэсэг нь ажиллагаагүй байна.

5.3 АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТ (ШААРДЛАГА 3.1)

5.3.1 Ашигт малтмалын хайгуул

2017 онд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажил

2017 онд Улсын төсвийн хөрөнгөөр 29 аж ахуй нэгжийн 48 төсөл хэрэгжүүлсэн байна. Үүнд 1:50,000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх 33 төсөл, Улсын геологийн зураглал хийх 3 төсөл, сэдэвчилсэн судалгааны 12 төсөл хэрэгжүүлсэн.

2017 оны төсвийн тодотголоор нийт 13,335,900 мянган төгрөг батлагдсанаас 11,375,536 мянган төгрөгийн гүйцэтгэлийн тайлан ирүүлж, 9,782,138 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа 2017 оны 11 дүгээр сарын байдлаарх геологийн судалгааны ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээг доорх хүснэгтүүдээс харна уу.

Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн геологи, судалгааны ажлын сүүлийн 5 жилийн тойм статистик мэдээллийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 5.24

| Ажлын төрөл | 2013 | | 2014 | | 2015 | |
|--------------------------|----------|-----------|----------|-----------|----------|-----------|
| | Сая.төг | Гүйцэтгэл | Сая.төг | Гүйцэтгэл | Сая.төг | Гүйцэтгэл |
| БҮГД | 6,809.90 | 93.0% | 9,209.20 | 92.0% | 9,280.60 | 82.0% |
| УГЗ 1:200000 | 763.80 | 95.6% | 807.20 | 89.0% | 330.50 | 63.0% |
| 1:50000 ГЗЕЭА | 5,809.40 | 96.5% | 7,314.80 | 93.0% | 5,556.70 | 78.0% |
| Сэдэвчилсэн ажил | 155.80 | 34.3% | 1,003.50 | 88.0% | 3,167.70 | 92.0% |
| Хамтын ажиллагааны төсөл | 80.90 | 168.9% | 83.60 | 70.0% | 225.60 | 79.0% |

| Ажлын төрөл | 2016 | | 2017 | |
|--------------------------|----------|-----------|-----------|-----------|
| | Сая.төг | Гүйцэтгэл | Сая.төг | Гүйцэтгэл |
| БҮГД | 9,341.10 | 100% | 12,255.10 | 91.8% |
| УГЗ 1:200000 | 642.70 | 100% | 482.30 | 100.0% |
| 1:50000 ГЗЕЭА | 4,975.80 | 100% | 5,355.87 | 100.0% |
| Сэдэвчилсэн ажил | 3,476.10 | 100% | 6,274.57 | 80.8% |
| Хамтын ажиллагааны төсөл | 246.60 | 100% | 142.40 | 100.0% |

Хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хайгуулын үйл ажиллагаа

Тусгай зөвшөөрлийн талбайд хувийн хөрөнгөөр гүйцэтгэх хайгуулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэсэн тайлан, зардал хянуулсан, баталгаажуулсан байдлын хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 48.1.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс жил бүрийн хайгуулын ажлын төлөвлөгөө, 48.1.2-д заасны дагуу хайгуулын ажлын жил тайланг хүлээн авч хянах бөгөөд 33.1, 33.2-т заасны дагуу хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хянаж, санхүүгийн жилийн тайлан тэнцэлд тулгуурлан баталгаажуулдаг.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2017 онд нийт 1,867 хайгуулын ажлын төлөвлөгөө ирснээс 93,8% буюу 1,751 төлөвлөгөө баталгаажиж, 6,2% буюу 115 төлөвлөгөө засвартай буцаагдсан байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2017 оны жилийн хайгуулын ажил гүйцэтгэлийн 1,538 тайлан ирүүлж, 1,531 тайлан хянагдаж, 1,278 тайлан баталгаажиж, 231 тайлан засвар хийгдэхээр буцаагдсан байна.

Тайлант онд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид геологи, хайгуулын ажилд урьдчилсан тооцоогоор 124,922.9 сая төгрөг зарцуулсан ба гүйцэтгэсэн ажлын төрлөөр нь сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 5.25

| Ажлын төрөл | 2013 (Сая ₮) | 2014 (Сая ₮) | 2015 (Сая ₮) | 2016 (Сая ₮) | 2017* (Сая ₮) |
|----------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|
| Бэлтгэл ажил | 3,842.3 | 3,146.2 | 2,998.7 | 8,924.2 | 3,398.6 |
| Зураглалын ажил | 2,328.8 | 3,006.8 | 2,314.2 | 5,815.3 | 1,831.2 |
| Эрлийн маршрут | 2,530.5 | 2,535.4 | 2,789.2 | 6,383.5 | 2,261.2 |
| Сорьцлолт | 2,659.3 | 2,259.7 | 2,047.1 | 32,645.9 | 76,793.7 |
| Геофизикийн ажил | 13,427.2 | 12,413.9 | 10,716.5 | 9,826.5 | 14,210.0 |
| Уулын ажил | 2,530.8 | 4,887.8 | 2,784.2 | 1,697.1 | - |
| Өрөмдлөг | 82,575.7 | 86,233.0 | 49,794.5 | 68,917.0 | 5,783.0 |
| Геохимийн ажил | 2,133.4 | 746.0 | 779.1 | - | - |
| Лаборатори | 10,889.8 | 10,490.8 | 6,710.6 | 8,833.1 | 11,213.7 |
| Топогеодезийн ажил | 1,880.4 | 1,357.9 | 1,638.3 | 2,248.6 | 4,457.7 |
| Гидрогеологийн ажил | 751.6 | 2,781.3 | 2,549.9 | 1,174.1 | 759.8 |
| Тээвэр | 5,182.5 | 3,780.9 | 3,112.8 | 17,331.0 | 341.4 |
| Суурин боловсруулалт | 11,233.7 | 21,563.1 | 11,055.0 | 11,685.7 | 1,064.5 |
| БОНС | 1,382.0 | 2,015.8 | 1,749.6 | 1,346.9 | 348.2 |
| Талбайн сорьцлолт | 416.6 | 1,484.7 | 1,246.9 | 2,101.3 | 898.5 |
| Геоморфологи | 25.3 | - | 20.6 | - | - |
| Археологи | 528.3 | 123.0 | 96.8 | 231.2 | 165.3 |
| Палеонтологи | 448.9 | 88.3 | 43.3 | | - |
| Бусад | 5,328.7 | 1,506.9 | 4,791.0 | 11,098.5 | 1,396.1 |
| БҮГД | 150,095.8 | 160,421.5 | 107,238.3 | 190,259.9 | 124,922.9 |

*Жич: 2017 оны зардлын мэдээлэл үргэлжлэн хянагдаж байгаа тул урьдчилсан тооцоогоор тусгав. Эх сурвалж: АМГГТ

Тайлант онд ЭБМЗ-ийн ашигт малтмалын хайгуулын асуудал хэлэлцэх хуралдаанаар хэлэлцэгдсэн тайлангуудын дэлгэрэнгүй мэдээллийн жагсаалтыг Хавсралт 16(з)-ээс харна уу.

5.3.2 Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл


Монгол улсын экспортын гол нэрийн түүхий эдийн үнэ 2017 онд ерөнхийдөө өсөлттэй байж, тус салбарын үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 21.73% болсон ба 2010-2017 оны үзүүлэлтийг тэрбум төгрөгөөр харуулав. Тухайлбал:

Хүснэгт 5.26

| № | Үйлдвэрлэл | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|--|---------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|
| 1 | Дотоодын нийт бүтээгдэхүүн | 9,756.6 | 13,173.8 | 16,688.4 | 19,174.2 | 22,227.1 | 23,166.8 | 23,886.4 | 16,992.1 |
| 2 | Уул уурхайн олборлолт | 2,102.2 | 2,536.2 | 2,742.8 | 2,849.4 | 3,661.0 | 3,867.7 | 3,984.8 | 3,692.8 |
| 3 | Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл | 4,987.0 | 6,185.6 | 5,723.6 | 7,651.7 | 9,299.6 | 8,714.4 | 9,927.1 | 12,932.7 |
| 4 | Уул уурхайн олборлох аж үйлдвэр | 3,097.0 | 3,752.3 | 3,839.7 | 5,217.4 | 6,388.9 | 5,858.0 | 7,884.7 | 9,386.0 |

Эх сурвалж: 2017 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 11, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

Дотоодын нийт бүтээгдэхүүн болон аж үйлдвэрлэлд уурхайн салбарын эзлэх хувь сүүлийн 8 жилд дараах байдалтай байсан. Үүнд:



Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ хуудас 11, 2017 он, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 5.27


| № | Ашигт малтмалын төрөл | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|--|---------|---------|---------|---------|----------|----------|----------|----------|
| 1 | Зэсийн баяжмал (метал агуулгаараа), мян.тн | 357.1 | 347.4 | 347.6 | 533.3 | 712.0 | 890.7 | 1,445.1 | 1,317.1 |
| 2 | Молибдений баяжмал (метал агуулгаараа), тн | 4,677.1 | 4,163.1 | 4,050.2 | 3,869.2 | 4,254.0 | 5,441.0 | 5,173.7 | 5,616.7 |
| 3 | Алт, кг | 6,037.1 | 5,702.6 | 5,995.0 | 8,904.4 | 11,503.8 | 14,556.2 | 18,435.7 | 19,846.8 |
| 4 | Хайлуур, жоншны баяжмал, мян.тн | 140.7 | 116.4 | 157.2 | 76.4 | 374.9 | 230.8 | 34.1 | 55.2 |
| 5 | Төмрийн хүдрийн баяжмал мян.тн | 3,203.2 | 5,678.3 | 7,561.4 | 6,011.2 | 10,260.5 | 6,173.4 | 2,209.9 | 3,675.0 |
| 6 | Цайрын баяжмал, мян.тн | 112.6 | 104.7 | 119.1 | 104.1 | 93.2 | 89.6 | 100.2 | 82.7 |
| 7 | Гянтболдын баяжмал, тн | 19.9 | 12.6 | 66.0 | - | - | - | - | - |

Эх сурвалж: Эрдэс баялгийн статистик мэдээ хуудас 11, 2017 он, УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар

5.3.3 Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт

Тайлант оны нийт экспортын хэмжээ өмнөх оныхоос 26.1 хувиар өсч Монгол Улсын түүхэнд хамгийн өндөр дүнд буюу 6.2 тэрбум ам. долларт хүрсэн. Энэ өсөлт нь уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспортын өсөлтөөс шууд хамааралтай байсан. Тайлант оны нийт экспортын 80%-ийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Мөн 2017 онд 4.9 тэрбум ам. долларын эрдэс бүтээгдэхүүн экспортолсон нь өмнөх оныхоос 41.6 хувиар илүү байсан. (Эх сурвалж: Монгол улсын Үндэсний статистикийн хорооны 2017 оны гадаад худалдааны статистикийн эмхтгэл ном, хуудас 13)

Эрдэс бүтээгдэхүүний экспортыг сүүлийн 5 жилээр харьцуулан дараах графикаар харууллаа. Үүнд:



Эх сурвалж: Монгол улсын Үндэсний статистикийн хорооны 2017 оны гадаад худалдааны статистикийн эмхтгэл ном, хуудас 14

Дээрх графикаас харахад чулуун нүүрсний экспорт нь нийт өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн нь харагдаж байна. Мөн зэсийн баяжмал болон чулуун нүүрсний экспортын орлогын хэмжээ нь нийт эрдэс бүтээгдэхүүний экспортын 77% эзэлсэн ба сүүлийн 5 жилийн дунджаар 72%-ийг эзэлсэн байна.

5.4 ГАЗРЫН ТОС БОЛОН БАЙГАЛИЙН ХИЙ

5.4.1 Газрын тосны тухай тойм

Монгол Улсад нийт 32 газрын тосны талбай байдгаас өнөөдрийн байдлаар 25 талбайд 21 гэрээлэгч БХГ байгуулан, Засгийн газраар батлуулан ажиллаж байна. Үүнээс олборлолтын үйл ажиллагаа явуулж буй 3 талбай, хайгуулын үйл ажиллагаа явуулж буй 22 газар, бусад талбайд эрлийн үйл ажиллагаа явуулж байна. Газрын тос олборлож буй 3 талбайд 2 компани үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Пэтрочайнагийн охин компани болох “Пэтрочайна Дачин Тамсаг” ХХК нь газрын тосны дийлэнх хувийг олборлож экспортод гаргадаг.

Одоогийн байдлаар Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр, тоног төхөөрөмж байхгүйн улмаас олборлосон газрын тосыг түүхий газрын тос хэлбэрээр экспортолж байна. Монгол Улс дотоодын хэрэгцээний газрын тосны бүтээгдэхүүнээ ихэвчлэн ОХУ-аас импортолдог.

Газрын тосны олборлолт явуулж байгаа компанийн талбайн мэдээлэл

Хүснэгт 5.28

| Д/д | Ашиглалтын талбайн нэр | Гэрээлэгч компани | Гэрээ байгуулсан огноо |
|-----|------------------------|------------------------------|------------------------|
| 1 | Тосон-Уул XIX | Петросайна Дачин Тамсаг ХХК | 1993/04/26 |
| 2 | Тамсаг-XXI | | 1995/12/11 |
| 3 | БХГ-97 | Доншен газрын тос Монгол ХХК | 1997/01/24 |

Тосон-Уул-ХИХ, Тамсаг-ХХИ талбайд “Петрочайна дачин тамсаг” ХХК, БХГ-97 талбайд “Доншен газрын тос Монгол” ХХК тус тус газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК: Хятадын Үндэсний газрын тосны корпорацийн харьяа төрийн өмчит “Дачин Ойл Фийлд Лимитед” компани нь 2005 оны 8 дугаар сард Тамсагийн сав газрын ХИХ, ХХИ, ХХII гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах БХГ-ний эрх үүргийг АНУ-ын “СОКО Интернейшнл” ХХК-иас шилжүүлэн авч, БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийг Монгол Улсад байгуулан Дорнод аймгийн Халх гол, Матад сумдын нутагт орших Тосон-Уул ХИХ, Тамсаг ХХИ талбайнуудад газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

“Доншен газрын тос Монгол” ХХК: БНХАУ-ын “Доншен Жингүн Петролеум Девелопмент Групп Сток” компани нь Монгол Улсын Засгийн газрын 1997.02.19-ний өдрийн 47 тоот тогтоолоор 2003 оны 2 дугаар сарын 15-нд батлагдсан БХГ-ний эрх, үүргийг Австралийн “Рок Ойл (Говь)” компаниас шилжүүлэн авч, БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Доншен газрын тос Монгол” ХХК-ийг Монгол Улсад байгуулан, Дорноговь аймгийн нутагт орших 1997 оны БХГ-т талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Газрын тосны үйл ажиллагаанд газрын тостой холбоотой хайгуул болон олборлолт багтана. Харин уламжлалт бус газрын тосны үйл ажиллагаа нь байгалийн битум, шатдаг занар, тослог элс, хийн элс, хийн занар болон нүүрсний метантай холбоотой.

5.4.2 Байгалийн хийн тухай тойм

Газрын тосны тухай хуулийн дагуух нэр томъёогоор “Газрын тос” гэдэгт түүхий тос, байгалийн хий орно. Мөн АМГТГ нь байгалийн хийн талаар ямар нэгэн гэрээ хэрэгжүүлээгүй ба байгалийн хийн эрэл, хайгуулын ажил явагдаагүй байна.

Эрдэнэс Метан ХХК нь 2016 оны 02 дугаар сард уламжлалт болон уламжлалт бус байгалийн хий, газрын тос хайх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийг зохицуулах болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-ийн 100% өмчлөлтэй охин компани болон байгуулагдсан.

5.4.3 Газрын тосны нөөц

“Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос Монгол” ХХК нь хайгуул, үнэлгээ, туршилтын олборлолт, ашиглалтын нийт 1465 цооног (Тосон-Уул ХИХ талбайд 869 цооног, Тамсаг ХХИ талбайд 477 цооног, БХГ-97 талбайд 119) өрөмдөн, 12.78 мянган тууш км хоёр хэмжээст (Тосон-Уул ХИХ талбайд 4.37 мянган тууш км, Тамсаг ХХИ талбайд 3.27 мянган тууш км, БХГ-97 талбайд 5.14 мянган тууш км), 5.33 мянган км² гурван хэмжээст (Тосон-Уул ХИХ талбайд 2.32 мянган км², Тамсаг ХХИ талбайд 2.67 мянган км², БХГ-97 талбайд 339.6 км²) чичирхийллийн судалгаа хийсэн.

ЭБМЗ-өөр 2011 онд Тосон-Уул ХИХ талбайн газрын тосны нөөцийн тооцооны нэмэлт тайланг дахин хэлэлцүүлж, тус зөвлөлийн 2011 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 06 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын 2011 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 148 дугаар тушаалаар газрын тосны “баталгаат” нөөцийг 60.06 сая тн, үүнээс газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 6.50 сая тонноор нэмж, Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэснээр дээрх талбайн нийт газрын тосны “баталгаат” нөөц 179.08 сая тн, үүнээс газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөц 20.17 сая тонн гэж бүртгэгджээ.

Тамсаг ХХИ талбайн газрын тосны нөөцийн тооцооны тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж, тус зөвлөлийн 2012 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 01/12 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын 2012 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 41 дүгээр тушаалаар газрын тосны “баталгаат” нөөцийг 127.509 сая тн, үүнээс байгалийн горимоор ашиглах газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 14.01 сая тонн, ус шахалтын горимоор ашиглах газрын тосны “ашиглалтын

баталгаат” нөөцийг 21.018 сая тонноор Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн.

БХГ-97 талбайн газрын тосны нөөцийг 26.05 сая тонн буюу 186.3 сая баррель; үүнээс “ашиглалтын баталгаат” нөөцийг 2.07 сая тонн буюу 14.86 сая баррелиар тус тус тогтоосон ба уг нөөцийн тооцооны тайланг ЭБЭХЯ-ны дэргэдэх ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн, тус зөвлөлийн 2010.04.18-ны өдрийн 03 тоот дүгнэлтийг үндэслэн ЭБЭХ-ний сайдын “Нөөц бүртгэх тухай” 2011.06.08-ны өдрийн 137 дугаар тушаалаар Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн байна.

2017 оны байдлаар газрын тосны нөөцийг БХГ-т талбай тус бүрээр харуулав.

Хүснэгт 5.29

| № | БХГ-т талбай | Баталгаат нөөц (сая тонн) | Ашиглалтын баталгаат нөөц (сая тонн) |
|-------------|---------------|------------------------------|--|
| 1 | Тосон-Уул XIX | 179.08 | 20.17 |
| 2 | Тамсаг XXI | 127.509 | 21.018 |
| 3 | БХГ-97 | 26.05 | 2.07 |
| Нийт | | 332.64 | 43.26 |

Газрын тосны эрэл, хайгуулын ажлын үр дүнд 332.6 сая тонн газрын тосны баталгаат нөөц, 43.2 сая тонн ашиглалтын баталгаат нөөцийг тогтоож, Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн.

1996-2017 онуудад нийт 49.2 сая баррель (6.6 сая тонн) газрын тос олборлон экспортолж, улсын төсөвт нийт 1.3 их наяд төгрөг төвлөрүүлсэн байна.

5.4.4 Газрын тосны хайгуул

Дараах хүснэгтэд 2017 онд хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн газрын тосны хайгуулын төслүүдийн үйл ажиллагааг харуулбал:

Хүснэгт 5.30

| Д/д | Талбайн нэр | Байршил | Техник эдийн засгийн үнэлгээ хийгдсэн эсэх | Баталгаат нөөц | Нөөцийн хэмжээ | Хайгуул хийгдэх хугацаа /эхлэх, дуусах огноо одоогийн байдлаар/ |
|-----|----------------|--|--|----------------|----------------|---|
| 1 | Матад ХХ | Дорнод, Сүхбаатар | Үгүй | Байхгүй | 0 | 2009.07.29 - 2020.07.04 |
| 2 | Галба XI | Дорноговь, Өмнөговь | Үгүй | Байхгүй | 0 | 2009.05.20– 2019.05.20 |
| 3 | Богд IV | Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай | Үгүй | Байхгүй | 0 | 2009.07.29 - 2019.07.28 |
| 4 | Онги V | Баянхонгор, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь | Үгүй | Байхгүй | 0 | 2009.07.29 - 2019.07.28 |
| 5 | Төхөм Х (хойд) | Дундговь, Дорноговь | Үгүй | Байхгүй | 0 | 2012.07.29 – 2020.07.28 |
| 6 | Хөх нуур XVIII | Дорнод | Үгүй | Байхгүй | 0 | 2009.07.29 - 2018.07.28 |
| 7 | Баянтүмэн XVII | Дорнод | Үгүй | Байхгүй | 0 | 2010.12.08 – 2021.12.07 |

| Д/д | Талбайн нэр | Байршил | Техник эдийн засгийн үнэлгээ хийгдсэн эсэх | Баталгаат нөөц | Нөөцийн хэмжээ | Хайгуул хийгдэх хугацаа /эхлэх, дуусах огноо одоогийн байдлаар/ |
|-----|--------------------|-------------------------------|--|----------------|----------------|---|
| 8 | Дарьганга XXIV | Сүхбаатар | Үгүй | Байхгүй | 0 | 2011.02.09 – 2021.02.08 |
| 9 | Төхөм X (урд) | Дундговь, Дорноговь, Өмнөговь | Үгүй | Байхгүй | 0 | 2012.07.29 – 2020.07.28 |
| 10 | Сүхбаатар XXVII | Дорнод, Сүхбаатар, Хэнтий | Үгүй | Байхгүй | 0 | 2013.01.05 – 2021.01.04 |
| 11 | Хэрлэнтохой XXVIII | Дорнод, Сүхбаатар | Үгүй | Байхгүй | 0 | 2015.11.19 - 2023.11.18 |
| 12 | Ар булаг XXIX | Дорнод, Сүхбаатар | Үгүй | Байхгүй | 0 | 2017.08.29 - 2025.08.28 |
| 13 | Эргэл XII | Дорноговь | Үгүй | Байхгүй | 0 | 2017.06.12 – 2025.06.11 |

5.4.5 Газрын тосны лиценз

Газрын тосны эрэл, хайгуул болон олборлолт, үйлдвэрлэлтийн үйл явцтай холбоотой харилцааг Газрын тосны тухай хууль (<http://www.legalinfo.mn/law/details/10484>)-аар зохицуулдаг.

Газрын тосны эрлийн үйл ажиллагаа нь тодорхой нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хэтийн төлөвийг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизикийн тойм судалгааны ажлыг хэлнэ.

Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа нь газрын тосны орд нээж, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизик, өрөмдлөг, олборлолтын туршилтын ажлыг багтаадаг.

Газрын тосны ашиглалт гэдэгт газрын тос, уламжлалт бус газрын тосны орд ашиглалтын бүтээн байгуулалт, олборлолтын үйл ажиллагааг оруулна.

2015 оны 11 дүгээр сард орон нутгийн засаг захиргаа болон газрын тосны лиценз эзэмшигчдийн хооронд байгуулах "Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх тухай" гэсэн хамтын ажиллагааны гэрээний загварыг Засгийн Газрын 430 тоот тогтоолоор баталсан.

2016 оны 3 дугаар сард орон нутгийн засаг захиргаа болон ашигт малтмалын хайгуул, олборлолтын лиценз эзэмшигчдийн хооронд байгуулах "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай" гэсэн хамтын ажиллагааны гэрээний загварыг Засгийн Газрын 179 тоот тогтоолоор баталсан.

Тусгай зөвшөөрөл олгох болон олгосон тусгай зөвшөөрлийн бүртгэл хөтлөх эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын Тосны Газар байсан бол 2016 оноос энэ газар нь АМГ-тай нийлж, АМГТГ болсон³.

5.4.6 Газрын тосны тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэх үйл явц (шаардлага 2.2.a.i)

Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

³ (<http://www.pam.gov.mn/>)

Хүснэгт 5.31

| Үе шат | Төрийн захиргааны төв байгууллага | Үйл явц |
|--------|-----------------------------------|---|
| I. | УУХҮЯ | УУХҮЯ-нд хүсэлт гаргана: <ul style="list-style-type: none"> - Бүтээгдэхүүн хуваах гэрээний хуулбар (БХГ); - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ; - Тухай жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө; - Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулсан баримт; |
| II. | | Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох <ul style="list-style-type: none"> - Газрын тосны хайгуулын хугацаа найм хүртэл жил байх бөгөөд уг хугацааг хоёр хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. - Уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа арав хүртэл жил байх бөгөөд уг хугацааг тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно. - БХГ-г байгуулсан өдрөөс хайгуулын хугацааг тооцно. - Газрын тосны газар (ГТГ) нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ |

Эх сурвалж: Газрын тосны тухай хуулиас

Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Газрын тосны тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргахад бусад хүсэлт гаргагчдаас давуу эрх эдэлнэ.

Хүснэгт 5.32

| Үе шат | Төрийн захиргааны төв байгууллага | Үйл явц |
|--------|-----------------------------------|--|
| I. | УУХҮЯ | УУХҮЯ газрын тосны нөөцийг хүлээн авах тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гэрээлэгч ашиглалтын үйл ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргана. |
| II. | | Ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад дараах бичиг баримтыг бүрдүүлж УУХҮЯ-нд ирүүлнэ: <ul style="list-style-type: none"> - Газрын тосны нөөц бүртгэсэн тухай УУХҮЯ-ны шийдвэр; - Тухай жид гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл; - Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө; - Ашиглалтын үеийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ; - Байр зүйн зураг ашиглалатын талбайн булангийн цэгүүдийн солбилцлыг тэмдэглэсэн зураг; - Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулсан баримт; |
| III. | УУХҮЯ | УУХҮЯ нь ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ |

Эх сурвалж: Газрын тосны тухай хуулиас

2016 онд Дарьганга ХХIV БХГ-г 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Засгийн Газрын 41 тоот тогтоолоор “Апедскро Инвэстмэнт” ХХК-аас “Монгол Шин Лью” ХХК руу шилжүүлсэнээс хойш өнөөдрийг хүртэл хугацаанд газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн компани хараахан байхгүй байна.

Түүнчлэн энэхүү БХГ-үүд нь сонгон шалгаруулалтаар олгогдсон.

“Түвшин Интернэшнл” ХХК болон “Си Си Эф Петролиум” ХХК нь Арбулаг ХХIX талбайн сонгон шалгаруулалтад оролцож шалгараагүй бол “Күнанан Юаншинг Индистри, Трейд” ХХК нь Эргэл ХII талбайн сонгон шалгаруулалтад оролцсон боловч шалгараагүй байна.

Лиценз олгоход ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 5.33

| Д/д | Төрийн захиргааны байгууллага | Үйл явц | |
|-----|-------------------------------|--|--|
| 1. | АМГТГ | ГТГ нь нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байгаа талаарх мэдээллийг өөрийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гурваас доошгүй удаа зарлана. | |
| 2. | | ГТГ сонгон шалгаруулалтын материалыг 60 хүртэл хоног байх бөгөөд сонгон шалгаруулалтын эхний захиалга хүлээн авсан өдрөөс хойш тав хоногийн дотор захиалга хүлээн авах эцсийн хугацааг зарлана. Оролцогч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ: <ul style="list-style-type: none"> - Эрх зүйн байдлыг нотлох баримт бичиг; (<i>Улсын бүртгэлийн гэрчилгээ</i>) - Хөрөнгө оруулагчийн танилцуулга; - Төлөөлөх хүний овог, нэр, албан тушаал, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг, түүнд эрх олгосныг нотлох баримт; - Техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн чадварыг нотлох баримт бичиг; - Ажилд зарцуулах хөрөнгийн баталгаа; - Гүйцэтгэх ажлын төлөвлөгөө төсөв; - Хуулиндд заасан хайгуулын талбайн захиалгын үйлчилгээний хөлс 20,000 ам доллар төлсөн баримт; - Оролцогч нь бизнесийн түншлэлтэй бол түүний хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, оролцох хувь, хэмжээ; | |
| 3. | | ГТГ нь өргөдлийг хүлээн авсан эсэх талаар ажлын таван өдрийн дотор оролцогчид бичгээр мэдэгдэнэ | |
| 4. | | УУХҮЯ ба АМГТГ | Оролцогчийн талаарх мэдээллийг гэрээ байгуулах хүртэл гуравдагч этгээдэд задруулахгүй. |
| 5. | | АМГТГ | ГТГ нь дараах шалгуурыг үндэслэн Засгийн газарт (ЗГ) хамгийн ашигтай санал ирүүлсэн орлоцогчийг ялагчаар тодруулан энэ тухай сонгоно: <ul style="list-style-type: none"> - ЗГ-т ноогдох ашиг газрын тосны ноогдох хувь; - Нөөц ашигласны төлбөрийн хувь; - Өртөгт газрын тосны хязгаарын хувь; - Хайгуулын хөрөнгө оруулалтын хэмжээ; - Байгаль орчны нөхөн сэргээлтэд зарцуулах хөрөнгийн хэмжээ; - Сургалтын урамшууллын хэмжээ; - Гэрээнд гарын үсэг зурсны урамшууллын хэмжээ; - Олборлолт эхэлсний урамшууллын хэмжээ; - Олборлолт нэмэгдүүлсний урамшууллын хэмжээ; |

| Д/д | Төрийн захиргааны байгууллага | Үйл явц |
|-----|-------------------------------|--|
| | | <ul style="list-style-type: none"> - Орон нутгийг хөгжүүлэх урамшууллын хэмжээ; - Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг - ЗГ-т санал болгох сусад ашигтай нөхцөл; |

5.4.7 Бүтээгдэхүүн хуваах гэрээ

2017 онд “Жи Өү Эйч” ХХК-тай Бүтээгдхүүн хуваах гэрээ байгуулж, Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн № 265 дугаар тогтоолоор баталгаажуулсан байна.

2016 онд хоёр талбайд БХГ байгуулсан ба эдгээр БХГ-ний тусгай зөвшөөрлийг 2017 онд олгосон байна.

- Макс Ойл” ХХК-тай байгуулсан Арбулаг ХХИХ талбайн БХГ нь 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн ЗГ-ын 337 тоот тогтоолын дагуу 2016 оны 7 дугаар сарын 06-ны өдөр батлагдаж, 2017 оны 8 дугаар сарын 29-нд тусгай зөвшөөрлийг олгосон.
- “Смарт Ойл Инвэстмент Лимитед” ХХК-тай байгуулсан Эргэл ХII талбайн БХГ нь 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн ЗГ-ын 53 тоот тогтоолын дагуу 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр батлагдаж, 2017 оны 6 дугаар сарын 12-нд тусгай зөвшөөрлийг олгосон.

2017 оны байдлаар БХГ байгуулсан компаниудыг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 5.34

| д/д | БХГ-т талбай | БХГ батлагдсан огноо, Засгийн газрын тогтоолын дугаар | Гэрээлэгч компани | Оператор компани | Гэрээлэгчийн харьяалал | Талбайн хэмжээ, км.кв |
|-----|-----------------|---|--|--------------------------------|---------------------------|-----------------------|
| 1 | Тосон-Уул XIX | 1993.04.26 | Daqing Oil Field Ltd | Петрочайна Дачин Тамсаг ХХК | БНХАУ | 650 |
| 2 | Тамсаг XXI | 1996.08.07- ЗГ-ын тогтоол №183 | | | | 209,2 |
| 3 | 1997БХГ | 1997.02.19- ЗГ-ын тогтоол №47 | Доншен Жингүн Девелопмент Групп | Доншен газрын тос (Монгол) ХХК | БНХАУ | 239,5 |
| 4 | Матад XX | 2006.07.19- ЗГ-ын тогтоол №170 | Petromatad Invest Limited | ПетроМатад ХХК | Их Британий Мэний арал | 10343,2 |
| 5 | Нялга XVI | 2007.06.20- ЗГ-ын тогтоол №148 | Panasian Energy Ltd | Шэйман ХХК | Канадын Невисийн арал | 9239,4 |
| 6 | Цагаан-элс XIII | 2009.05.20- ЗГ-ын тогтоол №148 | DWM Petroleum AG | Гоби энержи партнерс Гмбх ХХК | Швейцарь | 1980 |
| 7 | Зүүнбаян XIV | | | | | 1030,7 |
| 8 | Галба XI | 2009.05.20- ЗГ-ын тогтоол №147 | Zong Heng You Tian Ltd | Зон Хэн Юу Тиан ХХК | БНХАУ | 9769,2 |
| 9 | Сулинхээр XXIII | 2009.07.22- ЗГ-ын тогтоол №224 | Шунхлай Энержи ХХК | Шунхлай Энержи ХХК | Монгол улс | 13576 |
| 10 | Борзон VII | 2009.07.29- ЗГ-ын тогтоол №236 | Импайр Газ Монголиа ХХК | Импайр Газ Монголиа ХХК | Мэний арал | 31432 |
| 11 | Хөхнуур XVIII | 2009.07.29- ЗГ-ын тогтоол №238 | Эн Пи Ай ХХК | Эн Пи Ай ХХК | БНХАУ | 5276 |
| 12 | Төхөм X(хойд) | 2009.07.29- ЗГ-ын тогтоол №237 | Сансарын геологи хайгуул ХХК | Сансарын геологи хайгуул ХХК | Монгол улс | 9813 |
| 13 | Цайдам XXVI | | | | | 11175,2 |
| 14 | Богд IV | 2009.07.29- ЗГ-ын тогтоол №235 | Сентрал азиан петролеум корпорэйшн лимитед | Капкорп монголиа ХХК | Их Британий Кэйманий арал | 28998,6 |
| 15 | Онги V | | | | | 21148,7 |

| д/д | БХГ-т талбай | БХГ батлагдсан огноо, Засгийн газрын тогтоолын дугаар | Гэрээлэгч компани | Оператор компани | Гэрээлэгчийн харьяалал | Талбайн хэмжээ, км.кв |
|-----|--------------------|---|--------------------------------------|-------------------------------------|------------------------|----------------------------|
| 16 | Баянтүмэн XVII | 2010.12.08- ЗГ-ын тогтоол №316 | Магнай трейд ХХК | Магнай трейд ХХК | Монгол улс | 7832 |
| 17 | Дарьганга XXIV | 2011.02.09- ЗГ-ын тогтоол №39 | Апекспро инвестмент лимитед | Эй Пи Экс Пи Эр Эү ХХК | Британий Виржини арал | 17178 |
| 18 | Төхөм Х (урд) | 2012.07.25- ЗГ-ын тогтоол №253 | Монголын алт (МАК) ХХК | Монголын алт (МАК) ХХК | Монгол улс | 24706,2 |
| 19 | Сүхбаатар XXVII | 2013.01.05- ЗГ-ын тогтоол №39 | Вульф петролеум ХХК | Вульф петролеум ХХК | Австрали | 23047,5 |
| 20 | Номгон IX | 2014.02.09- ЗГ-ын тогтоол №39 | Өмнөд монголын газар нутгийн тос ХХК | | | 29866,8 |
| 21 | Увс I | 2015.04.20, ЗГ-ын тогтоол №162 | Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК | Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК | Хонгконг | 19720 |
| 22 | Хэрлэнтохой XXVIII | 2015.04.20- ЗГ-ын тогтоол №162 | Хонгконг Вэлпэк Индастриал ХХК | Хонгконг Вэлпэк Индастриал ХХК | Хонгконг | 14280 |
| 23 | Хар-ус II | 2015.06.15- ЗГ-ын тогтоол №246 | Ренова илч ХХК | Ренова илч ХХК | БНХАУ | 27409,3 |
| 24 | Эргэл-ХII | 2016.06.20- ЗГ-ын тогтоол №337, | Макс ойл ХХК | Макс ойл ХХК | Монгол улс | /875+894.41 6/ 1769.416 |
| 25 | Ар булаг-XXIX | 2016.08.24- ЗГ-ын тогтоол №53 | Смарт ойл инвестмент лимитед | Смарт ойл инвестмент ХХК | БНХАУ | 11035 |

2017 оны байдлаар хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн компани харахан байхгүй байна.

5.4.8 БХГ-ний талаарх ил тод байдал (Шаардлага 2.4)

Засгийн газар нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний мэдээллийг ил тод болгоход татгалзах зүйлгүй байгаа бөгөөд Бүтээгдэхүүн хуваах гэрээг олон нийтэд мэдээлэхийг үүрэг болгосон Засгийн газрын 222 тоот тогтоолыг 2012 оны 7 дугаар сарын 4-нд баталсан.

Ашигт малтмал, газрын тосны газрын вебсайтанд "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний мэдээллийг 2014 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс хойш шинэчлэл хийгээгүй байна. Мөн тус тойм мэдээлэлд, өргөдөл гаргасан огноо, олгосон огноо, үргэлжлэх хугацаа болон талбайн солбицол, үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүний мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газраас олон нийтэд ил болгоогүй байна.

5.4.9 Газрын тосны бүтээгдэхүүний орлого

Газрын тосны тухай хуульд зааснаар газрын тос олборлогч аж ахуй нэгжүүд нь газрын тосны орлогоо Засгийн Газартай хийсэн БХГ-нд заасан хувь хэмжээний дагуу хуваадаг. АМГТГ-ын мэдэгдсэнээр компаниуд нь одоогийн дагаж байгаа тохиролцооны дагуу Засгийн Газарт борлуулалтын ашгийг мөнгөөр буюу ам.доллараар төлдөг.

БХГ-ний загварт Засгийн газар ашигт газрын тосноос өөрт ногдох хувийг мөнгөн бус (газрын тосоор) хэлбэрээр авах эрх үүсдэг, эсвэл ЗГ-т ногдох газрын тосыг гэрээлэгч компани арилжаалаад орлогыг ЗГ руу шилжүүлэх хүсэлт тавьж болно. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ЗГ-т ГТНАТ төлөх ёстой. Одоогоор ЗГ өөрт ногдох ашигт газрын тосоо мөнгөн бус хэлбэрээр авахгүй байгаа.

ОУИТБС-ын Шаардлага 2.4-д зааснаар ЗГ, ТӨААН-үүдийн борлуулсан газрын тосны биет хэмжээ ба борлуулалтын орлогыг ил тод тайлагнах ёстой. Үүний дагуу, бид БХГ-нд зааснаар газрын тосны нийт үйлдвэрлэлээс ЗГ-т ногдох биет хэмжээгээр, болон мөнгөн дүнгээр тайлагнах

хүсэлтийг тавьсан боловч, борлуулалтаас ЗГ-ын хүлээн авсан хувь хэмжээг мөнгөн дүнгээр АМГТГ-аас гаргаж өгсөн, харин биет хэмжээгээр гаргаж өгөх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн.

Энэ асуудал дээр стандартын шаардлагыг мөрдөөгүй тухай бид зөвлөмж хэсэгт оруулсан болно.

АМГТГ-аас тайлагнасан мэдээллийг доорх хүснэгтээр харуулав:

Хүснэгт 5.35

| ААН-ийн нэр | Борлуулалтын орлогоос Засгийн газарт ногдох нийт хувь | | Газрын тосны нөөц ашигласны төлбөр /ГТНАТ/ (сая төгрөг) | Бүгд |
|-----------------------------------|--|---------------------------------|---|-------------------|
| | Сая.төгрөг | Тос (кг) | | |
| Петрочайна Дачин Тамсаг ХХК | 190,048.35 | Биет байдлаар хуваагаагүй | 29,552.51 | 219,600.86 |
| Доншен газрын тос (Монгол) ХХК | 7,991.36 | | 2,112.92 | 10,104.28 |
| Нийт | 198,039.71 | | 31,665.43 | 229,705.14 |

2017 онд ЗГ нь БХГ-ний дагуу газрын тосны бүтээгдэхүүний борлуулалтын орлогоос өөрт ноогдох газрын тосонд нийт 198,039.71 сая төгрөг, газрын тосны нөөц ашигласны төлбөрт нийт 31,665.43 сая төгрөг, бүгд 229,705.14 сая төгрөг олсон байна.

5.4.10 Газрын тосны үйлдвэрлэл, экспорт

2017 онд олборлолтын гурван бүсэд 7,624,055 баррель газрын тос олборлож, 7,504,137 баррель газрын тос экспортод гаргасан байна. БХГ XIX болон БХГ XXI нь Дорнод аймгийн Матад, Халхгол сумуудад байршилтай байдаг бол БХГ-97 нь Дорноговь аймгийн Сайншанд суманд байршилтай.

2017 оны газрын тосны олборлолт болон экспортыг компани тус бүрээр харуулбал:

Хүснэгт 5.36

| № | БХГ-т талбай | Олборлолт | | Экспорт | |
|---|---------------------------------------|---------------|-----------------|---------------|-----------------|
| | | (сая баррель) | (мянган тонн) | (сая баррель) | (мянган тонн) |
| 1 | Тосон-Уул XIX-Петрочайна Дачин Тамсаг | 3.39 | 448.97 | 3.35 | 445.55 |
| 2 | Тамсаг XXI-Петрочайна Дачин Тамсаг | 3.91 | 539.95 | 3.82 | 529.00 |
| 3 | БХГ-97-Доншен газрын тос ХХК | 0.32 | 45.84 | 0.34 | 47.04 |
| | Нийт | 7.62 | 1,034.76 | 7.51 | 1,021.60 |

Газрын тосны бүтээгдэхүүний импортыг улс тус бүрээр харуулбал:

(тонн)

Хүснэгт 5.37

| Улсын нэр | ОХУ | БНХАУ | БНСУ | Бусад улс | Нийт |
|---------------------------------|--------------------|-----------------|----------------|----------------|--------------------|
| Бүтээгдэхүүний нэр төрөл | | | | | |
| 90-ээс доош октантай автобезин | 61,623.6 | | - | - | 61,623.5 |
| 90-ээс дээш октантай автобензин | 349,345.0 | 15,860.6 | - | - | 365,205.6 |
| Дизелийн түлш | 830,163.6 | 8,468.6 | - | - | 838,650.2 |
| ТС-1 | 36,236.4 | - | - | - | 36,236.4 |
| Бусад (тос, мазут, битум хий) | 178,839.2 | 1,469.0 | 9,321.6 | 7,747.9 | 187,377.8 |
| Нийт дүн | 1,456,207.7 | 25,816.3 | 9,321.6 | 7,747.9 | 1,499,093.5 |

Эх сурвалж: АМГТГ-ын Газрын тосны ашиглалтын хэлтэс, Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс.

5.4.11 Газрын тосны бүтээгдэхүүний үнэ

Монгол улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2017 онд 1,498 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолж дотоодын хэрэгцээгээ хангасан байна. Газрын тосны бүтээгдэхүүний импортыг бүтцээр нь авч үзвэл 90-ээс дээш октантай автобензин 25%, 90-ээс доош октантай автобензин 4%, дизель түлш 55%, онгоцны түлш 2%, бусад /тос тосолгооны материал, мазут, хий / 14%-ийг эзэлж байна. Нийт импортын 94.5 хувийг ОХУ, 3.4 хувийг БНСУ, 1.8 хувийг БНХАУ, үлдсэн 0.3 хувийг бусад улсаас импортолсон байна.

Манай Улс нь ОХУ-ын “Роснефть” компанитай урт хугацаанд хамтран ажиллаж ирсэн. 2014 оны 05 дугаар сард ОХУ, Монгол улсын аж ахуйн нэгжүүд хооронд байгуулсан худалдааны гэрээнд бүтээгдэхүүний үнийг Сингапурын олон улсын бирж дээрх шатахууны үнэд суурилсан томъёоллоор сар бүр тооцдог. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны 2016 онд сүүлийн 10 жилд байгаагүй доод цэгт буюу баррель нь дунджаар 43.55 ам.долларт хүрсэн. Түүнээс хойш тасралтгүй өссөөр 2018 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 1 баррель нефть дунджаар 69.18 ам.доллар буюу 2016 оныхтой харьцуулахад 58% -иар өссөн харагдаж байна. Үүнээс үзэхэд шатахууны үнэ өссөн шалтгаан нь дэлхийн зах зээл дээрх шатахууны үнээс хамааралтайгаар өссөн болох нь харагдаж байна. Доорх хүснэгтээр 2017 оны шатахууны үнийг сар бүрээр харуулав.



2017 оны 1 сарын 12-ны Монголбанкны судалгаа, статистикийн газрын эдийн засагч С.Мөнхчимэг “Монгол улсын түлш шатахууны үнэ, түүний бүтэц” гэсэн сэдэвт судалгаагаар шатахууны үнийн 46%-ийг шатахууны импортын үнэ, 33%-ийг татвар, 16%-ийг үйл ажиллагааны бусад зардал, 5%-ийг ашиг эзэлдэг болохыг тооцож гаргасан. 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 26 дугаар тогтоолоор А-80 болон Аи-92 төрлийн автобензиний онцгой албан татварын хэмжээг “0”-лэсэн нь тус бүтээгдэхүүний жижиглэн борлуулалтын үнийн огцом өсөлтийг саармагжуулсан буюу шатахууны үнийн 33% болох татварт шууд нөлөө үзүүлж үнийг тогтворжуулах арга хэмжээ авсан байна.

Эхэнд дурьдсанчлан Монгол улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангадаг бол Монгол улсын нутаг дэвсгэрээс олборлосон газрын тосыг экспортод түүхийгээр нь гаргадаг. (Дэлгэрэнгүй мэдээллийг бүлэг 5.4-өөс харна уу). 2017 онд нийт 374,071.43 мян ам.долларын 7,514 мян.баррель газрын тосыг экспортолсон байна. Доорх хүснэгтээр 2017 оны сар бүрийн 1 баррель газрын тосны дундаж экспортын үнийг, дэлхийн зах зээл газрын тосны ханштай (Ам.доллар/Баррель) харьцуулж харуулав.



Эх сурвалж: Блүүмберг дата сан

5.4.12 Газрын тосны салбар дахь төрийн оролцоо

Монгол Улсын нутаг дэвсгэрт 2017 оны байдлаар 18 талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээ (газрын тосны 10, нүүрсний давхаргын метан хийн 5, шатдаг занарын 3), 25 талбай (газрын тосны хайгуулын 22, ашиглалтын 3)-д бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна.

Манай Улсад газрын тосны эрэл, хайгуул, олборлолт, ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах үндэсний компани байхгүй, мэргэшсэн боловсон хүчин дутмаг, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл байхгүй, боловсруулах үйлдвэр баригдаагүй, дотоодод боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүний хангамж, чанарын хяналт, хадгалалтын тогтолцоо хангалттай сайн бүрдээгүй зэрэг шалтгаанаар тус салбарт хийгдэж байгаа ихээхэн хэмжээний гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын дийлэнх хувь (90 орчим) нь гадаадаас авсан ажил, үйлчилгээ, зөвлөхийн төлбөр, ажиллах хүчний ажлын хөлс, зэрэгт зарцуулагдаж байгаа нь гадагшлах мөнгөн урсгалыг нэмэгдүүлж байна.

Иймд Төрөөс газрын тосны салбарт 2027 он хүртэл Монгол Улсын үндэсний болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдол бүхий газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, бүс нутгийн хөгжлийг дэмжих, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх замаар газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурийг бий болгоход зорьж байна.

Мөн түүнчлэн Монгол улсын засгийн газрын 2016-2020 оныг хүртэлх хөтөлбөртөө газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах зорилт дэвшүүлсэн байна. Энэхүү зорилтын хүрээнд Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн өмчит компани байгуулах шийдвэр гарч, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит ХХК-ийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 108-р тогтоолоор байгуулж, улмаар жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр барих нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байна.

Монгол Улсын газрын тосны олборлолтын хэмжээ 2016 онд 1.1 сая тонн, 2017 онд 960.0 мянган тонн байсан. Цаашид улам өсгөх төлөвтэй байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тогтвортой хангахын тулд газрын тосны эрэл, хайгуулыг эрчимжүүлж нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

5.5 ОЛБОРЛОХ САЛБАРЫН ЗҮГЭЭС ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

5.5.1 Ерөнхий тойм

2013-2016 онуудад Монгол Улсын эдийн засгийн өсөлт 12 орчим хувиас 1,2 хувь хүртэл буурч, 2017 онд 5,1 хувийн өсөлттэй гарсан бөгөөд харин уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь 2013-2016 онуудад 14,9 хувиас 17,2 хувь, 2017 онд 21,2 хувь хүртэл байнга өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү үзүүлэлт нь нь уул уурхайн салбар улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд голлох үүрэгтэй болохыг харуулж байна.

Эдийн засгийн өсөлт урьдчилсан гүйцэтгэлээр 2017 оны эцэст өмнөх онтой харьцуулахад 5.8 хувиар өссөн бөгөөд үүнд уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын өсөлт дийлэнх хувийг бүрдүүлж байна.

Уул уурхайн салбарын 2017 оны өсөлтөд Оюу толгойн зэсийн баяжмалаас бусад эрдэс бүтээгдэхүүний олборлолт нэмэгдсэн нь нөлөөлжээ. Харин 2013-2015 онуудад уул уурхайн салбарын өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлж байсан Оюу толгойн ил уурхайгаас олборлож буй зэсийн баяжмалын хэмжээ тогтворжиж, агууламж нь 2016 оны 2 дугаар улирлаас эхлэн буурч эхэлсэнтэй холбоотойгоор уул уурхайн салбарын өсөлтөд төдийлөн нөлөө үзүүлсэнгүй.

Хүснэгт 5.38

| Уул уурхайн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ | | | | | | | |
|--|--|-------------|---------|---------|---------|---------|-------------------|
| # | Бүтээгдэхүүний нэр, үзүүлэлт | Хэмжих нэгж | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 оны 1-12 сар |
| 1 | Зэсийн баяжмал (35%-ийн агуулгад шилжүүлснээр) | мян.тн | 533.3 | 712.0 | 890.7 | 1445.1 | 1317.1 |
| 2 | Молибдений баяжмал (47%-ийн ийн агуулгад шилжүүлснээр) | тн | 3869.2 | 4254.0 | 5441.0 | 5173.7 | 5616.7 |
| 3 | Алт | кг | 8904.4 | 11503.8 | 14556.2 | 18435.7 | 19846.8 |
| 4 | Хайлуур жоншны баяжмал | мян.тн | 76.4 | 374.9 | 230.8 | 34.1 | 55.2 |
| 5 | Төмрийн хүдэр, баяжмал | мян.тн | 6011.2 | 10260.5 | 6173.4 | 2209.9 | 3675.0 |
| 7 | Цайрын баяжмал | мян.тн | 104.1 | 93.2 | 89.6 | 100.2 | 82.7 |
| 8 | Гянтболдын баяжмал | тн | - | - | - | - | - |
| 9 | Нүүрс | мян.тн | 30123.3 | 25287.8 | 24205.9 | 35522.3 | 49480.3 |

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны мэдээ, www.1212.mn Ашигт малтмал, газрын тосны газар “Эрдэс баялгийн статистик мэдээ 2017 оны 1-12 дугаар сар”

Өмнөх оныхтой харьцуулбал уул уурхай, олборлох аж үйлдвэрлэлийн салбарт төмрийн хүдэр баяжмалын үйлдвэрлэл 66.3 хувиар, хайлуур жонш, баяжмалын үйлдвэрлэл 61.9 хувиар, нүүрсний олборлолт 39.3 хувиар, молибденийн баяжмалын үйлдвэрлэл 8.6 хувиар, алтны үйлдвэрлэл 7.7 хувиар тус тус өссөн бол цайрын баяжмалын үйлдвэрлэл 17.5 хувиар, зэсийн баяжмалын үйлдвэрлэл 8.9 хувиар буурсан дүнтэй байна.

Дараах хүснэгтээс харахад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны эхний 12 сарын байдлаар 4291.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны жилийн эцсийнхээс 306.5 тэрбум төгрөг буюу 7.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 5.39

| Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, дэд салбараар, (Дүнд харьцуулсан хувь) | | | | | |
|---|-------------|-------------|-------------|-------------|-----------------|
| Салбар | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 оны 12 сар |
| Бүгд | 100 | 100 | 100 | 100 | 100 |
| Уул уурхай, олборлолт | 58.4 | 64.4 | 55.1 | 58.9 | 72.6 |

| | | | | | |
|-------------------------------|------|------|------|------|-------|
| Нүүрс олборлолт | 14 | 7.5 | 6.4 | 10.1 | 19.03 |
| Газрын тос олборлолт | 7.4 | 7.8 | 5.6 | 4.5 | 7.2 |
| Металлын хүдэр олборлолт | 31.3 | 44.9 | 39.6 | 40.9 | 45.5 |
| Бусад ашигт малтмал олборлолт | 1.1 | 1.0 | 1.0 | 0.8 | 0.9 |

Эх үүсвэр: ҮСХ. Статистикийн эмхэтгэл 2017. www.1212.mn

5.5.2 Ашигт малтмал: зэс, алт, мөнгө, төмрийн хүдэр

Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд хүнд үйлдвэрийн салбарын эзлэх хувь, ач холбогдол, бусад салбарт үзүүлэх хүчин зүйлс байнга нэмэгдсээр байна. Уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байгаа манай улсын хувьд уул уурхайн гаралтай эрдэс түүхийг эдээр нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, эдийн засаг, нийгмийн хөгжилд эрс өсөлт бий болгох боломжтой юм.

Алт олборлолт

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль 2009 онд батлагдан, хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор алтны үйлдвэрлэлийн хэмжээ харьцангуй буурч байсан билээ. Засгийн газраас алтны олборлолтыг дэмжиж хууль эрхзүй, татварын таатай нөхцөл бүрдүүлснээр 2013 оноос үйлдвэрлэл өссөн. Цаашид ч алт олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай хэмээн үзэж, 2016 онд Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монгол Банкны хамтарсан ажлын хэсэг байгуулагдан, “Алт-2” хөтөлбөрийг боловсруулж, 2017 оноос хэрэгжүүлж эхлээд байна (Ашигт малтмал, газрын тосны газар).

2017 онд 19.8 тонн алт олборлосон нь өмнөх оноос 1.4 тонн буюу 7.7 хувиар, 2012 оноос 13.9 тонн буюу 3.3 дахин, 2008 оноос 5.4 тонн буюу 36.9 хувиар өссөн байна.

Нийт олборлосон алтны 14.6 тонн буюу 73.6 хувийг экспортолсон бөгөөд өмнөх оноос 4.6 тонн буюу 24.0 хувиар, 2008 оноос 7.5 тонн буюу 33.9 хувиар буурч, 2012 оноос 11.8 тонн буюу 5.2 дахин өссөн байна.

Нэг хүнд ногдох алт олборлолтын хэмжээ 2017 онд 6.4 грамм болж, өмнөх оноос 0.3 грамм буюу 5.2 хувиар, 2012 оноос 4.2 грамм буюу 2.9 дахин, 2008 оноос 0.9 грамм буюу 16.0 хувиар өссөн байна.

Харин нэг хүнд ногдох алтны экспортын хэмжээ 2017 онд 4.7 грамм болж өмнөх оноос 1.6 грамм буюу 25.7 хувиар, 2008 оноос 3.7 грамм буюу 44.0 хувиар буурч, 2012 оноос 3.7 грамм буюу 4.6 дахин өссөн байна.

Бусад ашигт малтмалын олборлолт

Уул уурхай, олборлох үйлдвэрийн бусад нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзвэл, 2017 онд молибдений баяжмал, төмрийн хүдэр, хайлуур жоншны баяжмал, төмрийн хүдрийн баяжмал өмнөх онтой харьцуулахад 11.3-66.3 хувиар өсөж, харин зэсийн баяжмал, гянтболдын баяжмал, цайрын баяжмал, хайлуур жонш өмнөх онтой харьцуулахад 8.8-35.1 хувиар буурсан байна.

Зэсийн баяжмал металл агуулгаараа 2017 онд 1317.6 мянган тонн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 127.5 мянган тонн буюу 8.8 хувиар буурч, 2012 оноос 799.7 мянган тонн буюу 2.5 дахин, 2008 оноос 792.3 мянган тонн буюу 2.5 дахин өссөн байна.

Нэг хүнд ногдох зэсийн баяжмал 2017 онд 425.4 кг болж өмнөх оноос 52.1 кг буюу 10.9 хувиар, цайрын баяжмал 26.7 кг болж 6.4 кг буюу 19.4 хувиар, хайлуур жонш 35.1 кг болж 20.3 кг буюу 36.6 хувиар тус тус буурчээ.

Харин нэг хүнд ногдох молибдений баяжмал 2017 онд 1.9 кг болж өмнөх оноос 0.1 кг буюу 8.8 хувиар, төмрийн хүдэр 2484.0 кг болж 853.3 кг буюу 52.3 хувиар, хайлуур жоншны баяжмал 17.8 кг болж 6.6 кг буюу 58.2 хувиар, төмрийн хүдрийн баяжмал 1186.4 кг болж 456.3 кг буюу 62.5 хувиар нэмэгдсэн байна.

5.5.3 Газрын тос олборлолт

Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 32 талбай ялгасан ба 25 талбайд БХГ-ний дагуу 21 гэрээлэгч компани газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 талбайд газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа явагдаж байна. Газрын тосны Тамсаг, Тосон-Уул, Зүүнбаянгийн ордуудын баталгаат нөөцийг 332.64 сая тонн, ашиглалтын батлагаат нөөцийг 43.2 сая тонноор тогтоосон байдаг.

Тамсаг, Тосон-Уул, Зүүнбаянгийн ордуудаас 1996-2017 оны хооронд нийт 51.44 сая баррель буюу 6.95 сая тонн тос олборлож, 49.0 сая баррель буюу 6.62 сая тонн газрын тос экспортлон Улсын төсөвт 1.3 их наяд орчим төгрөгийг төвлөрүүлжээ.

Газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор 2017 онд Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайнуудад 147 цооног өрөмдөж, 128 цооногт олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан ашиглалтанд шилжүүлж, 175 цооногт перфораци, 166 цооногт шингэн хагалбар болон газрын тосны олборлолттой холбоотой бусад ажлыг гүйцэтгэж, 452.0 сая ам.доллар (Тосон-Уул XIX талбайд 210.0 сая ам.доллар, Тамсаг XXI талбайд 231.0 сая ам.доллар, БХГ-97 талбайд 11.0 сая ам.доллар)-ын хөрөнгө оруулалтыг хийж 7.62 сая баррель (1.03 сая тонн) олборлож, 7.50 сая баррель (1.02 сая тонн) экспортлон Улсын төсөвт 198.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн.

График 1: Газрын тосны олборлолт, экспорт



Эх үүсвэр: СЯ. 2018

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хайгуулын үе шатанд хэрэгжиж буй шинэчлэх шаардлагатай нийт 18 Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдээс 7 талбайн БХГ (Шунхлай-энержи ХХК-ийн Сулинхээр XXIII, Өмнөд монголын газар нутгийн тос ХХК-ийн Номгон IX, Монголиа шин ий энерги ХХК-ийн Дарьганга XXIV, Вульф петролеум ХХК-ийн Сүхбаатар XXVII, Эн Пи Ай ХХК-ийн Хөхнуур XVIII, Монголын алт ХХК-ийн Төхөм Х урд, Импайр газ Монголиа ХХК-ийн Борзон-VII)-г шинэчлэн байгуулсан ба 4 талбайн БХГ (Шэйман ХХК-ийн Нялга XVI, Магнай трейд ХХК-ийн Баянтүмэн XVII, Капкорп Монголиа ХХК-ийн Богд IV, Онги V)-г шинэчлэн байгуулахад бэлэн болгож 2 талбайн БХГ (Петроматад ХХК-ийн Матад XX, Зон Хэн Юу Тиан ХХК-ийн Галба XI)-г шинэчлэх хэлэлцээр хийж байна.

Нийт олборлосон газрын тосны 7.5 сая баррель буюу 98.6 хувийг экспортолсон бөгөөд өмнөх оноос 0.5 сая баррель буюу 6.3 хувиар буурч, 2012 оноос 3.9 сая баррель буюу 2.1 дахин, 2008 оноос 6.5 сая баррель буюу 7.1 дахин өссөн байна.


Нэг хүнд ногдох газрын тос олборлолтын хэмжээ 2017 онд 2.5 баррель байгаа нь өмнөх оноос 0.2 баррель буюу 9.7 хувиар буурч, 2012 оноос 1.1 баррель буюу 84.4 хувиар, 2008 оноос 2.0 баррель буюу 5.5 дахин өссөн байна.

Харин нэг хүнд ногдох газрын тосны экспортын хэмжээ 2017 онд 2.4 баррель болж өмнөх оноос 0.2 баррель буюу 8.4 хувиар буурч, 2012 оноос 1.1 баррель буюу 85.2 хувиар, 2008 оноос 2.0 баррель буюу 6.0 дахин өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтэд газрын тос олборлолтын эзлэх хувь 2017 онд 4.4 хувь болж, өмнөх оноос 0.3 пунктээр, 2012 оноос 0.2 пунктээр буурч, 2008 оноос 1.3 пунктээр өссөн байна. Харин уул уурхай, олборлох үйлдвэрт газрын тос олборлолтын эзлэх хувь 2017 онд 7.9 хувь болж, өмнөх оноос 0.5 пунктээр, 2012 оноос 0.01 пунктээр буурч, 2008 оноос 2.6 пунктээр нэмэгджээ.

Монгол улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2013 онд 1,407 мян.тн, 2014 онд 1,314 мян.тн, 2015 онд 1,191 мян.тн, 2016 онд 1,227 мян.тн, 2017 онд 1,498 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолж дотоодын хэрэгцээгээ хангаж байна.

График 2: Газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ



Эх үүсвэр: СЯ. 2018

Автобензин, дизелийн түлшний импорт 2006 оноос 2013 оныг хүртэл жилд дунджаар 10 хувиар өсч ирсэн боловч сүүлийн 2 жилд эдийн засгийн байдалтай уялдан буурсан үзүүлэлттэй байна. Шатахууны импортын хэмжээг төрлөөр нь авч үзвэл сүүлийн арван жилд А-80 автобензин тогтмол буурч байгаа бол АИ-92 автобензины импорт тогтмол өсч байна. Харин дизелийн түлшний импорт уул уурхайн үйл ажиллагаатай уялдан тогтворгүй, хэлбэлзэлтэй байгаа боловч урт хугацаанд өсөх хандлага ажиглагдаж байна.

5.5.4 Олборлох салбараас орсон Засгийн газрын нийт орлого (Шаард 6.3.б)

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт орлогын 56.3 хувийг улсын төсөв, 23.4 хувийг орон нутгийн төсөв, 20.3 хувийг НДС-ийн төсвийн орлого тус тус бүрдүүлсэн байна. Нэгдсэн төсвийн 2017 оны нийт орлого ба тусламжийн дүнд нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж 91.4 хувийг, Тогтворжуулалтын сангийн орлого 4.1 хувийг, Ирээдүйн өв сангийн орлого 4.5 хувийг тус тус эзэлж байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 87.0 хувийг татварын, 13.0 хувийг татварын бус болон хөрөнгө, тусламжийн орлогоос тус тус бүрдүүлсэн.

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн ҮАГ-ын аудитын тайланд дурьдсанаар зэсийн баяжмал, нүүрс, цайрын баяжмал, төмрийн хүдэр, жонш зэрэг эрдэс бүтээгдэхүүний үнийн болон биет хэмжээний өсөлтөөс хамаарч уул уурхайн салбараас тайлант онд 1,827.3 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн нь төсвийн орлогын 23.0 хувийг эзэлж, энэ нь өмнөх оноос 7.0 нэгж хувиар өссөн байна. ОУИТБС-ын 2017 оны тайлангаар нийт уул уурхайн салбараас хүлээн авсан орлого нь 2,240.6 сая төгрөг бөгөөд ҮАГ уул уурхайн салбараас төвлөрүүлдэг нийгмийн даатгал, гааль, орон нутгийн орлого, хандив дэмжлэгийг өөрийн аудитын дүнд оруулаагүйгээс зөрүүтэй илэрхийлэгдэж байна.

2017 онд уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний борлуулалтаас орсон АМНАТ-ын орлого 847.7 тэрбум төгрөг төвлөрүүлж, 11.2 хувиар буюу 85.2 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 5.40

| Уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний борлуулалтаас орох АМНАТ-ын орлого | | | | | | |
|--|-------------|----------|---------------------|---------|-----------------------------|--------------|
| Бүтээгдэхүүний нэр төрөл | Биет хэмжээ | | Үнэ, (ам.доллар/тн) | | Нийт орлого (тэрбум төгрөг) | |
| | Төлөв | Гүйц | Төлөв | Гүйц | Төлөв | Гүйц |
| Алт /тн/ | 17.0 | 17.5 | 1,255.0 | 1,257.2 | 41.2 | 15.6 |
| Нүүрс /мян.тн/ | 32,038.8 | 33,400.5 | 59.1 | 68.4 | 256.1 | 269.1 |
| Зэсийн баяжмал /мян.тн/ | 1,371.3 | 1,447.2 | 6,030.0 | 6,162.3 | 413.9 | 479.5 |
| Цайрын баяжмал мян.тн/ | 100.0 | 118.2 | 1,765.5 | 1,529.4 | 18.0 | 23.8 |
| Жонш, жоншны баяжмал мян.тн/ | 298.5 | 319.3 | 276.7 | 263.7 | 7.0 | 7.6 |
| Бусад | | | | | 26.3 | 52.1 |
| НИЙТ ДҮН | | | | | 762.5 | 847.7 |

Эх сурвалж: УАГ, Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, 2018

Уул уурхайн салбараас 2017 онд улсын төсөвт төвлөрүүлсэн АМНАТ-ийн 88.3 хувийг зэс, нүүрсний салбарын, 11.7 хувийг бусад уул уурхайн бүтээгдэхүүний татварын орлого тус тус эзэлж байна. Үүний 56.6 хувь буюу 479.5 тэрбум төгрөг нь зэсийн баяжмал, 31.7 хувь буюу 269.1 тэрбум төгрөг нь нүүрсний үйлдвэрлэлээс төвлөрчээ.

Тайлант онд татварын орлого бүрдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

- Уул уурхайн голлох эрдэс бүтээгдэхүүн болох зэс, нүүрсний үнэ болон экспортын биет хэмжээ нэмэгдсэн;
- Татвар төлөгч аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого, ашигт ажиллагааны түвшин өссөн;
- Нийт бараа эргэлтийн хэмжээ /экспорт, импорт/ өмнөх оноос 27.3 хувиар буюу 2.3 тэрбум ам.доллараар өсч, импортын барааны НӨАТ, гаалийн болон онцгой албан татварын орлого нэмэгдсэн байна.

2017 онд уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ болон биет хэмжээ өссөн нь АМНАТ-аас Төсвийн тогтворжуулалтын санд 297.4 тэрбум, Ирээдүйн өв санд 357.7 тэрбум, улсын төсөвт 192.6 тэрбум, нийт 847.7 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэх боломжийг бий болгосон байна.

Зэс, нүүрсний зах зээлийн үнэ 2017 оны турш тэнцвэржүүлсэн үнээс дээгүүр байснаар дээрх 2 санд нийт 683.4 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулсан нь төлөвлөснөөс 107.6 тэрбум төгрөгөөр давж биелэхэд нөлөөлжээ.

5.5.5 Олборлох үйлдвэрлэлийн экспорт орлого

Монгол Улс 2017 онд дэлхийн 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 10.5 тэрбум америк доллар, үүнээс экспорт 6.2 тэрбум америк доллар, импорт 4.3 тэрбум америк долларт хүрлээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 2.3 (27.3%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 1.3(26.1%) тэрбум америк доллараар, импорт 977.3 (29.1%) сая америк доллараар тус тус өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2016 онд 1.6 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2017 онд өмнөх оноос 307 (19.7%) сая америк доллараар нэмэгдэж, 1.9 тэрбум америк долларт хүрчээ.

Экспорт 2017 онд өмнөх оноос 1.3 тэрбум америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1.4 тэрбум америк доллар, үүнээс нүүрсний экспорт 1.3 тэрбум америк доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Хүснэгт 5.41

| Экспорт, импорт, зарим барааны бүлгээр, сая америк доллар | | | | |
|---|------------|------------|-------------|-----------------------------|
| Үзүүлэлт | 2015 I-XII | 2016 I-XII | 2017* I-XII | 2017* I-XII % 2016 I-XII |
| Экспорт | 4 669.3 | 4 916.3 | 6 200.7 | 126.1 |
| Эрдэс бүтээгдэхүүн | 3 678.2 | 3 484.1 | 4 933.8 | 141.6 |
| Үүнээс: Нүүрс | 555.9 | 973.1 | 2267.7 | 2.31 |
| Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлс | 72.3 | 86.2 | 101.0 | 117.2 |
| Түүхий болон боловсруулсан арьс, шир | 33.8 | 30.2 | 23.9 | 79.2 |
| Нэхмэл бүтээгдэхүүн | 302.7 | 300.2 | 335.5 | 111.7 |
| Үнэт чулуу, металл, гоёлын зүйлс | 421.4 | 761.5 | 596.9 | 78.4 |

Эх үүсвэр: ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2017/12. www.nso.mn

Эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 94.6 хувийг эзэлж байна.

Экспортод гаргадаг голлох түүхий эдийн үнэ, хэмжээг доор графикаар харуулав.



Эх үүсвэр: СЯ. 2018

5.6 ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУД

Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хамгийн их оролцоотой Засгийн газрын байгууллагуудын нэрсийг, ажил үүргийн ерөнхий чиглэлийн хамт дор харуулав.

Хүснэгт 5.42

| Яамдууд | Вебсайтууд |
|---|--|
| 1 Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | www.mmhi.gov.mn |
| 2 Ашигт малтмал, газрын тосны газар | www.mrpam.gov.mn |
| 4 Байгаль орчин, аялал жуучлалын яам | www.mne.mn |
| 5 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | www.mlsp.gov.mn |
| 6 Татварын Ерөнхий Газар | www.mta.mn |
| 7 Гаалийн ерөнхий газар | www.customs.gov.mn |
| 8 Үндэсний аудитын газар | www.audit.mn |
| 9 Цөмийн энергийн комисс | www.nea.gov.mn |
| 10 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | www.pcsp.gov.mn |

5.6.1 Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхэм зорилго нь ил тод, хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулж, эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгоход оршино.

Уул уурхай, түлш, газрын тос, хүнд үйлдвэр, геологийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлого, дунд, урт хугацааны стратеги, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, хэрэгжилтэд дотоодын хяналт-шинжилгээ хийх, төсвийн санхүүжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах нь тус яамны зорилго юм.

5.6.2 Ашигт малтмал, газрын тосны газар

Ашигт малтмал, газрын тосны газрын эрхэм зорилго нь төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд зорилт тавьж ажилладаг.

Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны ашиглалт болон Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсүүд нь Газрын тосны тухай хууль болон холбогдох дүрэм, журмуудын дагуу Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй.

5.6.3 Байгаль орчин, аялал жуучлалын яам

БОАЖЯ-ны үндсэн үйл ажиллагаа нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой үндэсний бодлого, хууль журмын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалахад оршино. Түүнчлэн, БОАЖЯ нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой тусгай асуудлуудын хүрээнд нийслэлийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын дагаж мөрдвөл зохих дүрэм журам, бодлогыг боловсруулж батлах, түүнтэй холбогдох шийдвэрийг гаргадаг.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тусгай зөвшөөрөлдөө хүлээж аваад 30 хоногийн дотор байгаль хамгаалах төлөвлөгөө БОАЖЯ-нд ирүүлэх ёстой байдаг ба яам уг тайланг хүлээн авч, хянах үүрэгтэй. Яам нь компаниудын байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд төсөвлөсөн зардлын

50%-ийг тусгай дансанд төвлөрүүлдэг. Тухайн компани байгаль хамгаалах төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлээгүй нөхцөлд уг 50%-ийг төлөвлөсөн зориулалтаар нь БОАЖЯ зарцуулах эрхтэй.

5.6.4 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

ХНХЯ-ны үндсэн үүрэг нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах явдал бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бодлогыг хэрэгжүүлэх, хөдөлмөрлөх таатай орчин бүрдүүлэх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах замаар хүний нөөцийг хөгжүүлэх явдал юм.

ХНХЯ нь хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулах, ажиллах нөхцөл ба амьжиргааны өртгийн асуудлыг сайжруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэдийн ажил эрхлэлтийн асуудал болон гадаад улсад хөдөлмөр эрхлэгчдийн асуудлыг зохицуулах үүрэгтэй. ХНХЯ-ны эрхэм зорилго нь хөдөлмөрлөх таатай орчин болон хөдөлмөрийн зах зээл дэх тэгш боломжийг бүрдүүлэх явдал юм.

5.6.5 Татварын Ерөнхий Газар

Татварын ерөнхий хуульд зааснаар Үндэсний татварын алба нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ТЕГ), аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагчаас бүрдэнэ. ТЕГ нь ЗГ-ын санхүүгийн асуудал хариуцсан байгууллага болох Сангийн Яамны харъяа байгууллага бөгөөд түүний удирдлагад ажилладаг.

ТЕГ-ын үндсэн чиг үүрэг нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх явдал юм.

5.6.6 Гаалийн ерөнхий газар

Монгол Улсын Гаалийн үйл ажиллагааг гаалийн төв байгууллага болох ГЕГ удирдан чиглүүлдэг бөгөөд түүний харьяанд аймаг, нийслэлийн гаалийн албадууд хамаарна. ГЕГ нь гаалийн хууль тогтоомжийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага бөгөөд Сангийн Яамны хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг.

ГЕГ-ын үндсэн чиг үүрэг нь гаалийн хуулийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх, түүний нийцлийг хянах, гаалийн хяналтын стратегийг тодорхойлох, гаалийн алба хэлтсийн үйл ажиллагааг зохицуулах, Гаалийн Хөгжлийн Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх юм.

5.6.7 Үндэсний аудитын газар

Үндэсний аудитын газар нь Монгол Улсын аудитын дээд байгууллага бөгөөд Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт захирагдана.

Үндэсний аудитын газар болон Монгол Улсын Ерөнхий аудиторовн үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Улсын Их Хурлаас бусад байгууллага, албан тушаалтан хяналт тавих, үүрэг даалгавар өгөхийг хориглоно.

Улсын Их Хурлаас бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрээс нь үл хамааран аудит хийх бүрэн эрхтэй байдаг.

ҮАГ нь Гүйцэтгэлийн аудитын газар, Санхүүгийн аудитын газар, Нийцлийн аудитын газар, Бодлого, төлөвлөлтийн газар, Хуулийн хэлтэс гэсэн таван газар, хэлтсээс бүрддэг.

5.6.8 Цөмийн Энергийн Комисс

Монгол Улсад цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийг бэлтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилт тавьж ажилладаг.

Цөмийн Энергийн Комиссын үндсэн үйл ажиллагаанууд нь цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн ашиглалтыг зохицуулах Засгийн Газрын бодлогыг хэрэгжүүлэх; цөмийн байгууламж, материал, цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой тусгай зөвшөөрлийг олгох эсвэл цуцлах; Монгол Улсын цөмийн энергийн салбарын шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагааг зохицуулах, хянах; цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

Цөмийн Энергийн Комисс нь Тамгын газар, Цөмийн технологийн бодлогын газар, Цөмийн аюулгүй байдлын бодлогын газар, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс гэсэн дөрвөн газар, хэлтсээс бүрддэг.

5.6.9 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрхэм зорилго нь төрийн өмчийн талаарх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, удирдлагыг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааг олон улсын жишигт хүргэн ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангахад оршино.

ТӨБЗГ нь Захиргаа, хууль зүйн хэлтэс, Худалдан авах ажиллагааны хэлтэс, Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс, Бодлого, төлөвлөлт, удирдлагын хэлтэс, Мэдээллийн технологийн алба зэрэг алба, хэлтсүүдээс бүрддэг.

ТӨБЗГ нь төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны ил тод байдал болон хувьчлалын ил тод байдлыг хангаж ажиллах үүрэгтэй.

5.7 ОЛБОРЛОХ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО

5.7.1 Уул уурхайн салбар дахь төрийн өмчийн компаниуд

ОУИТБС-ын Стандарт (2.6.а)-д ОУИТБС-ын тайлагналын зорилгоор төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг “төрийн нэрийн өмнөөс олборлох үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд” гэж тодорхойлсон. Уг стандартаар ОУИТБС-ын тайлан ТӨААН-ийн талаар өргөн цар хүрээний мэдээллийг хамруулахыг шаарддаг. Тухайлбал, “тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад эзэмших өөрсдийн хувь эзэмшлийн түвшинг ил тод болгоно. Энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн салбар болон хамтарсан аж ахуйн нэгжид бас хамааралтай бөгөөд тайлангийн хугацаанд эзэмшилд гарсан өөрчлөлтийн тухай мэдээллийг ил тод болгох ёстой”.

5.7.1.1 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын дагуу Худалдан авах ажиллагааны газар нь татан буугдаж, *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай* хуулийн 53-р зүйлд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт чиг үүрэг шилжсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 55 дугаар зүйлд Төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан хувьцаа, ногдол хувийг нь худалдах замаар хувьчилж болно. Энэ тухай шийдвэрийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана гэж заасан. /Энэ хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар болон 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиудаар өөрчлөлт оруулсан/

Эдийн засаг нийгмийн хэрэгцээ шаардлагын үүднээс төр зарим хувьцааг нийтэд санал болгохгүй, өөрийн өмчлөлдөө авч үлдэн төрийн өмчийн оролцоотой этгээд үүсгэж болно.

Мөн Энэ хуулийн 56 дугаар зүйлд компани болон өөрчлөгдсөн төрийн өмчит үйлдвэрийн газрын болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хувьцаа, ногдол хувийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр чөлөөтэй, эсхүл багцалсан хэлбэрт оруулан биржээр болон биржийн гадуур арилжиж худалдах

тухай заасан. /Энэ хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар болон 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиудаар өөрчлөлт оруулсан/

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын хувь эзэмшлийг эзэмшлийн төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 5.43

| Төрөл | Тоо |
|--|------------|
| Төрийн өмчит болон хувь оролцоотой компани | 87 |
| Төрийн өмчит аж ахуй нэгж байгууллага | 2 |
| Төрийн өмчит үйлдвэрийн газар | 38 |
| Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар | 21 |
| Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар | 163 |
| Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар | 134 |
| Нийт | 445 |

Эх сурвалж: <https://www.shilendans.gov.mn/orglist/41>

5.7.1.2 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниуд

Ашигт малтмал, газрын тосны газраас ирүүлсэн мэдээллээр дээрх компаниудаас олборлох салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой дараах 16 байгууллага байна. Доорх хүснэгтэд ОУИТБС-ын нэгтгэлд хамрагдсан болон хамрагдаагүй компаниудын мэдээллийг хураангуйлсан.

Хүснэгт 5.44

| № | Регистрийн № | Байгууллагын нэр | Нэгтгэлд хамрагдсан эсэх | Ашигт малтмал | Өмчийн хэлбэр | Тусгай зөвшөөрлийн тоо |
|--|--------------|---|--------------------------|---------------------------------|---------------------------------------|------------------------|
| Нэгтгэлд хамрагдсан компаниуд | | | | | | |
| 1. | 5124913 | Эрдэнэс Монгол ХХК | тийм | төрөл бүрийн | 100% төрийн өмчит | 4 |
| 2. | 2004879 | Шивээ овоо ХК | тийм | нүүрс | Эрдэнэс монгол ХХК 90%, бусад 10% | 1 |
| 3. | 2008572 | Багануур ХК | тийм | нүүрс | Эрдэнэс монгол ХХК 75%, бусад 25% | 3 |
| 4. | 5435528 | Эрдэнэс таван толгой ХК | тийм | нүүрс | Эрдэнэс монгол ХХК 81.5%, бусад 18.5% | 8 |
| 5. | 2074192 | Эрдэнэт үйлдвэр ХХК | тийм | зэс, молибден | Маргаантай | 8 |
| 6. | 2550466 | Монголросцветмет ХХК | тийм | алт, хайлуур жонш, нүүрс, мөнгө | 100% төрийн өмчит | 30 |
| 7. | 2051303 | Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК | тийм | төмрийн хүдэр | 100% төрийн өмчит | 3 |
| 8. | 2076675 | УБТЗ-ын Чулуун завод | тийм | барилгын материал-хайрга | МУ-ын ЗГ 50%, ОХУ-ын ЗГ 50% | 1 |
| Нэгтгэлд хамрагдаагүй компаниуд | | | | | | |
| 9. | 9011706 | ШШГЕГ-ын харьяа Булган аймгийн хорих 439-р анги | үгүй | барилгын материал | Төрийн өмчит аж ахуйн нэгж | 1 |

| № | Регистрийн № | Байгууллагын нэр | Нэгтгэлд хамрагдсан эсэх | Ашигт малтмал | Өмчийн хэлбэр | Тусгай зөвшөөрлийн тоо |
|-----|--------------|--|--------------------------|-------------------|----------------------------|------------------------|
| 10. | 9103619 | ШШГЕГ-ын харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба | үгүй | барилгын материал | Төрийн өмчит аж ахуйн нэгж | 1 |
| 11. | 9069798 | ШШГЕГ-ын харьяа Хорих 443-р анги | үгүй | нүүрс | Төрийн өмчит аж ахуйн нэгж | 1 |
| 12. | 9073523 | ШШГЕГ-ын харьяа Шүүхийн Шийдвэр Биелүүлэх Алба | үгүй | Барилгын материал | Төрийн өмчит аж ахуйн нэгж | 3 |
| 13. | 2683857 | ШШГЕГ-ын харьяа Авдрантхайрхан ХХК | үгүй | боржин чулуу | Төрийн өмчит аж ахуйн нэгж | 1 |
| 14. | 2053152 | ШТН | үгүй | барилгын материал | Төрийн өмчит аж ахуйн нэгж | 1 |
| 15. | 5976723 | Мончех ураниум ХХК | үгүй | уран | МУ-ын ЗГ 51%, ЧУ-ын ЗГ 49% | 1 |
| 16. | 9102981 | Уул уурхайн аврах анги | үгүй | нүүрс | Төрийн өмчит аж ахуйн нэгж | 2 |

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар болон компаниудаас ирүүлсэн мэдээлэл.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий дараах орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд байна. Үүнд:

Хүснэгт 5.45

| № | Регистрийн № | Байгууллагын нэр | Нэгтгэлд хамрагдсан эсэх | Ашигт малтмал | Өмчийн хэлбэр | Тусгай зөвшөөрлийн тоо |
|--------------------------------------|--------------|------------------|--------------------------|---------------|--------------------------------------|------------------------|
| Нэгтгэлд хамрагдсан компаниуд | | | | | | |
| 1. | 2016656 | Таван толгой ХК | тийм | нүүрс | Орон нутгийн өмч 51%, хувийн өмч 49% | 1 |
| 2. | 2034859 | Могойн гол ХК | тийм | нүүрс | Орон нутгийн өмч 51%, хувийн өмч 49% | 2 |
| 3. | 2014491 | Баян тээг ХК | тийм | нүүрс | Орон нутгийн өмч 70%, хувийн өмч 30% | 1 |

Улсад төлсөн татварын хэмжээ нь материаллаг эсэхээс шалтгаалан төрийн өмчит 8, орон нутгийн өмчит 3 компани нэгтгэлд хамрагдсан ба төрийн өмчит 8, орон нутгийн өмчит 1 компани нэгтгэлд хамрагдаагүй байна.

5.7.1.3 Эрдэнэс Монгол ХХК

Эрдэнэс Монгол ХХК нь Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг боловсруулах болон эзэмшихэд ЗГ-ын хувьцааг төлөөлөх зорилгоор байгуулагдсан тусгай зориулалтын компани юм.

Тус компани нь Монгол Улсын уул уурхайн хамгийн том хөрөнгө болох найман компанийн хувьцааг эзэмшдэг. Үүнд:

- Оюу Толгой ХХК (Эрдэнэс Оюу Толгой ХХК-аар дамжуулан шууд бусаар),

- Эрдэнэс Таван Толгой ХК,
- Багануур ХК,
- Шивээ Овоо ХК,
- Монатом ХХК,
- Гашуун сухайт авто зам ХХК,
- Эрдэнэс Метан ХХК болон
- Эрдэнэс шивээ энерги ХХК.



Эх сурвалж: Эрдэнэс Монгол ХХК

5.7.1.4 Эрдэнэс Монгол ХХК-ийн үүсгэн байгуулалт

Эрдэнэс Монгол ХХК өөрийн охин компаниудаараа дамжуулан зэс, алт, молибден, мөнгө, коксжуулсан хүдэр, цайрын баяжмал, төмрийн хүдэр, холимог металл болон фосфорит үйлдвэрлэх зэргээр уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг. Компани нь 2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Засгийн Газрын 266 дугаар тогтоол болон 2007 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Төрийн Өмчийн Хорооны 52 дугаар тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан ба Улаанбаатар хотод байрладаг.

МУ-ын ЗГ-ын 2016 оны 80 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан.

Энэхүү журмын 2.6-д “Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяа төрийн өмчийн оролцоотой “Эрдэнэс Оюу толгой” ХХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Мон-Атом” ХХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 11.8-д заасан журмын дагуу томилж, чөлөөлнө. (Энэ заалтад Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

5.7.1.5 Гашуун сухайт авто зам ХХК

2011 онд Монголын хувийн хэвшлийн “Энержи Ресурс” ХХК 239 км замыг ашиглалтад оруулсныг Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Нүүрсний экспортыг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” 299 дүгээр тогтоолоор авто замын өмчлөлийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлсэн.

2014 онд нүүрсний голлох экспортлогч “Энержи Ресурс” ХХК, “Эрдэнэс Таван толгой” ХК болон “Таван толгой” ХК зэрэг компаниудын оролцоотойгоор “Гашуун Сухайт авто зам” ХХК-ийг компанийг байгуулж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн замын хариуцагчаар ажиллаж байна.

5.7.1.6 Эрдэнэс Метан ХХК

2016 оны 2 дугаар сард “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани “Эрдэнэс Метан” ХХК нь байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлэв. “Эрдэнэс Метан” ХХК нь тэргүүн ээлжид гадаадын хөрөнгө оруулалт татах замаар Таван Толгой болон бусад ордын нүүрсний давхаргын метаны нөөцийг тогтоох, дараагийн ээлжид метаны олборлолтыг эхлүүлж Улаанбаатар зэрэг хот суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, цаашид Монгол Улсыг хий экспортлогч орон болгох зорилготой ажиллаж байна.

5.7.1.7 Эрдэнэс шивээ энержи ХХК

Төр, хувийн хэвшлийн хамтарсан “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК нь 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдөр “Эрдэнэс Монгол” ХХК болон “Эйкүсора” ХХК-ийн хоорондын гэрээгээр байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 64-р хуралдааны тэмдэглэлийг үндэслэн байгуулагдсан 1.2 тэрбум тонн нүүрсний нөөцтэй “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК нь стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн байгуулах Эрчим хүчний экспортын Шивээ Энержи цогцолбор төслийг нүүрсээр хангах юм.

Тус компанийн 50 хувийг Төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК, үлдсэн 50 хувийг хувийн хэвшлийн “Шинэ Шивээ” ХХК-ийн хувьцааг эзэмшдэг “Эйкүсора” ХХК тус тус эзэмшдэг.

5.7.1.8 “Эрдэнэс оюу толгой” ХХК

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Оюу толгойн зэс-алтны ордыг ашиглах “Хөрөнгө оруулалтын гэрээ”-г Монгол Улсын Засгийн Газар, “Рио Тинто Интернашнл Холдингс Лимитед” ХХК, “Айвенхоу Майнз” ХХК-ууд 2009 онд байгуулсан. Түүнчлэн “Оюу Толгой” ХХК-ийн хувь нийлүүлэгч талуудын хооронд “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”-г 2010 онд байгуулан ажиллаж байна.

Эдгээр гэрээнүүдийн дагуу “Оюу Толгой” ХХК-ийн хувьцааны 34 хувийг Монгол Улсын Засгийн Газар эзэмшиж байгаа бөгөөд “Эрдэнэс Монгол” ХХК-нд энэхүү 34 хувийг эзэмшүүлсэн.

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 348 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолуудаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани болох “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийг шинээр үүсгэн байгуулж, “Оюу Толгой” ХХК-ийн хувьцааны 34 хувийг “Эрдэнэс Монгол” ХХК-иас “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-нд албан ёсоор шилжүүлэв.

“Эрдэнэс Оюу Толгой” ХХК нь Монголын талын 34 хувийн хувьцааг эзэмшин, “Оюу Толгой” ХХК-ийн үйл ажиллагаанд оролцож, ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх явдал юм.

Оюу толгойн ил болон гүний уурхай бүрэн ашиглалтад орсноор ирээдүйд дэлхийн хэмжээний 5 том зэсийн уурхайн нэг болж Ази тивд олборлох нийт зэсийн 24 хувийг олборлоно.

5.7.1.9 Оюу Толгой ХХК

2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Туркойз Хилл компанийн толгой компани болох Рио Тинто компанитай байгуулсан гэрээний дагуу “Эрдэнэс Монгол” ХХК нь ЗГ-ын нэрийн өмнөөс “Оюу Толгой” ХХК-ийн 34%-ийг эзэмшиж байсан. Эрдэнэс Монгол ХХК нь 2011 онд өөрийн эзэмшлийн бүх хувьцааг охин компани болох Эрдэнэс Оюу Толгой ХХК-д шилжүүлсэн.

5.7.1.10 Шивээ овоо ХК

1995 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус уурхайг Төрийн өмч давамгайлсан “Шивээ-Овоо” ХК болгон зохион байгуулав. Нийт хувьцааны 90 хувийг төр буюу “Эрдэнэс Монгол” ХХК, 10 хувийг иргэд эзэмшдэг.

Сүүлийн жилүүдэд уурхайн уулын ажлын/нүүрс олборлолт, борлуулалт, хөрс хуулалт/ хэмжээ тогтвортой нэмэгдэж нүүрсний дотоодын зах зээл дээр эзлэх байр суурь улам бүр бэхжиж байна. Тус компани нь Монгол Улсын дотоодын нүүрсний хэрэгцээний 30%, “ДЦС-4” ТӨХК-ийн хэрэгцээний 50%-ийг хангаж байна.

Шивээ-Овоогийн нүүрсний уурхай нь Улаанбаатар хотоос зүүн урагшаа 265 километрт, Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт, далайн түвшнээс дээш 1,200 метрт оршдог.

Шивээ-Овоогийн нүүрсний орд нь нийт 29,500.0 га талбайг хамардаг бөгөөд нийт 2,708.7 сая тн нүүрсний нөөцтэй, 3 үндсэн хэсгээс бүрдэж байна. Үүнд:

Ордын нийт нөөц: 2,708.7 сая. тн

- Шинэ усны хэсэг - 564.1 сая.тн
- Өөхийн цагааны хэсэг – 1,147.9 сая.тн
- Ногоон тойрмын хэсэг - 996.7 сая.тн

5.7.1.11 Багануур ХК

Багануур ХК анх 1978 онд Төвийн эрчим хүчний системийн харьяа Дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зориулалтаар байгуулагдсанаас хойш 39 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. 2015 оны 2-р сарын 9-нд 100.0 сая дахь тонн нүүрсээ олборлосон.

1995 онд хувьчлагдан төрийн өмч давамгайлсан “Багануур” хувьцаат компани болон өөрчлөгдсөн. Нийт хувьцааны 75 хувийг төр буюу “Эрдэнэс Монгол” ХХК, 25 хувийг иргэд эзэмшдэг.

Үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал 4.0 сая.тн бөгөөд дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч 3.6-3.8 сая.тн нүүрсийг олборлож 16.0-18.0 сая шоо метр хөрс хуулж, авто тээвэртэй болон тээвэргүй хосолсон ашиглалтын системээр олборлолт явуулдаг. Монгол Улсын нүүрсний хэрэгцээний 60%, төвийн бүсийн нүүрсний хэрэгцээний 70 гаруй хувийг дангаараа хангаж ирсэн.

Багануурын нүүрс нь өөрийн физик, хими шинж чанараараа зөвхөн эрчим хүчний зориулалтаар ашиглагдах төдийгүй дахин боловсруулалт хийгдэн шатдаг хий, түлш, шингэн ба шахмал түлш, бусад химийн үйлдвэрлэлийн түүхий эд болох бүрэн боломжтой нь судалгаагаар батлагдсан.

Ордын нийт нөөц: 812 060.6 мян.тн

- Балансын – 584 458.4 мян.тн
- Балансын бус – 227 602.2 мян.тн

Өмнөх хайгуулаар ордын нийт нөөц 599.7 сая.тн байсан ба нэмэлт хайгуулаар нөөц 812.1 сая.тн болж 212.4 сая.тн-оор нэмэгдсэн.

5.7.1.12 Эрдэнэс Таван Толгой ХК

МУ-ын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий Таван толгойн коксжих нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор 2010 онд “Эрдэнэс Таван толгой” ХК-ийг байгуулсан.

“Эрдэнэс Таван толгой” ХК нь “Ашигт малтмалын тухай” хуулийн дагуу стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлээр ажилладаг.

“Эрдэнэс Таван толгой” төсөл нь нүүрс олборлолт, бүтээгдэхүүн боловсруулах, дэд бүтэц, үйлдвэрүүдийг барьж байгуулах, ус хангамжийн системийг байгуулах, ордод нэмэлт хайгуул, судалгаа хийх, бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд хүргэх, дотоодын болон олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаа арилжаалах гэсэн үндсэн чиглэлээр хэрэгжих юм.

Цанхийн Зүүн уурхайн ТЭЗҮ-ийг 2011 онд батлуулан, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд Цанхийн Баруун ТЭЗҮ-ийг 2012 онд батлуулан, олборлолтын үйл ажиллагааг 2013 оны 2

дугаар сараас тус тус эхлүүлсэн.

Ордын нийт нөөц: 6.008 тэрбум.тн

- Коксжих – 2.050 тэрбум.тн
- Эрчим хүчний – 3.757 тэрбум.тн
- Исэлдсэн – 0.201 тэрбум.тн

Цанхийн Зүүн уурхайн үйл ажиллагаа эхэлсэн 2010 оноос хойш өссөн дүнгээр нийтдээ 14.86 сая.тн (2017 оны 1 дүгээр сарын байдлаар) нүүрс олборлосон байна.

Цанхийн Баруун уурхайн үйл ажиллагаа эхэлсэн 2013 оноос хойш өссөн дүнгээр нийтдээ 10.65 сая.тн (2017 оны 1 дүгээр сарын байдлаар) нүүрс олборлосон байна.

5.7.1.13 Мон атом ХХК

Цөмийн энергийн тухай хуульд цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хэмжээнээс нь үл хамааран стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулж, ордыг ашиглах тохиолдолд төрийн төлөөллийг заавал хангасан байхыг шаарддаг. Энэ чиг үүргийг хариуцуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 45 дугаар тогтоолоор уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх үүднээс “Мон Атом” ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Тус компани нь Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн салбарт баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд бодлого, зохицуулалтын хувьд Цөмийн энергийн газарт, санхүүгийн хувьд Төрийн өмчийн хорооны мэдэлд анх үйл ажиллагаа явуулж байсан.

УИХ-ын 2015 оны 100 дугаар тогтоолын дагуу Төрийн өмчийн хороо татан буугдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 68 дугаар тогтоолоор тус компанийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани хэлбэрээр шилжүүлсэн.

5.7.1.14 Улаанбаатар Төмөр Зам чулуун завод

Улаанбаатар Төмөр Замыг МУ-ын ЗГ 50%-ийг, үлдсэн 50%-ийг ОХУ-ын ЗГ эзэмшдэг. Түүний нэг салбар нэгж болох чулуун завод нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг бөгөөд 1956 оноос хойш Дорноговь аймгийн Даланжаргалан суманд хайрга олборлолтын үйл ажиллагааг явуулж байна.

5.7.1.15 Уулын Баяжуулах Эрдэнэт Үйлдвэр ХХК

Уулын Баяжуулах Эрдэнэт Үйлдвэр ХХК нь дэлхийд томоохонд тооцогддог зэсийн уурхай, баяжуулах үйлдвэр юм. Анх 1978 онд Монгол – Орос хоёр орны Засгийн Газар хоорондын гэрээний дагуу үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн.

2016 онд Оросын Засгийн Газрын эзэмшиж байсан 49% Монгол улс дахь хувийн эзэмшилд шилжсэн ба энэхүү хэлэлцээр нь хууль шүүхийн байгууллага дээр маргаантай байна. 2017 оны байдлаар тус үйлдвэр нь 657.3 сая тонн хүдэр зэсийн баяжмал үйлдвэрлэн боловсруулсан байна.

5.7.1.16 Монголросцветмет ХХК

Монголросцветмет нь хайлуур жоншны уул уурхайн үйлдвэрлэл явуулдаг бөгөөд одоогийн байдлаар гурван далд уурхайн орд, хоёр ил уурхайн орд болон боловсруулах үйлдвэрийн хүчин чадалтай компани юм. Компани нь хүчил болон төмөрлөгийн хайлуур жоншны, мөн алтыг баяжуулан боловсруулах үйл ажиллагаа явуулдаг.

5.7.1.17 Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр

Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр нь 1990 онд Дархан-Сэлэнгийн төмрийн хүдрийн уурхайн үйлдвэрт суурилан үүсгэн байгуулагдсан. Төмөрлөгийн хүдрийн стратегийн ач холбогдол бүхий орд газрын нөөц нь ойролцоогоор 230 сая тонн байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг

хөгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд төмрийн хүдрийн нойтон соронзон боловсруулах цогц үйлдвэрийг 2014 онд байгуулсан. 2015 онд Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр менежментийн хувьчлалд орсон.

5.7.1.18 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд

Тавантолгой ХК

Тус уурхай нь зах зээлийн нөхцөлд зохицон 1994 оны 12 дугаар сарын 05-ны Засгийн газрын өмч хувьчлалын комиссын хурлын 42 тоот тогтоолоор төрийн өмч давамгайлсан Тавантолгой ХК болсон байна. 1995 оноос эхлэн Тавантолгой ХК нь орон нутгийн өмчит компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тавантолгойн нүүрсний орд нь Өмнөговь аймагт, Хятад – Монголын хилээс ойролцоогоор 270 км-ийн зайтай байрладаг.

Могойн Гол ХК

Могойн Гол ХК нь 1970 онд үүсгэн байгуулагдсан нүүрс олборлодог компани юм. Уурхай нь Хөвсгөл аймагт байрладаг бөгөөд 1994 оноос хойш Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй байна.

Баянтээг ХК

Баянтээг ХК нь 1961 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд нүүрсний уурхайн орд газар нь Өвөрхангай аймагт буюу Улаанбаатар хотоос 560 км зайтай байрладаг. 1995 онд хувьцаат компани болж дахин зохион байгуулагдсан ба хувьцааны 70% нь төрийн эзэмшилд байдаг. 1994 оноос хойш Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй байна.

Бусад ТӨААН-үүд

АМГТГ-аас ирүүлсэн тусгай зөвшөөрлийн мэдээлэлд үндэслэн бид ТӨААН-үүдээр дамжуулаОҮ-ийн салбар дахь бусад төрийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн талаар олж мэдсэн. Гэвч эдгээр аж ахуй нэгжүүд нь 2017 онд материаллаг төлбөр хийгээгүй учраас нэгтгэлийн хүрээнд хамрагдаагүй. Эдгээр ТӨААН-үүдэд

- ШТН,
- Авдрант Хайрхан,
- Булган аймгийн Хорих 439-р анги,
- Уул уурхайн аврах анги,
- Хэнтий аймгийн шүүхийн шийдвэр биелүүлэх алба, болон
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нар багтаж байна.

5.7.1.19 Төлөөлөн Удирдах Зөвлөл

ТӨААН-ийн төрийн өмчийн төлөөллийг Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмаар зохицуулан томилдог. Энэхүү журмын 2 дугаар зүйлд олборлох салбарын төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд төрийн өмчийн төлөөлөгчийг дараах байдлаар тогтоож өгсөн байна.

- Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн дарга болон гишүүдийг Засгийн Газрын 2016 оны 104 тоот тогтоолоор баталсан Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмийн 7.1, 8.2-т заасны дагуу Засгийн Газар томилж, чөлөөлнө.
- "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн хуралд Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газраас чиглэл болгосны дагуу "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-иас оролцох ба "Эрдэнэс Оюу Толгой" ХХК нь "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн төрийн өмчийн төлөөллийг томилж, чөлөөлнө.
- "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компаниуд болох "Эрдэнэс Оюу Толгой" ХХК, Багануур ХК, Шивээ-Овоо ХК болон "Мон-Атом" ХХК зэрэг төрийн өмчит компаниудын ТУЗ-ийн дарга болон гишүүдийг Засгийн Газрын 2016 оны 104 тоот тогтоолоор баталсан Эрдэнэс Монгол ХХК-ийн компанийн дүрмийн 11.8-д заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.

- Эрдэнэт Үйлдвэр ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн ТУЗ-ийн дарга болон гишүүдийг Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газраас чиглэл болгосны дагуу төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага томилж, чөлөөлнө.
- Төрийн Өмчийг Хэрэгжүүлэх журмын 2.4-2.9-т зааснаас бусад тохиолдолд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-д төрийн өмчийн төлөөллийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага томилж, чөлөөлнө.

Нэгтгэлд хамрагдсан 11 ТӨААН-үүдээс “Дархан Төмөрлөгийн үйлдвэр” ХК ТУЗ-ийн мэдээллээ ирүүлээгүй бөгөөд ТУЗ-ийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 21-с харна уу.

5.7.2 Засгийн газар болон ТӨААН-үүдийн санхүүгийн харилцаа

ЗГ болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль болон хуулийн дагалдах Төрийн өмчийг хэрэгжүүлэх журмуудаар зохицуулдаг. Энэхүү хуульд тусгайлан заагаагүй бол ЗГ болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг Компанийн тухай хууль болон тухайн төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн дүрмээр зохицуулдаг.

Компаниудаас авсан нэмэлт мэдээллийн маягтаар орон нутгийн өмчит Баянтээг, Могойн гол, Тавантолгой зэрэг орон нутгийн өмчит хувьцаат компаниуд нь ногдол ашгийн мэдээллээ дараах байдлаар ирүүлсэн. Үүнд:

Хүснэгт 5.46

Сая.төгрөгөөр

| # | Компанийн нэр | 2017 оны хуримтлагдсан ашиг/алдагдал | 2017 оны цэвэр ашиг/алдагдал | Тайлант онд зарласан ногдол ашиг | Олгосон ногдол ашиг |
|-------------|--|--------------------------------------|------------------------------|----------------------------------|---------------------|
| 1 | Багануур | 10,569 | 462 | - | - |
| 2 | Баянтээг | 2,827 | 1,132 | 25 | 24 |
| 3 | Дархан Төмөрлөгийн үйлдвэр | (15,694) | (1,633) | - | - |
| 4 | Могойн гол | 1,096 | 246 | 83 | - |
| 5 | Монголросцветмет | (18,161) | 15,713 | - | - |
| 6 | Тавантолгой | 166,342 | 141,055 | 126,923 | 45,924 |
| 7 | Улаанбаатар төмөр зам /Чулуун завод/ ХНН | (0) | (0) | - | - |
| 8 | Шивээ-Овоо | 5,262 | 241 | - | - |
| 9 | Эрдэнэс Монгол | (28,614) | 20,049 | - | - |
| 10 | Эрдэнэс Таван толгой | 36,821 | 461,069 | - | - |
| 11 | Эрдэнэт | 936,212 | 323,452 | - | - |
| Нийт | | 1,096,658 | 961,784 | 127,031 | 45,948 |

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл болон аудитлагдсан санхүүгийн тайлан.

2017 онд олгосон ногдол ашгийн мэдээллийг компани тус бүрээр дэлгэрүүлбэл:

Хүснэгт 5.47

Сая.төгрөгөөр

| Компани | Хувьцаа эзэмшигч | Эзэмшдэг хувьцааны тоо /ширхэг/ | Эзэмшил %/ | 2017 онд хүртсэн ногдол ашиг /сая.төг/ | 2017 онд олгохоор зарласан ногдол ашиг /сая.төг/ |
|----------------|-------------------|---------------------------------|-------------|--|--|
| Тавантолгой ХК | Орон нутаг | 26,859,252 | 51% | 23,421 | 64,731 |
| | Шандас импекс ХХК | 8,584,428 | 16% | 7,486 | 20,688 |
| | Ажнай корпоарци | 10,375,044 | 20% | 9,047 | 25,004 |
| | Бусад | 6,846,476 | 13% | 5,970 | 16,500 |
| Нийт | | 52,665,200 | 100% | 45,924 | 126,923 |
| Баянтээг ХК | Орон нутаг | 176,876 | 70% | 18 | 18 |
| | Шунхлай групп ХХК | 60,643 | 24% | 6 | 6 |
| | Бусад | 15,161 | 6% | - | 2 |
| Нийт | | 252,680 | 100% | 24 | 25 |

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл.

5.7.2.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

1996 онд УИХ-аас төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг баталсан.

Хуулийн 15 дугаар зүйлд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдал, ажлын үр дүнд хяналт тавина гэж заасан.

Хуулийн 16 дугаар зүйлд Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана. /Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/ Гэхдээ тухайн санхүүгийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр богино хугацаанд авах зээл, үнэт цаасанд хамаарахгүй. Мөн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зээл хамаарахгүй.

5.7.2.2 ТӨААН-үүдийн хоорондын гүйлгээ

Нэгтгэл тайланд хамрагдсан нийт 11 төрийн өмчит компаниуд руу ТӨААН-үүдтэй хийсэн хоорондын гүйлгээ, болон нүүрсний талаарх мэдээлэл хүссэн. Үүнээс 6 төрийн өмчит компани огт ТӨААН-үүдтэй аливаа гүйлгээ хийгээгүй гэж мэдэгдсэн.

ТӨААН-үүдэд шилжүүлсэн төлбөрийг дэлгэрүүлбэл:

Хүснэгт 5.48

Сая.төгрөгөөр

| Компанийн нэр | ТӨААН-д шилжүүлсэн төлбөр | | |
|---------------------------|------------------------------------|--|---------------|
| | Гүйлгээний утга | Хүлээн авагч | Дүн |
| Эрдэнэс Тавантолгой ХК | Цахилгааны төлбөр | Өмнөд бүсийн цахилгаан түгээх станц ТӨХК | 712 |
| | Интернет болон ярианы төлбөр | Монголын цахилгаан холбоо ХК | 43 |
| | Цахилгааны төлбөр | УБЦТСтанц | 13 |
| | Дулаан ашигласны төлбөр | УБДС ТӨХК | 14 |
| | Усны төлбөр | Улаанбаатар хотын ус сувгийн удирдах газар | 2 |
| | Албан бичиг хүргэлт | Монгол шуудан ХК | 1 |
| | Үйлчилгээний зардал | Цахилгааны дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК | 0 |
| | Сургалтын төлбөр | Монгол Кувейтын Байгаль хамгаалах төв ТӨҮГ | 1 |
| | Үйлчилгээний төлбөр /усны дүгнэлт/ | Монгол Ус ТӨААТҮГ | 21 |
| Дэд дүн | | | 806 |
| Монголросцветмет ХХК | Цахилгааны төлбөр | БНЗӨБЦТС ТӨХК | 8,801 |
| | Төмөр замын тээврийн хөлс | Улаанбаатар төмөр зам ХНН | 4,238 |
| | Онгоцны тийз | МИАТ ХК | 1 |
| | Нүүрсний төлбөр | Шивээ Овоо ХХК | 455 |
| | Сэлбэгийн үнэ | Эрдэнэт үйлдвэр ХХК | 10 |
| Дэд дүн | | | 13,505 |
| Эрдэнэс Монгол ХХК | Тооцоогоор | Эрдэнэс Оюу толгой ХХК | 891 |
| | Гэрээний дагуу | Мон-Атом ХХК | 1,181 |
| | Тооцоогоор | Эрдэнэс Метан ХХК | 95 |
| | Тооцоогоор | Эрдэнэс Шивээ Энержи ХХК | 326 |
| Дэд дүн | | | 2,492 |

| Компанийн нэр | ТӨААН-д шилжүүлсэн төлбөр | | |
|----------------|---------------------------------|--|------------|
| | Гүйлгээний утга | Хүлээн авагч | Дүн |
| Шивээ Овоо ХК | Шуудангийн төлбөр | Монгол шуудан ХК | 2 |
| | Тээврийн хөлс | Улаанбаатар төмөр зам ХНН | 350 |
| | Суурин утас, интернетийн төлбөр | Монголын цахилгаан холбоо | 5 |
| | Тархалтын судалгааны үнэ | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв | 0 |
| | Сургалтын төлбөр | ШУТИС | 3 |
| Дэд дүн | | | 361 |
| Баянтээг ХК | Цахилгааны төлбөр | ЭБЦТС ТӨХК | 79 |

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

ТӨААН-үүдээс хүлээн авсан төлбөрийн дэлгэрүүлбэл:

Хүснэгт 5.49

Сая.төгрөгөөр

| Компанийн нэр | ТӨААН-ээс хүлээн авсан төлбөр | | |
|----------------|-------------------------------|----------------------------|---------------|
| | Гүйлгээний утга | Хүлээн авагч | Дүн |
| Шивээ Овоо ХК | Нүүрсний үнэ | Чандмань бадрал ХХК | 454 |
| | | ДЦС 4 ТӨХК | 38,875 |
| | | Монголросцветмет ХХК | 555 |
| | | Налайх дулааны станц ТӨХК | 465 |
| | | Илчлэг Шивээ ОНӨҮГ | 34 |
| | | Ус-Ду ОНӨҮГ | 302 |
| | | Чандмань илч ОНӨУҮГ | 832 |
| | | Сэлэнгэ-Зүүнхараа ОНӨААУҮГ | 198 |
| Дэд дүн | | | 41,714 |
| Могойн гол ХК | Нүүрсний үнэ | Хөвсгөл дулааны станц ТӨХК | 633 |

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

5.7.2.3 Зээл болон зээлийн баталгаа

Нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдээс Засгийн газар болон ТӨААН-үүдээс авсан зээл, зээлийн баталгаа болон бусад ТӨААН-үүдэд олгосон зээл, зээлийн баталгааны мэдээллийг хүссэн. Үүнээс Багануур ХК болон Шивээ-Овоо ХК-иас бусад ТӨААН-үүд байхгүй гэсэн хариу өгсөн.

Хүснэгт 5.50

Сая.төгрөгөөр

| № | Зээлдэгчийн нэр | Гэрээний нөхцөл | | | Зээлдүүлэгч | Зээлийн зориулалт | Гэрээний дүн |
|---|-----------------|-----------------|----------------|-------------|------------------|---|--------------|
| | | Олгосон огноо | Төлөгдөх огноо | Зээлийн хүү | | | |
| 1 | Багануур ХК | 2017.03.15 | 2017.12.31 | 0% | Эрчим хүчний яам | Өвөлжилтийн бэлтгэл ажил, засвар үйлчилгээнд Үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангах | 25,000.00 |
| 2 | Шивээ-Овоо ХК | 2017.07.06 | 2017.12.31 | 0% | Сангийн яам | | 4,100.00 |

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

Монгол улсын хөгжлийн банкнаас уул уурхай, газрын тосны төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүдэд олгосон зээл, зээлийн баталгааны мэдээлэл дараах байдалтай байна:

Хүснэгт 5.51

| Зээлдэгч | Зээл/Зээлийн баталгаа | Олгосон огноо | Төлөгдөж дуусах огноо | Валют | Олгосон дүн /сая.нэгж/ | Үлдэгдэл /сая.нэгж/ | Хүү |
|------------------------|-----------------------|---------------|-----------------------|-------|------------------------|---------------------|-------|
| Багануур ХК | Зээл | 2013 | 2018.04.24 | MNT | 18,634 | 3,886 | 9.60% |
| Эрдэнэс тавантолгой ХК | Зээл | 2012 | 2019.04.30 | USD | 100 | 50 | 8.45% |
| Эрдэнэс тавантолгой ХК | Зээл | 2013 | 2019.04.30 | USD | 100 | 50 | 8.45% |

Эх сурвалж: Монгол улсын хөгжлийн банк

Монгол улсын Хөгжлийн банкнаас уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дараах төслүүдийг санхүүжүүлсэн. Үүнд:

Хүснэгт 5.52

| № | Төсөл хөтөлбөрийн нэр | Төслийн эхлэх, дуусах хугацаа | Гэрээний дүн | Олгосон санхүүжилт /өссөн дүнгээр/ | Зээлдэгч | Төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцэлтэй ба төслийн гүйцэтгэл |
|---|---|-------------------------------|-------------------|------------------------------------|----------|--|
| 1 | Жижиг, дунд үйлдвэрийг хэрэгжүүлэх төсөл | 2013.05.10 2017.12.31 | 50,000 сая төгрөг | 48,969 сая төгрөг | ЖДҮХС | 98% |
| 2 | Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл | 2014 он 2017 он | 991.9 сая төгрөг | 585.5 сая төгрөг | УУЯ | 60% |

Эх сурвалж: Монгол улсын хөгжлийн банк

Дээрх төсөл хөтөлбөрийн талаар товч танилцуулбал:

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл

Жижиг, дунд үйлдвэрлэгчдэд үйлдвэрээ өргөжүүлэхэд нь зориулан хөнгөлөлттэй зээлийг олгох замаар бизнесийг өргөжүүлэх, улмаар ажлын байрыг нэмэгдүүлэхэд, улс орны эдийн засагт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх юм.

Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл

Төслийн зорилго нь хүрэн нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх технологи нэвтрүүлж, жилд дунджаар 16.0 тэрбум шоо метр хий үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрүүд, гадаргын усны болон хий дамжуулах нийт 1500 км урттай хоолойнууд барьж, аж үйлдвэрийн томоохон кластер үүсгэх юм.

Эрчим хүчний байгаль орчинд ээлтэй байгалийн хийн үйлдвэрлэлийг нэвтрүүлж, дэд бүтцийг хөгжүүлснээр Улаанбаатар хотын утааны асуудлыг богино хугацаанд бууруулах боломжийг бүрдүүлнэ. Мөн эрчим хүчний шинэ эх үүсвэртэй болж, эрчим хүчний аюулгүй байдал, хараат бус байдлыг хангана.

5.7.2.4 ТӨААН-үүдэд хийгдсэн хөрөнгө оруулалт

Нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдээс тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын мэдээллийг хүссэн. Үүнээс Улаанбаатар төмөр зам /Чулуун завод/ ХНН болон Могойн гол ХК-иуд хөрөнгө оруулалт байхгүй гэсэн хариу өгсөн.

Хүснэгт 5.53

| ТӨААН | Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт | | | Нийт |
|--------------------------------|---|---------------|-----------------|----------------|
| | Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр | Банкны зээл | Бусад эх үүсвэр | |
| Багануур ХК | 66,114 | 4,002 | 13,678 | 83,794 |
| Баянтээг ХК | 781 | - | - | 781 |
| Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК | 7,757 | 16,719 | - | 24,475 |
| Монголросцветмет ХХК | 9,348 | - | - | 9,348 |
| Тавантолгой ХК | 3,850 | - | - | 3,850 |
| Шивээ-овоо ХК | 3,767 | - | - | 3,767 |
| Эрдэнэс монгол ХХК | 1,446 | - | - | 1,446 |
| Эрдэнэс тавантолгой ХК | 3,554 | - | - | 3,554 |
| Эрдэнэт үйлдвэр ХХК | 162,492 | | | 162,492 |
| Нийт | 259,109 | 20,721 | 13,678 | 293,508 |

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

Монгол улсын хөгжлийн банкнаас нэгтгэлд хамрагдсан компаниудад уул уурхайн бус чиглэлээр олгосон санхүүжилт

Монгол улсын Хөгжлийн банкнаас энэхүү нэгтгэлд хамрагдсан тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад уул уурхайн салбараас бусад салбарт дараах зээлийг олгосон байна. Үүнд:

Хүснэгт 5.54

| № | Төсөл хөтөлбөрийн нэр | Төслийн эхлэх, дуусах хугацаа | Гэрээний дүн | Олгосон санхүүжилт /өссөн дүнгээр/ | Зээлдэгч | Төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй ба төслийн гүйцэтгэл |
|---|-------------------------------------|-------------------------------|--|--|-------------------|--|
| 1 | Монцемент төсөл | 2013.07 2015.11 | 65 сая ам.доллар | 65 сая ам.доллар | “Монполимет” ХХК | 98% |
| 2 | Барилгын арматурын үйлдвэрийн төсөл | 2013 он 2015 он | 22,7 сая ам.доллар | 17,7 сая ам.доллар | “Бэрэн Групп” ХХК | 75% |
| 3 | Хөх цавын цементийн үйлдвэр | 2014.10 2017.06 | 20.0 тэрбум төгрөг, 45.6 сая ам.доллар | 20.0 тэрбум төгрөг, 45.6 сая ам.доллар | “МАК Цемент” ХХК | 91% |

Эх сурвалж: Монгол улсын хөгжлийн банк

Монцемент төсөл

Төслийн зорилго нь Жилд 1.0 сая тонн цемент үйлдвэрлэх үйлдвэрийг дэд бүтцийн хамт барих. “Монполимет” ХХК болон түүний охин компани “Сэнжсант” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Монцемент” төслийн цементийн үйлдвэрийг түлхүүр хүлээлгэн өгөх нөхцөлөөр, олон улсын стандартын дагуу барьж байгуулах гүйцэтгэгчээр Швейцарь улсын Holcim Групптэй хамтарсан БНХАУ-ын Хуашин цемент компани сонгогдон ажиллаж байгаа. “Хуашин Цемент” ХХК нь цементийн үйлдвэрийн зураг төсөл, тоног төхөөрөмж үйлдвэрлэл, нийлүүлэлт, барилгын болон тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд цементийн шугам 100%, чулуунцарын шугам 90%, дэд бүтэц 100%, нийт барилгын ажил 94%-ийн гүйцэтгэлтэй байна. Үйлдвэрийн цементийн шугамыг ашиглалтад оруулж, 2015 оны 08 дугаар сарын 13-ны өдөр нээлтээ хийсэн.

Барилгын арматурын үйлдвэрийн төсөл

Төслийн зорилго нь төслийн үр дүнд UHF Electric Arc Furnace технологитой жилд 100 мянган тонн өндөр чанарын ган цувимал бүтээгдэхүүний үйлдвэр бий болох бөгөөд Монгол улсад төмрийн хүдрийг бүрэн боловсруулан эцсийн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх металлургийн цогцолбор үйлдвэр шинээр бий болно.

“Бэрэн групп” ХХК нь “Барилгын арматурын үйлдвэр”-ийн тоног төхөөрөмжүүдийг Сингапур улсын FABER компаниас худалдан авахаар гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний дагуу туслах тоног төхөөрөмжийн төлбөрийн 80 хувь, үндсэн тоног төхөөрөмжийн төлбөрийн 20 хувийг хэсэгчлэн санхүүжүүлэхээр шийдвэрлэж, холбогдох гэрээнүүдийг байгуулан, туслах тоног төхөөрөмжийн гэрээний дагуу 80 хувь болох 17.7 сая ам.долларыг 2 үе шаттайгаар олгосон.

Хөх цавын цементийн үйлдвэр

Хөх Цавын цементийн үйлдвэр жилд нэг сая тонн цемент, 100 мянган тонн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай, Дорноговь аймгийн Даланжаргалан сум дахь Хөх Цавын чулууны ордод түшиглэн байгуулсан ба 2017 оны 6 сарын 9-нд нээлтээ хийсэн. Энэхүү үйлдвэр ашиглалтад орсноор дотоодын цементийн зах зээлийн 30-40 хувийг хангах боломжтой, 700 ажлын байр шинээр бий болгож, Монгол улсын төсөвт жилд 32.5 тэрбум төгрөгийн татвар төвлөрүүлж, 70-75 орчим сая ам.долларын импортыг орлох юм.

5.7.2.5 ТӨААН-үүдээс орон нутагт хийгдэж буй төлбөр

Сая.төгрөгөөр

Хүснэгт 5.55

| Компанийн нэр | Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг | Ус ашигласны төлбөр | Газрын төлбөр | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Түгээмэл тархацтай АМНАТ | Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн | Бусад | Торгууль | Нөхөн төлбөр |
|--|--|---------------------|---------------|-------------------------------------|---|--------------------------|---|-----------|-----------|--------------|
| Багануур ХК | - | 711 | 274 | 102 | 20 | - | - | 5 | - | - |
| БаянтээгХК | 16 | 1 | 1 | 13 | 1 | - | - | - | - | - |
| Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХК | - | - | 15 | 30 | 27 | - | - | - | - | - |
| Могойн гол ХК | 21 | 0 | 3 | 10 | 1 | - | 4 | - | - | 2 |
| Монголросцветмет ХХК | - | 615 | 38 | 52 | 17 | - | - | 8 | 0 | - |
| Тавантолгой ХК | 23,421 | 23 | 30 | 41 | 4 | - | - | - | 3 | - |
| Улаанбаатар төмөр зам /Чулуун завод/ ХНН | - | - | 0 | - | 1 | 89 | - | - | - | - |
| Шивээ-Овоо ХК | - | 578 | 3 | 75 | 2 | - | 14 | - | - | - |
| Эрдэнэс Монгол ХХК | - | - | - | - | 2 | - | - | 1 | - | - |
| Эрдэнэс Таван толгой ХК | - | 295 | 240 | 26 | 24 | 0 | - | - | 8 | - |
| Эрдэнэт үйлдвэр ХХК | - | 14,068 | 9,974 | 6,187 | 51 | 47 | - | - | - | - |
| Нийт | 23,458 | 16,290 | 10,578 | 6,536 | 149 | 136 | 18 | 14 | 11 | 2 |

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл.

5.7.2.6 Төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрүүд

ОУИТБС-ын стандартын шаардлагын дагуу төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрт төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хүлээн зөвшөөрсөн нийтийн нийгмийн хөрөнгө оруулалт, тухайлбал нийгмийн үйлчилгээ, нийтийн дэд бүтэц, түлшний татаас, засгийн газрын өрийн төлбөр гэх мэт улсын төсвөөс гадуурх зардлууд ордог.

Нэгтгэлд хамрагдсан 11 ТӨААН-үүдээс төсвийн шинжтэй зарцуулалтын мэдээг хүссэн. Үүнээс 5 ТӨААН зарцуулалттай тайлагнаж, Эрдэнэс монгол ХХК, Эрдэнэс таван толгой ХК, Монголросцветмет ХХК, Улаанбаатар төмөр зам /Чулуун завод/ ХНН, Таван толгой ХК, Могойн гол ХК-иуд төсвийн шинжтэй зарцуулалт байхгүй гэж мэдээлсэн. Тодруулбал:

Хүснэгт 5.56

Сая.төгрөгөөр

| ТӨААН | Төсвийн шинжтэй зарцуулалт | Төлбөрийн хэлбэр | Дүн |
|---|---|------------------|---------------|
| Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХК | Дэд бүтэцтэй холбоотой төлбөрүүд | | |
| | Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын наадмын талбайн засварт | Мөнгөн | 27 |
| | Сэлэнгэ аймгийн Хүдэр сумд шилэн кабел татахад | | 21 |
| Дэд дүн | | | 48 |
| Эрдэнэт үйлдвэр ХХК | Нийгмийн үйлчилгээ | | |
| | Уурхайчин соёлын ордонд соёлын арга хэмжээ | Мөнгөн | 2,292 |
| | Хүүхдийн орос цэцэрлэгт боловсролыг дэмжих | | 1,505 |
| | Эмнэлэг, сувиллын албанд | | 2,640 |
| | Ажилчдын байрлах зардалд | | 419 |
| | "Сэлэнгэ" амралтын бааз | | 3,380 |
| | Хүүхдийн зусланд боловсролыг дэмжих | | 479 |
| | Хүүхэдасрах "Энэрэл" төвд боловсролыг дэмжих | | 832 |
| | Орос сургуульд боловсролыг дэмжих | | 2,877 |
| Спорт комплексд спорт арга хэмжээнд | 4,361 | | |
| Дэд дүн | | | 18,783 |
| Багануур ХК | Түлшний татаас/хөнгөлөлттэй үнээр нүүрс борлуулсан/ | | |
| | ДЦС-4 ТӨХК | Мөнгөн бус | 1,832 |
| | ДЦС-3 ТӨХК | | 1,011 |
| | ДЦС-2 ТӨХК | | 561 |
| | ДДЦС ТӨХК | | 218 |
| | Амгалан ДС | | 99 |
| | Багануур ДС | | 1,167 |
| Дэд дүн | | | 4,889 |
| Шивээ-Овоо ХК | Түлшний татаас /хөнгөлөлттэй үнээр нүүрс борлуулсан/ | | |
| | ДЦС-4 ТӨХК | Мөнгөн бус | 3,296 |
| | Налайх дулааны станц ТӨХК | | 439 |
| | Монголросцветмент ХХК | | 97 |
| | Чандмань илч ОНӨУҮГ | | 62 |
| | Чандмань бадрал ХХК | | 27 |
| | Ус-Ду ОНӨУГ | | 19 |
| | Сэлэнгэ-Зүүнхараа ОНӨААУҮГ | | 9 |
| | Бусад ААНБ | | 165 |
| | Нийгмийн үйлчилгээ | | |
| Цэцэрлэгийн бэлтгэлийн Б бүлгийн ерөөний тохижилт | Мөнгөн бус | 3 | |
| Эмнэлэгийн хүүхдийн тасгийн ерөөний тохижилт | | 1 | |
| Дэд дүн | | | 4,117 |
| Баянтээг ХК | Нийгмийн үйлчилгээ | | |
| | Нарийнтээл сумын Бизнес хөгжлийн төвийн засвар | Мөнгөн бус | 20 |
| | Баянтээг Цэцэрлэгийн гадаад талбайн тоглоом | | 10 |
| | Өвөрхангай аймгийн Ахмадын өргөөд тавилга эд хогшил | | 80 |
| Дэд дүн | | | 110 |

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

Багануур ХК болон Шивээ-Овоо ХК-ийн түлшний татаасыг дэлгэрүүлбэл дулааны цахилгаан станцуудад дэлхийн зах зээлийн үнээс 3-4 дахин бага үнээр нүүрс нийлүүлдэг гэдэг нь харагдаж байна.

Хүснэгт 5.57

| № | ААНБ | Нийт татан авалтад эзлэх хувь | Нийлүүл элт нүүрс тн | Нийлү үлэлт сая.төг | 1тн нүүрсний дундаж үнэ /төг/ | 1тн нүүрсний дундаж өртөг /төг/ | 1 тн нүүрсний дундаж үнэ ам.доллар | 1 тн дулааны нүүрсний дундаж дэлхийн зах зээлийн үнэ ам.доллар |
|----------------------|---------------------------|-------------------------------|----------------------|---------------------|-------------------------------|---------------------------------|------------------------------------|--|
| Багануур ХК | | | | | | | | |
| 1 | ДЦС-4 ТӨХК | 50% | 1,732,775 | 52,780 | 30,460 | 31,518 | 12.92 | 42.15 |
| 2 | ДЦС-3 ТӨХК | 100% | 1,294,220 | 39,780 | 30,737 | | | |
| 3 | ДЦС-2 ТӨХК | 100% | 244,202 | 7,135 | 29,219 | | | |
| 4 | ДДЦС ТӨХК | 30% | 112,997 | 3,343 | 29,585 | | | |
| 5 | Амгалан ДС | 40% | 61,461 | 1,838 | 29,909 | | | |
| 6 | Багануур ДС | 100% | 56,878 | 626 | 11,000 | | | |
| 7 | УБТЗам ХНН | | 51,474 | 1,867 | 36,264 | | | |
| 8 | Багануур Илч ХХК | 100% | 19,518 | 676 | 34,645 | | | |
| 9 | Бусад | | 465,675 | 16,365 | 35,142 | | | |
| Шивээ-Овоо ХК | | | | | | | | |
| 1 | ДЦС-4 ТӨХК | 50% | 1,729,658 | 42,230 | 24,415 | 26,320 | 10.79 | 42.15 |
| 2 | Налайх дулааны станц ТӨХК | - | 31,265 | 384 | 12,280 | | | |
| 3 | Монголпро с цветмент ХХК | - | 46,092 | 1,116 | 24,220 | | | |
| 4 | Чандмань илч ОНӨУҮГ | - | 29,546 | 716 | 24,220 | | | |
| 5 | Чандмань бадрал ХХК | - | 12,677 | 307 | 24,220 | | | |
| 6 | Ус-Ду ОНӨУГ | - | 9,048 | 219 | 24,220 | | | |
| 7 | Зүүнхараа ОНӨААУҮ Г | - | 4,388 | 106 | 24,220 | | | |
| 8 | Илчлэг шивээ ОНӨУГ | - | 269 | 7 | 27,380 | | | |
| 9 | Бусад ААНБ | - | 157,338 | 3,976 | 25,271 | | | |

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл, ОУ-ын 33-ийн үнийг АМГТГ-ын статистик мэдээлэл

Төгрөгөөрх нүүрсний борлуулалтын үнийг ам.долларт хөрвүүлэхдээ Монголбанкны 2017 оны дундаж албан ханшийг ашигласан.

5.8 ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ БОЛОН ОРЛОГЫН ХУВААРИЛАЛТ

5.8.1 Орлогын менежмент

Засгийн газраас Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн төслийг 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Энэхүү баримт бичгийн хүрээнд өргөн барьсан “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” хуулийн төсөлд дараах зүйлсийг тусгаад байна. Үүнд:

- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогын 50 хувийг 2019 оноос эхлэн тухайн хайгуулын талбай байршиж байгаа аймгийн орон нутгийн хөгжлийн санд улсын төсвөөс шилжүүлж байгаатай холбогдуулан шинэ хөрөнгө оруулалтын төслүүдийг эрэмблэх замаар хөрөнгийг оновчтой үр дүнтэй төлөвлөж зарцуулах, гүйцэтгэлийн хяналтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- Түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн 50 хувь, газрын тосны тусгай зөвшөөрлийн орлогын 30 хувийг нүүрс болон газрын тос олборлож байгаа тухайн аймагт улсын төсвөөс шилжүүлж байгаа тул хуваарилсан хөрөнгийг агаарын бохирдолыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах үйл ажиллагаанд үр дүнтэй зарцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

5.8.1.1 Олборлох салбарын орлогын хуваарилалт ба орон нутгийн шилжүүлэг

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн төслүүдэд улсын төсвийн орлогын хуваарилалтад орж буй өөрчлөлтүүдийг дараах байдлаар тусгаад байна. Үүнд:

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг 2019 оноос эхлэн орон нутагт шилжүүлнэ.
- Уул уурхайн салбар хөгжихийн хэрээр тус салбарын нийгмийн хариуцлага нэмэгдэж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх шаардлага бий болохын зэрэгцээ уул уурхайн салбараас бий болсон орлогоос тухайн орон нутагт нь ахиу хөрөнгө хуваарилах шаардлага мөн бий болж байна.
- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.7 дах заалтад “ашигт малтмалын хайгуулын болон тусгай зөвшөөрлийн төлбөр”-ийн орлогыг Улсын төсвийн татварын орлогын бүрэлдэхүүнд тусгасан. Энэхүү эх үүсвэрийн 50 хувийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.7-д заасны дагуу аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилах хуулийн зохицуулалттай бөгөөд энэ нь 2020 оноос эхлэн мөрдөгдөнө.
- Хуулийн хэрэгжилтийг нэг жилээр наашлуулж ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувийг 2019 онд, үлдэх 50 хувийг 2020 онд буюу нийтдээ 100 хувь тухайн хайгуулын талбай оршиж байгаа орон нутгийн төсөвт шилжүүлэх зохицуулалтыг хийнэ. Харин ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлогын 50 хувийг тухайн олборлолт явагдаж байгаа орон нутгийн төсөвт 2020 оноос эхлэн шилжүүлнэ. Энэхүү зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.7-д өөрчлөлт оруулах байдлаар хийх ба үүнтэй уялдуулан мөн хуулийн 71 дүгээр зүйлийн 71.6 дахь хэсгийг хүчингүй болгохоор тооцов гэжээ.

5.8.1.2 Олборлох салбараас орж ирсэн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж бүртгээгүй тохиолдол (Шаардлага 5)

Бид улсын төсөвт бүртгээгүй байж болох орлогын мэдээлэл, ирээдүйд авах татварыг урьдчилан авчигсан боловч “өр” гэж бүртгэсэн байж болох мэдээллийг ирүүлэхийг Сангийн яамнаас хүссэн. Гэвч мэдээллээр гарах боломжгүй гэсэн хариу ирүүлсэн болно.

5.8.1.3 Орлогын тогтвортой байдал, байгалийн баялагаас хамааралтай байдал (Шаардлага 5.3.е)

Уул уурхайн салбарын 2019 оны хөгжлийн зорилтууд, 2020-2021 оны хөгжлийн төсөөлөл: Хараат бус хянагч–нэгтгэгч (Улаанбаатар Аудит Корпораци ХХК) нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Сангийн яамнаас ирээдүйд төсвийн мөчлөгт гарах өөрчлөлтүүдийн талаарх таамаглал, олборлох салбарын үйлдвэрлэлийн хэмжээний талаарх төсөөлөл, ашигт малтмалын зах зээлийн үнийн төлөв байдал, олборлох салбараас орох орлогын хэмжээний тухай урьдчилсан тооцоо, олборлох салбарын орлогын улсын төсөвт эзлэх урьдчилан таамаглаж буй хувь хэмжээ зэрэг мэдээлэл ирүүлэхийг хүссэн.

Эдгээр яамдаас Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг ирүүлсэн бөгөөд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, “Алт-2” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор олборлох үйлдвэрлэлийн салбарын 2019 оны хөгжлийн зорилт, 2020-2021 оны хөгжлийн төсөөллийг гаргасан байна.

Уул уурхайн салбарт 2019 онд ашигт малтмалыг хаягдал, бохирдолт багатайгаар, хүрээлэн буй орчин, хүний амьдрах орчинд сөрөг нөлөө багатайгаар үйл ажиллагаа явуулах төслийг дэмжихээс гадна экспортын чиглэлийг дэмжиж нэмэгдүүлэх зорилттой ажиллана. Мөн Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт, Тавантолгой төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

Гацууртын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулж улс, орон нутгийн төсөвт орох орлогыг нэмэгдүүлж, ажлын байр шинээр бий болгоно.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх” гэсэн зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Эрдэс баялгийн бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, экспортын нэг цонхны бодлогыг хэрэгжүүлэх;
- Эрдэс баялгийн нөөцийг байгаль орчинд ээлтэй технологиор иж бүрэн ашиглаж, боловсруулалтын түвшинг ахиулснаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэх;
- Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг боловсруулж, салбар хоорондын уялдааг хангах;
- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэх;
- Өнгөт болон хар төмөрлөг, нүүрс-хими, барилгын материалын үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг болно.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлсэнээр уул уурхайн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2016-2020 онд хэрхэн өсөх төсөөллийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5.58

| Салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл | | | | | |
|--|----------------------------------|-------------|---------|----------|----------|
| № | Бүтээгдэхүүний нэр, үзүүлэлт | Хэмжих нэгж | 2017 | Төсөөлөл | |
| | | | | 2018 | 2019 |
| 1 | Зэсийн баяжмал | мян.тн | 1,251.9 | 1,220.2 | 1,138.4 |
| 2 | Экспортын нүүрс | мян.тн | 41,480. | 28,360.0 | 32,075.5 |
| 3 | Төмрийн хүдэр /агуулга 56%/ | мян.тн | 3,675.0 | 5,000.0 | 5,000.0 |
| | Төмрийн баяжмал | мян.тн | - | - | 1,000.0 |
| 4 | Алт | тн | 19.8 | 19.0 | 19.0 |
| 5 | Цайрын баяжмал /агуулга 50%/ | мян.тн | 82.7 | 110.0 | 110.0 |
| 6 | Жоншны хүдэр, баяжмал | мян.тн | 164.1 | 200.0 | 200.0 |
| 7 | Молибдений баяжмал /агуулга 47%/ | мян.тн | 5.6 | 5.0 | 5.0 |
| 8 | Газрын тос | мян.тн | 1,080.0 | 1,087.0 | 1,481.2 |

Эх үүсвэр: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 2016

5.8.1.4 Уул уурхайн салбарт тулгарч болзошгүй эрсдэл

Хууль эрхзүйн хувьд. Ашигт малтмалын тухай, Газрын хэвлийн тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Байгаль орчны багц хуулиуд зэрэг 30 гаруй хууль, 40 гаруй журмаар тус салбарын асуудлыг тодорхой хүрээнд зохицуулж байгаа боловч тэдгээрийн өөр хоорондын уялдаа, хэрэгжүүлэх механизм хангалттай бус байгаа юм.

Олон улсын судалгааны байгууллагууд болох Канадын Фрейзер Институт, Эрдэс баялгийн засаглалын олон улсын хүрээлэнгээс Монгол Улсын уул уурхайн салбар дахь хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хийсэн судалгаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, тайлбарлах болон тэдгээрийг хэрэгжүүлэх механизмын хангалттай байдлын талаарх судалгаанд Монгол Улс ямар ч оноо аваагүй, 109 улсаас 104 дүгээр байранд, хууль тогтоомжийн хоорондын уялдаа, холбооны талаарх судалгаанд 101 дүгээр байранд тус тус орсон нь хөрөнгө оруулалт татахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Бүтээгдэхүүний үнэ, зах зээлийн хувьд. Монгол улс уул уурхайн бүтээгдэхүүний 90 гаруй хувийг зөвхөн БНХАУ-д экспортолдог. Энэ нь уул уурхай бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдал болон барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалтын идэвхээс шууд хамаарах нөхцөлийг үүсгэдэг.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын эдийн засгийн идэвхижилт суларч байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүн экспортлодог Австрали, Канад, Орос, Бразил болон Монгол зэрэг улсуудын эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна. Монгол Улсын валютын орох урсгалын 30 орчим хувийг зэсийн баяжмалын экспортоос бүрдүүлдэг. 2017 онд Монгол улс 14.7 сая тонн зэсийн хүдэр, баяжмалыг 1.61 тэрбум ам.доллараар экспортолсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал экспортын хэмжээ 9 хувиар буурсан байна. Дэлхийн зах зээл дээрх зэсийн ханшийн хэлбэлзэл болон эрэлт нийлүүлэлтийн нөхцөл байдал манай улсын эдийн засагт шууд нөлөөлдөг хүчин зүйлийн нэг бөгөөд дэлхийн болон уул уурхайн бүтээгдэхүүний гол импортлогч орны эдийн засгийн хямралаас шалтгаалсан үнэ ханшны бууралт нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, түүнээс олох орлогыг бууруулах, уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг урт болон богино хугацаанд зогсоох эрсдэлийг дагуулж байгаа юм.

Тээвэр ложистикийн хувьд. Уул уурхайн бүтээгдэхүүнийг авто зам, төмөр зам, далайн тээврээр хэрэглэгч буюу зах зээлд хүргэдэг тул уул уурхайн салбарын хөгжил нь зам тээврийн салбарын хөгжилтэй салшгүй холбоотой.

Зам, тээврийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын саатлаас шалтгаалан уул уурхайн төлөвлөсөн төсөл арга хэмжээний хэрэгжилт хойшлох, бүтээгдэхүүний тээврийн өртөг нэмэгдэх, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар буурах, зорилтот зах зээлд хүрч чадахгүй байх, бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн үнээс хэт багаар борлуулах зэрэг сөрөг нөлөө ажиглагдаж байна.

Нийгмийн нөлөө. Ашигт малтмал олборлолтод газар нутгийг идэвхитэй ашиглах нь газрын гадаргууг сүйтгэх, уулын боловсруулалт, уулын газар шорооны ажил, голын гидрологи горим алдагдах, хөрсний бохирдол, гадаргын болон гүний ус бохирдох, экологийн системийн бүрэн бүтэн байдал алдагдах, байгалийн ландшафтад эвдрэл гарах зэрэг хүрээлэн буй орчинд олон талын хүчтэй таагүй нөлөө үзүүлдэг үйлдвэрлэлийн салбар юм. Хүрээлэн буй орчинд үзүүлж байгаа таагүй нөлөөллөөс шалтгаалан уул уурхайн үйлдвэрлэлийн талаар сөрөг сэтгэлзүй нийгэмд түгээмэл байна.

5.8.1.5 Байгалийн баялагаас хамаарах төсвийн орлогын хамаарал

Манай улс зэсийн баяжмал, нүүрс, цайрын баяжмал, төмрийн хүдэр, жонш зэрэг нийт 20 төрлийн эрдэс бүтээгдэхүүн экспортолдог. Эдгээр бүтээгдэхүүний экспортоос хамаарч улсын төсөвт төвлөрдөг орлого 2011-2015 оны хугацаанд төсвийн орлогын 23 орчим хувийг эзэлж байсан бөгөөд 2011 онд 35 хувьд хүрч байсан нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Харин энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч, 2016 онд өмнөх 5 жилийн хамгийн бага түвшин буюу 14 хувьд хүрч байсан бол 2017 онд 23 хувийг эзэлсэн байна.

Засгийн газраас Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн төслийг 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Тус хуулийн төсөлд олборлох салбарын орлого 3.0 их наяд төгрөг буюу төсвийн нийт орлогын 27 хувийг бүрдүүлэхээр тооцсон. Үүнээс үзэхэд уул уурхайн салбараас хамаарах төсвийн орлогын хамаарал байсаар байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль Улсын Их Хурлын 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар батлагдсан. Уг хуулиар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 8,888.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 25.6 хувь, нийт зарлагын дээд хэмжээг 10,993.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.7 хувь байхаар тус тус тооцож нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -2,105.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 6.1 хувийн алдагдалтай байхаар баталсан.

Гадаад дотоод эдийн засгийн нөхцөл байдал, дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний төлөв болон ирэх 2019 онд Засгаас газраас авч хэрэгжүүлэх Гааль, татварын шинэчлэлийн бодлогын хүрээнд татварын бааз суурийг нэмэгдүүлэн, төсвийн орлого бүрдүүлэлтийн бүхий л боломжийг бүрэн дайчилснаар төсвийн орлого нэмэгдэхээр тооцож байна.

5.8.1.6 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (шаардлага 5.2)

Орон нутгийн хөгжлийн сан бол иргэдийн саналаар шийдэж зарцуулах төсөв юм. Тус сан нь засаг захиргааны нэгжүүд өөрсдийн хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд болон бие даан хэрэгжүүлэх ёстой чиг үүргүүдээ санхүүжүүлэх боломж бүрдүүлдгээрээ давуу талтай юм.

2017 оны хувьд дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын 5%, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 5%, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30%, олон улсын байгууллагаас олгох урамшуулал, дэмжлэгийг нийлүүлээд нийт 53.0 тэрбум төгрөгийг санд хуваарилсан байна.

Сангаас хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн хөгжлийн индекс зэргийг харгалзсан томъёогоор аймаг, нийслэл бүрт ногдох шилжүүлгийг хуваарилна. Аймаг, нийслэл өөрт ногдох хэсгээ үлдээж, 30%-иас доошгүйг сум, дүүрэгтээ мөн ижил үзүүлэлт бүхий томъёо ашиглан шилжүүлэх ёстой.

Тухайн орон нутгийн иргэд олон нийтийн бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн, мөн тэдний санал санаачилгаар дэмжигдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах бөгөөд тухайн орон нутгийн иргэдийн нийтийн хурал, ИТХ-ын шийдвэрээр баталгаажиж төсөвт тусгагдах ёстой.



Эх үүсвэр: Иргэдийн төсөв-2018, СЯ

2013 онд Сангийн яамнаас орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн системийг нэвтрүүлсэн. Уг системээс 2013 оноос хойших хугацааны орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хуваарилалтыг аймаг, нийслэл, сум, дүүргээр харах боломжтой. www.tusuv-oronnutag.mof.gov.mn харна уу.

2017 онд ОНХНС-ийн олгохоор тооцсон нийт 53.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн 39.1 хувь буюу 20.7 тэрбум төгрөгийг дотоодын НӨАТ, 31.2 хувь буюу 16.5 тэрбум төгрөгийг АМНАТ, 16.2 хувь буюу 8.6 тэрбум төгрөгийг газрын тосны НАТ, 13.5 хувь буюу 7.2 тэрбум төгрөгийг Тогтвортой амьжиргаа 3 төслийн урамшуулал, дэмжлэгээс бүрдүүлсэн байна.

ҮАГ нь 2018 онд ОНХС-ийн хөрөнгийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж байна гэсэн мэдээг Сангийн яамнаас ирүүлсэн.

Засгийн газраас 2018 оны 9 сард УИХ-д өргөн барьсан Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн төслийн хүрээнд Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогын 50 хувийг 2019 оноос эхлэн тухайн хайгуулын талбай байршиж байгаа аймгийн орон нутгийн хөгжлийн санд улсын төсвөөс шилжүүлэхээр төлөвлөж байна.

5.8.1.7 Ирээдүйн өв сан

Урт хугацааны хуримтлалын сан байгуулах, уул уурхайн салбарын орлогыг оновчтой удирдах хүрээнд Ирээдүйн өв сангийн тухай хууль 2016 онд батлагдаж, 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс Ирээдүйн өв сан үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

| Ирээдүйн өв санд төвлөрсөн орлого, зарцуулалт, 2017 он | | | |
|---|-------|--|-------|
| Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.2-т заасны дагуу төвлөрсөн, тэрбум төгрөг | 357.7 | Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу хуримтлагдсан үлдэгдлээс зарцуулсан, тэрбум төгрөг | 160.0 |

Эх үүсвэр: Сангийн яам, 2018

Ирээдүйн өв сан нь Монгол Улсын Нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг тул тусдаа санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гардаггүй. Иймд тус санд Үндэсний аудитын газраас тусгайлан аудит хийж, тайлан дүгнэлт гаргадаггүй.

Ирээдүйн өв сангийн эх үүсвэр дараах орлогоос бүрдэнэ:

- Ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;
- Төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь;

- Сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогоос энэ хуулийн 9.6-д заасны дагуу шилжүүлсний дараа Санд үлдэх хэсэг;
- Монгол Улсын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, шинээр хууль батлах замаар татвар бий болгох, татварын хувь, хэмжээг өөрчилсөн тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.7-д заасан ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдээс улсын төсөвт орох нэмэлт орлогын 50 хувь;
- 2018 оноос эхлэн тухайн жил улсын төсөвт орох энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4-т зааснаас бусад эрдэс баялгийн орлогын суурь жилийн орлогын гүйцэтгэлээс давсан хэсгийн 20 хувь.

Сангийн эх үүсвэр, хөрөнгөөс 2030 он хүртэл зарцуулахыг хориглоно. Өөрөөр хэлбэл үйл ажиллагаа, хяналттай холбоотой зардлаас бусад хэлбэрээр ямар нэг зарцуулалт хийхгүй. Мөн Сангийн хөрөнгийг зөвхөн олон улсын санхүүгийн зах зээлд гаргасан гадаад улсын нутаг дэвсгэрт арилжаалагдаж байгаа хөрөнгө оруулах хэрэгсэлд байршуулна гэж хуулийн 12.1.5-д заасан.

Тус хуульд зааснаар энэхүү сан нь нийт ард түмний өмч байх бөгөөд орлого, эх үүсвэр, хуримтлалын хувьд улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байхаар тусгасан. Хуулийн үйлчлэлийн хүрээнд байгуулагдах “Ирээдүйн өв сан корпораци” нь сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Энэ нь 100 хувь Төрийн өмчит хуулийн этгээд байна гэж хуульд заасан. Энэхүү корпораци нь хөрөнгө оруулах шийдвэрийг бусад байгууллага, албан тушаалтнаас хараат бусаар, бие даан гаргана.

5.8.1.8 Төсвийн тогтворжуулалтын сан

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 16 дугаар зүйлийн 16.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.1 дэх заалтын дагуу гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого болон нэгдсэн төсвийн суурь орлогоос давсан хэсгийг Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасны дагуу гол нэр төрлийн эрдэс баялаг зэс, нүүрсний 2017 онд баримтлах тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын валютын сан болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл хийдэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан өмнөх 12 жилийн үнийн дундаж болон тухайн төсвийн жил, түүний дараахь 3 жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тооцсон байна.

Нэгдсэн төсвийн 2017 оны нийт орлого ба тусламжийн дүнд нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж 91.4 хувийг, Тогтворжуулалтын сангийн орлого 4.1 хувийг, Ирээдүйн өв сангийн орлого 4.5 хувийг тус тус эзэлж байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 5.59


| Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж | | | | | | | |
|--|--|---------------|----------------|------------|--------|-------|-------|
| # | Төсвийн орлогын ангилал, зүйл | 2016 оны гүйц | 2017 оны | | | | |
| | | | Анх батлагдсан | Тодотгол 2 | Гүйц | Хувь | Зөрүү |
| | Нийт орлого ба тусламжийн дүн | 5,835.0 | 6,390.2 | 7259.5 | 7958.3 | 109.6 | 698.8 |
| | Тогтворжуулалтын сан | 0.0 | 8.4 | 242.4 | 325.7 | 134.4 | 83.3 |
| | Ирээдүйн өв сан | 0.0 | 221.7 | 333.3 | 357.7 | 107.3 | 24.4 |
| | Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн | 5,835.0 | 6160.1 | 6683.8 | 7274.9 | 108.8 | 591.1 |
| I. | Татварын орлого | 4,950.9 | 4983.7 | 5717.8 | 6315.1 | 110.4 | 597.4 |
| II. | Татварын бус орлого | 884.1 | 1176.4 | 966.0 | 959.8 | 99.3 | -6.2 |

Эх сурвалж: УАГ, Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, 2018

5.8.2 Төсвийн гүйцэтгэл, тайлагнал, аудитын цагалбар

Төсвийн захирагч нарын тайланд аудитын дүгнэлт гаргуулах, дээд шатны захирагчид хүргүүлэх, нэгтгэх, улмаар нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг батлах үйл явц, цаглабарыг доор харуулав.

НЭГДСЭН ТӨСВИЙН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ



Төсвийн гүйцэтгэл. Тухайн оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн төсөв зарцуулах эрх нээгдэх бөгөөд 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болдог. Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар болон бусад орлого төвлөрүүлэх үүрэгтэй байгууллагууд нь төсвийн орлогыг төрийн санд төвлөрүүлдэг ба батлагдсан төсвийн хуваарийн дагуу төрийн сангаас төсвийн байгууллагад санхүүжилт олгож, төлбөр тооцоог гүйцэтгэдэг.

Төсвийн тайлагнал. Сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээг төсвийн байгууллагууд гаргаж тогтоосон хугацаанд дээд шатны захирагчид хүргүүлдэг. ТЭЗ нар мэдээллийг нэгтгээд Сангийн яаманд хүргүүлнэ. Сангийн яам мэдээг нэгтгэн гаргаж сар бүрийн 8-ны дотор Үндэсний статистикийн хороонд хүргүүлэн олон нийтэд мэдээлдэг. Харин улирал, хагас жил, бүтэн жилээр төсвийн байгууллагууд санхүүгийн тайланг гаргаж дээд шатны захирагчид хүргүүлдэг. Аудитын байгууллагаар жилийн эцсийн санхүүгийн тайланд заавал аудит хийлгэдэг. Сангийн яам төсвийн ерөнхийлөн захирагчдын аудит хийлгэсэн тайланг нэгтгэн Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг гарган Үндэсний аудитын газарт хүргүүлнэ. Үндэсний аудитын газар нь тайланд аудит хийж, аудитын дүгнэлтийн хамт Засгийн газар, УИХ-д өргөн мэдүүлдэг. УИХ нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцсэнээр Монгол Улсын төсвийн гүйцэтгэл батлагддаг.

Төсвийн хариуцлага. Улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг Засгийн газар УИХ-ын өмнө хариуцдаг бол орон нутгийн төсвийн хувьд гүйцэтгэлийг бүх шатны засаг дарга тухайн шатны ИТХын өмнө хариуцдаг.

6 БУСАД АСУУДЛУУД

6.1 БЕНЕФИЦИАР ЭЗЭД (ШААРДЛАГА 2.5)

Бенефициар эзэд гэдэг нь аливаа компанийг жинхэнэ эзэмшдэг, удирддаг, эсвэл түүнээс ашиг хүртдэг хүмүүсийг хэлэх ба хууль ёсны хувьцаа эзэмшигчид болон компанийг төлөөлж ажиллаж байгаа албан тушаалтнуудаас өөр хүмүүсийг хэлдэг. Бенефициар эзэн нь тухайн компанид заавал хувь эзэмшсэн байх шаардлагагүй бөгөөд компанийн шийдвэр гаргалтад оролцож, нөлөөлж, нарийн төвөгтэй өмчлөлийн бүтцийн ард нуугдаж, шууд болон шууд бусаар ашиг хүртэж байдаг.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон улсын стандартаар 2020 оны 1 дүгээр сарын 1 гэхэд эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, тендерт оролцогч компаниудын ашиг хүртэгч эцсийн эзэнг олон нийтэд нээлттэй болгох, холбогдох бүртгэлийн сантай байхыг хэрэгжүүлэгч улс орнууддаа шаардлага болгосон билээ.

Бенефициар эздийн талаар ОУИТБС-ын Олон улсын хорооноос дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

| | |
|-------------------|--|
| 2013 оны 5-р сар | БӨ-ийн бүртгэлийг тайлагнахыг шаардах болсон. |
| 2013 оны 10-р сар | ОУИТБС-ын 11 орон БӨ-ийн туршилтын төслийг хэрэгжүүлсэн |
| 2016 оны 1-р сар | ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч 29 орон тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байна. 9 орон тайландаа энэ мэдээллийг оруулж байна. |
| 2016 оны 2-р сар | ОУИТБС-ын шинэ стандартаар 2020 оны 1-р сарын 1 гэхэд БӨ-ийг ил тод болгохыг шаардсан. |

6.1.1 Монгол улсын хандлага, ЗГ-ын бодлого

2016 онд ОТАХ-ээс ашиг хүртэгч эзэд буюу бенефициар гэдэг ойлголт, түүний эрх зүйн орчин, боломж, сорилт, асуудал, ашиглаж болох тогтолцоо зэргийг судлах ажлын дэд хэсэг томилсон ба тус дэд ажлын хэсгээс бенефициар эздийн мэдээллийг ил тод болгох Замын зургийн төслийг боловсруулж, 2016 оны 12-р сарын 20-ны өдрийн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, 2017 оны 12-р сарын 21-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

Замын зурагт 2020 он хүртэл хэрэгжүүлэх 32 үйл ажиллагааг 7 зорилтын хүрээнд төлөвлөсөн. Замын зургийн дэлгэрэнгүйг дараах линкээр үзнэ үү. <http://www.eitimongolia.mn/mn/beneficial-ownership-disclosure>.

ОУИТБС-ын Ажлын хэсгийн 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар ашиг хүртэгч эцсийн эзэнг ил тод болгохтой холбоотойгоор нэр томъёо, тодорхойлолт, хамрах хүрээ, материаллаг босго, цуглуулах мэдээлэл зэргийг хэлэлцэж, эцэслэн баталсан. Энэхүү хуралдаанаар батлахаас өмнө төр, компани, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн 9 цуврал хэлэлцүүлгээр нийт 260 гаруй оролцогчид хэлэлцэж, саналыг тусган, эцсийн хувилбарыг боловсруулсан байна. Мөн дараах тодорхойлолтуудыг тохирсон:

“Ашиг хүртэгч эцсийн эзэн” гэдэгт эрдэс баялгийн салбарт тусгай зөвшөөрөл эзэмшигч, хөрөнгө оруулагч, тендерт оролцогч, гэрээлэгч хуулийн этгээдийн 5 хувь буюу түүнээс дээш хувьцаа эсхүл түүнтэй адилтгах үнэт цаасыг, 20 хувь буюу түүнээс дээш саналын эрхийг, хувь буюу түүнээс ногдол ашгийг шууд болон шууд бусаар эзэмшдэг, өмчилдэг, хүртдэг, удирдлага, хяналтыг шууд болон шууд бусаар хэрэгжүүлдэг, эсхүл бусад хэлбэрээр эрхээ хэрэгжүүлдэг хувь хүнийг ойлгоно.

“Эзэмшил, өмчлөлийн эрхийг шууд бус хэлбэрээр хэрэгжүүлэх” гэдэгт өөрийн эзэмшлийн хувьцаа, түүнтэй адилтгах үнэт цаас, саналын бусад эрхийг гэрээ, итгэмжлэл, төлөөллийн бусад хэлбэрээр өөрийн хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой, холбогдох этгээдээр дамжуулан хэрэгжүүлэх эсхүл 1 буюу түүнээс дээш үргэлжлэх гинжин холбоо бүхий хуулийн этгээдийн үүсгэн байгуулахыг ойлгоно.

“**Шууд удирдлага, хяналтын эрх**” гэдэгт Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл болон компанийн дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтныг томилох, их хэмжээний хэлцлийг байгуулах шийдвэрийг дангаараа болон нэгдмэд сонирхолтой этгээдтэй хамтран гаргах эрхийг ойлгоно.

“**Шууд бус удирдлага, хяналт**” гэдэгт Компанийн удирдлага, хяналтын эрхийг гэрээ, итгэмжлэл, төлөөллийн бусад хэлбэрээр эсхүл өөрийн хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой этгээдээр дамжуулан хэрэгжүүлэх нөхцөл байдлыг ойлгоно

Хэрэв ашиг хүртэгч эцсийн эзэн нь **улс төрд нөлөө бүхий этгээд** бол түүнд болон түүний хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой этгээдийн хувь эзэмшилд босго тогтоох шаардлагагүй (0%) бөгөөд нийтэд заавал ил тод мэдээлнэ.

Улс төрд нөлөө бүхий этгээд гэдэгт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20,2-т заасан албан тушаалтнуудыг ойлгоно.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 4-р сарын 12-ны 114 тоот тогтоолоор Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан. Энэхүү тогтоолын хавсралт төлөвлөгөөний 4.1.6.5-д Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох ба 2020-2022 онд хэрэгжүүлж, МОУИТБС-ын Ажлын алба хариуцахаар тусгасан байна.

Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлөөс “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө (ҮАҮТ)”-г Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаар ҮАҮТ-ний төслийг дэмжиж, Засгийн газрын гишүүдийн саналыг тусгасан ба нийт 13 зорилтот үйл ажиллагаа бүхий ҮАҮТ-ний төслийг Үндэсний зөвлөл 2016 оны 6 дугаар сарын 7-ны өдөр хуралдан хэлэлцэж, батласан.

Энэхүү төлөвлөгөөний 12 дахь зорилтот үйл ажиллагаа нь Байгалийн баялгийг ашиглагч этгээдийн эздийг буюу бенефициар өмчлөгчдийг ил болгох тухай бөгөөд Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллахаар даалгажээ.

6.1.2 Бенефициар эздийн ил тод байдал

2017 оны ОУИТБС-ын тайланд зориулан нэг үе шат бүхий асуулгаар шууд бенефициар өмчлөгчийг тодорхойлох маягыг боловсруулж, цахим тайлангийн системд оруулсан.

Маягтаар ОУИТБС-ын шаардлагын дагуу дараах мэдээллийг цуглуулах боловч нийтэд хэсэгчилэн ил тод болгосон. Үүнд:

- Овог нэр,
- Үндэс угсаа,
- Регистрийн дугаар,
- Төрсөн огноо,
- Иргэний харьяалал, давхар иргэншил
- Оршин суугаа улсын нэр
- Улс төрд нөлөө бүхий этгээд эсэх,
- Компанидаа удирдах албан тушаал хашдаг эсэх
- Одоо хашиж буй ажлын газрын хаяг,
- Өмчлөлийн хувь хэмжээ,
- Бусдын өмнөөс эрх хэрэгжүүлдэг эсэх,

Хараат бус хянагч-нэгтгэгч нь бенефициар өмчлөгч гэж юу болох, энэ ойлголттой холбоотой маягыг хэрхэн бөглөх талаар сонгогдсон компаниудад Монголын ОУИТБС-ын Ажлын албатай хамтран 2 удаагийн сургалт зохион байгуулсан.

Ийнхүү нийт 230 компаниас 184 компани бенефициар өмчлөгчийн мэдээллээ ирүүлсэн нь 2014 оноос хойш бенефициар өмчлөгчийн мэдээллийг ил тод болгож байсан статистиктэй харьцуулахад маш дэвшилттэй зүйл болсон.

Үүнээс гадна 38 компани бенефициар өмчлөгчийн мэдээлэл ирүүлээгүй, 4 компанитай холбогдож чадаагүй, 4 компани цахим тайлангийн системд мэдээллээ хадгалсан боловч илгээгээгүй байна. Мэдээллээ ирүүлээгүй компаниудын талаар яагаад мэдээллээ бөглөхгүй байгаа тухай тайлбарыг нь авсан.

Нийт нэгтгэлд хамрагдсан 230 компанийн бенефициар өмчлөгчийн талаар ирүүлсэн мэдээллийг хураангуйлбал дараах байдалтай байна.

| | | | |
|---------------------------------|------------|--|-----|
| Нийт бенефициар эзэмшигч | 291 | | |
| үүнээс: | | | |
| Хуулийн этгээд | 82 | | |
| Дотоод | 29 | | |
| Гадаад | 53 | | |
| Хувь хүмүүс, улс орноор | 209 | | |
| Монгол | 167 | Эдгээр хувь хүмүүс нь: | |
| БНХАУ | 27 | Улс төрд нөлөө бүхий этгээд эсэх | |
| АНУ | 2 | Тийм | 5 |
| Өвөр монгол | 3 | Үгүй | 204 |
| | | Тухайн компанид удирдах албан тушаал хашдаг эсэх: | |
| Хонгконг | 2 | | |
| Япон | 2 | Тийм | 137 |
| Малайз | 1 | Үгүй | 72 |
| БНСУ | 1 | | |
| Казакстан | 1 | | |
| ОХУ | 1 | | |
| Тайвань | 1 | | |
| Шинэ Зеланд | 1 | | |

Бенефициар өмчлөгч болсон дотоод, гадаадын хуулийн этгээдийн зохион байгуулалт болон байршлын мэдээлэл:

| | | | |
|----------------------------------|-----------|----------------------------------|----|
| ХУУЛИЙН ЭТГЭЭД | 82 | | |
| ДОТООДЫН | 29 | | |
| Төрийн | 9 | | |
| Төрийн өмчит ААН | 6 | | |
| Орон нутгийн өмчит ААН | 3 | | |
| Хувийн | 20 | | |
| ХХК | 15 | | |
| ХК | 3 | | |
| ТББ | 2 | | |
| ГАДААДЫН | 53 | | |
| Зохион байгуулалт | | | |
| Нээлттэй | 23 | | |
| Хаалттай | 30 | | |
| Нээлттэй компанийн хувьд: | | Хаалттай компанийн хувьд: | |
| Бүртгэлтэй хөрөнгийн бирж | 23 | Харьяалагдах улс | 30 |
| Торонто | 7 | Хятад | 8 |
| Австрали | 6 | Их Британийн Виржиний арлууд | 6 |
| Хонг Конг | 4 | Сингапур | 3 |
| Лондон | 3 | Өмнөд Солонгос | 2 |
| Шанхай | 1 | Сейшлийн арал | 2 |
| Торонто болон Нью Йорк | 1 | Люксембургийн вант улс | 2 |
| Торонто болон Хонг Конг | 1 | Франц | 2 |
| | | Австрали | 1 |
| | | Беларусь | 1 |
| | | Маршалын арал | 1 |
| | | Самао | 1 |
| | | Хонг Конг | 1 |

Монгол Улсын хувьд 2013 оноос эхлэн Ашиг хүртэгч жинхэнэ эздийн зарим мэдээллийг тайлагнаж буй байдлыг дараах линкээр үзнэ үү: www.eitimongolia.mn/mn/beneficial-ownership-disclosure

Компаниудаас ирүүлсэн мэдээллийн дэлгэрэнгүйг Хавсралт 21(б,в,г)-д харуулсан.

6.2 ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ

6.2.1 Гэрээний ил тод байдлыг сайжруулах санаачлага

Нээлттэй нийгэм форумас (ННФ) “Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдал” олон талт оролцогчдын хэлэлцүүлгийг ОУИТБС-ын Ажлын алба, Төлсөн Авсанаа Нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвсэл, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУА)-тай хамтран УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Уул уурхайн яамны дэмжлэгтэйгээр 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан.

Хэлэлцүүлгээр эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдалтай холбоотой өнөөгийн хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт, олон улсын туршлага сургамж, гэрээг ил тод болгохтой холбоотойгоор талуудад тулгарч буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, олон талын хамтын ажиллагааны талаар хэлэлцэн дараах асуудлуудаар нэгдсэн ойлголт, байр сууринд хүрсэн. Үүнд:

- Эрдэс баялгийн салбарын гэрээний ил тод байдал, мэдээллийн хүртээмж, зохион байгуулалтыг хангах үүднээс Засгийн газар, түүний холбогдох байгууллагаас ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн салбарт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан Тогтвортой байдлын гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Геологийн ажлын гэрээ болон Ашиглалтын өмнөх гэрээ зэрэг гэрээнүүдийн эх

бичвэрүүдийг мэдээллийн нэгдсэн сан үүсгэж системтэйгээр байршуулахын сацуу холбогдох төрийн байгууллагын цахим хуудаст байршуулан бүхэлд нь олон нийтэд ил тод болгох;

- Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах гэрээний ил тод байдлыг нэмэгдүүлж, орон нутгийн захиргааны байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах болон орон нутгийн иргэдийн онцлог хэрэгцээ шаардлагад тохирсон хэлбэрээр мэдээлэл түгээхэд нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч нар санаачилга гарган хамтран ажиллах; Гэрээ байгуулах, батлах, гэрээний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх бүх шатанд мэдээллийг ил тод байлгах, нийтийн сонсгол, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх замаар олон тал, ялангуяа иргэний нийгмийн оролцоог хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

6.2.2 Хууль, эрх зүй

Олборлох салбарын гэрээ, хэлэлцээрийг зохицуулдаг чухал хуулиудыг харуулбал:

| Гэрээний төрөл | Зохицуулж буй хууль | Зүйл, заалтууд |
|---|------------------------------|----------------|
| Бүтээгдхүүн хуваах гэрээ | Газрын тосны тухай хууль | 17.3 |
| Орд газрыг хөгжүүлэх гэрээ | Цөмийн энергийн тухай хууль | 29 |
| Хөрөнгө оруулалтын гэрээ | Ашигт малтмалын тухай хууль, | 5.3-5.5 |
| Хөрөнгө оруулалтын гэрээ | Цөмийн энергийн тухай хууль | 30 |
| Концессийн гэрээ | Концессын тухай хууль | 20 |
| Нутгийн захиргаатай байгуулсан гэрээ | Ашигт малтмалын тухай хууль | 42.9 |
| Хамтарсан гэрээ. Жишээлбэл газар, ус ашиглалтын гэрээ | Ашигт малтмалын тухай хууль | 35.3.7 |

6.2.1 хэсэгт дурдсан санаачилгын хүрээнд хөгжүүлсэн вебсайтад олборлох үйлдвэрлэлийн хууль, журмын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл багтсан байна. (<http://www.iltodgeree.mn/legal/3/detail>).

Засгийн газрын зүгээс олборлох компаниудтай байгуулсан гэрээний ил тод байлыг сайжруулах зорилгоор хэд хэдэн арга хэмжээ авсан. Үүнд:

- УИХ-аас Газрын тосны тухай хуульд 2014 онд нэмэлт, өөрчлөлт оруулснаар уламжлалт бус газрын тостой холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн боломжтой болсон. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах загвар гэрээнээс гэрээний нууцлалтай холбоотой заалтыг хүчингүй болгосон.
- 2015 онд батлагдсан Захиргааны ерөнхий хуульд Засгийн газрын байгууллагуудын байгуулсан гэрээнүүд нь бүгд ил тод байх ёстой гэсэн заалт орсон.

Сүүлийн жилүүдэд олборлох үйлдвэрлэлд зориулсан авто зам, төмөр зам, цахилгаан, дулаан, ус хангамж бусад ложистикийн бүтцийг дэмжих зорилгоор концессын гэрээг Засгийн газраас байгуулж байна. 2014 онд батлагдсан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 болон 6.5.9-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Концессын гэрээ, түншлэлийн Концессын гэрээ, түншлэлийн гэрээний талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлнэ” гэж заасан ба энэ нь гэрээг бүхэлд нь биш, зөвхөн мэдээлэл бэлтгэж олон нийтэд мэдээлэх тухай заалт юм.

6.2.3 Гэрээний ил тод байдал

Засгийн газар 2016 оны 1 дүгээр сарын хуралдаанаараа бүх БХГ-г ил тод болгохоор шийдвэрлэж, Газрын тосны газар БХГ-үүдийг ил тод болгохоор болсон. Гэвч Газрын тосны тухай хуулийн өөрчлөлтөөс хойш байгуулагдсан 3 гэрээ өнөөг хүртэл ил тод болоогүй байна.

2017 онд БХГ-үүдийг ил болгоход тулгарч буй саад бэрхшээлийг хянан шийдэх зорилгоор Ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Учир нь БХГ-ний хуучин загвараас шинэ загварт шилжүүлэхдээ гэрээний үндсэн нөхцлөөс болоод зарим компаниуд дээр зарчимын шинжтэй зөрүүтэй санал гарсан тул БХГ-г шинэ загварт шилжүүлэх асуудал үүнээс болоод зогссон байна. Гэсэн ч гэрээний үндсэн нөхцлийг тусгахгүйгээр гэрээнүүдийг <http://www.iltodgereee.mn/> сайт дээр ил болгох талаар гэрээлэгч нарт мэдэгдэж, хариу ирүүлэхийг хугацаа заан мэдэгдсэн боловч одоогоор нэг ч гэрээлэгчээс хариу ирээгүй байна.

2017 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Нээлттэй нийгэм форум, ОУИТБС болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хамтран ОУИТБС-ын стандарт 2.4 дэх шаардлагыг биелүүлэх, гэрээний ил тод байдлыг сайжруулах зорилгоор Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн цахим санг байгуулсан. Энэхүү мэдээллийн цахим сан нь олон нийт, сэтгүүлчид, эрдэмтдэд эрдэс баялагийн гэрээнүүд болон бусад холбогдох баримт бичгүүдийг бүрэн эхээр нь нээлттэй болгож өгсөн.

Одоогийн байдлаар энэхүү мэдээллийн санд 309 гэрээг байршуулсан байна:

Хүснэгт 6.1

| № | Гэрээний төрлүүд | Тоо |
|-------------------|---|------------|
| 1 | Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар | 1 |
| 2 | Бүтээгдэхүүн хуваах гэрээ (ДМЖ Петролиум АГ) | 1 |
| 3 | Хөрөнгө оруулалтын гэрээ | 1 |
| 4 | Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээ | 1 |
| 5 | Гол мөрний урсац бүрэлдэх эх, Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, Ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, Ашиглахыг хориглох тухай хуулийн дагуу хийгдэх гэрээ | 23 |
| 6 | Ус ашиглах гэрээ | 48 |
| 7 | Концессийн гэрээ | 4 |
| 8 | Хамтран ажиллах гэрээ | 38 |
| 9 | Орон нутагтай хамтран ажиллах гэрээ | 68 |
| 10 | Газар ашиглах гэрээ | 125 |
| 11 | Бусад гэрээнүүд | |
| Нийт гэрээ | | 310 |

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор орж харна уу: <http://www.iltodgereee.mn/>

Бид нэгтгэл тайланд хамрагдсан компаниудаас орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээний мэдээллийг цахим тайлагналын системд нэмэлт мэдээллийн маягтаар авсан бөгөөд нийт 72 компанийн 151 гэрээний мэдээлэл ирсэн ба дэлгэрэнгүйг Хавсралт 22-оос харна уу.

6.3 БЭЛЭН БУС ОРЛОГО (ШААРДЛАГА 4.1.В)

Нэгтгэлийн үр дүнд компаниуд болон төрийн байгууллагуудын мэдээллийг тулган баталгаажуулсны дараах байдлаар нийт 2,501.7 сая төгрөгийн мөнгөн бус хандив дэмжлэгийг уул уурхайн компаниуд төрийн байгууллагуудад олгосон байна.

Тохируулгын дараах байдлаар нийт мөнгөн бус хандив, дэмжлэгийн 83.4% буюу 2,087.1 сая төгрөгийг эхний 10 компани олгосон байна. Эдгээр компанийн мөнгөн бус хандивыг зориулалтаар нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 6.2

| Д/д | Компанийн нэрс | Мөнгөн бус хандивын дүн/сая төгрөгөөр/ | Мөнгөн бус хандивын зарцуулалтын тайлбар |
|-----|------------------------|--|---|
| 1 | Өсөх зоос ХХК | 795.0 | Эмнэлэгийн өргөтгөлийн барилга |
| 2 | Энержи Ресурс ХХК | 508.2 | Сумдад нүүрсний нийлүүлэлт |
| 3 | Болдтөмөр Ерөө гол ХХК | 200.0 | Сэлэнгэ аймгийн эмнэлэгт Компьютер томограф |

| Д/д | Компанийн нэрс | Мөнгөн бус хандивын дүн/сая төгрөгөөр/ | Мөнгөн бус хандивын зарцуулалтын тайлбар |
|----------|-------------------------|--|--|
| 4 | Оюу Толгой ХХК | 166.4 | Үндэсний Түлэнхийн төв, Хүүхэд, Жирэмсэн эмэгтэйчүүдийн үндэсний төв-д эм, тоног төхөөрөмж |
| 5 | Эрдэнэс Таван толгой ХК | 119.2 | |
| 6 | Саусгоби Сэндс ХХК | 99.6 | |
| 7 | Шар Нарст ХХК | 57.0 | Булган аймгийн 80 жилийн ой |
| 8 | Монвольфрам ХХК | 49.6 | Сумын төвийн айлуудын хашаа |
| 9 | Эрдэнэс Монгол ХХК | 48.2 | |
| 10 | БМНС | 43.9 | Архангай аймгийн Цэнхэр суманд олон нийтийн халуун ус, 00-ын өргөтгөлийн ажил |
| Нийт дүн | | 2,087.1 | |

6.4 ДЭД БҮТЦЭД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ БА БАРТЕРЫН СОЛИЛЦОО (ШААРДЛАГА 4.1.Г)

Зарим тохиолдолд улс орны байгалийн нөөц баялгийг ашиглах эрх олох зорилгоор олборлох үйлдвэрлэлийн компаниуд мөнгөн бус хэлбэрээр бараа болон үйлчилгээ үзүүлэх (дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх) гэрээг төрийн байгууллагуудтай хийдэг. Эдгээр дэд бүтцийн хөрөнгө оруулалтын жишээнд зам, төмөр зам, цахилгаан станц, сургууль болон эмнэлгүүд багтана.

Тухайн компаниудад ирэх өгөөж нь газрын тос, байгалийн хий эсвэл ашигт малтмалын нөөц бөгөөд газар, эрчим хүч болон усны нөөц ашиглах эрх гэх мэт бусад элементээс бүрддэг. Ийм гэрээг бартерын солилцооны гэрээ эсвэл “дэд бүтцийг ашигт малтмалаар солилцох гэрээ” гэж нэрлэдэг.

Бид нэгтгэлд хамрагдсан компаниуд болон төрийн байгууллагуудаас 2017 онд дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт ба бартерын солилцооны талаар мэдээлэл ирүүлэхийг хүссэн.

Дараах компаниуд дэд бүтцэд хөрөнгө оруулсан талаараа мэдээлэл ирүүлсэн.

Хүснэгт 6.3

| Компанийн нэр | Хөрөнгө оруулалтын нэр | Хөрөнгө оруулалт хийгдсэн огноо | Гэрээний нөхцөл | Хөрөнгө оруулалтын хэмжээ /сая төгрөгөөр/ | Оролцогч талууд |
|---------------------|--------------------------------|---------------------------------|--|---|---|
| “Бадмаараг хаш” ХХК | 200 метр талбай бүхий авто зам | 8/21/2017 | Сум орон нутгийн хөгжилд зориулж бүтээн байгуулалт хийх | 100.0 | “Чоно гол хөгжил” ОНӨААТҮГ, Сүхбаатар аймаг Эрдэнэ цагаан сум |
| “Өсөх зоос” ХХК | Эмнэлгийн өргөтгөлийн барилга | 10/9/2017 | Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт хөрөнгө оруулах | 795.0 | “Веркон констракшин” ХХК, Өмнөговь аймаг Гурван тэс сум |

Эх сурвалж: Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас ирүүлсэн мэдээлэл

Дээрх дэд бүтцийн хөрөнгө оруулалтаас товч танилцуулбал:

“Бадмаараг хаш” ХХК

Тус компани нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Сум орон нутгийн хөгжилд зориулж бүтээн байгуулалт хийх зорилгоор авто зам барих ажилд зориулж 100.0 /зуун сая/ төгрөгийн санхүүжилтийг хийж, “Чоно гол хөгжил” ОНӨААТҮГ-аар ажлыг

гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт 200 метр /7 метрийн өргөнтэй, 17 см-ийн зузаантай/ талбай бүхий авто зам барьж байгуулсан.

“Өсөх зоос” ХХК

“Өсөх зоос” ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс суманд нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт хөрөнгө оруулж, Эмнэлгийн өргөтгөлийн барилга 795.0 сая төгрөгийн санхүүжилтийг хийж, “Веркон констракшн” ХХК-аар ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. “Өсөх зоос” ХХК-ий хандиваар баригдсан эмнэлгийн өргөтгөлийн барилгыг 2017 оны 12 –р сарын 31-ний өдөр Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Эрүүл мэндийн төв үндсэн хөрөнгөндөө бүртгэсэн байна.

6.5 НИЙГМИЙН ЗАРЦУУЛАЛТ (ШААРДЛАГА 6.1)

Нийгмийн хөрөнгө оруулалт, зарцуулалтад компаниудаас нийгмийн сайн сайханд зориулан гаргасан зардлууд багтдаг ба эдгээр нь ихэвчлэн уул уурхайн ойр орчмын нутгийн иргэдэд зориулагддаг.

Зайлшгүй тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтаас бусад мөнгөн болон мөнгөн бус зарцуулалтуудыг сайн дурын нийгмийн хөрөнгө оруулалт гэж тодорхойлсон. Компаниуд зайлшгүй тайлагнах болон сайн дураар тайлагнах нийгмийн хөрөнгө оруулалтаа МОУИТБС-ын цахим тайлангийн системд тайлагнадаг.

Зайлшгүй тайлагнах мөнгөн болон мөнгөн бус нийгмийн хөрөнгө оруулалтын 97%-ийг дараах компаниуд бүрдүүлсэн байна

Хүснэгт 6.4

| Компанийн нэр | Мөнгөн хандив / сая төгрөгөөр/ | Мөнгөн бус хандив /сая төгрөгөөр/ | Дүн/ сая төгрөгөөр/ |
|----------------------------|--------------------------------|-----------------------------------|---------------------|
| АУМ АЛТ | 71.0 | 4.0 | 75.0 |
| Бадмаараг хаш | 140.0 | - | 140.0 |
| Бадрах Энержи | 72.7 | 31.0 | 103.7 |
| Болдтөмөр Ерөө гол | 233.0 | 200.0 | 433.0 |
| Доншен газрын тос (Монгол) | 90.0 | - | 90.0 |
| Жи Энд Юу Голд | 56.0 | - | 56.0 |
| Монвольфрам | 0.6 | 49.6 | 50.2 |
| Монголболгаргео | 104.6 | - | 104.6 |
| Монголросцветмет | 47.4 | 35.0 | 82.4 |
| МоЭнКо | 678.7 | 8.6 | 687.2 |
| Оюу Толгой | 24,145.7 | 166.4 | 24,312.1 |
| Өгөөжбаян хангай | 76.5 | - | 76.5 |
| Өсөх зоос | - | 795.0 | 795.0 |
| Платинумланд | 78.4 | 3.8 | 82.3 |
| Саусгоби Сэндс | - | 99.6 | 99.6 |
| Спейшлмайнз | 100.0 | - | 100.0 |
| Тэн Хун | 102.5 | - | 102.5 |
| Уулсзаамар | 109.5 | - | 109.5 |
| Форс Голд Майнинг | 64.0 | 9.0 | 73.0 |
| Хос-Хас | 63.0 | - | 63.0 |
| Цайртминерал | 769.1 | - | 769.1 |
| Шар Нарст | 220.0 | 57.0 | 277.0 |
| Шижир-Аранжин | 58.0 | 14.0 | 72.0 |
| Энержи Ресурс | 27.6 | 508.2 | 535.8 |
| Эрдэнэ Монгол | 184.0 | 48.2 | 232.2 |
| Эрдэнэс Таван толгой | - | 119.2 | 119.2 |
| Эрдэнэт | 218.2 | - | 218.2 |

6.6 ТЭЭВРИЙН ОРЛОГО (ШААРДЛАГА 4.1.Е)

Газрын тос, байгалийн хий, байгалийн баялгийн тээвэрлэлтээс олсон орлого нь материаллаг байгаа үед Засгийн газар болон Төрийн өмчит аж ахуйн нэгж (ТӨААН)-үүд хүлээн авсан орлогоо толилуулах шаардлагатай байдаг.

Газрын тос, байгалийн хий, байгалийн баялгийн тээвэрлэлтээс олох орлого нь олборлох үйлдвэрлэлийн томоохон орлогын эх үүсвэрүүдийн нэг болдог бол ЗГ болон ТӨААН-үүд ил тод болгох шаардлагатай.

Дараах ТӨААН-үүд тээвэрлэлтийн орлогын мэдээлэл болох тээвэрлэсэн бүтээгдэхүүний дэлгэрэнгүй, тээвэрлэлтийн орлогыг хүлээн авагч төрийн байгууллагуудын талаар тайлагнасан байна.

Хүснэгт 6.5

/Сая төгрөгөөр/

| Компанийн мэдээлэл | Гүйлгээний утга | Орлогыг хүлээн авагч төрийн байгууллага, ТӨААН | Нийт үнэ |
|--------------------|-------------------|--|----------|
| Шивээ овоо ХК | Нүүрс | Дулааны цахилгаан станц 4 ТӨХК | 38.9 |
| | Нүүрс | Монголросцветмент ХХК | 0.6 |
| | Нүүрс | Налайх дулааны станц ТӨХК | 0.5 |
| | Нүүрс | Илчлэг шивээ ОНӨҮГ | 0.0 |
| | Нүүрс | Ус-ду ОНӨҮГ | 0.3 |
| | Нүүрс | Чандмань илч ОНӨУҮГ | 0.8 |
| | Нүүрс | Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААУҮГ | 0.2 |
| | Шуудангийн төлбөр | Монгол шуудан ХК | 1.9 |
| | Тээврийн хөлс | Улаанбаатар төмөр зам ХНН | 350.0 |
| Багануур ХК | Нүүрс | Улаанбаатар төмөр зам ХНН | 522.0 |

Эх сурвалж: Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас ирүүлсэн мэдээлэл

6.7 ХАНДИВ

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын нэгтгэлд хамрагдсан 230 компанийн 2017 онд мөнгөн ба мөнгөн бус хэлбэрийн хандив дэмжлэгийг төрийн болон орон нутгийн байгууллагуудад үзүүлсэн. Төрийн байгууллагууд болон компаниудаас ирүүлсэн мэдээллүүд нь зөрүүтэй байсан тул тохируулга хийж зөрүүг тохируулсан. Дээр дурдсанчлан заавал тайлагнах хандив дэмжлэгүүдийг нэгтгэлд оруулж тохируулга хийсэн бол сайн дурын хандив дэмжлэгүүд тохируулга хийгдээгүй болно.

2017 онд нэгтгэлд хамрагдсан компаниудаас 82 компани нийт 30,758 сая төгрөгийн мөнгөн ба мөнгөн бус хандивыг олгосон байна. Нийт хандив, дэмжлэгийн 89,5 %-ийг Оюу Толгой ХХК, Өсөх зоос ХХК, Цайртминерал ХХК, МоЭнКо ХХК, Энержи Ресурс ХХК, Болд төмөр Ерөө гол ХХК гэсэн 6 компани үзүүлжээ.

| Зориулалт | Хандивын дүн /сая төгрөгөөр/ | Эзлэх хувь |
|-------------|------------------------------|-------------|
| Боловсрол | 551 | 1% |
| Эрүүл мэнд | 2,136 | 7% |
| Соёл, спорт | 824 | 3% |
| Бусад | 27,247 | 89% |
| Нийт | 30,758 | 100% |

Тохируулгын дараах байдлаар нийт хандив, дэмжлэгийг зориулалтаар нь харуулбал дараах байдалтай байна.

Тохируулгын дараах байдлаар нийт хандив, дэмжлэгийг авсан төрийн байгууллагуудын төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6.6

| Хандив хүлээн авагч | Мөнгөн хандив /сая төгрөгөөр/ | Мөнгөн бус хандив /сая төгрөгөөр/ | Дүн /сая төгрөгөөр/ | Эзлэх хувь |
|--------------------------|-------------------------------|-----------------------------------|---------------------|------------|
| Яам, агентлагт | 33 | 66 | 99 | 0% |
| Аймаг, нийслэлд | 2,557 | 907 | 3,463 | 11% |
| Сум, дүүрэгт | 25,322 | 1,401 | 26,723 | 87% |
| Бусад байгууллагад | 345 | 129 | 474 | 2% |
| Хандивын тохируулсан дүн | 28,257 | 2,502 | 30,758 | |

Тохируулгын дараах байдлаар нийт хандив, дэмжлэгийг авсан аймгуудаар нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6.7

| Хандив хүлээн авагч | Мөнгөн хандив /сая төгрөгөөр/ | Мөнгөн бус хандив /сая төгрөгөөр/ | Дүн /сая төгрөгөөр/ | Эзлэх хувь |
|---------------------|-------------------------------|-----------------------------------|---------------------|------------|
| Архангай | 22 | 44 | 66 | 0.2% |
| Баян-өлгий | 21 | - | 21 | 0.1% |
| Баянхонгор | 499 | 102 | 601 | 2.0% |
| Булган | 369 | 60 | 429 | 1.4% |
| Говь-алтай | 35 | 1 | 36 | 0.1% |
| Говьсүмбэр | - | 3 | 3 | 0.1% |
| Дархан | 29 | - | 29 | 0.1% |
| Дорноговь | 830 | 62 | 892 | 2.9% |
| Дорнод | 57 | - | 57 | 0.2% |
| Дундговь | 126 | - | 126 | 0.4% |
| Завхан | 66 | 7 | 73 | 0.2% |
| Орхон | 3 | - | 3 | 0.1% |
| Өвөрхангай | 100 | 4 | 104 | 0.3% |
| Өмнөговь | 24,387 | 1,721 | 26,108 | 84.9% |
| Сүхбаатар | 173 | - | 173 | 0.6% |
| Сэлэнгэ | 353 | 334 | 687 | 2.2% |
| Төв | 390 | 118 | 508 | 1.7% |
| Улаанбаатар | 76 | - | 76 | 0.2% |
| Ховд | 679 | 9 | 688 | 2.2% |
| Хөвсгөл | 17 | - | 17 | 0.1% |
| Хэнтий | 27 | 34 | 61 | 0.2% |
| Нийт | 28,259 | 2,499 | 30,758 | |

6.8 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн асуудлын зохицуулалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) болон тус яамны харьяа Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) зэрэг үндсэн 3 байгууллага хариуцдаг.

Уул уурхайн салбар байгаль орчинд хамгийн их доройтол учруулдаг, байгалийн нөхөн сэргээгдэхгүй баялгийг ашигладаг, Монголын ард түмний уламжлалт нүүдлийн мал аж ахуйд сөрөг нөлөөлдөг.

Ийм ч учраас уул уурхайн байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн ажилд дагаж мөрдөх хууль, журам, стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх, баталгаажуулах, хэрэгжилтийг хангах ажилд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байнга анхаарал хандуулж ажиллаж ирсэн.

6.8.1 Төрөөс байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн хүрээнд баримтлах бодлого

Байгаль орчны хамгаалах уул уурхайн нөхөн сэргээлтийн ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин 1988 оноос эхлэн бүрэлдэж, холбогдох хуулиуд батлагдаж, шинэчлэгдсээр байна.

Уул уурхайн ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр дараах эрхзүйн актууд төрдөгдөж байна. Үүнд:

- Газрын хэвлийн тухай хууль (1988),
- Ашигт малтмалын тухай хууль (1997, 2006),
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009),
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2001, 2006, 2012),
- Байгаль орчны бусад хуулиуд, эрх зүйн актууд мөрдөгдөж байна.

Түүнчлэн эдгээр хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 30 гаруй журам, аргачлал батлан мөрдүүлж байна. Тухайлбал:

- "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал" (2015),
- "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам" (2014),
- "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" (2014) зэрэг

2014-2025 он хүртэл Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогод байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн хүрээнд дараах бодлогуудыг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

- олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийн үе шатуудад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, хүрээлэн байгаа орчны экологийн тэнцвэрт байдлыг хангасан байх;
- төрийн өмчийн аж ахуйн нэгж нь ерөнхий гэрээлэгчийн зарчмаар ажиллаж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг хэрэгжүүлэх;
- уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт, журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах;
- эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлд газрын гүний цэнгэг усыг аль болох ашиглахгүй байх, гадаргын усыг түлхүү ашиглах, холбогдох хуульд заасны дагуу хэрэглэсэн усыг дахин ашиглах, уул уурхайн салбарын ахуйн хэрэглээнд саарал усыг ашиглах, орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжих;

Төрөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр гаргасан эрх зүйн зохицуулалт, дүрэм журамд 2017 оны байдлаар гарсан өөрчлөлтүүд: Үүнд:

| № | Тогтоол шийдвэр | Дүрэм журмын дэлгэрэнгүй |
|---|------------------------------------|--|
| 1 | Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030 | Нэгдсэн үндэстний байгууллагын 2015 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн Ерөнхий ассамблейн тогтоолоор "Тогтвортой |

| № | Тогтоол шийдвэр | Дүрэм журмын дэлгэрэнгүй |
|---|---|--|
| | | хөгжлийн зорилтууд 2030” хөтөлбөр батлагдаж, дараагийн 15 жилд хүн төрөлхтөн, гариг ертөнцийн хувьд нэн чухал ач холбогдолтой тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудыг тодорхойлсон. |
| 2 | Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол | “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” батлагдаж, “Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болно” гэж зорилтоо тодорхойлсон юм. |

6.8.2 Байгаль орчныг хамгаалах тусгай данс

Нөхөн сэргээлтийн хувьд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид Байгаль орчны тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн 38, 39 дүгээр заалтуудыг дагаж мөрдөх ёстой. Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар заалт нь хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах үүргийг тодорхойлсон бол 39 дүгээр заалт нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг тодорхойлсон байдаг.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг байгаль орчныг хамгаалах шаардлага хангуулах зорилготойгоор хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид аль аль нь холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд өөрсдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд шаардагдсан тухайн жилийн төсвийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнг шилжүүлэх үүрэгтэй.

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд /БОХТ/ тусгагдсан үүргээ биелүүлсэн тохиолдолд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцааж олгоно. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид БОНБУ болон БОХТ-д тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол байршуулсан мөнгөн хөрөнгийг уурхайн хаалтын үе шатанд буцааж олгоно. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОХТ-д тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглан шаардлагатай арга хэмжээг нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Ийм тохиолдолд нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд нэмж шаардагдах мөнгөн дүнг тусгай зөвшөөрөл эзэмшигч маргаангүй олгох ёстой.

Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй байгууллагуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 26-аас харна уу.

БОАЖЯ-ны мэдээлснээр 2017 онд нийт 1,326 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн зардал Байгаль хамгаалалтын тусгай дансанд төвлөрсөн ба буцаан олголт байгаагүй байна. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн үлдэгдэл нь 12,626 сая төгрөг байна. Тухайлбал:

Хүснэгт 6.8

Сая.төгрөгөөр

| Онууд | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|-----------------|------|------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|--------|--------|--------|
| Орлого | 22 | 612 | 566 | 385 | 942 | 1,216 | 2,014 | 1,545 | 2,273 | 1,027 | 1,317 | 1,102 |
| Зарлага | - | - | 21 | 126 | 1 | 5 | 16 | 225 | 1 | - | - | - |
| Эцсийн үлдэгдэл | 22 | 634 | 1,179 | 1,438 | 2,379 | 3,590 | 5,588 | 6,908 | 9,180 | 10,207 | 11,524 | 12,626 |

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

2017 онд Эко алтан заамар ХХК тусгай дансанд хамгийн их орлого төвлөрүүлсэн бөгөөд доорх хүснэгтэд орсон компаниуд нь нийт байгаль орчин хамгаалах тусгай дансанд орсон орлогын 57.38%-ийг бүрдүүлсэн байна. Үүнд:

Харт Нойрс Лтд болон Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хамтарсан концерциум 140

Хүснэгт 6.9

| № | Байгууллагын нэрс | Байршуулсан дүн | |
|-------------|------------------------------------|--------------------|----------------|
| | | Мян.төгрөгөөр | Хувь хэмжээ |
| 1 | Өсөх зоос ХХК | 29,212.5 | 2.65% |
| 2 | Шинь Шинь ХХК | 91,426.0 | 8.30% |
| 3 | Алтай голд ХХК | 65,100.0 | 5.91% |
| 4 | Баянгол эко заамар | 38,050.0 | 3.45% |
| 5 | Голден Хаммер ХХК | 55,100.0 | 5.00% |
| 6 | Пента Терра | 50,000.0 | 4.54% |
| 7 | Петрочайна Дачин Тамсаг Монгол ХХК | 58,000.0 | 5.26% |
| 8 | Тод Ундрага ХХК | 28,680.0 | 2.60% |
| 9 | Шарын гол ХК | 23,797.0 | 2.16% |
| 10 | Эко Алтан Заамар ХХК | 193,041.0 | 17.52% |
| Дүн | | 632,406.5 | 57.38% |
| Нийт | | 1,102,113.0 | 100.00% |

Эх сурвалж: Байгаль орчин, Ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн мэдээлэл

Нөхөн сэргээлтийн зардлын 50 хувь болох нийт 1,102.1 сая төгрөгийг дансанд төвлөрүүлсэн бүх 128 компанийн мэдээллийг Хавсралт 23-аас харна уу.

6.8.3 2017 оны уулын ажлын болон нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн мэдээлэл

АМГТГ-ын ирүүлсэн мэдээгээр 2017 онд нийт 917.6 га талбай газар уулын ажилд хамрагдсанаас 61% буюу 556.0 га талбай газарт нөхөн сэргээлт хийгдсэн байна. 2017 онд нөхөн сэргээлтийн нийт зардал нь 2,560.0 сая төгрөг болсон байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас нийт 28,657 га талбай уулын ажилд хамрагдсан байна. Үүнээс техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 12,891 га, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 8,322 га, нөхөн сэргээлтэд зарцуулсан зардал 96,734 сая төгрөг, байгаль орчинг хамгаалахад зарцуулсан зардал 67,062 сая төгрөг байна.

2017 онд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын уулын ажлын болон нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 6.10

| Онууд | Уулын ажилд хамрагдсан талбай (га) | Нөхөн сэргээлт хийгдсэн талбай (га) | Нөхөн сэргээлтийн харьцаа (%) | Нөхөн сэргээлтийн зардал (сая.төгрөг) |
|--------------|------------------------------------|-------------------------------------|-------------------------------|---------------------------------------|
| өмнөх жилүүд | 22,168.0 | 16,146.0 | 73% | 57,458.0 |
| 2012 | 1,430.0 | 1,402.0 | 98% | 14,808.0 |
| 2013 | 1,038.0 | 807.0 | 78% | 7,382.0 |
| 2014 | 1,561.0 | 960.0 | 61% | 9,212.0 |
| 2015 | 871.0 | 750.0 | 86% | 4,019.0 |
| 2016 | 671.0 | 623.9 | 93% | 6,369.0 |
| 2017 | 917.6 | 556.0 | 61% | 2,560.0 |
| Нийт | 28,656.6 | 21,244.9 | 75% | 101,808.0 |

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар, статистик-2017

Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулын ажлын болон нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл (нүүрс олборлогчдоос бусад)

АМГТГ-ын мэдээлснээр 2017 онд нийт 145 компани уулын ажил болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хэрэгжилтээ тайлагнасан байна. Компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 20(а)-с харна уу.

Уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн хураангуйг дараах байдлаар харуулав. Үүнд:

Хүснэгт 6.11

| Ашигт малтмалын төрөл | Нийт компанийн тоо | Уулын ажил | | | | Нөхөн сэргээлт | | | | |
|-----------------------|--------------------|-------------|------------|-------------------|-------------------|----------------|------------|------------------|------------------|-----------------------------|
| | | Талбай (га) | | Эзэлхүүн (м3) | | Талбай (га) | | Эзэлхүүн (м3) | | Нийт зардал (сая төгрөгөөр) |
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө |
| Зэс | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Алт | 87 | 377 | 593 | 21,728,862 | 42,363,330 | 476 | 473 | 1,327,580 | 1,218,048 | 2,796 |
| Манган | 1 | 88 | 49 | 240,000 | 150,000 | 1 | 0 | 1,500 | 600 | 3 |
| Мөнгө | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Жонш | 22 | 23 | 14 | 722,538 | 318,633 | 15 | 9 | 27,775 | 5,099 | 72 |
| Төмөр | 11 | 57 | 55 | 16,614,499 | 9,382,671 | 58 | 50 | 73,968 | 35,500 | 276 |
| Цагаан тугалга | 1 | 10 | 3 | 420 | 115,753 | - | - | - | - | - |
| Гөлтгөнө | 4 | 2 | 4 | - | 221,264 | 16 | 1 | 242,100 | - | 3 |
| Цайр | 1 | 1 | 1 | - | - | 1 | 1 | - | - | - |
| Барилгын материал | 14 | 44 | 36 | 940,516 | 760,244 | 16 | 13 | 76,735 | 47,498 | 42 |
| Цеолит | 1 | - | - | - | - | 2 | - | 4,500 | - | 2 |
| Гянтболд | 3 | 3 | 1 | 72,896 | 32,822 | 16 | 8 | 27,427 | 23,905 | 44 |
| Нийт | 145 | 605 | 755 | 40,319,731 | 53,344,717 | 600 | 554 | 1,781,585 | 1,330,650 | 3,237 |

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар, статистик-2017

6.8.4 Нүүрс олборлогчдын уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Нүүрсний асуудлыг АМГТГ-т тусдаа хэлтэс зохицуулдаг тул төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан нь бусад ашигт малтмалын тайлангаас ялгаатай гардаг. Нийт 37 нүүрс олборлогч компаниуд уулын ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийн мэдээгээ тайлагнасан байна. Нүүрс олборлогч 37 компанийн уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө гүйцэтгэлийн дэлгэрэнгүйг Хавсралт 20(б)-с харна уу.

6.8.5 Газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, Гүйцэтгэл

| Талбайн нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Гүйцэтгэл хувиар |
|---------------|--|---|------------------|
| Тосон-Уул XIX | 1. Өрмийн шингэн хаягдлын санг саармагжуулах нөхөн сэргээлт хийх | 1. "Эко Инээмсэглэл" ХХК 2016 онд өрөмдөгдсөн 21 цооногийн өрмийн шингэн хаягдлын санд нөхөн сэргээлт хийсэн. | 100 |
| | 2. Хөрсний дээж авах, шинжлүүлэх | 2. "Байгаль тандалт" ХХК 30 цооноогоос хөрсний дээж авч шинжлүүлсэн. | 100 |
| | 3. Байгаль орчны үнэлгээ хийх | 3. "Өндөр Хаан Трейд" ХХК хийж гүйцэтгэсэн боловч тайлан нь батлагдаагүй. | 50 |
| | 4. Гүний усны хяналтын цооног өрөмдөх | 4. Гүний усны хяналтын 2 цооног өрөмдөх ажил сүүлийн 3 жилийн төлөвлөгөө, төсөвт тусгагдсан хэдий ч уг ажил хийгдээгүй. | 0 |
| Тамсаг XXI | 1. Өрмийн шингэн хаягдлын санг саармагжуулах нөхөн сэргээлт хийх | 1. "Сансар сүлжээ" ХХК 2016 онд өрөмдөгдсөн цооногуудын дэргэдэх өрмийн шингэн хаягдлын 18 санд нөхөн сэргээлт хийсэн. | 100 |
| | 2. Хөрсний дээж авах, шинжлүүлэх | 2. "Оюун шим мандал" ХХК 30ш хөрсний дээж авч, шинжилгээ хийсэн. | 100 |
| | 3. Үйлдвэрлэлийн шингэн хаягдлын санг саармагжуулах | 3. "Эко-Ургамал" ХХК үйлдвэрлэлийн шингэн хаягдлын 5 санд техникийн нөхөн сэргээлт хийсэн. | 83 |
| | 4. Биологийн нөхөн сэргээлт | 4. "Эм Өү Ди Би" ХХК далд шугам хоолойн биологийн нөхөн сэргээлт хийсэн. | 100 |
| | 5. Байгаль орчны үнэлгээ хийх | 5. "Глобал инвайрон" ХХК-тай гэрээ байгуулсан боловч, ажил хийгдээгүй. | 20 |
| | 6. Гүний усны хяналтын цооног өрөмдөх | 6. Гэрээ байгуулагдаагүй тул ажил хийгдээгүй. | 0 |
| PSA-97 | 1. Хуучин 22 цооногийг сэргээх, ус шахалт, олборлолтын үед хийгдэх цооногийн талбайн байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн ажил | 1. 22 цооноогоос 11 цооногт нөхөн сэргээлт хийгдсэн. | 50 |
| | 2. Хуучин цооногийн талбайн байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн ажил | 2. 86 цооноогоос 49 цооногт нөхөн сэргээлт хийгдсэн. | 57 |
| | 3. Олборлолтын талбайн хөрсний дээжийн лабораторийн шинжилгээ | 3. Хийгдээгүй. | 0 |
| | 4. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 4. Гүйцэтгэсэн | 100 |
| Нийт | 14 | 10 | 61.4 |

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

6.8.6 Газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нөхөн сэргээлт 2017 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

| Ажил | Нэгж үнэ (доллар) | Төлөвлөг дсэн хэмжээ | Тайлбар | Гүйцэтгэл |
|--|-------------------|----------------------|--|-----------|
| Тосон-Уул талбай XIX | | | | |
| Өрмийн хаягдал шингэний саармагжуулалт, нөхөн сэргээлт | 3800 | 21 | "Эко Инээмсэглэл" ХХК 2016 онд өрөмдөгдсөн 21 цооногийн өрмийн шингэн хаягдлын санд нөхөн сэргээлт хийсэн. | 100 |
| Газрын хөрсний дээж авах, авсан дээжинд лабораторын шинжилгээ хийх | 600 | 30 | "Байгаль тандалт" ХХК 30 цооноогоос хөрсний дээж авч шинжлүүлсэн. | 100 |
| Байгаль орчны үнэлгээний ажил | 20000 | 2 | "Өндөр Хаан Трейд" ХХК хийж гүйцэтгэсэн боловч тайлан нь батлагдаагүй. | 50 |
| Биологийн нөхөн сэргээлт ба ургамалжуулалт | - | - | - | - |
| Гүний усны мониторинг хийх зориулалт бүхий усны цооногийн өрөмдлөг | 35000 | 2 | Гүний усны хяналтын 2 цооног өрөмдөх ажил сүүлийн 3 жилийн төлөвлөгөө, төсөвт тусгагдсан хэдий ч уг ажил хийгдээгүй. | 0 |
| Тамсаг талбай XXI | | | | |
| Өрмийн хаягдал шингэний саармагжуулалт, нөхөн сэргээлт | 3800 | 18 | "Сансар сүлжээ" ХХК 2016 онд өрөмдөгдсөн цооногуудын дэргэдэх өрмийн шингэн хаягдлын 18 санд нөхөн сэргээлт хийсэн. | 100 |
| Газрын хөрсний дээж авах, авсан дээжинд лабораторын шинжилгээ хийх | 600 | 30 | "Оюун шим мандал" ХХК 30ш хөрсний дээж авч, шинжилгээ хийсэн. | 100 |
| Үйлдвэрлэлийн шингэн хаягдлын санг саармагжуулах | 25000 | 6 | "Эко-Ургамал" ХХК үйлдвэрлэлийн шингэн хаягдлын 5 санд техникийн нөхөн сэргээлт хийсэн. | 83 |
| Байгаль орчны үнэлгээний ажил | 20000 | 2 | "Глобал инвайрон" ХХК-тай гэрээ байгуулсан боловч, ажил хийгдээгүй. | 20 |
| Биологийн нөхөн сэргээлт ба ургамалжуулалт | 1 | 40000м2 | "Эм Өү Ди Би" ХХК далд шугам хоолойн биологийн нөхөн сэргээлт хийсэн. | 100 |
| Гүний усны мониторинг хийх зориулалт бүхий усны цооногийн өрөмдлөг | 60000 | 2 | Гэрээ байгуулагдаагүй тул ажил хийгдээгүй. | 0 |

Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбай дахь нөхөн сэргээлтийн мэдээллийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

| Төлөвлөгдсөн ажил | Гүйцэтгэгч | Ажлын тайлан илгээсэн эсэх |
|--------------------------------|--------------------------------|----------------------------|
| Орчны хяналт шинжилгээ | "ЭНКО" ХХК | Илгээсэн |
| Талбайн хөрсний дээж шинжилгээ | | Уг ажил хийгдээгүй |
| Нөхөн сэргээлт | "Өгүүлэшгүй өнө бат орших" ХХК | Илгээсэн |

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

6.8.7 Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниуд, тэдгээрийн байршил

Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниуд нь уул уурхайн компаниуд эсвэл уурхай байрлах холбогдох дүүрэг, аймгийн Засаг дарга нартай гэрээ хийж шаардагдах ажлыг гүйцэтгэдэг.

БОАЖЯ-ны мэдээлснээр 2016 онд 96 компани нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй байсан бол 2017 онд 103 компани нэмж тусгай зөвшөөрлийн эрх авсан ба 2017 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 199 компани нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй байна. (2017 оны зөвшөөрөлтэй 103 компанийн дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт26-с харна уу.)

Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниудыг байршлаар нь авч үзвэл 132 компани Улаанбаатар хотод байршилтай бөгөөд үлдсэн 67 компаниуд Дорнод, Булган, Баянхонгор гэх зэрэг нийт 13 аймагт байршилтай байна. Ихэнх нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниуд нь уул уурхайн компаниудтай гэрээ хийж ажилладаг болохыг БОАЖЯ мэдээлсэн ба нөхөн

сэргээлтийн компаниудын байршил нь тэдгээрийн үйл ажиллагаа явуулж буй байршлыг тодорхойлохгүй болно.

Нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниудыг байршлаар нь ангилж доорх хүснэгтэд харуулав. Үүнд:

Хүснэгт 6.12

| Хот/ Аймаг | Дүүрэг/ Сум | Компаниудын тоо | Хот/ Аймаг | Дүүрэг/ Сум | Компаниудын тоо |
|------------|-------------|-----------------|------------|----------------|-----------------|
| Баянхонгор | Баянхонгор | 25 | Сэлэнгэ | Ерөө | 5 |
| Баянхонгор | Баян-Овоо | 2 | Сэлэнгэ | Мандал | 2 |
| Баянхонгор | Бөмбөгөр | 2 | Төв | Зуунмод | 1 |
| Баянхонгор | Номгон | 1 | Увс | Баруунтуруун | 1 |
| Баянхонгор | Өлзийт | 1 | Увс | Тариалан | 1 |
| Булган | Хялганат | 1 | Увс | Улаангом | 1 |
| Говьсүмбэр | Сүмбэр | 1 | Ховд | Жаргалант | 4 |
| Дархан-Уул | Дархан | 1 | УБ | Сонгинохайрхан | 18 |
| Дорнод | Хэрлэн | 7 | УБ | Баянгол | 30 |
| Дундговь | Өлзийт | 1 | УБ | Багахангай | 1 |
| Орхон | Баян-Өндөр | 4 | УБ | Баянзүрх | 32 |
| Өвөрхангай | Арвайхээр | 3 | УБ | Сүхбаатар | 21 |
| Өвөрхангай | Тарагт | 1 | УБ | Хан-Уул | 13 |
| Өмнөговь | Даланзадгад | 2 | УБ | Чингэлтэй | 17 |
| Дүн | | | | | 199 |

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

6.9 ЦАХИМ ТАЙЛАГНАЛЫН СИСТЕМ

6.9.1 Цахим тайлагналын системийн танилцуулга

Цахим тайлагналын системийн зориулалт нь газрын тос, байгалийн хий, ашигт малтмал зэрэг байгалийн баялгийг хэрхэн удирдаж буй талаар иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээлэх, энэ талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэгдэж байдаг. Үүний үр дүнд төр болон компани, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, итгэлцлийг нэмэгдүүлэх юм. Тиймээс энэхүү цахим тайлагналын систем нь улс орны хэмжээнд өндөр ач холбогдолтой.

Уул уурхайн салбарт өрнөж буй үйл ажиллагааны талаарх гол мэдээллүүдийг интернетээр олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй болгох боломж ийнхүү бүрдсэн юм. Мөн тус цахим тайлагналын системийг боловсруулахдаа баримталсан зарчмуудыг тодорхойлбол:

- Нээлттэй ба үнэ төлбөргүй мэдээлэл: Мэдээллийг интернетээр нийтлэх, ингэснээр олон нийтэд үнэ төлбөргүй мэдээллийг хүртээх боломжтой
- Олон нийт хандах боломжтой байх: Компьютер ба цахимд суурилсан хэрэгслүүдийг ашиглан мэдээлэлд хандах боломжтой байх буюу оролцогч талууд өөрсдийн хэрэгцээний дагуу мэдээллийг бүх төрлөөр харж болдог байх,
- Өөртөө үйлчлэх: хэрэглэгч өөрийн хүссэнээр дагуу мэдээллийг МОУИТБС-ын өгөгдлийн сангаас шууд татан авч, төрөл бүрийн байдлаар задлан шинжлэх хэрэглэх боломжтой байх (Эх сурвалж: “ОУИТБС-ын онлайн тайлагналын системийн хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт” кейс судалгаа, Хуудас 11, 2016 он)

Одоогоор тус цахим хуудсаар олон нийт, иргэдэд Монгол улсын ОУИТБС-ын нэгтгэлийн тайлангуудыг хавсралтуудын хамт үнэ төлбөргүйгээр хүргэхээс гадна уул уурхайн салбарт өрнөж

буй үйл ажиллагааны талаар дараах гол статистик тойм мэдээллүүдийг цахим хуудсаар (<http://eitimongolia.mn/>) толилуулдаг байна. Үүнд:

- Олгогдсон тусгай зөвшөөрлийн статистик мэдээлэл
- Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний статистик мэдээлэл
- Хайгуулын ажлын статистик мэдээлэл
- Бүтээгдэхүүн борлуулалтын статистик мэдээлэл
- Татвар төлбөрийн статистик мэдээлэл
- Хандив дэмжлэгийн статистик мэдээлэл
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн статистик мэдээлэл
- Эдийн засагт оруулсан хувь нэмэрийн талаарх статистик мэдээлэл
- Нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд байгуулсан гэрээ
- Бенефициар эзэд
- Ил тод, нээлттэй компаниуд
- Ашиг хүртэгч эздийн ил тод байдал
- Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ

Эдгээр агуулгын одоогийн нөхцөл байдал ямар байгаа тухай 6.9.2 бүлгээс үзнэ үү.

6.9.2 Цахим тайлагналын системийн байдал

Төрийн байгууллагууд болон компаниудаас тайлагнасан татвар хураамжийн тоо мэдээллийг тулган баталгаажуулж, нэгтгэх ажлын эхний явцад МОУИТБС-ийн цахим тайлагналын системд хэд хэдэн төрлийн доголдууд гарсан ч Ажлын албаны мэдээллийн технологийн менежер цаг удаалгүй арга хэмжээ авч хэвийн ажиллагаанд оруулсан.

Олон нийт, хэрэглэгчид цахим тайлагналын системээс хандаж авч болох мэдээллийн төрөл хязгаарлагдмал байгаа.

Харин статистик тойм мэдээллүүдийг МОУИТБС-ийн цахим тайлагналын системд ил болгосон хэдий ч мэдээллийн чанар хангалтгүй байна. Энэ талаарх дүгнэлт тайлбарыг дараах хүснэгтээр харууллаа. Үүнд:

| Тойм статистик мэдээллийн төрөл | Мэдээлэл боловсруулалтын талаарх дүгнэлт |
|--|--|
| Олгогдсон тусгай зөвшөөрлийн статистик мэдээлэл | 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй |
| Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний статистик мэдээлэл | Линкээр дэлгэрэнгүй жагсаалтыг харуулах товч байгаа боловч ажиллагаагүй. Ашигт малтмал, газрын тосны газрын цахим хуудсын мэдээлэл шинэчлэгдсэн холбоотойгоор ажиллахгүй болсон. |
| Хайгуулын ажлын статистик мэдээлэл | 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй |
| Бүтээгдэхүүн борлуулалтын статистик мэдээлэл | 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй |
| Татвар төлбөрийн статистик мэдээлэл | 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй |
| Хандив дэмжлэгийн статистик мэдээлэл | 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй |
| Байгаль орчны нөхөн сэргээлтийн статистик мэдээлэл | 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй |
| Эдийн засагт оруулсан хувь нэмэрийн талаарх статистик мэдээлэл | 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй |
| Бенефициар эзэд | 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй |
| Ил тод, нээлттэй компаниуд | 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулсан ба түүнээс хойшх мэдээлэл оруулаагүй |
| Ашиг хүртэгч эздийн ил тод байдал | 2016 оны байдлаар 68 компанийн мэдээллийг ил тод болгосон |
| Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ | 2016 оны байдлаар харуулсан. |

Мөн тус цахим хуудас нь Англи хэл дээр харуулах сонголттой боловч “Transparency”, “Press release” “Article interviews” “Infographics” цэснүүдийн агуулгууд нь Англиар орчуулагдаагүй, Монгол хэл дээр харагдаж байна.

6.10 АШИГЛАСАН УСНЫ МЭДЭЭЛЭЛ

Монголын ОУИТБС-ын ОТАХ-ийн гишүүдийн саналаар 2017 оны ОУИТБС-ын нэгтгэл тайланд сонгогдсон уул уурхайн компаниудын ашигласан усны хэмжээг ил тод болгохыг хүссэн. Иймд ашигласан усны мэдээллийг компаниудаас авах зорилгоор цахим тайлагналын системд шинэ маягт оруулснаас 132 компани ашигласан усны мэдээллээ гаргаж ирүүлсэн.

Маягтыг бөглөсөн 132 компанийн мэдээллийг нэгтгэж үзэхэд нийт 73,695,603.35 метр.куб ус ашиглахаар гэрээ хийсэн боловч 68,183,323.33 метр.куб буюу гэрээлсэн усны 92.5 хувийг ашигласан байна.

Ашигласан усны хэмжээгээр Оюу Толгой, Эрдэнэт, Багануур, Шивээ-Овоо компаниуд тэргүүлж байна. “Доншен газрын тос Монгол” ХХК 4,432,458.26 метр.куб ашиглах усны гэрээ хийсэн боловч 165,106.50 метр.куб ус ашигласан гэж тайлагнасан ба үүний шалтгааныг тодорхойлохдоо энэ жил шуурга босч, тоосжилт гарах өдрүүд багатай байсан тул тоосжилт дарах усыг хэмнэж ажилласан гэсэн тайлбарыг өгсөн байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 31-ээс харна уу.

| Үзүүлэлт | Гэрээнд заасан ашиглах усны мэдээлэл (метр куб) | Ашигласан гадаргын усны хэмжээ (метр куб) | Ашигласан газрын доорх усны хэмжээ (метр куб) | Ашигласан нийт усны хэмжээ (метр куб) | Саарал ус буюу ахуйн хэрэглээнээс үүссэн бохир усыг дахин ашигласан (метр куб) |
|-------------|---|---|---|---------------------------------------|--|
| Тоо, хэмжээ | 73,695,603.35 | 8,003,409.46 | 60,179,913.87 | 68,183,323.33 | 3,408,628.58 |

6.11 ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголын ОУИТБС-ын ОТАХ-ийн гишүүдийн саналаар хог хаягдлын мэдээллийг цахим тайлангийн маягтаар нэгтгэсэн ба дэлгэрэнгүй байдлаар 113 компани мэдээллээ оруулсан.

2017 онд 113 компани нийт 318,452,834 төгрөгийг хог, хаягдлын төлбөрт төлсөн байна. Нийт төлбөрийн 69 хувийг Саусгоби Сэндс, Эрдэнэт төлсөн байна.

Олборлох салбарын томоохон аж ахуй нэгж болох Оюу Толгой компани улсад хог хаягдлын төлбөр төлдөггүй ба нийт 3,885.60 метр.куб хог хаягдлыг дахин боловсруулж, компани дотроо ашигласан гэж мэдээлсэн. 17 компани тогтмол дүнгээр хогны хэмжээнээс хамаарахгүйгээр төлбөрийг төлсөн байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 32-оос харна уу.

| Үзүүлэлт | Энгийн хог хаягдлын хэмжээ (метр.куб) | Аюултай хог хаягдлын хэмжээ (метр.куб) | Нийг хог хаягдлын хэмжээ (метр.куб) | Төлсөн төлбөр (төгрөг) | Дахин боловсруулсан аюултай хог хаягдлын хэмжээ (метр.куб) | Устгасан аюултай хог хаягдлын хэмжээ (метр.куб) | Экспортолсон аюултай хог хаягдлын хэмжээ (метр.куб) |
|------------|---------------------------------------|--|-------------------------------------|------------------------|--|---|---|
| Тоо хэмжээ | 39,880.14 | 3,232.68 | 43,112.82 | 318,452,834 | 1,780.40 | 802.92 | 484.00 |

6.12 ОУИТБС-ын тайлангийн задаргааны түвшин, хэлбэр (шаардлага 4.7)

Монгол Улсын Засгийн газар болон аж ахуйн нэгжүүд нь төлбөр, орлогын урсгалыг төслийн түвшинд хуваарилдаггүй ба дээр дурдсанчлан 2016 оны тайлангаар боломжтой бол төслөөр тайлагнах асуудлыг авч үзэхийг зөвлөсөн.

Эхлэлийн семинарийн үед төслөөр тайлагнах асуудлыг ОТАХ-тэй хэлэлцсэн ба цар хүрээ тодорхойлох ажилд Хараат бус хянагч-нэгтгэгч оролцож эхлэх үед компаниуд аль хэдийн тайлангаа тушаасан, цахим тайлагналын систем хаагдсан байсан тул 2017 оны тайланг төслөөр задалж тайлагнахгүй байх шийдвэрийг гаргасан.

6.12.1 МОУИТБС 2017 Нэгтгэл тайланд тавигдах шаардлага

ОУИТБС-ын стандартад мэдээллийг багадаа доорх задаргаагаар тайлагнахыг шаарддаг. Үүнд:

- Аж ахуйн нэгж,
- Засгийн газрын нэгж,
- Орлогын урсгал

ОУИТБС-ын стандарт АНУ-ын Үнэт цаасны арилжааны хорооны журам болон удахгүй мөрдөгдөх Европын холбооны шаардлагуудтай нийцүүлэн төслийн түвшинд тайлагнахыг шаарддаг (Шаардлага 4.7).

Богота хотод 2017 оны 3 дугаар сард зохион байгуулагдсан ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн хурлаар 2018 оны 12 дугаар сарын 31 болон түүнээс хойш дуусгавар болох санхүүгийн жилийг хамарсан ОУИТБС-аар ил тод болгох бүх мэдээллийг төслийн түвшинд тайлагнах шаардлагатай гэдгийг дахин баталсан.

Тийм учраас төслийн түвшинд тайлагнах шаардлагыг Монгол улс 2017 оны нэгтгэл тайлан дээр нэвтрүүлэх шаардлагагүй. Харин ОТАХ-ын зүгээс Хараат бус нэгтгэгч нь дараагийн буюу ОУИТБС 2018 оны тайланд төслөөр тайлагнах шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар судлаж, 2017 оны тайланд танилцуулах хүсэлтийг тавьсан, үүнд дараах асуудлуудыг авч үзэх юм:-

1. “Төсөл”-ийн Монголын хувьд тохирох тодорхойлолт
2. Төслийн түвшинд болон аж ахуйн нэгжийн түвшинд ногдуулсан төлбөрийг тодорхойлох
3. Төслийн түвшинд ногдуулсан төлбөрийг ил тод болгоход учирч болох аливаа саад бэрхшээлийг авч үзэх
4. Төлбөр хийж буй аж ахуйн нэгжүүдийг тодорхойлох
5. Цахим тайлангийн маягтад орох өөрчлөлтүүд

6.12.2 Төслийн тодорхойлолт

Монголоос бусад оронд ашиглаж буй тодорхойлолтууд

Төслийг Монголд тохиромжтой байдлаар тодорхойлохын тулд бусад улс орны тодорхойлолтыг харгалзан үзэх нь зүйтэй.

Европын холбооны Нягтлан бодох бүртгэлийн удирдамжийн 41 дүгээр зүйл төслийг дараах байдлаар тодорхойлсон байна:

“дан ганц гэрээ, лиценз, түрээс (lease), концесс эсвэл ижил төстэй гэрээ хэлцлээр зохицуулагдаж буй мөн засгийн газарт төлөх төлбөрийн үүрэг хариуцлагын үндэслэл бий болгож байгаа үндсэн үйл ажиллагаанууд. Гэсэн хэдий ч тиймэрхүү гэрээнүүд хоорондоо бодит холбоотой байвал нэг төсөл гэж үзнэ.”

Канадын Олборлох салбарын ил тод байдлын арга хэмжээний тухай акт дээрхтэй дүйцэхүйц төслийн тодорхойлолтыг багтаасан байна:

“Төсөл” гэдэг нь дан ганц гэрээ, лиценз, түрээс (lease), концесс эсвэл ижил төстэй гэрээ хэлцлээр зохицуулагдаж буй мөн засгийн газарт төлөх төлбөрийн үүрэг хариуцлагын үндэслэл бий болгож байгаа үндсэн үйл ажиллагаануудыг хэлнэ. Гэсэн хэдий ч тиймэрхүү гэрээнүүд хоорондоо бодит холбоотой байвал нэг төсөл гэж үзнэ. “Бодит холбоотой” байх гэдэг нь засгийн газартай үзэглэсэн бөгөөд төлбөрийн үүрэг хариуцлага бий болгож буй үйл ажиллагаа болон газар зүйн хувьд нэгдмэл, нөхцөл нь үндсэндээ ижил төстэй гэрээ, лиценз, түрээс, концесс эсвэл холбогдох гэрээ хэлцлүүдийг хэлнэ.”

Нэгдсэн Вант улсын Засгийн газарт төлөх төлбөрийн тухай журам 2014 төслийг дараах байдлаар тодорхойлсон:

“Төсөл” гэдэг нь дан ганц гэрээ, лиценз, түрээс (lease), концесс эсвэл ижил төстэй гэрээ хэлцлээр зохицуулагдаж буй мөн засгийн газарт төлөх төлбөрийн үүрэг хариуцлагын үндэслэл бий болгож байгаа үндсэн үйл ажиллагаануудыг хэлнэ.

Хэрэв “төсөл”-ийн тодорхойлолтод дурдсан гэрээ хэлцлүүд хоорондоо бодит холбоотой бол тэдгээр гэрээ хэлцлийг энэхүү Журмын зорилгоор дан ганц төсөл гэж авч үзнэ. “Бодит холбоотой” байх гэдэг нь засгийн газартай үзэглэсэн бөгөөд төлбөрийн үүрэг хариуцлага бий болгож буй үйл ажиллагаа болон газар зүйн хувьд нэгдмэл, нөхцөл нь үндсэндээ ижил төстэй гэрээ, лиценз, түрээс, концесс эсвэл холбогдох гэрээ хэлцлүүдийг хэлнэ.

Тийм гэрээ хэлцлүүд дан ганц гэрээ, хамтарсан хэлцэл, бүтээгдэхүүн хуваах гэрээ эсвэл бусад ерөнхий (overarching) хуулийн гэрээ хэлцлээр зохицуулагдаж болно.”

Дээрх тодорхойлолтуудын дагуу:

- Татвар/нөөц ашигласны төлбөрийг баримталдаг бол төсөл нь ерөнхийдөө төлбөр үүсгэж буй лиценз байна.
- Бүтээгдэхүүн хуваах гэрээг баримталдаг бол төсөл нь ерөнхийдөө төлбөрийн үүрэг хариуцлага үүсгэдэг гэрээ байна.

Дээрх тодорхойлолтуудад хоорондоо “бодит холбоотой” гэрээ хэлцлүүдийг нийлүүлсэн дан ганц төсөл байж болох талаар авч үзсэн байна. НВУ-ын Журамд үйл ажиллагаа хоорондын зардлыг нэгтгэх эсвэл хуваарилах нь хэрхэн зохистой байх талаар илүү дэлгэрэнгүй удирдамж өгсөн бөгөөд *“НВУ-ын Журмын хэрэгжилтээс зайлсхийх зорилгоор төслүүдийг зохиомлоор салгах эсвэл нийлүүлж болохгүй”* гэж дүгнэсэн байдаг.

6.12.3 Монгол дах “Төсөл”-ийн орчин

5.2 болон 5.3 хэсэгт тайлбарласнаар Монголын эрдэс баялгын хөгжүүлэлтийг дараах байдлаар зохицуулдаг:

- Ашигт малтмалын хайгуулыг хайгуулын лицензээр,
- Ашигт малтмалын ашиглалтыг ашиглалтын лицензээр,
- Газрын тос, байгалийн хийн эрлийг эрлийн лицензээр зохицуулдаг.

Газрын тос, байгалийн хийн хайгуулын ажил эхлэхээс өмнө тал/талууд Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ) үзэглэсний дараа дараах лицензүүдийг олгодог:

- Газрын тос, байгалийн хий хайх зөвшөөрөл олгодог хайгуулын лиценз

- Газрын тос, байгалийн хий ашиглах зөвшөөрөл олгодог ашиглалтын лиценз

Тийм учраас ОУИТБС-ын тайлагналын зорилгоор тайлбарлахад Монголд олборлох үйл ажиллагааг холбогдох лицензийн дагуу, газрын тос, байгалийн хийн хувьд лиценз болон БХГ-ний дагуу явуулдаг.

6.12.4 Монгол дах “Төсөл”-ийн тодорхойлолт

Монголд “төсөл”-ийг дан ганц гэрээ, хэлцэл, лиценз бөгөөд Засгийн газарт төлөх төлбөрийн үүрэг хариуцлагын үндэслэл бий болгож байгаа үндсэн үйл ажиллагаанууд гэж тодорхойлдог.

6.12.5 Төслийн түвшинд болон аж ахуйн нэгжлийн түвшинд ногдуулдаг төлбөрүүдийг тодорхойлох нь

Монголд Засгийн газарт төлөх төлбөрүүдийг улсын хэмжээнд, аймгийн болон сумын хэмжээнд хийдэг. ОТАХ олборлох компаниудын төлсөн төлбөрийг улс, аймаг, сумын түвшинд төлсөн байдлыг тодорхойлж, ОУИТБС-ын тайланд багтаах төлбөрүүдийг тогтоосон.

Доорх хүснэгт 1-д ОУИТБС-д тайлагнах төлбөрүүдийг төслийн түвшин эсвэл байгууллагын түвшиний алинд ногдуулсан болохыг харуулав

Хүснэгт 6.13

| N | Сонгож авсан улсын түвшний орлогын урсгалууд | Ногдуулсан түвшин | | Цахим тайлангийн системд маягт нэмж оруулах эсэх |
|----|--|-------------------|----------|--|
| | | Компанид | Лицензэд | |
| 1 | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр | | ✓ | ✓ |
| 2 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | ✓ | | |
| 3 | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого | | ✓ | ✓ |
| 4 | Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл | | ✓ | ✓ |
| 5 | Нэмэгдсэн өртгийн албан татвар (Гааль) | ✓ | | |
| 6 | Нэмэгдсэн өртгийн албан татвар (ТЕГ-т төлсөн) | ✓ | | |
| 7 | Гаалийн үйлчилгээний хураамж | ✓ | | |
| 8 | Гаалийн албан татвар | ✓ | | |
| 9 | Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр | | ✓ | ✓ |
| 10 | Агаарын бохирдлын төлбөр | ✓ | | |
| 11 | Рояльти | | ✓ | ✓ |
| 12 | Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар | ✓ | | |
| 13 | Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | ✓ | | |
| 14 | БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ | | ✓ | ✓ |
| 15 | Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | ✓ | | |
| 16 | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр | | ✓ | ✓ |
| 17 | Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал | | ✓ | ✓ |
| 18 | Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | | ✓ | ✓ |
| 19 | Автобензин, дизелийн түлшний албан татвар | ✓ | | |
| 20 | Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр | | ✓ | ✓ |

| No. | Сонгож авсан орон нутгийн түвшний орлогын урсгал | Ногдуулсан түвшин | | Цахим тайлангийн системд маягт нэмж оруулах эсэх |
|-----|---|-------------------|----------|--|
| | | Компанид | Лицензэд | |
| 1 | Орон нутгийн түвшний орлогын урсгал | | ✓ | ✓ |
| 2 | Ус ашигласны төлбөр | | ✓ | ✓ |
| 3 | Газрын төлбөр | | ✓ | ✓ |
| 4 | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал | | ✓ | ✓ |
| 5 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | | ✓ | ✓ |
| 6 | Торгууль | ✓ | | |
| 7 | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | | ✓ | ✓ |
| 8 | Ус бохирдуулсны төлбөр | | ✓ | ✓ |
| 9 | Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн | | ✓ | ✓ |
| 10 | Нөхөн төлбөр | ✓ | | |
| 11 | Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг | ✓ | | |
| 12 | Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | ✓ | | |

6.12.6 Төлбөр төлөгч аж ахуйн нэгжүүдийг тодорхойлох нь

Монголд Засгийн газарт төлөх төлбөрүүдийг улсын хэмжээнд, аймгийн болон сумын хэмжээнд хийдэг. ОТАХ олборлох компаниудын төлсөн төлбөрийг улс, аймаг, сумын аль түвшинд төлсөнийг тодорхойлж, ОУИТБС-ын тайланд хамруулах төлбөрүүдээ сонгосон.

Доорх хүснэгт 1-д ОУИТБС-д тайлагнах төлбөрүүдийг төслийн түвшин эсвэл байгууллагын түвшиний алинд ногдуулсан болохыг харуулав.

| No. | Сонгож авсан улсын түвшний орлогын урсгалууд | Ногдуулсан түвшин | | Цахим тайлангийн системд маягт нэмж оруулах эсэх |
|-----|--|-------------------|----------|--|
| | | Компанид | Лицензэд | |
| 1 | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр | | ✓ | ✓ |
| 2 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | ✓ | | |
| 3 | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого | | ✓ | ✓ |
| 4 | Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл | | ✓ | ✓ |
| 5 | Нэмэгдсэн өртгийн албан татвар (Гааль) | ✓ | | |
| 6 | Нэмэгдсэн өртгийн албан татвар (ТЕГ-т төлсөн) | ✓ | | |
| 7 | Гаалийн үйлчилгээний хураамж | ✓ | | |
| 8 | Гаалийн албан татвар | ✓ | | |
| 9 | Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр | | ✓ | ✓ |
| 10 | Агаарын бохирдлын төлбөр | ✓ | | |
| 11 | Рояльти | | ✓ | ✓ |
| 12 | Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар | ✓ | | |
| 13 | Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | ✓ | | |

| No. | Сонгож авсан улсын түвшний орлогын урсгалууд | Ногдуулсан түвшин | | Цахим тайлангийн системд маягт нэмж оруулах эсэх |
|-----|--|-------------------|----------|--|
| | | Компанид | Лицензэд | |
| 14 | БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ | | ✓ | ✓ |
| 15 | Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг | ✓ | | |
| 16 | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр | | ✓ | ✓ |
| 17 | Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал | | ✓ | ✓ |
| 18 | Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | | ✓ | ✓ |
| 19 | Автобензин, дизелийн түлшний албан татвар | ✓ | | |
| 20 | Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр | | ✓ | ✓ |

| No. | Сонгож авсан орон нутгийн түвшний орлогын урсгал | Компанид | Лицензэд | Цахим тайлангийн системд маягт нэмж оруулах эсэх |
|-----|---|----------|----------|--|
| | | | | |
| 2 | Ус ашигласны төлбөр | | ✓ | ✓ |
| 3 | Газрын төлбөр | | ✓ | ✓ |
| 4 | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал | | ✓ | ✓ |
| 5 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | | ✓ | ✓ |
| 6 | Торгууль | ✓ | | |
| 7 | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | | ✓ | ✓ |
| 8 | Ус бохирдуулсны төлбөр | | ✓ | ✓ |
| 9 | Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн | | ✓ | ✓ |
| 10 | Нөхөн төлбөр | ✓ | | |
| 11 | Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг | ✓ | | |
| 12 | Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр | ✓ | | |

6.12.7 Төслийн түвшинд ногдуулсан төлбөрийг ил тод болгоход учрах аливаа саадыг авч үзэх

ОУИТБС-ын тайлан дээр ажилласан бидний туршлага, оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөөний үндсэн дээр тайлагналын энэхүү шаардлагыг хэрэгжүүлэхэд саад бэрхшээл тулгарах асуудал үүсэхгүй болохыг тогтоосон.

6.12.8 Төлөгч аж ахуйн нэгжүүдийг тодорхойлох

Зарим улсад хэд хэдэн компани хамтран консерциум хэлбэрээр гэрээ байгуулдаг. Компаниуд эрсдэл, зардал, санхүүжилтээ хуваах бөгөөд тэр дундаа бусад оролцогчдоос захиргаа, үйл ажиллагааны үүрэг хариуцлага арай илүүтэй үйл ажиллагааг гардан явуулах компанийг томилох нь элбэг байдаг. Уг үйл ажиллагааг гардан явуулах компани нь консорциумын бусад компаниудыг төлөөлөн тодорхой төлбөрүүдийг гүйцэтгэж болно.

Монголд харин ийм консерциумын оролцоотой гэрээ хэлцэл байхгүй бөгөөд лиценз эзэмшигч нь лицензэд үндэслэн ногдуулсан (АМНАТ г.м) бүх төлбөрийг Засгийн газарт төлөх үүрэг хүлээдэг.

7 ЗӨВЛӨМЖ

7.1 ӨМНӨХ ЖИЛИЙН НЭГТГЭЛ ТАЙЛАНГААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2016 онд өгөгдсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийн байдлын талаарх дүгнэлтийг дор харуулав. Үүнд:

| Зөвлөмжүүд | 2016 оны ОУИТБС тайлагнал дахь лавлагаа | 2017 оны ОУИТБС тайлагналаар хэрэгжүүлсэн эсэх | |
|---|---|--|--|
| | | Статус | Тайлбар |
| Төрийн байгууллагуудаас тайлагнасан ОУИТБС-ын мэдээллийг баталгаажуулах журмыг амжилттай хэрэгжүүлэх ажлыг УАГ-тай хамтран зохион байгуулах нь зүйтэй | 6.2.1 | Цаашид арга хэмжээ авах шаардлагатай | Монголын УАГ-ын 2019 онд хийгдэх ажлын төлөвлөгөөндөө баталгаажуулах журмыг оруулж өгөх хэрэгтэй ОУИТБС-ын тайлангийн мэдээлэлтэй холбоотой сургалт, семинарыг хараат бус хянагч-нэгтгэгч зохион байгуулсан. |
| ОУИТБС-ын ач холбогдол болоод ОУИТБС-ын мэдээллийг бэлтгэдэг Засгийн Газрын агентлагуудын хамтын ажиллагааны ач холбогдлыг таниулах ажлын төлөвлөгөөг Үндэсний зөвлөлөөс батлах нь зүйтэй. | 6.2.2 | Хэрэгжүүлсэн | |
| ТӨААН-үүдтэй холбоотой ОУИТБС-ын стандартын тухайлсан шаардлагуудын талаарх сургалтыг ОТАХ болон МОУИТБС-ын Ажлын албаны (эсвэл хөндлөнгийн мэргэжилтнүүдийн) зүгээс Хараат бус хянагч-нэгтгэгчийн ажил эхлэхээс тодорхой хугацааны өмнө зохион байгуулах, сургалтын гарын авлага танилцуулах гэх мэтээр ТӨААН-үүдийн чадавхийг үргэлжлүүлэн бэхжүүлэх нь зүйтэй. | 6.2.3 | Хэрэгжиж байгаа | МОУИТБС-ын 2018 оны тайлангийн ажлын төлөвлөгөөнд багтсан. Хэрэгжиж байгаа. |
| МОУИТБС-ын цахим тайлангийн системд НӨАТ-ын орлогын урсгалыг дараах 2 байдлаар ялган тайлагнах боломжтой байхаар загварчлах нь зүйтэй: - Татварын албанд төлөгдөх НӨАТ; болон - Гаалийн албанд төлөгдөх НӨАТ | 6.2.4 | Хэрэгжүүлсэн | Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газарт төлсөн НӨАТ-ын мэдээлэл цахим тайлангийн системд тусдаа харагдаж байна. Зөвлөмжийг хэрэгжүүлсэн |
| ЗГ-ын түвшинд бизнесийн олон үйл ажиллагаа эрхэлдэг аливаа аж ахуйн нэгжийн олборлох үйлдвэрлэл эсвэл бусад бизнесийн үйл ажиллагаанаас орсон орлогын урсгалуудыг хооронд нь ялгаж, тайлагнах шинэ тогтолцоо бий болгон түүнийг хэрэгжүүлэх тал дээр анхаарах хэрэгтэй. | 6.2.5 | Цаашид арга хэмжээ авах шаардлагатай | Төслөөр тайлагнах асуудлуудыг тодорхойлж өгөхдөө энэхүү тогтолцоог бий болгож ажиллахыг МОУИТБС-д зөвлөж байна |
| ОУИТБС-ын стандартаар шаардсан наад захын шаардлагуудад нийцсэн мэдээллийг олон нийт авах боломжийг бүрдүүлэх үүднээс тусгай зөвшөөрлийн кадастрын мэдээллийг АМГТГ-ын зүгээс сайжруулах арга хэмжээг авах нь зүйтэй. | 6.2.6 | Арга хэмжээ авах шаардлагатай | Хэрэгжүүлээгүй |
| Үндэсний зөвлөл эсвэл ОТАХ нь БХГ-г ил тод болгох асуудлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тавьж, одоогоор хүчин төгөлдөр байгаа бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг ОУИТБС-ын стандартын дагуу олон нийтэд ил тод болгох нь зүйтэй. | 6.2.7 | Цаашид арга хэмжээ авах шаардлагатай | БХГ-нүүдийг ил тод болгоогүй байна |

7.2 ОУИТБС-ЫН ТАЙЛАГНАЛ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Монгол улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх явдлыг улам сайжруулах талаар 2017 оны ОУИТБС-ын тайланг бэлтгэх явцад үүссэн асуудлаар дараах зөвлөмжүүдийг өгч байна.

7.2.1 Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийг батлуулах

2017 оны ОУИТБС-ын тайлангийн мэдээллийг авахаар бид тайлагнагч байгууллагуудад хандах явцад мэдээлэл өгөхийг хуулиар хязгаарласан гэх буюу зарим тохиолдолд ямар ч тайлбаргүйгээр мэдээллээ гаргаж өгөхгүй байх зэрэг нэлээд хүндрэлүүд тулгарсан, жишээ дурдвал:-

- ГЕГ нь мөн Гаалийн ерөнхий хуулиар заасан хязгаарлалтаас шалтгаалан дэлгэрэнгүй мэдээллийг шууд Хараат бус хянагч нэгтгэгчид гаргаж өгөх боломжгүй байна гэсэн хариу өгсөн,
- Стандартчилал хэмжил зүйн газраас сорьцын хяналтаар орсон мэдээлэл хүсэхэд энэ нь Төрийн албаны нууцын тухай хуулиар хориглосон гэх жишээтэй,
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын зүгээс үндсэн болон нэмэлт мэдээллийн маягтаар гаргаж ирүүлэхийг хүссэн мэдээлэл, ялангуяа Бенефициар эздийн мэдээллийг Хувь хүний нууцтай холбоотой тул гаргаж өгөхөөс татгалзаж байсан,
- Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс ТЕХ-д заасны дагуу тухайн ААН-ийн зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн нэмэлт мэдээлэл, тодруулга, тайлбар өгөх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн,
- Бидний явуулсан 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 02/213 дугаартай "Мэдээлэл хүсэх тухай" албан бичигтэй "Эрдэнэс Монгол" ХХК-ийн удирдлагууд танилцаад, албан бичигт дурдсан мэдээллийг гаргаж өгөх боломжгүй гэж үзсэн бөгөөд ямар шалтгаанаар мэдээлэл ирүүлэх боломжгүйгээр тайлбарласан хариугаа албан бичгээр ирүүлэхээс татгалзсан.

Эрдэс баялгийн салбарын мэдээллийг ил тод болгоход дараах хуулиудад заасан хязгаарлалтууд нөлөөлж байна. Тухайлбал:-

1. Татварын ерөнхий хууль
2. Гаалийн ерөнхий хууль
3. Төв банкны тухай хууль
4. Хувь хүний нууцын тухай хууль
5. Байгууллагын нууцын тухай хууль
6. Төрийн албаны нууцын тухай хууль
7. Улсын бүртгэлийн тухай хууль

Зөвлөмж

Дээрх хуулиудад эрдэс баялгийн салбарын мэдээллийг ил тод болгохыг хязгаарласан заалтуудыг хүчингүй болгож, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийг даруй батлан гаргах шаардлагатай нь харагдаж байна.

7.2.2 Бүтээгдхүүн хуваах гэрээг ил тод болгох

БХГ-үүдийг ил болгох Ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа боловч одоогоор ил тод болгосон БХГ хараахан байхгүй байгаа. Ажлын хэсгээс гэрээний үндсэн нөхцлийг ил болгохгүйгээр гэрээнүүдийг <http://www.iltodgereee.mn/> сайт дээр ил болгох талаар гэрээлэгч нарт мэдэгдэж, хариу ирүүлэхийг хугацаа заан мэдэгдсэн боловч одоогоор нэг ч гэрээлэгчээс хариу ирүүлээгүй байна.

Учир нь БХГ-ний хуучин загвараас шинэ загварт шилжүүлэхдээ гэрээний үндсэн нөхцлөөс болоод зарим компаниуд дээр зарчимын шинжтэй зөрүүтэй санал гарсан тул БХГ-г шинэ загварт шилжүүлэх асуудал үүнээс болоод зогссон байна.

Зөвлөмж

БХГ-г ил тод болгох зөвлөмжийг өмнөх ОУИТБС-ын тайлангуудад оруулсаар ирсэн. ЗГ-аас 2015 оны 7 сарын 4-ний өдрийн 222 тоот тогтоол баталсан байдаг, ийнхүү ил тод болгохыг хязгаарласан хуулийн болоод практик хязгаарлалт байх үндэсгүй.

Тиймээс Үндэсний Зөвлөл холбогдох төрийн яам, агентлагуудыг татан оролцуулж БХГ-нүүдийг ил тод болгохыг ажлыг зохион байгуулахыг зөвлөж байна.

7.2.3 Тусгай зөвшөөрлийн мэдээллийн ил тод байдал

АМГТГ-аас тусгай зөвшөөрлийн талаар нийтэлсэн мэдээлэл нь ОУИТБС-ын Стандартаар наад захын байвал зохих шаардлагыг хангаж байгаа боловч, тодорхой ашигт малтмалын нэр төрлийн хувьд хангалтгүй байгаа, тухайлбал:

- Ураны хайгуул, ашиглалт
- Газрын тосны БХГ (зөвлөмж 7.2.2-ийг үзэх)

Мөн зарим тогтоолуудыг вэб хуудас руу оруулаагүй орхигдуулдаг ялангуяа тогтоолуудын хавсралт буюу дэлгэрэнгүй жагсаалтыг оруулаагүй байна.

ОУИТБС-ын стандартаар шаардсан хэмжээнд мэдээллийг цаг тухайд нь АМГТГ-ын вэб хуудас дээр нийтлэх ажил хийгдэхгүй байна, хэд хэдэн цэс, гарчгуудын доорх мэдээлэл нь шинэчлэгдээгүй байгаа юм.

Зөвлөмж

АМГТГ олон нийтэд ил тод болгох тусгай зөвшөөрлийн мэдээллээ цаг тухайд нь нийтэлдэг байх, түүнчлэн газрын тос болон бусад бүх ашигт малтмалын нэр төрлүүдийн хувьд ОУИТБС-ын Стандартаар наад захын байвал зохих шаардлагыг хангасан байх ба оруулсан мэдээллээ байнга шинэчилдэг байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. *(энэ зөвлөмжийг өмнө жил бас өгсөн байсан)*

7.2.4 Нийт үйлдвэрлэлээс ЗГ-т ногдох хэмжээг ил тод болгох

БХГ-ний дагуу Засгийн газар олборлосон газрын тосноос өөрт ногдох хувийг авах эрх үүсдэг. Засгийн газар, гэрээлэгч компани хоорондын гэрээнд зааснаар ЗГ-т ногдох газрын тосыг гэрээлэгч компани арилжаалах ба орлогыг ЗГ руу шилжүүлэх үүрэгтэй.

ОУИТБС-ын Шаардлага 4.2-д зааснаар хэрэв газрын тосны борлуулалтаас ЗГ-т ногдох хувь хэмжээ, эсвэл мөнгөн бус хэлбэрээр хүлээн авсан орлогын хэмжээ материаллаг дүнтэй бол ЗГ, ТӨААН-үүдийн борлуулсан газрын тосны биет хэмжээ ба борлуулалтын орлогыг ил тод тайлагнах ёстой.

Бид БХГ-нд зааснаар газрын тосны нийт үйлдвэрлэлээс ЗГ-т ногдох биет хэмжээг тайлагнах хүсэлтийг тавьсан боловч, АМГТГ-аас энэ мэдээллийг гаргаж өгөөгүй.

Зөвлөмж

Үндэсний зөвлөл, МОУИТБС-ын Ажлын албаны зүгээс АМГТГ-тай хамтран ажиллаж 2018 оны олборлох үйлдвэрлэлийн гүйцэтгэлийг тайлагнахад энэ мэдээллийг ирүүлэх шаардлагатай.

7.2.5 МОУИТБС-аас баталгаажуулалттай холбоотой тавьсан шаардлагын нийцлийг сайжруулах

ОТАХ-ын шийдвэрийн дагуу тайлагнагч байгууллагуудаас дараах зүйлсийг шаардаж баталгаажуулалт авах ёстой:

- Мэдээллээ цахим тайлагналын систем ашиглаж ирүүлэх,

- Байгууллага, аж ахуйн нэгжийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтны гарын үсэгтэй Удирдлагын хариуцлагын захидлыг тайлагнагч бүх байгууллагууд Хараат бус хянагч-нэгтгэгчид гаргаж өгөх,
- Хараат бус аудиторын баталгаажуулсан аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлэх

Дээрх баримт бичгүүдийг бүгдийг нь эсвэл заримыг нь ирүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгжүүд олон байгаа бөгөөд энэ нь тайлагнасан мэдээллийн баталгаатай эсэхэд нөлөөлж болох талаар ОУИТБС-ын тайланд дэлгэрэнгүй тусгасан байгаа. Мөн зарим компаниуд цахим тайлагналын систем ашиглаагүй.

Зөвлөмж

Тавьсан шаардлагын дагуу зохих гарын үсэг бүхий хариуцлагын захидал болон аудитын тайланг ирүүлээгүй төрийн байгууллагууд, ТӨААН-үүдтэй Үндэсний зөвлөл хариуцлага тооцдог байх, ирүүлээгүй баталгаажуулалтыг МОУИТБС-ын ажлын албанд даруй ирүүлэхийг шаардах ба энэ талаар дараагийн ОУИТБС тайланд тусгахыг зөвлөж байна.

МОУИТБС-ын Ажлын алба цахим тайлагналын системийг ашиглаагүй компаниуд, шаардсан баталгаажуулалтын бичиг баримтыг гаргаж өгөөгүй компаниудад хариуцлага тооцож, энэ асуудлын ач холбогдлыг таниулах ойлгуулах замаар дараагийн ОУИТБС тайланд нийцлийн тал дээр ахиц гаргаж ажиллахыг зөвлөж байна.

7.2.6 Гаалийн Ерөнхий Газрын тайлагналын зөрүү

ГЕГ дээр жил бүр томоохон хэмжээний зөрүү үүсдэг ба зөрүүгийн шалтгааныг тодруулахад компаниуд урьдчилгаа данс нээлгэж ашигладаг, компани нь Гаалийн албан татвар болон НӨАТ-ыг нэгтгэж тайлагнадаг зэрэг асуудлуудаас үүсдэг байна.

ГЕГ нь гаалийн бүрдүүлэлт хийдэг боомт тус бүрээр компаниудын хийсэн төлөлтийг нэгтгэж гаргах боломжгүй байдаг ба нэгтгэж гаргасан ч үнэн зөв гаргах боломжгүй байдаг.

| Тайлагнагч | Гаалийн албан татвар | Нэмэгдсэн өртгийн албан татвар | Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар | Гаалийн үйлчилгээний хураамж |
|-----------------------|----------------------|--------------------------------|--|------------------------------|
| Компаниуд | 50,604 | 106,975 | 53 | 60,713 |
| Гаалийн ерөнхий газар | 8,650 | 17,145 | (1,697) | (40) |

Дээрх хүснэгтэд ГЕГ-ийн газрын хүлээж авдаг татварын орлогын дүнд хийсэн тохируулгыг харахад Компаниуд ихээхэн дүнгээр дутуу тайлагнадаг ба зөрүүгийн шалтгааныг олоход ГЕГ-ын ногдуулалтын мэдээлэл маш чухал үүрэгтэй байдаг. Учир нь ГЕГ-ын ногдуулалтын мэдээ нь татварын төрөл тус бүрээр, компани тус бүрээр гардаг ба мөнгөөр төлсөн дүнтэйгээ бараг тэнцүү тул зөрүү үүсэх магадлал бага, зөрүү үүссэн ч бага хэмжээтэй.

Гэвч ГЕГ-ын ногдуулалтын мэдээллийн сан нь хуулиар тогтоосон нууцлалын өндөр зэрэглэлд хамаардаг тул анхны тайлан болон нэмэлт тайлбар мэдээллийг ногдуулалтын мэдээллийн сангаас гаргахад бэрхшээлтэй байдаг байна.

Зөвлөмж

Үндэсний зөвлөл болон ОТАХ-ийн зүгээс асуудлыг нааштай шийдвэрлэхэд зохих дэмжлэг үзүүлэн, ОУИТБС-ын эрх зүйн үндэслэлийг ГЕГ-ын удирдлагад ойлгуулж, анхны тайлангаа алдаа багатай тайлагнахад тус нэмэр болохыг зөвлөж байна.

7.2.7 Орлогын бус мэдээллийг ил тод болгох ажлыг хэрэгжүүлэх

ОУИТБС-ын стандартад шаардсаны дагуу орлогын бус төрөл бүрийн мэдээллийг ОУИТБС тайланд ил тод болгох эсвэл олон улсын жишгээр нийтэд байнга мэдээлдэг тайлагналдаа багтаагаад оруулж болно.

Монгол улсад ийм практик байхгүй байгаа болохоор төрийн байгууллагуудаас уг мэдээллээ бичгээр авч, ОУИТБС-ын тайланд оруулдаг (Хараат бус хянагч-нэгтгэгчийн хүссэн мэдээллийн жагсаалтыг Хавсралт 5-аас харна уу).

Энэ мэдээллийг бэлтгэх, цуглуулах үйл явц жигдрээгүй харагдаж байна, цаашид сайжруулах шаардлагатай. Одоогийн байдлаар Хараат бус хянагч-нэгтгэгчээр олон дахин шаардуулж, дээд шатны дарга нартай нь уулзаж, үүрэг даалгавар өгүүлэх замаар найдвартай мэдээллийг цаг тухайд нь гаргуулж байна. Сүүлийн жилүүдэд стандартаар шаардсан мэдээллүүдийг холбогдох яам, агентлагуудаас авч, ОУИТБС тайланд удаа дараа оруулсан ба оруулж буй мэдээллүүд нь жил бүр давтагдах хандлагатай болж, ил тод болгох шаардлагатай мэдээллүүд илүү тодорхой болж байна.

Зөвлөмж

Жил бүр ОУИТБС-ын стандартад шаардсан ямар ‘орлогын бус мэдээллийг’ ямар байгууллага, ямар хэмжээнд ил тод болгохыг МОУИТБС-ын Ажлын албаны зөвлөснөөр ОТАХ-ээс зааж өгч шийдвэрлэхийг зөвлөж байна. Холбогдох төрийн байгууллагууд өөрсдөө нийтэд байнга мэдээлдэг тайландаа оруулаагүй бол эдгээр мэдээллийг зайлшгүй дараагийн ОУИТБС тайланд бэлтгэж ирүүлэхийг шаардах нь зүйтэй.

7.2.8 Бенефициар эздийн мэдээллийг ил тод болгох

Бенефициар эздийн мэдээллийг ил тод болгохыг цахим тайлангийн системд оруулсан шинэчилсэн маягтаар бөглөхийг хүссэн ба нийт нэгтгэлд хамрагдсан 230 компаниас 184 компани бенефициар өмчлөгчийн мэдээллээ ирүүлсэн.

Бенефициар эздийн мэдээллээ ирүүлээгүй компаниудаас яагаад гаргаж өгөх боломжгүй байгаа талаар нэг бүрчлэн лавлахад дараах хариултыг өгсөн. Үүнд:-

- Толгой компани нь гадаад хуулийн этгээд тул мэдэх боломжгүй,
- Хууль эрхзүйн үндэслэл байхгүй,
- Далд эзэн байхгүй, хувьцаа эзэмшигчидтэйгээ адилхан тул давхар бөглөх шаардлагагүй,
- Шаардлагатай тохиолдолд татварын газраас энэ мэдээллийг өөрсдөө олж аваарай,

Мөн зарим компани өөрсдийн толгой компани болох гадаад, дотоодын хаалттай компанийг (ХХК) бенефициар эзэд гэж мэдээллээ ирүүлсэн.

Зөвлөмж

Бенефициар эздийг ил тод болгох талаар Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуульд тодорхой оруулж, бусад хуулиудад заасан хязгаарлалтуудыг хүчингүй болгож, хуулиудын уялдаа холбоог сайжруулах замаар ил тод байдлыг хангах асуудлыг шийдвэрлэхийг зөвлөж байна.

Мөн компаниудад зориулан Бенефициар эздийн талаар явуулах сургалт, олон талт хэлэлцүүлэгийг үе шаттай зохион байгуулж байх нь зүйтэй байна.

7.2.9 ТӨААН-үүдийн аудитын тайлан

ҮАГ-аас 2017 оны ЗГ-ын нэгдсэн санхүүгийн тайланд аудит хийсэн тайландаа “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Шивээ овоо” ТӨХК, Мон-атом ХХК гэсэн олборлох салбарын ТӨААН-ийн 2017 оны санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна . “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьд ЗГ-ын 2017 оны 5-р сарын 30-ны өдрийн 154 тоот тогтоолын 8.2-т заасан хувьцааны бүртгэл дээр хөндлөнгийн аудиторуд нэгж хувьцааны нэрлэсэн үнийг тооцоолсон тооцоолол, түүний нотлох баримтыг олж авч чадаагүй тул хязгаарлалттай дүгнэлт өгчээ.

Хөндлөнгийн аудитор зөрчилтэй дүгнэлт гаргасан байгаагаас ТӨААН-үүдийн тайлагналыг сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа гэдэг нь харагдаж байна.

Зөвлөмж

ҮАГ гэх зэргийн эрх бүхий байгууллагаас ТӨААН-үүдийн зөрчилтэй дүгнэлтийн асуудлыг цааш тодруулж, тэдэнд зөрчилтэй асуудлуудаа засаж сайжруулах ажлыг даалгах, цаашлаад ялангуяа “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн хувьцааны үнэлгээтэй холбоотой материаллаг буруу илэрхийллийг шалгаж, санхүүгийн тайлангийн үнэн зөв эсэхэд өөрсдийн дүгнэлтийг өгөх нь зүйтэй юм.

7.2.10 ТӨААН-ийн санхүүгийн тайланг ил тод болгох

ҮАГ-ын вэб хуудас дээр ТӨААН-үүдийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дараах мэдээллүүд нийтлэгдсэн байна :-

- Баланс
- Орлогын тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Аудитын дүгнэлт

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн хавсралт тодруулга бүхий санхүүгийн тайлангийн аудитлагдсан мэдээллийг иж бүрэн байдлаар нийтлэхгүй бол ТӨААН-ийн үйл ажиллагааны тухай бүрэн гүйцэд ойлголт авах боломжгүй юм.

Зөвлөмж

Олборлох салбарын бүх ТӨААН-ийн аудитлагдсан иж бүрэн санхүүгийн тайланг цахимаар нийтэд мэдээлэх буюу тодруулбал тухайн ТӨААН-ийн өөрийн вэб хуудсанд болон ҮАГ, ОУИТБС буюу АМГТГ-ын вэб хуудсанд тус тус нийтлэхийг зөвлөж байна.

7.2.11 Цахим тайлагналын системд хийх нэмэлт өөрчлөлт

2018 оны ОУИТБС-ын тайлан буюу дараагийн тайланг төслийн түвшинд задалж тайлагнах шаардлага тавигдсан байгаа. Энэ тайлагналын асуудлыг хэрэгжүүлэхийн тулд Цахим тайлангийн системд зарим маягтууд нэмж оруулах нь зүйтэй (6.12-р бүлгийг үзнэ үү).

Зөвлөмж

Мэдээллийг төслийн түвшинд задаргаатай гаргуулж авахын тулд МОУИТБС-ын Ажлын албанаас холбогдох маягтуудыг цахим тайлагналын системд оруулсан байх ёстой.

7.2.12 ОУИТБС-ын тайлагнал ба компанийн санхүүгийн тайлан хоорондын зөрүү

“Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн санхүүгийн тайланд “Энур аудит” ХХК аудит хийсэн ба тус аудитын тайлангаар 2017 оны жилийн орлого нь 39 тэрбум төгрөг гэж баталгаажуулсан. Мөнгөн гүйлгээний тайлангаар бол тайлант жилд 3Г-д төлсөн роялтын төлбөр байхгүй.

Харин 3Г-ын тайлангаар Петрочайна дачин тамсаг компаниас 2017 онд нийт 235 тэрбум төгрөг хүлээн авсан, үүнээс ашигт газрын тосоор 190 тэрбум төгрөг, газрын тосны нөөц ашигласны төлбөрт 25 тэрбум төгрөг ба бусад төлбөрт 16 тэрбум төгрөг орсон байна.

Санхүүгийн тайлан ба ОУИТБС-ын тайлан хоёр хоорондоо илэрхий зөрүүтэй харагдаж байгаа юм.

Газрын тосны тухай хуулийн 36.2-д заасан “Гэрээлэгч нь тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдэж байгаа газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана”, НББ-ийн тухай хуулийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил, гүйлгээ, бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, бүх өр төлбөр, аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр, бүх орлого, бүх зардал, нягтлан бодох

бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлсийг заавал бүртгэнэ” гэж заасан байдаг.

ОУИТБС-ын тайланд өгсөн мэдээллээс үзвэл санхүүгийн тайланг бэлтгэхдээ эдгээр хуулиудын шаардлагыг зөрчсөн байх магадлалтай байна.

Зөвлөмж

ОТАХ–ын зүгээс АМГТГ-т энэ асуудлыг цааш тодруулах хүсэлтийг тавьж ажиллах нь зүйтэй. Нөгөө талаас Сангийн яам нь тухайн компаний санхүүгийн тайлангаа Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхийг шалгаж, тавьсан шаардлагыг биелүүлээгүй шалтгаан үндэслэлийг Ажлын хэсэгт танилцуулах нь зүйтэй. Петрочайна дачин тамсаг компанийн ОУИТБС-д ирүүлсэн дүн материаллаг хэмжээтэй байгаа учир эдгээр авсан арга хэмжээний үр дүнг ОТАХ-д ирүүлж байж ОУИТБС-ын тайлагнал зарчмын дагуу зөв зүйтэй явагдах юм.

Түүнчлэн ОТАХ-ын зүгээс ашигт малтмал, газрын тосны салбарын компаниудын санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангахад төр хэрхэн оролцох тухай бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

ЗГ-ын 2012 оны 222 дугаар тогтоолоор ОУИТБС-ын зорилгоор мэдээллийн хэрэгцээ шаардлага байгаа тул холбогдох зарим хуулиар хийсэн байсан нууц хадгалах тухай хязгаарлалтуудыг хүчингүй болгосон байдаг. Гэвч төрийн байгууллагууд энэ талаар бүрэн мэдээлэлгүйгээс болж уул уурхайн компаниудын санхүүгийн тайлан бүрэн ил тод болж чадахгүй байна.

8 ХАВСРАЛТУУД

| № | Хавсралтууд |
|---------------|--|
| Хавсралт 1 | МОУИТБС-ын 2017 оны тайланд хамрагдсан компаниудын мэдээлэл |
| Хавсралт 2 | Нэгтгэлийн ажилд мэдээлэл өгсөн ЗГ-ын байгууллагуудын албан тушаалтан |
| Хавсралт 3 | Нэгтгэлийн ажилд мэдээлэл өгсөн орон нутгийн засаг захиргааны байгууллагын албан тушаалтан |
| Хавсралт 4 | Компаниудад илгээсэн тайлангийн маягтуудын бүтэц |
| Хавсралт 5 | Төрийн байгууллагуудад илгээсэн тайлангийн маягтуудын бүтэц |
| Хавсралт 6 | Гол орлогын урсгал (Засгийн газрын тайлагнаснаар, нийт ОУ-ийн урсгал) |
| Хавсралт 7 | Компаниудын ирүүлсэн мэдээлэл |
| Хавсралт 8 | ЗГ-ын байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл |
| Хавсралт 9 | Шийдвэрлээгүй зөрүү (компаниудаар) |
| Хавсралт 10 | Анхны нэгтгэл, залруулга болон залруулгын дараах нэгтгэл (Компаниудаар) |
| Хавсралт 11.а | Нэгтгэлийн дараах төрийн байгууллагуудад олгосон хандив, тусламжийн дэлгэрэнгүй мэдээлэл |
| Хавсралт 11.б | Нэгтгэлийн дараах төрийн байгууллагуудад олгосон хандив, тусламжийн дэлгэрэнгүй мэдээлэл |
| Хавсралт 11.в | Төрийн бус байгууллага, иргэн, компаниудад өгсөн хандив, тусламжийн дэлгэрэнгүй мэдээлэл /компаниудын тайлагнаснаар/ |
| Хавсралт 12 | Тохируулгын дараах улсын хэмжээний гол орлогын урсгалууд, ЗГ-ын дүнгээр |
| Хавсралт 13 | Тохируулгын дараах орон нутгийн хэмжээний гол урсгалууд, ЗГ-ын дүнгээр |
| Хавсралт 14 | Нэгтгэлд хамрагдсан компаниудын санхүүгийн тайлангийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эх сурвалжууд |
| Хавсралт 15 | Ажилчдын мэдээлэл |
| Хавсралт 16.а | Хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт |
| Хавсралт 16.б | Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт |
| Хавсралт 16.в | Шинээр олгосон хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт |
| Хавсралт 16.г | Шинээр олгосон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт |
| Хавсралт 16.д | Шилжүүлсэн хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт |
| Хавсралт 16.е | Шилжүүлсэн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт |
| Хавсралт 16.ё | Нийт шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт |
| Хавсралт 16.ж | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалт |
| Хавсралт 16.з | ЭБМЗ-ийн ашигт малтмалын хайгуулын асуудал хэлэлцэх хуралдаанаар 2017 онд хэлэлцэгдсэн тайлангууд |
| Хавсралт 16.и | Хүчин төгөлдөр ураны тусгай зөвшөөрлийн жагсаалт (2017.12.31-ний байдлаар) |
| Хавсралт 16.к | Түгээмэл тархацтай ашигт малтмалын лиценз |
| Хавсралт 16.л | Хүчин төгөлдөр ураны тусгай зөвшөөрлийн солбилцлын цэгүүд |
| Хавсралт 16.м | Хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн сонгон шалгаруулалтын шийдвэрийн жагсаалт |
| Хавсралт 16.н | Газрын тосны тусгай зөвшөөрлүүдийн жагсаалт |
| Хавсралт 16.о | Хүчин төгөлдөр БХГ-үүдийн солбилцлын цэгүүд |
| Хавсралт 17 | Нийгмийн зарцуулалт /компаниудын ирүүлсэн мэдээлэл/ |
| Хавсралт 18 | Ашигт малтмалын олборлолт болон борлуулалт |
| Хавсралт 19 | Санхүүгийн тайландаа аудит хийлгэсэн байдал |
| Хавсралт 20.а | Уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл (Нүүрсний салбараас бусад) |
| Хавсралт 20.б | Уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл - Нүүрс |
| Хавсралт 21 | Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүн |
| Хавсралт 21.а | Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл |

МОУИТБС-ын 12 дугаар буюу 2017 оны нэгтгэл тайлан

| | |
|---------------|--|
| Хавсралт 21.б | Бенефициар өмчлөгчид (хувь хүн) |
| Хавсралт 21.в | Бенефициар өмчлөгчид (хуулийн этгээд) |
| Хавсралт 21.г | Бенефициар өмчлөгчийн мэдээлэл бэлтгэж өгөөгүй компаниудын тайлбар |
| Хавсралт 21.д | Ногдол ашиг |
| Хавсралт 22 | Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хийсэн гэрээний мэдээлэл |
| Хавсралт 23 | Компаниудын байгаль орчныг хамгаалах тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгө |
| Хавсралт 24 | Компаниудын нөхөн сэргээлтийн талбай болон зардлын мэдээлэл (нүүрс) |
| Хавсралт 25 | Компаниудын ирүүлсэн нөхөн сэргээлтийн мэдээлэл |
| Хавсралт 26 | 2017 оны нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниудын жагсаалт |
| Хавсралт 27.а | Нэгтгэлд хамрагдсан компаниудын ОУИТБС-д оролцооны үнэлгээ |
| Хавсралт 27.б | ЗГ, Төрийн байгууллагуудын ОУИТБС-д оролцооны үнэлгээ |
| Хавсралт 28 | Орон нутаг дахь бичил уурхайн ГТББ-уудын гишүүдийн мэдээлэл |
| Хавсралт 29 | АМГТГ-аас ирүүлсэн БУУ-н үйл ажиллагааны мэдээлэл |
| Хавсралт 30 | Ашигласан усны мэдээлэл |
| Хавсралт 31 | Хог хаягдлын мэдээлэл |
| Хавсралт 32.а | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй, цахим тайлангийн системд ороогүй компаниудын жагсаалт |
| Хавсралт 32.б | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй, цахим тайлангийн систем дээр ЗГ-ын тайланд орсон компаниудын жагсаалт |
| Хавсралт 33 | Ном зүй ба эх сурвалж |